



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ
ᠴᠢᠭᠤᠯᠭᠠᠨ ᠨᠢᠭᠳᠦᠰᠢᠨ ᠬᠤᠷᠠᠯᠳᠠᠨᠳᠠ
ᠶᠡᠷᠦᠨᠬᠡᠢ ᠰᠠᠶᠳᠠᠨ ᠬᠢᠶᠦᠰᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД
ЕРӨНХИЙ САЙДЫН ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ**

№60

УЛААНБААТАР
2025



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД
ЕРӨНХИЙ САЙДЫН ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулган
/2024.10.01 - 2025.01.24/

№ 60

Улаанбаатар хот
2025 он

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйл. Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх	3
2. Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээллийн талаарх статистикийн мэдээ	5
3. 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээлэл	6
4. 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээллийг хэлэлцсэн тухай	16
5. 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын явцын талаар” Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээлэл	45
6. 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын явцын талаар” Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээллийг хэлэлцсэн талаар	62
7. 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны хүрээнд хийгдсэн “Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээлэл	110
8. 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны хүрээнд хийгдсэн “Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээллийг хэлэлцсэн талаар	115

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬ:

2024 оны 05 сарын 16 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

112 дугаар зүйл. Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх

112.1. Хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, улс орны эдийн засаг, нийгэм, санхүүгийн төлөв байдал болон бусад асуудлаар Ерөнхий сайд сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх буюу Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдийн асуултад хариулна.

112.2. Ээлжит чуулганы хугацаанд Ерөнхий сайдын хийх мэдээллийн нэгдсэн сэдвийн жагсаалтыг тухайн ээлжит чуулган эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурлын даргад, Ерөнхий сайдын хийх мэдээллийг нэгдсэн хуралдаанаар сонсохоос 7 хоногийн өмнө Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдэд тус тус бичгээр ирүүлнэ.

112.3. Ерөнхий сайдын мэдээллийг Байнгын хороодын хуралдаанаар урьдчилан хэлэлцэхгүй.

112.4. Ерөнхий сайдын мэдээллийг нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд өөрөө хийх ба холбогдох Засгийн газрын гишүүдийг байлцуулна.

112.5. Нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд 25 минутад багтаан мэдээлэл хийх бөгөөд Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийн төлөөлөл 25 минутад багтаан үг хэлнэ.

112.6. Энэ хуулийн 112.5-д заасны дагуу Ерөнхий сайд мэдээлэл хийж, цөөнхийн төлөөлөл үг хэлсний дараа цөөнхийн төлөөлөл тус бүр Ерөнхий сайдаас асуулт асууж, үг хэлж болох бөгөөд асуулт асууж, үг хэлэх хугацаа 3 минутаас, хариулт өгөх хугацаа 5 минутаас тус тус хэтрэхгүй.

112.7. Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авах, үг хэлэх нийт хугацаа 1 цаг 30 минутаас хэтрэхгүй.

112.8. Цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудлаар Ерөнхий сайд мэдээлэл хийх шаардлагатай гэж үзвэл энэ зүйлд зааснаас өөр цаг, өдөрт хийж болно.

112.9.Энэ хуулийн 112.2-т заасан мэдээллийг ирүүлмэгц сэдвийг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд 5 хоногийн хугацаанд иргэдээс асуулт асуухаар байршуулна.

112.10.Энэ хуулийн 112.9-д заасан цахим хуудсанд иргэдээс ирүүлсэн асуултыг Тамгын газар нэгтгэж нам, эвслийн бүлгүүдэд хүргүүлнэ.

112.11.Энэ хуулийн 112.10-т заасан асуултыг нам, эвслийн бүлэг ангилан багцалж, нам, эвслийн бүлэг тус бүрээс нэг гишүүн төлөөлж Ерөнхий сайдаас асуулт асууж, хариулт авах хугацаа 20 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно. Асуулт, хариултыг цөөнхийн төлөөлөл эхлүүлнэ.

112.12.Энэ хуулийн 112.11-д заасан хугацаа нь энэ хуулийн 112.7-д заасан хугацаанд хамаарахгүй.

112.13.Иргэдийн асуултад Ерөнхий сайд энэ хуулийн 112.11-д заасан хугацаанд багтааж хариулт өгөөгүй бол хариултыг 3 хоногийн дотор Улсын Их Хурлын Тамгын газарт бичгээр ирүүлнэ. Тамгын газар бичгээр ирүүлсэн хариуг энэ хуулийн 112.10-т заасан цахим хуудсанд байршуулна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД
ЕРӨНХИЙ САЙДЫН ХИЙСЭН МЭДЭЭЛЛИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭ

№	Сэдэв	Мэдээлэл хийсэн сайд	Мэдээлэл хийсэн огноо	Цөөнхөөс дүгнэлт уншсан эсэх (УИХ-ын гишүүн)	Цөөнхөөс асуулт тавьсан УИХ-ын гишүүн (Асуултын тоо)	Иргэдээс ирсэн асуултыг асуусан УИХ дахь намын бүлгийн төлөөлөл (УИХ-ын гишүүн)		Иргэдээс ирсэн асуултын тоо
						МАН	АН	
1	"Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан Боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар;	Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр	2024.10.25	О.Цогтгэрэл, Ж.Золжаргал, А.Ундраа Б.Батбаатар	Л.Мөнхбаясгалан, Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл, Ж.Баярмаа, Р.Батболд, Г.Ганбаатар, Б.Батбаатар нарын 7 гишүүн, 16 асуулт	Б.Уянга	Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан асуулт асуух байсан боловч тухайн цагт хуралдааны танхимд байгаагүй	3 иргэн 5 асуулт
2	2024-2025 оны евелжилт, хаваржилтын бэлтгэл ажлын явцын талаар;	Монгол Улсын Шадар сайд, УОК-ын дарга С.Амарсайхан	2024.11.29	О.Цогтгэрэл, Ж.Золжаргал, А.Ундраа Б.Батбаатар	О.Цогтгэрэл, Л.Мөнхбаясгалан, П.Батчимэг, Г.Ганбаатар, С.Цэнгүүн, С.Эрдэнэболд, М.Нарантуяа-Нара, Да.Цогтбаатар, Ж.Золжаргал, Д.Жаргалсайхан нарын 10 гишүүн 36 асуулт	У.Отгонбаяр	С.Эрдэнэболд	2 иргэн 15 асуулт
3	Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны хүрээнд хийгдсэн "Шил" ажиллагааны хэрэгжилтийн талаар;	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	2024.12.27	Б.Жаргалан, П.Ганзориг, А.Ундраа Б.Батбаатар	Ж.Баярмаа, О.Цогтгэрэл, Б.Батбаатар нарын 3 гишүүний 16 асуулт	-	-	Асуулт ирээгүй

---000---

НЭГ.МОНГОЛ УЛСЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙСЭН ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДРИЙН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД “ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-Д ТУСГАГДСАН БООМТЫН СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ



Л.Гантөмөр: - Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, цар тахлын дараах эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулж, төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх зорилгоор эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулах дунд хугацааны зорилтот хөтөлбөр “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг дэвшүүлсэн. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын тэргүүлэх зорилтын нэг болох “Боомтын сэргэлтийн бодлого”-ыг

хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Нэг. Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон БНХАУ-ын буцалтгүй тусламжийн санхүүжилтаар дараах боомтуудад өргөтгөл шинэчлэл, барилга угсралтын ажлыг хийж дуусган, ашиглалтад орууллаа.

- Замын-Үүд боомт

Шинээр бүтээн байгуулалт хийгдсэн зорчигч тээврийн цогцолборт импортын тээврийн хэрэгслийн 8 байсан гарцыг 20, экспортын 4 байсан гарцыг 24 гарцтай болгож, иж бүрэн инженерийн дэд бүтцийн шугам, нэгдсэн удирдлагын төвтэй холбогдсон орчин үеийн хяналтын систем бүхий тээврийн хэрэгслийг автоматаар бүртгэх ухаалаг гарцууд, өндөр хүчин чадлын авторентген бусад хилийн хяналтын тоног төхөөрөмжүүд суурилуулснаар зорчигч болон тээврийн хэрэгсэл түргэн шуурхай нэвтэрч, иргэд ая тухтай орчинд үйлчлүүлэх боломж бүрдсэн.

Шинэ ачаа тээврийн цогцолборт импортын тээврийн хэрэгслийн 3 байсан гарц 22, экспортын 2 байсан гарц 5 болж нэмэгдэн, 28 барилга байгууламж,

иж бүрэн инженерийн дэд бүтцийн шугам, 11 км цахилгаан хангамжийн шугам, дэд өртөө, зам талбайн гэрэлтүүлэг, холбоо дохиолол камержуулалт, хашаа хамгаалалтын хэрэгсэл зэрэг ажлуудыг гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгсөн.

- Гашуунсухайт боомт

Хуучин байсан боомтын барилга байгууламж, зам талбайг бүрэн шинэчилж, зорчигчийн шалган нэвтрүүлэх 4188м² цогцолбор барилгыг өргөтгөн шинэчилж, зорчигч ачаа тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх импортын 1 гарц байсныг 3, экспортын 1 гарц байсныг 3 гарцтай, нүүрс тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх экспортын 6 гарцтай байсныг 10 гарцтай болгож олон улсын жишигт нийцсэн ухаалаг гарц, авто пүү, хүнд даацын авто зам, рентген, ариутгал, эрэлч нохойн байр, лаборатор, холбоо дохиолол камержуулалт зэрэг ажлууд хийгдсэнээр боомтын нэвтрүүлэх хүчин чадал даруй 3 дахин нэмэгдэх боломж бүрдсэн.

Мөн Гашуунсухайт боомтын өргөтгөл шинэчлэлийн ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Хайрхан багт хил хяналтын байгууллагуудын албан хаагчдын орон сууц, дэд өртөөний барилга, гадна дулаан, цэвэр бохир ус цэвэрлэх байгууламж, уурын зуухны барилгын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.

1.2. Дараах боомтуудад улсын төсвийн хөрөнгө оруулалт болон БНХАУ-ын буцалтгүй тусламжийн санхүүжилтаар бүтээн байгуулалтын ажил хийж гүйцэтгэж байна.

- Цагаандэл-Уул боомт

БНХАУ-ын ӨМӨЗО-ы Альшаа аймгийн 114 сая юаны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хилийн Цагаандэл-Уул боомтын өргөтгөл шинэчлэлийн ажлын ерөнхий төлөвлөгөө, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны үнэлгээ, зураг төсвийг боловсруулах ажил хийгдэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 82 хувь байна.

Цагаандэл-Уул боомтын барилга байгууламж, шугам сүлжээ, суурьшлын бүс, нүүрс, эрдэс баялаг, ачаа тээврийн 12 эгнээ бүхий хүнд даацын авто зам, аялал жуулчлал, зорчигч шалган нэвтрүүлэх хэсэгт 6 эгнээ авто зам зэрэг иж бүрэн бүтээн байгуулалтын ажлыг 2025 онд эхлүүлнэ.

1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараах боомтуудын техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны үнэлгээ болон зураг төслийн ажлыг хийж байна.

- Хавирга, Ханх, Шивээхүрэн, Цагааннуур боомтын техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, нарийвчилсан зураг төслийн ажил иж бүрэн хийгдэж дууссан.
- Ульхан, Бургастай, Ханги боомтын техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны үнэлгээ, нарийвчилсан зураг төслийн ажил дуусаж, экспертизээр хянагдаж дүгнэлт гарсан. Ажлын явц 99 хувь байна.

- Ханги, Сүмбэр, Баянхошуу, Булган боомтын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан.
- Ханги боомтын барилга, байгууламжуудын зураг төсөв болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ баталгаажиг дууссан.
- Булган боомтын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулан, холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлж байна. Боомтын барилга байгууламжийн болон шугам сүлжээний зураг, төсөв экспертизээр хянагдсан. Ажлын явц 96 хувь байна.
- Сүмбэр, Баянхошуу боомтын техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны үнэлгээ, нарийвчилсан зураг төслийн ажил дууссан. Ажлын явц 96хувь байна.

1.4. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл тусламжийн санхүүжилтаар дараах боомтуудын өргөтгөл шинэчлэл, барилга угсралтын ажил хийгдэж байна.

- Боршоо боомт

Боршоо боомтын иж бүрэн өргөтгөл шинэчлэлийн ажил, авто зам, гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил дуусаж, байнгын ашиглалтад хүлээн авсан.

Боомтын шинэчлэлээр нийт талбай 3.5 дахин, өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 4.8 дахин, ачааны автомашины тоо 3 дахин, суудлын тээврийн хэрэгслийн тоо 6.7 дахин нэмэгдэж зорчигч, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэн, иргэд ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдсэн. Түүнчлэн хууль бус, чанарын шаардлага хангахгүй бараа, бүтээгдэхүүн хилээр нэвтрэхээс урьдчилан сэргийлж иргэдийн эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

- Алтанбулаг боомт

Алтанбулаг боомтод зорчигч тээврийн 19, ачаа тээврийн 18, дэд бүтцийн 5 барилга, иж бүрэн инженерийн шугам сүлжээ, 6,000м² ногоон байгууламж, тусгаарлах зурвас бүхий 4 эгнээ 1.7 км урттай авто зам, 7,000м² авто зогсоол, 30,000м² боомтын доторх зам талбай, зорчигч, тээврийн хэрэгслийг түргэн шуурхай нэвтрүүлэх, орчин үеийн технологи бүхий гарцуудыг шинээр ашиглалтад оруулсан.

Энэхүү бүтээн байгуулалтын үр дүнд Алтанбулаг боомтоор өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 3 дахин, ачааны тээврийн хэрэгслийн тоо 4 дахин, суудлын тээврийн хэрэгслийн тоо 4 дахин нэмэгдэнэ.

- Сүхбаатар боомтын нэг цэгийн үйлчилгээний цогцолбор

Цогцолборын иж бүрэн өргөтгөл шинэчлэлийн ажлыг дуусгаж, 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр улсын комисст хүлээлгэн өгсөн. Сүхбаатар

хилийн боомтын Нэг цэгийн үйлчилгээний цогцолборын барилгыг ашиглалтад оруулснаар хил дээр хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын үйлчилгээг хүртээмжтэй, ил тод, үр ашигтай хүргэх механизмыг бий болгосон. Түүнчлэн зорчигчид болон гадаад худалдаа эрхлэгчдийн төмөр замын боомт дээр зарцуулж буй цаг хугацаа, зардлыг 30-аас доошгүй хувиар бууруулж, улмаар боомтоор түргэн шуурхай нэвтрэх боломжийг бүрдүүлж эхэлсэн.

- Бичигт боомт

Бичигт боомтод зорчигч тээврийн 24 барилга байгууламж, дэд бүтэц, ногоон байгууламж бүхий өргөтгөл шинэчлэл, барилга угсралтын ажил явагдаж байна. Тус боомтод гаалийн шуурхай удирдлагын төвтэй холбогдсон орчин үеийн теле хяналтын систем бүхий тээврийн хэрэгслийг автоматаар бүртгэх ухаалаг гарцууд болон өндөр хүчин чадлын рентген, тоног төхөөрөмжүүд суурилагдахаар төлөвлөсөн.

Боомтын шинэчлэлээр нийт талбай 3 дахин, өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 4 дахин, ачааны автомашины тоо 3 дахин, суудлын тээврийн хэрэгслийн тоо 4 дахин нэмэгдэж зорчигч, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэн, иргэд ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.

- Хавирга, Булган, Цагааннуур боомтууд

Азийн хөгжлийн банкны 106.3 сая ам.долларын санхүүжилтээр 2024-2030 онд хэрэгжүүлэх “Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдааны төсөл”-ийн хүрээнд хилийн Хавирга, Булган, Цагааннуур боомтын өргөтгөл шинэчлэлтийн ажил хийгдэх бэлтгэл ажил хангагдаад байна.

- Гадаад худалдааны цахим нэг цонхны систем

Монгол Улсын худалдааны тэнцэл таатай чиглэлд шилжиж байгаатай холбогдуулан Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны (CAREC) коридорын дагуух хил дамнасан худалдааг хөнгөвчлөх, Монгол Улс дахь худалдааны зардлыг бууруулахад дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх хуваарийн 10.4-т "Нэг цонх"-ны эцсийн хугацааг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр гэж тодорхойлсон. Үүний дагуу Монгол Улс гадаад худалдааны нэгдсэн цахим цонхыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2023 онд шийдвэр гарган, “Гадаад худалдааны цахим нэг цонхны систем”-ийг хэрэгжүүлж байна.

1.5. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар дэд бүтэц, олон төрөлт тээврийн, ачижбуулгах, шилжүүлэн ачих терминалууд барих бүтээн байгуулалтын чиглэлд дараах ажлууд хийгдсэн.

- Гашуунсухайт боомтод 92 сая ам.долларын өртөг бүхий 10 сая.тн ачаа тээвэрлэх хүчин чадал бүхий автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал ашиглалтад орсон.

- Гашуунсухайт боомт дахь чингэлэг тээврийн терминалыг нийт 30 га талбайд 40 тэрбум 350 сая төгрөгийн санхүүжилтээр байгуулсан бөгөөд 8,100 чингэлэг буюу 259,200 тонн нүүрсний багтаамжтай, жилд 8 сая тонн хүртэл нүүрс ачиж буулган экспортлох хүчин чадалтай болсон.
- Гашуунсухайт боомтын 34 га талбайд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт болон төмөр замаас автотээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтын ажлыг нийт 1 тэрбум 282 сая ам.долларын санхүүжилтээр хийсэн.
- Шивээхүрэн боомтод жилд 23 сая.тн ачаа тээвэрлэх хүчин чадал бүхий ачаа шилжүүлэн ачих, буулгах чингэлэг тээврийн, автомат удирдлагатай 5G тээврийн терминалыг 100 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад орсон.
- Шивээхүрэн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд зориулж 929 сая төгрөгийн өртөг бүхий хилийн шалган нэвтрүүлэх 8 хаалга, 2.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий гаалийн хяналтын барилга ашиглалтад орсон.
- Ханги боомтод 60 орчим сая ам.долларын өртөг бүхий жилд 20 сая.тн ачаа тээвэрлэх хүчин чадалтай олон төрөлт чингэлэг тээврийн терминал ашиглалтад орсон.
- Хавирга боомтод 4.7 тэрбум төгрөгийн өртөг бүхий ачаа тээврийн терминал, 43.3 тэрбум төгрөг өртөг бүхий уурхайгаас хилийн боомт хүртэлх 96 км авто зам, 16 тэрбум төгрөгийн өртөг бүхий хүнд даацын төмөр бетон гүүрний ажлууд хийгдэж байна.

Цаашид хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж, хувийн хэвшилтэй хамтран боомтын хөгжлийг дараагийн шатанд гаргах боомтын шинэлэг менежментийг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Ингэснээр боомтын хөгжлийг эдэлбэр газартай, эдийн засгийн үр өгөөжтэй байлгаж, боомт нь орчин үеийн дэвшилтэт технологи бүхий терминал, агуулах, авто зам, төмөр зам болон агаарын тээвэрийн цогцолбор болон хөгжиж, олон төрлийн үйлдвэр, үйлчилгээ тэдгээрийг дагасан хот суурин, аж үйлдвэрийн парк үүсэх, хөгжих нөхцөл боломж бүрдэнэ.

1.6. Боомтын ажиллах цагийн горим, зэрэглэлийг нэмэгдүүлэх, чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Экспорт, импортын хэмжээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд боомтын ажиллах цагийн хуваарийг уртасгах, зэрэглэл, горимыг дээшлүүлэх, боомтын үйл ажиллагааг сэргээх, нээх асуудлаар хоёр орны хилийн харилцааг зохицуулах Засгийн газар хоорондын хэлэлцээрт өөрчлөлт оруулах чиглэлээр хамтарсан уулзалт, яриа хэлэлцээрүүд тогтмол хийгдэж байна.

Хилийн боомтуудын ажиллах цагийн хуваарийг уртасгах, боомтын зэрэглэл горимыг нэмэгдүүлэх талаар Монгол, Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комисс, Монгол Улсын Хилийн боомтын

захиргаа болон БНХАУ-ын ӨМӨЗО-ы Боомтын захиргаа хоорондын хамтын ажиллагааны механизмын хуралдаан, Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын “Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комисс”-ын хуралдаанд санал оруулан тодорхой шийдвэрт хүрч ажиллаж байна.

Хилийн боомтуудын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлж, ажиллах цагийн хуваарийг уртасган ажилласны дүнд хилийн боомтын ажиллах хугацааг сард дунджаар 430 гаруй цаг буюу 18 ажлын өдрөөр уртасгасан. Ингэснээр Монгол Улс 2024 оны гуравдугаар улирлын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 20.4 тэрбум ам.доллар болж, энэ нь өмнөх оны мөн үеэс 12.7 хувиар, ковид цар тахлын өмнөх жил буюу 2019 оны мөн үеэс 94.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хилийн боомтод үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын хэрэгцээ шаардлагыг үндэслэн авто замын боомтуудын цагийн горим, зэрэглэлийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хэлэлцээр хийж, зарим боомтыг ажиллах цагийн хуваарийг уртасгасан цагаар болон амралтын өдрүүдэд туршилтын журмаар ажиллуулж байна. Үүнд:

- Баянхошуу-Өвдөг, Бичигт-Зүүнхатавч боомт Бямба, Ням гарагт 08.00-17.00 цагийн хооронд,
- Шивээхүрэн-Сэхээ боомт Даваа гарагаас Баасан гарагт 17.00-20.00 цаг, Бямба, Ням гарагт 08.00-20.00 цагийн хооронд,
- Гашуунсухайт-Ганцмод боомт Даваагаас Баасан гарагт 17.00-20.00, Бямба, Ням гарагт 08.00-20.00 цагийн хооронд,
- Ханги-Мандал боомт Даваа гарагаас Баасан гарагт 17.00-20.00, Бямба, Ням гарагт 08.00-20.00 цагийн хооронд,
- Булган-Такашикэн боомт Бямба, Ням гарагт,
- Бургастай-Лаомяо боомт Бямба гарагт тус тус нэмэлт цагаар ажиллаж байна.

Мөн Сүмбэр-Рашаан боомтыг байнгын ажиллагаатай, Хавирга-Ар хашаат боомтыг олон улсын зэрэглэлтэй болгох асуудлыг БНХАУ-ын талтай тохиролцоод байна.

Замын-Үүд-Эрээн авто замын боомтын ачаа тээврийн хэсгийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл 24 цагаар ажиллуулсан. Энэ ажлын хүрээнд дараах үр дүнгүүд гарсан байна.


- Тус ачаа тээврийн цогцолбороор улсын хил нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 30.6 хувиар өссөн.
- Улсын хилээр нэвтэрсэн бараа эргэлтийн хэмжээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад импортын бүрдүүлэлт 25,188 буюу 70.6 хувь, барааны статистик дүн 573 сая ам.доллар буюу 49.2 хувь, ачааны жин 318.7 мянган тонн буюу 32.4 хувь, татварын дүн 296.1 тэрбум төгрөг буюу 58.9 хувиар тус тус өссөн.

- Экспортын бүрдүүлэлт 5062 буюу 3 дахин, барааны статистик дүн 33.2 сая ам.доллар буюу 116.9 хувь, ачааны жин 362 мянган тонн буюу 5 дахин тус тус өссөн.
- Замын-Үүд суманд ачааны автомашины дараалал үүсэж, жолооч, ард иргэдийг бухимдуулах болон эмх замбараагүй байдал үүсэх асуудал арилсан бөгөөд Замын-Үүд суманд том оврын ачааны автомашины дарааллаас үүдэлтэй орчны болон хөрсний бохирдол буурсан зэрэг үр дүн гарсан.
- Замын-Үүд боомтын ачаа тээврийн цогцолбороор 2023 оны 4-8 дугаар сард гарах урсгалд 45,178, орох урсгалд 48,669, нийт 93,843 автомашин улсын хил нэвтэрч байсан бол 2024 оны 4-8 дугаар сард гарах урсгалд 65455, орох урсгалд 69,825, нийт 135,280 автомашин улсын хил нэвтэрсэн байна.
- Замын-Үүд боомтын ачаа тээврийн цогцолбороор хийгдсэн бараа эргэлтийн хэмжээ дараах байдлаар байна.

Замын-Үүд-Эрээн автозамын боомтод хийгдсэн туршилтын үр дүнд үндэслэн ачаа тээврийн хэсгийг 24 цагийн горимыг үргэлжлүүлэх талаар холбогдох талтай яриа хэлэлцээр хийгдэж байна.

ОХУ-ын Алтанбулаг, Цагааннуур боомтын ажиллах цагийн горимд өөрчлөлт оруулан 24 цагийн горимд шилжүүлэх талаар, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Боомтын захиргаатай хил дамнасан автомат удирдлагатай тээвэр /AGV/-ийн ажиллах цагийн хуваарийг 24 цаг болгох талаар хэлэлцэж, тодорхой үр дүнд хүрээд байна.

1 дүгээр зураг. Замын-Үүд-Эрээн автозамын боомт дахь ачаа тээврийн барааны эргэлт /2024 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар/



Хоёр. Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд:

Хилийн боомтуудыг нийт 2650 км хатуу хучилттай авто зам, 4600 км төмөр зам барих, шинээр 11 боомтыг авто замаар, 4 боомтыг төмөр замаар холбох ажлыг хийж, гүйцэтгэж байна. Тухайлбал:

- Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто замыг байнгын ашиглалтад оруулсан.
- Ульхан боомтын чиглэлд Норовлин-Баян-Уул чиглэлийн хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц 70 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Баян-Уул-Ульхан боомт хүртэлх 118.3 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц 50 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц 30 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 477.1 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлын явц 97 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Баруун-Урт-Бичигт чиглэлийн 277.3 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц 23 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Сүхбаатар-Замын-Үүд боомт чиглэлийн төмөр замын төв коридорыг хос замтай болгох, шинэчлэх төслийн хүрээнд төмөр замын шугамыг шинэчлэн хөгжүүлэх ажлын ТЭЗҮ-ийг хийсэн.
- Эрэнцав-Баянтүмэн чиглэлийн төмөр замыг шинэчлэх төслийн хүрээнд тус чиглэлийн төмөр замыг шинэчлэх нарийвчилсан зураг төслийг хийсэн.
- Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын ТЭЗУС-г Сангийн яам, Зам, тээврийн яам болон БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яам хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд Солонгосын KOICA, KORAIL зэрэг байгууллагууд хамтран боловсруулсан.
- Зүүнбаян-Ханги чиглэлийн 229 км төмөр замыг байнгын ашиглалтад хүлээн авсан бөгөөд төслийн барилга угсралтын замын доод бүтэц 100 хувь, замын дээд бүтэц 85 хувь, Ханги, Номгон өртөөний барилга байгууламжийн ажил 100 хувь, дохиолол холбооны ажил 60 хувьтай явагдаж байна.

Ази-Европыг холбосон бүс нутгийн логистикийн төв байгуулах, дамжин өнгөрөх ачаа тээврийг нэмэгдүүлэх чиглэлээр БНСУ-ын Сангийн яам, Худалдаа, хөрөнгө оруулалтын агентлаг (KOTRA)-тай хамтран Алтанбулаг тээвэр, логистикийн төвийг байгуулах урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах техникийн тусалцааны төслийг хэрэгжүүлсэн.

Гурав. Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлалыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалын салбарыг дэмжих ажлын хүрээнд:

Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны 2023 оны “Агаарын замын хилийн боомтын асуудлаар авах арга хэмжээний тухай” А/04 дүгээр тогтоолоор Увс аймгийн “Дэглий цагаан” нисэх буудалд шинэ боомт байгуулах асуудлыг Монгол Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэхээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтсон. Энэхүү шийдвэрийн дагуу “Хилийн боомт байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

Хэнтий аймгийн “Өндөрхаан” нисэх буудлыг ЗС ангиллын болгох төслийн барилгын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.

Мөн Агаарын замын байнгын ажиллагаатай олон улсын боомтын тоог нэмэгдүүлэх чиглэлээр Ховд аймгийн “Ховд” нисэх буудлыг 4С ангиллын болгох төсөл, Хөвсгөл аймгийн “Мөрөн” нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж олон улсын 4С ангиллын болгох төсөл, Дорнод аймгийн “Чойбалсан” нисэх буудлыг 4С ангиллын болгох төсөл, Өмнөговь аймгийн “Гурвансайхан” нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж 4D ангиллын болгох төсөл, Увс аймгийн “Дэглийцагаан” нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Дөрөв. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн Эдийн засаг-Нийгмийн комисс (ESCAP)-ийн 2023 оны 09 дүгээр сард зохион байгуулагдсан ээлжит хуралдаанаар Монгол Улсад байгуулах боломжтой хуурай боомтуудын асуудлыг хэлэлцүүлж, “Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хавсралтад Алтанбулаг, Сайншанд, Улаанбаатар, Замын-Үүд, Чойбалсан, Ховд хот (Ховд), Хөшигийн хөндий (Төв), Бичигт (Сүхбаатар) гэсэн нийт 8 байршилд хуурай боомт байгуулахаар батлуулсан.

Монгол Улсад олон улсын чанартай хуурай боомт байгуулах ажлын хүрээнд шаардлагатай ажлуудыг үе шаттайгаар хийж байна.

- > “Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т тусгагдсан хуурай боомт байгуулах боломжтой “Баруун бүсийн коридор: - Ховд”, “Төвийн бүсийн коридор: - Замын-Үүд, Улаанбаатар, Алтанбулаг, Хөшигийн хөндий, Сайншанд”, “Зүүн бүсийн коридор: - Бичигт, Чойбалсан” байршлуудад нөхцөл байдлын судалгааг хийсэн.
- > Хуурай боомтын байршлуудад баруун, төвийн, зүүн бүсийн коридорын дагуу зах зээлийн болон байршлын хамтарсан судалгааг БНХАУ-ын холбогдох судалгааны байгууллагуудтай хамтарч хийсэн.
- > Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг үндэслэн Замын-Үүд суман дахь “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн хуурай боомт байгуулах

техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан. Тус төлөвлөгөөний хүрээнд “Замын-Үүд хуурай боомт” байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын суурь судалгаа боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж судалгааны ажлыг мэргэжлийн зөвлөх үйлчилгээний байгууллагаар гүйцэтгүүлж байна.

Хуурай боомтыг байгуулснаар өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний худалдааны өртгийг бууруулах буюу тээврийн зардал, тээвэрлэлтийн хугацааг бууруулах, Орос, Хятад хөрш орнуудын зах зээлийг цаашлаад Ази-Европыг холбосон дамжин өнгөрөх тээврийн орлогыг нэмэгдүүлэх, дотоод экспорт, импортын худалдааны эргэлтийг сайжруулахад томоохон түлхэц болно.

Боомтын хөгжлөөр тэргүүлэгч улс орнууд боомтыг ачаа тээврийн эргэлтийг зохицуулах зорилго бүхий томоохон эдэлбэр газар бүхий хот, суурин хэмээн тодорхойлж, үйлчилгээ авагч аж ахуйн нэгж, иргэдэд чирэгдэлгүй, мэргэжлийн үйлчилгээ үзүүлж тэрхүү үйлчилгээний орлогоор санхүүждэг хэлбэрээр хөгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газраас боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулах, боомтуудын бүс нутгийн эдийн засгийн интеграцид үзүүлэх нөлөө, орон нутгийн хөгжилд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, бусад орны боомтуудтай гадаад худалдаанд эзлэх байр сууриар өрсөлдөхүйц олон улсын жишигт хүргэн хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Боомтыг зөвхөн хил нэвтрүүлэх, шалгах, гаалийн татвар хураамж хураах цэг төдийгөөр ойлгож байсан уламжлалт хандлагыг өөрчилж, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, эдийн засгийн идэвхитэй үйл ажиллагаатай, эдэлбэр газартай, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хэлбэрээр хөгжүүлэх шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын Засгийн газар боомтын сэргэлтийн асуудалд онцгойлон анхаарч, эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор Боомтын тухай хуулийг боловсруулан Монгол Улсын Их Хуралд өргөн барихаар ажиллаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДРИЙН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ЕРӨНХИЙ САЙДЫН “ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-Д ТУСГАГДСАН БООМТЫН СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ХИЙСЭН МЭДЭЭЛЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ

Чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын дарга Н.Учрал, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны Ажлын албаны дарга О.Нарандэлгэр, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын зөвлөх Д.Одгэрэл, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, Автозамын бодлого зохицуулалтын газрын дарга Ч.Сугармаа, Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Артур, Хилийн боомтын захиргааны дарга Б.Батхишиг, Боомтын үйл ажиллагааны хэлтсийн дарга Д.Балдорж, Гаалийн ерөнхий газрын Боомтын хэлтсийн дарга Д.Зоригоо, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, Боомтын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч П.Оюун-Эрдэнэ, Гаалийн ерөнхий газрын Хяналт бүрдүүлэлтийн газрын гаалийн ахлах байцаагч Ц.Цэвээндарь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Тамгын газрын тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Тамгын газрын дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Хяналт шалгалтын газрын дарга Т.Нармандах, мөн газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг нар байлцав.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, ХҮН намыг Ж.Золжаргал, Үндэсний эвслийг А.Ундраа, Иргэний Зориг Ногоон Намыг Б.Батбаатар нар төлөөлж үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл, Ж.Баярмаа, Р.Батболд, Г.Ганбаатар, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын дарга Н.Учрал, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.11-д заасны дагуу цахим хуудсанд 3 иргэнээс ирүүлсэн 5 асуултыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Л.Мөнхбаясгалан, Ардын намын бүлгийн төлөөлж Б.Уянга нар иргэдийн асуултыг тавьж, хариу авав.

О.Цогтгэрэл: - Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ.

Өнөөдөр ээлжит чуулганы анхны Ерөнхий сайдын мэдээлэл хийгдэх ёстой өдөр. Ерөнхий сайдын мэдээлэл гэдэг өөрөө онцлогтой. Улсын Их Хурал дахь цөөнхийн төлөөлөл асуулт асууж тодруулга авдаг.

Ерөнхий сайд мэдээлэл нь салбар хоорондын асуудлууд байдаг. Өнөөдрийн хийгдэх ёстой боомтын сэргэлтийн асуудал гэдэг бол боомт дээр Шадар сайдын харьяаны бус Хил хамгаалах газар үүрэг гүйцэтгэдэг. Боомт дотор Гаалийн газар үйл ажиллагаа явуулж байдаг. Өнөөдрийн сэдэв боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар гэж байгаа. Ийм учраас Ерөнхий сайд энэ анхныхаа мэдээлэлд орж ирж тодорхой хэмжээний хариултаа өгөх ёстой.

Цөөнхийн гишүүдийг хүндэтгээд Ерөнхий сайд анхны мэдээлэлд заавал орж ирж оролцох ёстой, асуултад хариулах ёстой гэдэг байр суурийг Ардчилсан намын бүлгийн гишүүд илэрхийлж байгааг үгийн эхэнд дамжуулъя.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ.

Монгол Улсын Засгийн газраас “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрийг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хурлаар батлуулсан. Бусад хөтөлбөр, төслүүдийн адилаар их хүлээлт дагуулсан, том төсөвтэй, энтертайнмент арга барилтай, сүртэй хурал, сүржин танилцуулга нь хэтийдсэн агуулгаасаа илүүтэй хэлбэрт анхаарсан уг хөтөлбөрийг бидэнд танилцуулж, Улсын Их Хурлаар батлуулснаас хойш даруй 3 жил өнгөрсөн ч үзүүлэх ахиц, хийсэн ажил байхгүй байгаа нь харамсалтай байна.

Энэхүү хөтөлбөрт боомтын хүчин чадлыг 2019 онд экспортолж байсан 50 сая тонн ачааг 3 дахин нэмэгдүүлж, 150 сая тонн хүргэх зорилт тавьсан. Уг зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 100 гаруй сая тонн, Монгол Улсын хөгжлийн 2025 оны хөтөлбөрт 80 сая тонн-д хүргэхээр тус тус тодотгосон. Гэвч бодит байдал дээр өнгөрсөн 3 жилийн хугацаанд боомтын хоногт ажиллах хугацааг уртасгах, нэмж гарц байгуулах зэргээр боомтын хүчин чадлыг механик аргаар нэмэгдүүлснээс өөрөөр бодит шинэчлэлийн ажлууд хийгдсэнгүй.

Дэлхийн эдийн засгийн форумас гаргасан өрсөлдөх чадварын индексээр Монгол Улсын хувьд 141 орноос 119 дүгээр байранд орсон. Дэлхийн банкны ложистикийн гүйцэтгэлийн индексээр Монгол Улс дэд бүтэц, гаалийн үйл ажиллагаа, ложистикийн үйлчилгээ зэрэг нь доогуур үнэлэгдсэн буюу 130 дугаар

байранд эрэмбэлэгдсэн байна. Эдгээр тоо баримт, статистикууд биднийг тээвэр ложистик, боомтын чиглэлдээ анхаарах ёстойг сануулж байгаа. Тэгээд энэ чиглэлд хөтөлбөр боловсруулж, ажиллуулж буйд нь Засгийн газарт талархалтай хандаж болох хэдий ч тулгамдаж буй асуудлууд байна. Тодруулбал, авч буй арга хэмжээ нь зөвхөн хатуу дэд бүтэц, хөрөнгө оруулалт руу чиглэж байгаа болохоос биш зөөлөн дэд бүтцийг бий болгохтой холбоотой хууль, эрх зүйн шинэчлэл, бусад олон тулгамдаж буй асуудлуудыг шийдэхэд хандахгүй байна.

Эдгээрийн үр дүнд өнгөрсөн 7 хоногийн байдлаар гэхэд БНХАУ-ын Тяньжин боомтоос чингэлэг татах хугацаа 95-150 хоног болж сунаж, Монгол Улсад ирэх 4400 чингэлэг хилийн цаана бөөгнөрч, иргэн, аж ахуйн нэгж 3 дахь орноос татан авч буй ачаа 180 хоногоор саатаж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний импортын үнэ нэмэгдэхэд нөлөөлж, бизнесийн байгууллагуудын үйл ажиллагаа доголдох, орлого, ашиг буурах зэрэг олон хүчин зүйлд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, иргэдийн худалдан авах чадварт дам байдлаар дарамт үүсгэж байна.

Дэлхийн банкаас гаргасан 2023 оны ложистикийн гүйцэтгэлийн индексээр Монгол Улс хилийн боомт дээрх хүлээлгийн хугацаа, дэд бүтцийн дутагдалтай байдал, бараа, бүтээгдэхүүнд тавих хяналт ложистикийн чадавх зэрэг хүчин зүйлсээр ижил төстэй улс орнуудаас хэт хол хоцрогдолтой байгааг дахин дурджээ.

Мөн түүнд зөвхөн дэд бүтцийн хөрөнгө оруулалтаас гадна зөөлөн дэд бүтэц болох худалдааг хөнгөвчлөх, хил гаалийн үйлчилгээг хялбарчлах чиглэлээр үйл ажиллагаа явуулахгүй, Засгийн газрын зүгээс санаачилгагүй ажиллаж байгааг онцлон дурджээ.

Асуудлыг шийдэх гэж ажиллах биш, харин тухайн асуудлыг сайд нар өөрийн төсвөө нэмэгдүүлэх, зарцуулах, хөрөнгө оруулалт ахиулах шалтгаан төдийгөөр ашигласаар буйг эрс буруутгаж байгааг Ардчилсан намын бүлгийн зүгээс илэрхийлж байна.

Амласан ажил нь ажил хэрэг болохгүй, олон асуудал эзэнгүй, шийдэлгүй байгаагаас ганц нэгийг онцгойлон дурдъя. Гашуунсухайт Ганц мод, Ханги мандал, Шивээ хүрэн, Сэхээ чиглэлд мухар төмөр замууд тавигдаж, төмөр замын тээврийн хил холболтын асуудлууд өнөөдрийг хүртэл тодорхой шийдэлгүй байсаар байна.

2025 онд эдгээр төслүүдийн хил холболт хийгдэхгүй тохиолдолд боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэхээр Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгасан зорилт хэрэгжихээргүй байдалтай байна.

Төмөр замаар холбох хил холболтын төслүүд БНХАУ-ын талын шийдлийг хүлээгээд зогссон. Төмөр замын сүлжээг шинэчлэн сайжруулах хүрээнд зарим голд төмөр замыг хос болгох чиглэлд бодит ажил хийгдэж эхлээгүй. Шинээр төмөр замын сүлжээ байгуулах хүрээнд Зүүнбаян, Ханги чиглэлээс бусад

төслүүд эхлээгүй. Транзит хурдны авто зам болон хилийн боомтуудын хатуу хучилттай авто замаар холбох төслүүдийн хэрэгжилт тун хангалтгүй, ихэнх нь эхлээгүй. Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, ачаа тээврийн терминалуудыг байгуулах, импортын ачаа бараа тээвэрлэх хүрээнд тодорхой ажлууд хийгдээгүй. Чингис хаан ОУНБ-аас өргөтгөж, олон улсын агаарын тээврийн транзит төв болох зэрэг асуудал тодорхойгүй байгаагаас харахад боомтын сэргэлтийн зорилтот хөтөлбөрүүд төлөвлөсөн хугацаандаа, хугацааных нь дийлэнх өнгөрчихсөн байхад ахиц гараагүй байгааг онцгойлон сануулж хэлэх ёстой.

Боомтын сэргэлтийн хүрээнд батлагдах ёстой хуулиудын жагсаалтад байгаа Тээврийн нэгдсэн хуулийн төсөл, Боомтын тухай хуулийн төсөл зэрэг тэргүүтэй хуулиудыг Засгийн газраас одоог хүртэл өргөн бариагүй байгаа нь боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх, энэ хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажилд хувийн хэвшлийг татан оролцуулах, салбар хоорондын уялдаа, давхардал, хийдлийг арилгах зэрэг эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэх Замын-Үүд Алтанбулаг чиглэлийн олон улсын транзит хурдны зам барих ажил олон жил яригдаж байсан ч цаашид хэрхэх нь тодорхойгүй байдалтай байна. Энэ мэт аминд тулсан яаралтай шийдэх төслүүдийг хөдөлгөлгүй орхиод асуудлыг мартуулах бол .../ минут дуусав/

Д.Амарбаясгалан: - Цаг дууслаа. О.Цогтгэрэл гишүүнд 1 минут нэмж өгье.

О.Цогтгэрэл: - Өмнө эхлүүлсэн хөтөлбөрийнхөө үр дүнг гаргаад, дараа дараагийн ажил хөтөлбөрүүд рүү ордог бол ядаж өчүүхэн ч төдий үр дүн гарахад ард, иргэдэд мэдрэгддэг бол ажил, хөтөлбөр, төсөл бүхнийг тань 2 гараа өргөөд дэмжихэд бэлэн байгаагаа Ардчилсан намын бүлгийн зүгээс илэрхийлж байна.

Өнөөдрийн байдлаар манай улсын эдийн засаг, улсын төсвийн орлого, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлогоос хэт хамааралтай болсон бөгөөд үүнийг дагасан төсвийн зарлагын хэт тэлэлт бий болсон. Төмөр замын хил холболт төлөвлөсөн хугацаанд биелэхгүй тохиолдолд ирээдүйд тооцсон орлого тасалдаж, эдийн засаг төсөвт эрсдэл үүсэхээр байгааг Монгол Улсын 2025 оны төсвийг батлахаар хэлэлцэж буй энэ цаг үед Та бүхэнд анхааруулъя. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: - Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал таныг индэрт урья.

Ж.Золжаргал: - Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ.

Монгол Улс боомтын сэргэлтийн бодлого гэсэн нэртэйгээр өнгөрсөн жилүүдэд харагдахаар үнэхээр үр дүнтэй ажил хийсэн гэдгийг хил гаалийн

байгууллага, тээвэр ложистик, уул уурхай дээр ажиллаж байгаа хүмүүс тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрч байгаа гэдгийг хэлмээр байна.

Боомтын хөдөлгөөнийг хянах тооны зөрөө, хил гаалийн мэдээлэл дээр будилаан гардаг. Түүнээс болоод нүүрсний хулгай гэдэг асуудал босож байсан. Ард нь янз бүрийн маргаан гардаг. Энэ тал дээр хил, гаалийн байгууллагын цахимжилтын түвшин шинэ шатад гарсан гэдгийг Та бүхэндээ хуваалцмаар байна.

Инновац, цахим бодлогын байнгын хорооноос холбогдох байгууллагууд дээр ажилласан. Цахимжилтын түвшин бол нэлээн сайн болсон. Одоо хилийн болоод гаалийн байгууллага хооронд мэдээллийг нэгтгэх, солилцдог шийдэл нь туршилтын шатдаа яваад байгаа. Харин энэ нэлээн удаж байна. Үүнийг бол шахаж шаардах, яаравчлах хэрэгтэй гэдгийг зориуд цохож хэлмээр байна.

Тэгээд суурь дэд бүтцийн асуудал, хил гаалийн бүтээн байгуулалт, цахимжилт энэ бүгд нь Монголын бараа бүтээгдэхүүний хөдөлгөөнийг хянах, хулгай болон бүртгэлгүй зүйлс гарахаас урьдчилан сэргийлэх, түүхий эдийн тээвэр нь ойлгомжтой, нээлттэй, биржээр борлуулдаг болох, орлогоо нэмэгдүүлэх зэрэг зорилготой гэж бодож байгаа.

Тийм учраас Монгол Улс эрх зүйн орчиндоо өөрчлөлтүүд оруулаад, биржээр жишээ нь нүүрсээ зараад эхэлсэн. Хэрвээ энэ бүхний үр дүнд тээвэрлэлт нь нэмэгдэхгүй, хилээр нэвтэрч байгаа бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ өсөхгүй, нүүрсээ биржээр зарж чадахгүй байх юм бол үр дүнгүй ажил болно. Тийм болохоор энэ их хөрөнгө оруулсан ажлаа ажил хэрэг болгож бодитоор ашиглахад анхаарах, үүн дээр Засгийн газар онцгой анхаарч ажиллах шаардлага үүсээд байна.

Юуны түрүүнд дурдахад Гашуунсухайт, Ганц модын боомт, хил холболтын төмөр замын асуудал. Хэрвээ үүнийг холбохгүй бол бусад боомтууд холбогдохгүй. Тэгэхээр нүүрс гаргахгүй, нүүрс гаргахгүй болохоор орлого байхгүй, орлого байхгүй болохоор тэлчихсэн төсөв өөрийгөө тэжээж чадахгүй. Ингээд Монгол Улс хүнд байдалд орно. Мега төслүүд хэрэгжихгүй. Ийм яриа нэлээн их явж байгаа. Тэгэхдээ энд бодох зүйлс их байна.

1 дүгээрт, нэгэнт барьчихсан дэд бүтэц, төмөр замаа ашигламаар байна. Тавантолгойн ордоос Гашуунсухайт хүртэл хүчин чадлын 4 хувийг 9 дүгээр сарын байдлаар ашиглаж байна. Нийт 30 сая тонн тээвэрлэх чадалтай, ойролцоогоор 4 хувийг буюу 1,3 сая тонныг л одоогоор тээвэрлэсэн байна. Төмөр замын холболт хийгдсэн эсэхээс үл хамаараад төмөр замын толгой дээр нүүрс ачих байгууламж нүсэр технологитой орчин үеийн байгууламж ашиглалтад орчихсон. Төмөр замын төгсгөл дээр төмөр замаас аваад, машин дээр ачаад цааш нь гаргах олгогдсон терминалууд нь байгуулагдчихсан, ажиллаж байгаа. Өөрөөр хэлбэл, ачаа бараагаа ачаад, хил дээр аваачаад, цааш нь гаргах боломж нь байгаа. Яагаад 1,3-хан сая тонн нүүрс одоогоор гарч байна вэ? Тарифын асуудал байна уу. Явуулахгүй сонирхол байна уу? Энэ дээр бүтээсэн ажил, хөрөнгө оруулалтаа

ашиглаад Монгол Улсынхаа экспортын барааг гаргах, тээврийн зардлыг бууруулах, орлогоо нэмэгдүүлэх ажлыг явуулмаар байна.

2 дугаарт, хил холболтын төмөр замын техник, эдийн засгийн зураг төслийн ажлыг БНХАУ-ын Зураг төслийн 3 дугаар хүрээлэн хийгээд дуусчихсан. Гүйцэтгэгч нь Монгол Улсын 2023 оны 7 дугаар сарын 07-ны Улсын Их Хурлаас гарсан тогтоолоор Хятад талдаа суурь дэд бүтэц эзэмшдэг компани байна. Тэр нь “Чайна Энержи” гэсэн ганц компани гүйцэтгэнэ. Тэгээд 20 сая тонны хөрөнгө оруулалт, худалдан авалт, нүүрсний гэрээ байгуулна гээд нөхцөл тавьчихсан байдаг.

Нэмээд ирж байгаа мэдээллээр олборлолт дээр Хятадын тал оролцоно. Барилга угсралтаа хийнэ. Тээвэр дээр нь оролцоно. Өөрөөр хэлбэл аж ахуйн нэгж болон Монгол Улс, БНХАУ-ын төр, өөр өөр түвшний, өөр өөр чиглэлийн байгууллагууд. Монгол Улсын болон БНХАУ-ын төрийн дээд түвшинд тээврийн асуудлууд, төмөр замын асуудлуудыг ярьж тохирсон гэсэн мэдээлэл байгаа. Өнөөдөр гишүүдэд мэдээлэл түгээгдсэн байна. Төрийн асуудлыг тусдаа, аж ахуйн нэгжийн асуудал тусдаа байх ёстой. Тийм болохоор Хятадын талаас гүйцэтгэгчийг эцэслэж тохироод, хийх ажлыг нь “Эрдэнэс Тавантолгой”, “Чайна Энержи” гэх зэрэг аж ахуйн нэгжүүд үнэхээр тэр бүтээн байгуулалт, барилга угсралтыг хийх юм бол тэр ажлыг нь шахаж шаардмаар байна. Явахгүй байгаа бол 2 улсын төрийн харилцааны хүрээнд гадаад харилцаагаараа асуудлыг тавимаар байна.

Хэрвээ энэ төсөл удаад, нөхцөл нь манай хувьд хүлээж авахын аргагүй байх юм бол энэ нь цаанаа нүүрсний үнэ дээр асуудал үүсгэнэ. Нүүрсний олборлолтыг Монголчууд 100 хувь хийж чадна. Нөхцөл тохирохгүй бол заавал холбох гээд байх шаардлага ч байхгүй байж болно. Цэвэр эдийн засгийн үр ашгийн болоод бодлогын шийдвэр хэрэгтэй гэж үзэж байна.

Эцэст нь нэг зүйл нэмээд хэлэхэд өчигдөрхөн хүмүүс Говь-Алтай аймгийн Нарансэвстэй боомтын талаар асуудал тавьсан. Тэр бол эдийн засаг болоод байгаль орчноо дэнсэлж байж шийдвэр гаргасан гэж үзэж байгаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: - Баярлалаа. Агваанлуvsсангийн Ундраа гишүүн үг хэлнэ. Индэрт урьж байна.

А.Ундраа: - Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Мөн Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байгаа залуучуудад мэнд хүргэе.

Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд боомтын сэргэлтийн бодлогын талаарх мэдээллийг сонслоо. Өнөөдрийн боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Ерөнхий сайд өгөх ёстой байсан. Үүн дээр би Ардчилсан намын байр суурьтай адилхан байна. Ерөнхий сайд өөрийн биеэр мэдээлэл хийх нь зүйтэй гэж үзэж байна. Тэгээд Шадар сайдын мэдээллийг сонслоо.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд мэдээж боомтын сэргэлт маш чухал үүрэгтэй. Энэ хүрээнд дараах 4 чиглэлээр танилцуулга хийгдлээ.

1. Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийн талаар. Энэ нь боомтын ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг хэрхэн дээшлүүлж байгаа талаар;
2. Хилийн боомтуудын төмөр зам болон авто замын хатуу хучилттай авто замын үйл ажиллагаа. Тэр нь улсын төсвөөр болон гадаадын зээл тусламжийн хүрээнд хийгдэж байгаа ажлын талаар;
3. Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт агаарын зам ашиглалтын талаар;
4. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан чөлөөт бүс хуурай боомтын байгуулалтын талаар мэдээлэл хийлээ.

Өнөөдөр хийсэн мэдээллүүдийн хүрээнд нэлээд хөрөнгө оруулалт талаасаа тоочсон шинжтэй, үйл ажиллагааны явцыг мэдээлэх маягтай байна.

Гэтэл боомтын сэргэлтийн асуудлын хамгийн чухал зүйл болох хүний нөөц, боомтууд дээр ажиллаж байгаа ажиллагсад, гаалийн байгууллага, хилийн шалган нэвтрүүлэх болон бусад төрийн байгууллага хувийн хэвшлийн хүмүүсийн амьдрах, ажиллах орчны талаар нэг ч үг, үсэг, өгүүлбэр алга. Ажиглагсдын нөхцөл байдлын талаар ялангуяа уул уурхайн хамгийн их хэмжээний бараа бүтээгдэхүүний эргэлттэй Гашуунсухайтын боомтын тухайд ярихад, жолооч нар тэнд олон цагаар ажилладаг, түгжирдэг зэрэг ажиллах орчны болон нийгмийн мөн байгаль орчны нөлөөллийн тулгамдаж буй асуудлууд хуримтлагдсан байдаг. Эдгээрийг хэрхэн шийдэж байгаа талаар энэ мэдээлэл дотор дурдагдсангүй.

Энэ нь юуг харуулж байна вэ гэвэл Засгийн газраас өргөн барьсан төслийг харж байхад ч гэсэн дандаа бүтээн байгуулалт, барилга байгууламж, хөрөнгө оруулалтын чиглэлийг дурддагаас биш хүн рүүгээ чиглэсэн арга хэмжээ шат шатандаа дутагдаж байгааг өнөөдрийн мэдээлэл ч гэсэн дахин харуулж байна.

Тэгээд хүн рүүгээ чиглэсэн бодлого дутагдсан. Мөн түүнчлэн салбар хоорондын бодлогын уялдаа алдагдсаны улмаас ямар үр дагавар гарч байгаа талаар зарим жишээ дурдахад саяхан Замын-Үүдийн боомтын үйл ажиллагаатай танилцаад ирлээ. Тэгэхэд жишээлэхэд, гаалийн байгууллага нийт орон тооныхоо 85 орчим хувийг ажилтнуудаар бүрдүүлсэн. Орон тоо дутуу, тэнд ажиллах сонирхолтой, боломжтой боловсон хүчин бол тэр болгон олдохгүй нөхцөлд ажиллаж байна.

Мөн хил дээр ажиллаж байгаа ажиллагсдын хувьд ажиллах орон байрны асуудал, хилийн орчмын суурин газруудын нийгмийн асуудал, жишээлэхэд, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хүртээмжийг анхаарахгүй байгаа нь харагдаж

байна. Хэдийгээр боомтуудын нэвтрэлтийг сайжрууллаа гэсэн боловч түүнийг авч хэрэгжүүлдэг, тэр ажлыг хийж гүйцэтгэдэг хүний нөөцийн асуудлаа орхигдуулсан байгаа нь харагдаж байна.

2 дугаарт, амьдрах, ажиллах орчны талаас гадна ажлаа хийх нөхцөл бололцоог бүрдүүлэх асуудал бол туйлын дутагдалтай байна. Жишээлбэл, Замын-Үүдийн боомтын хувьд хилээр нэвтэрч байгаа ачаанд хяналт шалгалт хийхэд лабораторийн тоног төхөөрөмжийг ажиллуулах нарийн мэргэжлийн хүний нөөц, бололцоо дутуу байна.

3 дугаарт, лабораторийн тоног төхөөрөмжөө ашиглуулъя гэхэд хэрэгцээ шаардлагатай урвалж бодисууд хангалттай нийлүүлэгддэггүй гэдэг шалтгаануудаас болоод Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа бараа бүтээгдэхүүн хүн ардад аюулгүй байх эсэхийг баталгаажуулах, тэдгээр лабораторийн тоног төхөөрөмжүүдийг ашиглах бололцоо байхгүй байна. Өөрөөр хэлбэл бид нарт ямар нэгэн баталгаа алга гэдэг нь харагдаж байна.

Цаашлаад, Монгол Улсын агаарын зай, зохион байгуулалт, агаарын замын ашиглалтын талаар мэдээлэлд дурдсан байгаа. Үүн дотор аялал жуулчлалын салбартай уялдуулан авч хэрэгжүүлж байгаа бодлогоо дурдаж байгаа нь зүйтэй боловч ялангуяа Монгол Улс далайд гарцгүй орны хувьд агаарын тээвэр онцгой чухал үүрэгтэй. Энэ тохиолдолд гуравдагч хөршүүд рүү шууд нислэгтэй болох, нислэгийн чиглэлийг нэмэгдүүлэх, хэрхэн аялал жуулчлалын бодлоготойгоо уялдаж байгаа талаар энэ боомтын мэдээлэл дээр дурдагдсангүй.

Тэгэхээр дараа, дараагийн мэдээлэл хийхдээ зөвхөн хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, зам, харилцаа гээд хатуу дэд бүтэц, зөөлөн дэд бүтэц буюу гэрээ хэлэлцээр, эрх зүйн орчныг ярихаас гадна хамгийн чухал баялаг болох хүний нөөцийн асуудлыг хөндөж, энэ талаарх бодлогоо танилцуулна уу гэж анхааруулахыг хүсэж байна. Та бүхэнд баярлалаа.

Д.Амарбаясгалан: - Мэдээлэлтэй холбогдуулан Тэргүүн Шадар сайд, асуудал хариуцсан сайд нар ажлын хэсгийн гишүүд хариулт өгөхөөр ирсэн байгаа.

Батын Батбаатар гишүүнийг индэрт урьж байна.

Б.Батбаатар: - Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар сөрөг хүчний хувьд Иргэний Зориг Ногоон Намыг төлөөлөн байр сууриа илэрхийлье.

Монгол Улс бүс нутаг, Ази номхон далай, дэлхийд санхүү, хөрөнгө оруулалт, биржийн чиглэлээр ажиллаж, санхүүгийн хувьд боомт улс орон болох тухай санаачилгыг гаргаж байна. Энэ чиглэлд илүү сэтгэж, илүү ажиллахыг Засгийн газраас уриалж байна.

Монгол Улс БНХАУ-тай 4709 км, ОХУ-тай 3543 км-ээр хиллэдэг, далайд гарцгүй орон. Гэвч манай улсын эдийн засгийн урсгал харилцаа ердөө 4 боомт дээр төвлөрдөг. Энэ нь бараа бүтээгдэхүүний хомсдол үүсгэх, үнийн өсөлт, бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгааг та бид мэднэ. Үүнийг сайжруулах, гарц урсгалыг нэмэгдүүлэх үүднээс боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн, ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлэх ажлыг хийх ёстой. Гэсэн хэдий ч зөвхөн томоохон корпорацууд болон гадаадын хөрөнгө оруулагчид эрх мэдэл дагасан компани, хэсэг бүлгийн ашиг хүртдэг тогтолцоог бий болгох гарц болох магадлал өндөр байгааг Иргэний Зориг Ногоон Нам сэрэмжлүүлж байна.

Тухайлбал, Засгийн газраас гааль, боомтын удирдлагын тогтолцоонд зориулж 106 тэрбум төгрөг төсөвлөжээ. Засгийн газрын арга барил нь зөвхөн дэд бүтцийн шинэчлэлээр хязгаарлагдах ёсгүй. Манай боомтуудын удирдлагад тулгардаг хүнд суртлын саад бэрхшээлийг арилгах шаардлагатай байна. Бүх бизнесийн хувьд цаг хугацаа хэмнэх, зардлыг бууруулах нь нэн чухал бөгөөд үүний тулд захиргааны үйл ажиллагааг оновчтой болгох нь чухал юм.

2-т нь, экспортын ачаа 3 боомтоор буюу Гашуунсухайт, Шивээ хүрэн, Замын-Үүдийн боомтуудаар 90 хувь нь гадагшилдаг. Импортын ачаа 2 боомт дээр буюу Алтанбулаг, Замын-Үүд боомтуудаар 90 хувь нь Монгол Улсад нэвтэрч орж ирдэг. Боомтуудыг холбосон авто зам, дэд бүтэц, төмөр замын дэд бүтэц хангалтгүйгээс шалтгаалан бараа, бүтээгдэхүүний эвдрэл, гэмтэл, чанарын шаардлага алдагдах, тээвэрлэлтийн зардал өсөх гэх мэт асуудлууд үүсдэг. Үүний улмаас хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар холбон, тээвэр логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, ачаа тээврийн урсгалыг сайжруулах нь зүйтэй байна. Гэсэн хэдий ч томоохон дэд бүтцийн төслүүд, байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаар Иргэний Зориг Ногоон нам санаа зовниж байна. Тухайлбал, Алтанбулагийн хуурай боомтын бүтээн байгуулалтад 15 тэрбум төгрөг төсөвлөгдсөн бөгөөд хил дамнасан худалдааг сайжруулах боломжийг онцолж байна. Гэхдээ Засгийн газар эдгээр төслүүдийн байгаль орчны үнэлгээг сайтар хийсэн эсэх, экологийн хохирлыг багасгах төлөвлөгөө байгаа эсэхийг бид анхаарах ёстой.

Тэгээд ч энэ төслүүдийг Монгол Улсын тусгаар тогтнолыг алдагдуулж, ер зээлээр буюу гаднын санхүүжилтээр санхүүжүүлэхгүй байх ёстой гэж Иргэний Зориг Ногоон Намынхан анхааруулж байна.

Засгийн газар гадаадын хөрөнгө оруулалтад найдаж байгаа нь урт хугацааны өрийн үүрэг болон үндэсний нөөцөд тавих хяналтаа алдаж болзошгүй гэсэн болгоомжлолыг төрүүлж байна. Өнөөдөр Монгол Улсын гадаад өр 3 жилийн ДНБ-тэй тэнцэх хэмжээнд хүрээд байгааг бид мартаж болохгүй. Өрийг өрөөр, бондыг бондоор хаасаар байгаад баялаг бүтээдэг бус орлого олдоггүй зүйлд өр тавьж хөрөнгө оруулалт хийсээр байгаад даруй 35 тэрбум ам.долларын өртэй болсон байдаг. Ирээдүй хойч үедээ санхүүгийн хүнд дарамт учруулахгүйн тулд эдгээр төслүүдийг сайтар нягтлах ёстойг Иргэний Зориг Ногоон Намынхан бид дахин анхааруулж байна.

3-д нь, Монгол Улсын агаарын орон зайн зохион байгуулалтыг боловсронгуй болгох, агаарын тээврийг үе шаттайгаар либералчлах, Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь Монгол Улсыг ачаа тээврийн төв болгох аялал жуулчлалын салбарыг дэмжих зорилготой гэж ойлгож байна. Энэхүү санаачилга нь эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх боломжтой хэдий ч болгоомжтой байхыг Иргэний Зориг Ногоон Нам анхааруулж байна.

Агаарын тээврийг оновчтой зохицуулалтгүйгээр хурдацтай либералчлах нь манай үндэсний агаарын тээврийн компаниудыг хохироож, гадаадын тээвэрлэгчдийг монополчлоход хүргэж болзошгүй юм. Тухайлбал, Засгийн газраас ТЭЗҮ болон агаарын замыг өргөтгөхөд 20,5 тэрбум төгрөг төсөвлөжээ. Энэ нь дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлэхэд тусална. Гэсэн хэдий ч дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлэхийн тулд агаарын хөдөлгөөнийг удирдах аюулгүй байдлын дэд бүтцэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай. Хэрэв бид либералчлахын хажуугаар эдгээр дэд бүтцийг хөгжүүлж чадахгүй бол системийн хэт ачаалалд орж аюулгүй байдлаа алдагдуулж болзошгүй.

Түүнчлэн аялал жуулчлалын хөгжлийг тогтвортой үйл ажиллагаатай уялдуулах, ялангуяа байгалийн үзэсгэлэнт тогтоц, өв соёл нь Монгол Улсын үнэт зүйлс тул аялал жуулчлалыг богино хугацаанд ашиг олох салбар болгохоос урьдчилан сэргийлэх ёстойг Иргэний Зориг Ногоон Нам сануулж байна. Бид ногоон аялал жуулчлалыг хөгжүүлэхийг дэмжинэ.

4-т нь, 2023 онд 60 сая тонн нүүрсийг доод үнээр нь зөөж төсвөө өсгөсөн. Өнөөдөр багадаа 80 гаруй сая тонн нүүрсийг дахин доод үнээр зөөх төлөвтэй болоод байна. Энэ мэтчилэн багтаамж, гарцын хэрээр хэн нэгний бэлдэц бааз импортын эрэлт хэрэгцээний ханган нийлүүлэгч, арыг даагч болохоос Иргэний Зориг Ногоон Нам сэрэмжлүүлж байна.

Тиймээс Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүс хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхдээ болзошгүй нөхцөлөөс сэргийлсэн төрийн бодлого юу юунаас чухал байна.

Сэлэнгэ аймаг дахь хуурай боомтын бүтээн байгуулалтад ихээхэн хэмжээний төсөв төсөвлөсөн нь дэд бүтцийг хөгжүүлэх замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд төрөөс анхаарч байгааг онцолж байна. Гэсэн хэдий ч чөлөөт бүс ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: - 1 минут нэмж өгье.

Б.Батбаатар: - Тэнцүү байдлыг харгалзаж үзсэнд баярлалаа. Гэсэн хэдий ч чөлөөт бус бүсээс орж ирэх татварын орлогын алдагдлыг худалдааны өсөлтөөр нөхөх үү гэдэгт бид эргэлзэж байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого” нь эдийн засгийг сэргээх, өсгөх алсын харааг илэрхийлж байгаа ч үр өгөөжөө

шударга, тогтвортой хуваарилахад шаардлагатай хамгаалалт дутмаг байна гэж Иргэний Зориг Ногоон Намынхан үзэж байна.

Боомт, төмөр зам, агаарын тээвэр, хуурай боомт гээд дэд бүтцийн бүтээн байгуулалтыг ил тод, хүртээмжтэй байгаль орчинд ээлтэй байдлаар хийх ёстой.

Нөгөөтэйгүүр эдгээр төслүүдэд орон нутгийн оролцоо маш чухал юм. Эдгээр бүс нутагт амьдардаг ард иргэдийн хэрэгцээ, тэргүүлэх чиглэлтэй нийцүүлэхийн тулд иргэдийг бүтээн байгуулалтын шийдвэр гаргах үйл явцад оролцуулах ёстойг анхаарахыг Та бүхэнд зөвлөж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: - Горимын санал. Н.Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: - Сөрөг хүчин гээд байх юм. Энэ Ардчилсан нам, ХҮН нам 2 чинь Засгийн газрыг бүрдүүлж байгаа гишүүд мөн биз дээ эсвэл Л.Гантөмөр гуай өөр нам болчихсон юм уу. Яагаад өөрөөсөө асуугаад байгаа юм бэ? Бүгд асууж байгаа юм бол, би ч гэсэн асуумаар байна шүү дээ, Б.Батбаатар, А.Ундраа 2 л асууна биз дээ. Нөгөө 2 нь Засгийн газрын гишүүд шүү дээ. Яагаад ийм тэгш бус байгаа юм бэ? Шадар сайд нь сая илтгэл тавилаа. Ардчилсан намын дарга нь. Тэгээд Ардчилсан нам асуулаа. Энэ юу болоод байгаа юм. Жинхэнэ жонхуу болж байна шүү дээ. Ичмээр юм. Бид ч гэсэн асуух хэрэгтэй шүү дээ. Энэ дэгээ өөрчлөх хэрэгтэй.

Д.Амарбаясгалан: - Юм л бол Улсын Их Хурлын гишүүд өөрсдийнхөө хүсэл сонирхолд нийцүүлж дэг өөрчилье гэж ярьдгаа хязгаарлах хэрэгтэй шүү. Байгаа дүрэм, журам, дэгт зохицож ажиллаж амьдарч сурах ёстой. Тэгэхгүйгээр өөрийнхөө хүсэл бодолд тааруулж дэг өөрчилье гэж ярьдгаа ер нь таслан зогсоо. Тийм хэмжээний ёс суртахууныг Улсын Их Хурлын гишүүд өөрсдөөсөө гаргах ёстой шүү. Яг нөхцөлдөө тааруулаад өөрчилнө гэдэг асуудал байнга ярьдаг боллоо. Энэ тийм муу дэг биш шүү. Олон улсын түвшинд ардчилал хөгжчихсөн, парламентын засаглал хөгжсөн улс орнуудын жишигт нийцсэн дэг гэдгийг та бүхэн минь их сайн ойлгож ярьж байгаарай.

Л.Мөнхбаясгалан гишүүн, асуултаа асууя.

Л.Мөнхбаясгалан: - Үг хэлье. Өнөөдөр Улсын Их Хурлын эрхэм гишүүд, Засгийн газрын гишүүд бүгдээрээ Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийг зөрчөөд энд сууж байгаа. Дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйл Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх тухай зохицуулсан байна. 112.4 дүгээр хэсэгт Ерөнхий сайд мэдээллийг нэгдсэн хуралдаанд өөрөө хийнэ гэсэн байгаа юм. Шаардлагатай бол Засгийн газрын бусад гишүүдийг байлцуулна. Гэтэл энд ямар хуулийн зохицуулалтаар өнөөдөр Тэргүүн Шадар сайд мэдээлэл хийгээд, бид нар энд ингээд сууж байгаа юм. Дэгийн тухай хуулиа зөрчсөн Ерөнхий сайд Улсын Их Хурлын гишүүн. Ерөнхий сайдад ямар арга хэмжээ авах юм. Засгийн газар яагаад дандаа өөрсдөдөө таалагдсан хуулийн заалтыг барьж орж ирж байдаг юм. Хэрвээ Засгийн газрын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуультай зөрчилдөж байгаа бол нарийвчилсан хуулиа

мөрдөнө. Тэгвэл энэ дэгийн тухай хууль байгаад яах юм. Сая Улсын Их Хурлын дарга та хэлж байна шүү дээ, дэгээ барина. Энэ сайн хууль гэж.

Тэгвэл өнөөдөр дэгээ зөрчөөд, бид нар энд жүжиг тоглоод сууж яах юм. Улсын Их Хурал Засгийн газрын харьяаны байгууллага биш. Улсын Их Хурал Засгийн газрын хуулийн тасаг ч биш. Тэгж давармааргүй байна. Ерөнхий сайд энэ чуулганд өөрөө үгээ хэлээд, өөрөө бид нарт тайлбараа өгөх ёстой.

Хэрвээ үүнийг мөрдөхгүй юм бол дэгийн тухай хууль гэж байж яах юм. Тэгэхээр Ерөнхий сайдыг дуудаж оруулж ирмээр байна. Засгийн газрын гишүүд энд суугаад тайлбар хийх ямар ч шаардлага байхгүй шүү дээ.

Тэгэхээр Ардчилсан намынхныг энэ хурлыг хаяж гарахыг уриалж байна. Ингэж бид нар байж яах юм. Бид нар өнөөдөр хууль тогтоодог байгууллага. Бид нар өөрсдөө хуулиа барьж ард түмэнд үлгэр дуурайлаа харуулах ёстой. Гэтэл нэг л Засгийн газрын давхар дээлтэй хэдэн нөхдийн үгэнд ороод энд ингээд сууж байгаад бөөнөөрөө жүжиг тоглож байдгаа болих хэрэгтэй шүү дээ. Өөрсдөө хуулиа зөрчихөөд, яаж бид хууль батлах юм.

Улсын Их Хурлын дарга аа, Ерөнхий сайдыг дуудаж оруулж ирье. Дэгийн тухай хуулиа баримталъя. Би Дэгийн хуулийг өөрчилъе гээгүй, баримталъя гэж байна.

Д.Амарбаясгалан: - Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж хуулийн хэрэгжилттэй холбоотой тайлбар өгье. Ажлын хэсгийн 12 дугаар микрофон.

Б.Баасандорж: - Өнөөдрийн Ерөнхий сайдын нэгдсэн хуралдаанд хийж байгаа мэдээлэл Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлд заасан журмын дагуу явагдаж байна. 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга Н.Учралаас Монгол Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар мэдээлэл хийхээр товлогдсон боловч энэ хугацаанд Ерөнхий сайд түр эзгүй байгаа тул Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдын мэдээллийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд хийнэ гэсэн албан бичгийг ирүүлсэн байгаа.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг нь Ерөнхий сайдын түр эзгүйд түүний үүргийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд гүйцэтгэнэ. Түр эзгүйд орлоно гэсэн үг байгаа.

Тэгэхээр Монгол Улсын Ерөнхий сайдын оронд Тэргүүн Шадар сайд мэдээлэл хийж байна гэж ойлгож байна.

Д.Амарбаясгалан: - ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал сайд нэмж тайлбар хийе. Тайлбар хийж байгаа, асуултад хариулаагүй.

Н.Учрал: - Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад тайлбар өгье. Мэдээлэл хийх энэ өдөр Ерөнхий сайд түр эзгүй байх байсан учраас энэ цагийг хойшлуулж өгнө үү гэдэг хүсэлтийг албан бичгээр гаргасан боловч хуульд заасан хугацаанд Ерөнхий сайдын мэдээлэл хийгдэх шаардлагатай гэдэг тайлбар байсан. Энэ хүрээнд Засгийн газрын тухай хуулийн 17.2-ыг баримтлаад Ерөнхий сайдын түр эзгүйд түүний үүргийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд гүйцэтгэнэ гэсэн заалтын дагуу Тэргүүн Шадар сайд өнөөдрийн мэдээллийг хийж байгаа.

Д.Амарбаясгалан: - Энэ дээр Засгийн газрын зүгээс сар бүрийн сүүлийн 7 хоногийн Баасан гарагийн үдээс хойших хуралдаанд ямар асуудлаар мэдээлэл хийх, түүний хуваарийг гаргаж ирүүлсэн байгаа.

Тэгэхээр энэ ажлын төлөвлөлт дээр анхаараад, хэрвээ яг энэ цаг үе дээр Ерөнхий сайд байхаар, байх боломжгүй болсон тохиолдолд 7-гоос дээш хоногийн өмнө урьдчилж мэдэгдэх зайлшгүй шаардлагатай. Учир нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиараа Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотой материалыг Засгийн газраас Улсын Их Хуралд ирүүлээд, тухайн материалыг парламентын сайтад байршуулах, D.parliament.mn-аас санал авах, Улсын Их Хурал дахь улс төрийн намуудын бүлэг болон Улсын Их Хурлын гишүүдэд мэдээллийг тарааж өгөх зэрэг ажил нэгэнт эхэлсэн бол үүнийг хойшлуулах боломжгүй болдог.

Тэгээд Засгийн газрын тухай хуулиар уг асуудал зохицуулагдаад явж байгаа гэдгийг Л.Мөнхбаясгалан гишүүнд тайлбар хэлье.

Ингээд мэдээлэлтэй холбогдуулан Тэргүүн Шадар сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Монгол Улсын сайд Буяагийн Тулга болон бусад ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, үг хэлэх цөөнхийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Ингээд нэр өгсөн дарааллаар Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: - Боомтын хүндрэл ямар байдгийг бүгдээрээ мэдэж байгаа. Ковидын үеэр, нүүрсний хулгайн ид үеэр 1 машин нүүрс 120 сая төгрөгөөр 21-хэн километр газар л зөөж байсан шүү дээ. Боомтын хүндрэл ямар байдгийг эндээс харж байгаа.

Замын-Үүд дээр 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 07-ны өдрийн хооронд Хятадын баяр болсон. Хятадын баяр дуусангуут нөгөө 24 цаг чинь байхгүй болчихсон шүү. Одоо машинууд маш их очертой байна. Өнөөдрийн байдлаар Монголын талаас 1650 машин хил дээр оччихсон, очерлочихсон байж байна. Өдөрт аль аль талаасаа 300 машиныг оруулж, гаргаж байна. Үүнээс

болоод үнэ нь өсчихсөн. Өмнө нь 9,000 юаниар Эрээнээс Улаанбаатар хүрч байсан бол одоо 13,000 юань хүрчихлээ. Хоёрхон өдрийн дотор 2 сая төгрөгөөр нэмэгдчихлээ. Дахиад энэ очер нэмэгдэх юм бол үнэ улам их нэмэгдэнэ. Яагаад гэвэл Монголын нүүрсний эскпортын ийм их хэрэгцээ зөвхөн Замын-Үүд боомтоор гарч байгаатай холбоотой. Иймд цаашид боомтын тоог олон болгох, боомтын нэвтрэлтийг сайжруулах, үйл ажиллагааг байнгын болгох зэрэг ажлыг хамгийн гол нь хийх ёстой. Тухайлбал, жилд 50-хан машин гаргадаг Байтагийн боомт байна.

Б.Тулга сайдаас нэг зүйлийг асууя. Энэ Боомтын тухай хуулийг хурдан оруулж ирэх хэрэгтэй. Энэ хавар ажлууд эхэлнэ. Түүнээс өмнө боомтын эрх зүйн байдлаа тодорхой болгох хэрэгтэй. Энэ хууль дээр Ардчилсан намын бүлгээс төлөөлөл оруулаад, хуулийн төсөл дээр ажиллаад, хурдан шуурхай батлуулах тал дээр ажиллаж өгье. Дэлхийн олон улсуудад хувийн хэвшлийн менежменттэй боомтууд үр ашигтай ажиллаж байгаа. Учир нь төрийнхөн залхуураад, аль болох бага машин гаргадаг. Гэтэл хувийн хэвшлийн менежменттэй боомтоор явал олон машин гаргаж тэр хураамжаа илүү авах вэ гэдэг ийм л бодлого явагддаг. Жишээ нь уул уурхайн бүтээгдэхүүн болох нүүрсийг рентген аппаратаар хүн шаардахгүйгээр шалгадаг боомтуудыг хувийн хэвшлийнхэн оруулаад хийж байгаа шүү дээ. Ер нь хурдан ажиллахгүй бол, сайжруулахгүй бол Монголын ачааллыг барахгүй байна. Тийм учраас яг тэр бүс нутгийнх нь ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: - Хариулт өгье. Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Буяагийн Тулга хариулт өгнө.

Б.Тулга: - Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрье. Сая үг хэлсэн намын бүлгүүдийн төлөөлөлд талархал илэрхийлье. Боомт дээр болж байгаа асуудлууд дээр болохгүй байгааг нь шүүмжлээд, болж байгааг нь дэмжсэн агуулгатай үгнүүд хэллээ. Үүнийг бид сайн тэмдэглэн авч, энэ тал дээр илүү анхаарал хандуулж ажиллана гэдгээ юуны өмнө хэлье.

Б.Пүрэвдорж гишүүний асуусан асуултад хариулъя. Өнгөрсөн хугацаанд Замын-Үүдийн боомтын зорчигч тээвэр болон ачаа тээврийн шалган нэвтрүүлэх цогцолборыг сайжруулж шинээр бүтээн байгуулж дууссан. Үүнтэй холбоотойгоор 2023 оны 6 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайд БНХАУ-д хийсэн ажлын айлчлалын үеэр Хятадын боомтын удирдлагуудтай ярьж, Замын-Үүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд ямар шийдвэр гаргаж болох вэ гэдэг дээр хэлэлцээр хийсэн. Үүний үр дүнд 1992 оноос хойш Замын-Үүдийг 24 цагаар ажиллуулах хүсэлтийг Монголын талаас тавьж байсан боловч Хятадын талаас үүнийг зөвшөөрдөггүй байсан. Тэгээд анх удаа боомтыг 24 цагаар ажиллуулах туршилтыг хийж болох юм гэдэг яриа хэлэлцээрт хүрээд Замын-Үүдийн ачаа тээврийн цогцолборыг 2022 оны 12 дугаар сарын 15-наас 30 хүртэл 14 хоногийн хугацаанд буюу ачаалал багатай үеэр 14 хоногийн туршилтыг хийж эхлүүлсэн. Энэ туршилт амжилттай болоод 2 дахь шатын туршилтыг 2023 оны 4 дүгээр сарын 01-нээс 9 дүгээр сарын 30 буюу 6 сарын хугацаанд ид ачааллын үеэр хийж үзье гэсэн энэ туршилтыг явуулсан байгаа. Туршилтын үр дүн сайн гарсан.

Ингээд Хятадын талын үндэсний боомтын захиргаатай хийх уулзалт дээр Замын-Үүд боомтын ачаалал эдийн засгийн хувьд 24 цагаар ажиллуулах нь сайн байгаа учраас улирлын чанартай 24 цаг байх уу, бүтэн жилийн турш байнгын 24 цаг байх уу гэдэг дээр тодорхой шийдвэрийг гаргахаар ажиллаж байна.

Ер нь БНХАУ-ын хувьд бол манайх шиг ийм хуурай боомт 180 орчим байдаг. Нийтдээ 14 улстай хиллэдэг. Энэ 180 боомт дотор 24 цагаар ажилладаг ганцхан боомт өнөөдөр байгаа нь Манжуурын боомт. Манай Замын-Үүд хэрвээ 24 цагаар ажилладаг болох юм бол Хятадынхаа хувьд 2 дахь 24 цагийн ажиллагаатай боомт болох юм.

Засгийн газрын боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд Замын-Үүдэд байгаа албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, орон тоог нэмж, цалин хөлсийг тусгасан. Харамсалтай нь Хятадын талд шийдвэр гаргахдаа манайхтай харьцуулбал арай удаан процесстой байна. Энэ утгаар хил, гаалийн ажилчдын орон тоо нэмэгдээгүй. Үүнээс болоод хил, гаалийнх нь Хятадын талын ажилчдын гомдол байна. Үүнийг засахаар ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Замын-Үүд боомт дээр ачаалал их байна гэдэгтэй 100 хувь санал нэг байгаа. Ийм учраас бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулаад зүүн бүс, баруун бүс гэдэг 2 бүстэй Замын-Үүдтэй дүйцэхүйц хүчин чадалтай боомтуудыг байгуулахаар ажиллаж байгаа. Боомтын тухай хуулийн үзэл баримтлал, анхны төслийг боловсруулж гаргасан. Улсын Их Хурлын даргад Боомтын хуулийг богино хугацаанд буюу энэ намрын чуулганд багтааж гаргахаар хүсэлтийг тавьсан байгаа. Энэ дээр та дэмжиж ажиллана гэсэнд талархал илэрхийлье. Та бүхэнд хуулийн төслийн баримт бичгийг хүргүүлье.

Д.Амарбаясгалан: - Бөхчулууны Пүрэвдорж гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Б.Пүрэвдорж: - Төр, засгийн удирдлагууд 2 орны хөршийн удирдлагуудтай яриад байдаг. Гэтэл Монголчуудын ачаан дээр шимэгчилж амьдардаг доогуур нь Өвөр Монголчуудаар толгойлуулсан Эрээний мафийнхан, Баяннуурын мафийнхан байдаг.

Харин Шинжань Уйгур луу гарч байгаа баруун аймагт хяналт шалгалт нь чангараад явчихдаг. Тийм учраас нэвтрэлтийг чөлөөтэй, олон газраар, илүү сайн явуулдаг болгох, өрсөлдөх чадварыг бий болгож байж боомтын нэвтрэлт сайжирч, улмаар боомтын бараа бүтээгдэхүүний үнэ бууна, хүнд суртал нь багасана. Энэ ажил дээр голлож та нар онцгойлж ажиллаарай. Тэгээд энэ асуудал дээр Зам тээврийн сайд Б.Дэлгэрсайхан сайд ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: - Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: - Манай улс дэлхийн зах зээлээс, далай тэнгисээс хол, газраар, төмөр замаар асар их зайнаас харилцдаг, худалдааны хувьд таатай биш нөхцөлтэй. Энэ нь манай улсын худалдааг хөнгөвчлөх, хурдавчлах тал дээр

биднээс өөр бодлого баримтлах нөхцөлийг шаарддаг. Өнгөрсөн цаг хугацаанд боомт дээр тодорхой хэмжээний ач холбогдол өгч байгааг үгүйсгэх боломжгүй.

Ажлын үр дүн гарахын тулд дэд бүтцийн ажил, цемент арматурын ажлаас гадна зөөлөн дэд бүтцийн гэдэг технологи, менежментийн бодлого, шийдвэрийн олон ажлуудын хамт дундын үр дүнгээс ажлын үр дүн гардгийг бүгдээрээ л мэдэж байгаа.

Өнгөрсөн цаг хугацаанд төр, засгаас явуулж байгаа бодлого дээр дандаа мөнгө төгрөг, хүн хүч нэмчихнэ, тэгээд цемент, арматур цутгачихаар болчихдог юм шиг ажилд ханддаг. Харин менежмент технологи гэдэг зүйлд анхаарал хандуулдаггүй учраас хэрэгжүүлсэн төслүүд ямар үр дүнтэй явж байгааг бид харж байна. 200 км замыг бараг 10 жил барьж байна. Нэг л цемент, арматуртай байхаар ажил болчихдог гэдэг сэтгэхүйтэй байдаг.

Ер нь хүн төрөлхтний шинжлэх ухааны онолд хөдөлмөр, капитал, технологи гэдэг 3 зүйл хөгжил дэвшлийг авчирдаг гэдэг. Гэхдээ үүнийг бид орчуулахдаа хүний тоо нэмээд, мөнгө нэмээд байхаар болчихдог гэж, үндсэндээ сайд нарын багцын төсвийг нэмээд байхаар болчихдог гэдэг хандлагатай.

Тэгэхээр Б.Тулга сайдаас асуух гээд байгаа зүйл яг үүнтэй холбоотой. Боомтын сэргэлт гэдэг бодит ажил цемент, арматураасаа гадна хууль, эрх зүйн хувьд ямар шинэчлэлийг өнгөрсөн хугацаанд хийгдсэн бэ? Хууль, эрх зүйн талаасаа бараг орж ирээгүйг би мэдэж байна. Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр юу хийгдсэн юм бэ? Гадаад худалдааны бодлого шийдвэр, хууль, дүрэм журам нь хаачихсан юм бэ? Боомтын сэргэлтийн хүрээнд 2, 3 хуулийн нэр явж байна. Тээврийн нэгдсэн хууль, Боомтын тухай хуулиудыг өргөн барина гээд бараг 3 жилийн өмнө ярьж байсан. Тэр хуулиуд нь хаачихсан юм бэ? Технологи, менежментийг агуулсан бодлогын шийдвэрүүд буюу зөөлөн бодлогын шийдлүүд хаачсан юм бэ?

Нэг л мөнгө төгрөг, хүн хүч ярьсан технологитой, нэг ийм арга барилтай болчихлоо. Тэгээд нэг гоё мега төсөл гэж нэрлэхээд, цаг хугацааны хувьд төсөвт өртгүүд нь хэд дахин нэмэгдчихсэн, сунжирсан байдалтай болчихлоо.

Тэгэхээр тэр зөөлөн дэд бүтэц, технологи, менежмент, бодлогын хувьд ер нь ямар ажил өнгөрсөн хугацаанд хийгдээд, цаашид юуг төлөвлөж байгаа вэ, ямар үр дүн хүлээж байгаа талаар мэдээлэл өгөөч?

Д.Амарбаясгалан: - Буяагийн Тулга сайд хариулъя.

Б.Тулга: - О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Хатуу дэд бүтцийг зайлшгүй ярихгүй бол болохгүй. Манайх сүүлийн 30 жилийн хугацаанд Замын-Үүд, Сүхбаатар, Алтанбулаг боомтоос бусад боомтууд нэлээн хоцрогдсон. Сүүлийн үед Гашуунсухайт боомт сүүлийн 10-аад жил нэлээн ачаалалтай болж эхэлж байгаа. Тийм учраас боомтуудын анхан шатны шалган нэвтрүүлэх цогцолборуудыг олон улсын жишигт нийцүүлэх ажил зайлшгүй хийгдэх шаардлагатай байгаа.

Мөн боомтуудыг холбосон авто зам болон төмөр замын бүтээн байгуулалтыг зайлшгүй хийх шаардлагатай. Тиймээс боомтуудад хөрөнгө оруулалт хийх буюу хатуу дэд бүтцээ бий болгох тал дээр ажиллахаас өөр арга байхгүй байна.

Таны хэлж байгаа менежментийн хувьд буюу зөөлөн дэд бүтцийн хувьд хийгдсэн ажлуудын талаар асууж байна. Би тантай 100 хувь санал нэг байна. Сүүлийн 30 жилийн хугацаанд боомтын хяналт шалгалтын цэг буюу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулдаг газар гэдэг ойлголт байгаад байгаа. Тэгэхээр үүнийг засах, сэтгэлгээний хувьд өөрчлөлт оруулах шаардлага байна. Бид нэлээн судалгаа хийж үзсэн. Дэлхий дээр амжилттай явж байгаа боомтуудын загварыг аваад үзэх юм бол төр, хувийн хэвшил хамтарсан, нэг бол цэвэр хувийн хэвшлийн менежменттэй боомтуудын загвар нь илүү амжилттай, богино хугацаанд төлөвлөлт, хөрөнгө оруулалт, үйл ажиллагаагаа явуулдаг загварууд байна.

Тийм учраас таны дурдаж байгаа Боомтын тухай хуулийг шинэчилж оруулж ирэх үндсэн нэг агуулга, зорилт бол манай боомтуудын удирдлагыг корпораци хэлбэрээр, энэ корпораци нь төрийн хяналттай, хувийн хэвшлийн төлөөлөл удирдаж явдаг хэлбэрт шилжүүлэх бодлогын хуулийн төслийг Улсын Их Хуралд оруулахаар бэлдэж байна. Монгол Улсын шинэ нисэх буудал манай улсын агаарын хамгийн том буюу ганц ажиллаж байгаа боомт нь байгаа. Энэ боомтын өдөр тутмын үйл ажиллагаа, боомтын өргөтгөл шинэчлэлтийн ажил, төлөвлөлтийн ажлыг Японы компани хариуцаад явж байгаа.

Агаарын боомт дээр хэрэгжсэн сайн туршлагыг бусад боомтууд дээр хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнээс гадна боомтуудаар нэвтэрч байгаа худалдааг дэмжиж, хурдан шуурхай болох үүднээс технологийн дэвшлүүдийг нэвтрүүлж байна. Одоогийн байдлаар Гашуунсухайт боомт, Шивээхүрэн боомт дээр жолоочгүй авто тээврийн буюу Эй Жи Ви-ийн терминалыг бүрэн ашиглалтад оруулсан байгаа. Энэ жилийн хувьд нийт тээвэрлэж байгаа нүүрснээс 3 сая тонныг дангаараа Эй Жи Ви-ээр тээвэрлэж байгаа.

Тэгэхээр үүнийг 24 цагийн ажиллагаатай болгохоор Хятадын талтай хэлэлцээрт орж ажиллаж байгаа гэдгийг Та бүхэнд хэлье. Мөн худалдааг дэмжих үүднээс боомтуудыг рентген аппаратаар бүрэн тоноглохоор ажиллаж байгаа. Ачаалал ихтэй байгаа боомтууд дээр рентген аппаратыг суурилуулж, хяналт шалгалтын хугацааг богиносгох арга хэмжээнүүдийг авч байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: - О.Цогтгэрэл гишүүнд нэмж 1 минут, өгье.

О.Цогтгэрэл: - Боомттой холбоотой зүйл дээр заавал хэлмээр нэг зүйл байна. Ер нь энэ Засгийн газрын 14 мега төслийн хамгийн эхэнд нь Гашуунсухайт Ганц модын хил холболтын цэгийг холбоно. Энэ өөрөө Монгол Улсын 14 мега төслийн хамгийн том нь гэж байгаа. Магадгүй эдийн засгийн тоон дүн байж магадгүй. Гэтэл 15 жилийн өмнө хувийн хэвшлийн компани энэ төслийг бариад, замаа тавиад холболтоо хийчихнэ гэж байсан. Харин 15 жилийн дараа буюу өнөөдөр зөвхөн түүнийг холбох хэсэг нь Монгол Улсын мега төсөл болсон.

Тэгэхээр Монгол Улс урагшлаад байгаа юм уу, ухраад байгаа юм уу? Үүнийг тайлбарлахдаа мега учраас, том төсөл учраас үүнийг төр л хийхгүй бол өөр хэн ч хийж чадахгүй гэдэг суртал ухуулгатай. Гэтэл үүнийг чинь 15 жилийн өмнө зураг төсөл, санхүүжилт зэрэг олон зүйл нь шийдэгдээд явж байсныг төр булааж аваад л, өнөөдөр 15 жилийн дараа мега төсөлд хамрагдаж байгаа бөгөөд номер нэг мега төслийг төр хийх ёстой гэдэг нэг ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: - Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууж үг хэлнэ.

Ж.Баярмаа: - Мэдээж, эдийн засагт олон улсын худалдаа, дэд бүтэц маш чухал. Олон улсын худалдааг хөгжүүлэх, ялангуяа хил орчмын худалдааг хөгжүүлэхэд боомтын асуудал маш чухал. Тэгэхээр бодитоор манай эдийн засагт маш том чухал хүчин зүйлс болдог.

Тэгээд энэ дээр “Шинэ сэргэлтийн бодлого”-д 6 зорилт тавьсны нэг нь боомтын сэргэлт юм. Энэ зорилтод зөв зүйтэй зүйл тусгасан байна. Гэхдээ боомтын сэргэлт маань яг юу болж байна? Сэргэж байна уу, үгүй юу гэдэг асуулт байнга тавигдаж байгаа. Ялангуяа иргэдийн аж амьдралтай холбоотой. Тяньжин боомт дээр хэдэн мянгаараа чингэлэг гацаж байгаа нөхцөлд нийлүүлэлтээс үүдэх инфляцад нөлөөлж байгаа олон үр дагаврууд байгаа учир боомтын нэвтрүүлэх чадалд онцгой анхаарал хандуулж ажиллах нь чухал юм. Жишээлбэл, Хятадаас 2 чингэлгээр бараа нэвтрүүлдэг байсан бол нэг болгож багасгаад байгаа мэдээллүүд байдаг.

Манайх газар зүйн байршлын хувьд хоёрхон оронтой бол хиллэж байгаа. Тэгэхдээ энэ нь ашиглаж болохуйц хүчин зүйлс мөн. Бодлогын хувьд энэ 2 хөрштэйгөө боомтоо хөгжүүлэх тал дээр ямар ажил хийж байгаа юм бэ?, яаж хөгжүүлэх вэ?, арга хэрэгслээ тохирсон юм болов уу? Яагаад гэвэл тэд нараас бүрэн хамаараад байна шүү дээ. Бид энд хэдэн тэрбум төгрөгийн төсөв тавиад байдаг, гэтэл 2 хөршөөс хамаарч байгаа учир энэ их чухал фактор байдаг. Тэгэхээр 2 хөрштэйгөө энэ бодлогоо, эсвэл тэдний бодлоготой уялдуулсан ч юм уу, нийцүүлсэн үү? Хамтарч арга хэрэгслээ тодорхойлсон зүйл байна уу? Байгаа бол ямар олон улсын гэрээ хэлэлцээрээр баталгаажсан юм бэ?

2-т, боомт бүрээр гарах эдийн засгийн үр ашгийн тооцоолол гэж байгаа. Тэгэхээр гарах зардал, хөрөнгө оруулалт, үр ашгийн тооцоолол гэж байгаа юу? Яагаад гэвэл бүх юманд үр ашиг байх ёстой, эдийн засгийн тооцоолол байх ёстой. Энэ тооцоолол нь хийгдсэн эсэх, хэрхэн үр ашгийг нь тооцоолсон бэ? гэсэн ийм 2 асуулт байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: - Буяагийн Тулга сайд хариулъя. Дараа нь Борхүүгийн Дэлгэрсайхан сайд нэмж хариулна.

Б.Тулга: - Ж.Баярмаа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр боомтын асуудал бол олон улсын худалдааны асуудал гэдэгтэй 100 хувь санал нэг байна. Тэгээд олон улсын худалдааны асуудал учраас 2 талаас харилцан тохиролцож, зэрэг төлөвлөж, стратегия тааруулж байж, хэн юу худалдаж авах вэ гэдгээ

шийдэж байж боомтын хөгжлийг цааш нь ярих ёстой гэдэгтэй 100 хувь санал нэг байна.

Тяньжин боомт дээр гарч байгаа ачаалал энэ жилийн хувьд хамгийн их байсан. Энэ нь хэд хэдэн шалтгаантай юм. Монгол Улсын боомт дээр байгаа ачаалал буюу Замын-Үүд дээр татаж байгаа чингэлэг, түүн дээр нэвтрүүлж байгаа хүчин чадлын хувьд ачаалал харьцангуй бага байсан. Энэ зун Замын-Үүд дээр үүсдэг байсан ачаалал ер нь байхгүй болсон гэж хэлж болно.

Харин 10 дугаар сарын 30-наас хойш ачаалал бага зэрэг нэмэгдсэн байгаа. Нөгөө 24 цаг ажиллагаа түр зогссонтой холбоотой ачаалал үүссэн. Тяньжин дээрх чингэлгийн тоо энэ жил эрс өссөн. Энэ нь Япон улсад ханшийн уналт болж, бараа бүтээгдэхүүн хямдарсантай холбоотойгоор Монголын иргэд, худалдаачид ихээхэн хэмжээний автомашиныг өмнөх жилүүдээс илүү оруулж ирсэн ажиглагдсан. Эргээд Монгол руу орж ирээд Монгол талдаа буюу Улаанбаатарт, Сайншандад болон бусад суурин газрууд, төвүүд дээр галт тэргээр орж ирсэн чингэлэг тээврийг шингээн авч, түүнийг боловсруулаад, яаралтай чингэлгээ суллаад, вагоноор буцаах үйл ажиллагаа дутагдалтай байсан. Улаанбаатарын хувьд нэг галт тэрэг бүтэн оруулж ирээд боловсруулалт хийгээд, буцааж өдөрт нь буцаах чадалтай логистикийн төвүүд байхгүй байгаа.

Тийм ч учраас олон улсын эдийн засгийн хамтын байгууллага дээр хуурай боомтоор зөвхөн Сайншанд Замын-Үүдийг бүртгүүлэхээс гадна Улаанбаатарт дор хаяж 2-3 логистикийн төвүүд, хуурай боомтуудыг байгуулж байж, энэ чингэлгийн ачаалал хурдан хугацаанд буурах бололцоо үүснэ. Энэ жилийн хувьд дунджаар 2 галт тэрэг өдөрт татдаг байсан тоо харин энэ 4 дүгээр сараас хойш нэлээн бууж, одоогийн байдлаар 2 луугаа дөхөж байгаа. 1 дүгээр сард 2,4 цуваа буюу 2,4 галт тэрэг татдаг байсан. Энэ маань 4 дүгээр сараас эхлээд 1,6 руу унасан бол 6 дугаар сард 1,1 болж унасан, одоо өсөөд 9 дүгээр сарын байдлаар 1,6, 10 дугаар сард 1,6 галт тэрэг буюу 50 вагон татаж байна гэсэн үг. Тэгэхээр чингэлгийн ачаалал буураад явна. 10 дугаар сарын 18-ны байдлаар 4000 орчим чингэлэг байна. Энэ нь хэвийн хэмжээнд байж байдаг, 2-3 мянгаас нэг мянга орчим чингэлгээр илүү байгаа юм. Тэгэхээр цаашид буураад явна гэдэгт эргэлзэхгүй байна.

Хоёр хөршийн боомтын захиргаатай Монгол Улсаас Боомтын Үндэсний хороог сайдтай болгосны дараагаас нэлээн идэвхтэй хамтын ажиллагааг өрнүүлж байгаа. Жил болгон 2 улсын боомтын менежментийн комиссын хурал болдог. 2023 оны 9 дүгээр сард БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод Хятадын боомтын үндэсний захиргааны удирдлагуудтай миний бие очиж комиссын хуралдааныг хийсэн. Уг хуралдаанаар 40 асуудлыг шийдвэрлэхээр харилцан тохиролцож, протоколоор тохирсон. Одоогийн байдлаар энэ 40 асуудлаас 36 асуудалд нь үр дүн гарсан, хэрэгжилтийг бүрэн хангаж байгаа.

2024 оны хурлын товыг Хятадын талаас өгөөгүй байгаад байна. Хятадын талын боомтын удирдлагад өөрчлөлт орж байгаа гэдэг мэдээлэл бидэнд байгаа. Тэгээд удирдлага нь шинэчлэгдэхээр энэ ондоо багтаад хийх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа гэдгийг Та бүхэнд хэлье.

Зөвхөн Бээжинтэй ингэж харьцахаас гадна бид ӨМӨЗО-той, Шинжаан Уйгарын ӨЗО-той шууд харилцах механизмыг бий болгож өгсөн. Сая өнгөрсөн 8 дугаар сард ӨМӨЗО-ны боомтын зөвлөлтэй манай хилийн боомтын захиргаа хамтарсан хурлыг Өвөр Монголын Хянган аймагт очиж хуралдаад тодорхой асуудлуудыг тохирч ирсэн.

Саяын Ерөнхий сайдын мэдээлэлд гарч байгаа цагийн хуваарийн өөрчлөлтүүд, боомтын 2 талаас уулзах төмөр замын цэгүүд, мөн боомтоор нэвтрэх ачаа бараа, тээвэр логистикийн төвүүдийг уялдуулах тал дээр механизмуудаар дамжиж хэрэгжүүлдэг байгаа. Манай Гадаад харилцааны яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Зам, тээврийн яам гээд бүтэн төлөөлөл энэ комисст орж ажилладаг гэдгийг та бүхэнд дуулгая.

Бид боомтын цогцолборын барилгыг барьж байгуулж дуусаж байгаа. Цаашлаад энэ нутгийн иргэдэд өгөөжтэй, хүртээмжтэй байх, тухайн боомт хот, боомт, сумыг төлөвлөлтөд оруулах ерөнхий мастер төлөвлөлтүүдийг хийж байгаа. Одоогийн байдлаар Гашуунсухайт, Шивээ хүрэн боомтын мастер төлөвлөгөө хийх тендерийг зарлаад, компаниуд нь шалгараад явж байгаа. Энэ төлөвлө ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: - Борхүүгийн Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: - Ж.Баярмаа гишүүний асуултад нэмж хариулъя. Энэ Зам тээврийн яамнаас чингэлэг хуримтлагдаж байгаатай холбогдуулаад Хятадын тээврийн сайдтай өнгөрсөн сард уулзалт хийсэн. Энэ асуудлыг сайжруулаад одоогийн байдлаар Тяньжин боомт дээр 316 чингэлэг байна. Өмнөх 8 сард 5000 гаруй чингэлэг байсныг 1,7 галт тэрэг болгосноор 2000 гаруй чингэлгийг татсан. Нийт чингэлгийн 70 хувьд нь дандаа автомашин байгаа. Бид автомашины чингэлгийг хурдан буцаахын тулд хот руу оруулж ирэхгүйгээр, Замын-Үүд дээр шууд буулгах, тэнд нь гаалийн бүрдүүлэлт хийх шийдвэр гаргаад, машинуудыг Замын-Үүд дээр ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: - Гүйцээж хариулъя. Б.Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: - Эзэнд нь хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулснаар чингэлгийг хурдан буцаах боломжтой болж байгаа. Нэн тэргүүнд урд хөрштэйгөө ярьж байгаа зүйл бол үлдсэн 30 хувь нь дандаа хүнсний бүтээгдэхүүн болон бусад ачаа бараа байгаа учраас үүнийг хурдан түргэн оруулж ирэх дээр бид хоорондоо ярилцаж байгаа.

2 дахь далайн боомтын асуудлаар Зам тээврийн яамны Далайн боомтын захиргааны удирдлагуудыг явуулж, Леонон мужийн Жинжүү боомтыг нэмэлтээр ашиглахаар ярилцаад, ингээд эхний хэлэлцээр хийгээд явж байгаа гэдгийг нэмэлтээр хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: - Ринчиндоржийн Батболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Р.Батболд: - Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе. Энэ боомт нэвтрүүлэлтийн талаар ярьж байгаа учраас нэг ганц зүйл асуучихмаар байна. Бид нүүрсээ төмөр замаар тээвэрлээд, тэрийгээ БНХАУ-ын төмөр замтай холбож чадахгүй хил дээр гацчихсан байдаг. Тэгэхээр Эрдэнэс Тавантолгой нүүрсээ ачих, түүнийг төмөр замаар тээвэрлэх, цааш нь нэвтрүүлэх асуудлыг Эрдэнэс Тавантолгой, Зам, тээврийн яам, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны яг хэн нь хариуцаж ажиллаад байдаг юм бэ гэдэг 1 дэх асуулт байна. Та нар хоорондоо учраа олохгүй яваад байдаг юм уу? Эрдэнэс Тавантолгойгоос ачигдаж очсон вагонтой нүүрс хил дээр очоод 40 хоносон гэж байгаа. Яагаад гэвэл зөвшөөрлөө авч чаддаггүй гэдэг. 2 дугаарт, нөгөө ачигдаад 4 цаг яваад очиж байгаа нүүрс автомашинд сэлгэн ачигдаад, тэгээд цаашаа гарах гэхээр Тавантолгойгоос шууд очиж байгаа автомашинуудын араас нь очерлоод гарах гэсэн асуудал үүсчихдэг. Тэгэхээр, хэн нь хариуцаад байгаа юм бэ?, хариуцаж байгаа хүн нь шинэ терминал үүсгээд, вагоноор очиж байгаа ачаагаа шууд гардаг шинэ терминал үүсгэж болдоггүй юм уу? Үүнийгээ шийдээч гэдэг асуудал байгаа юм.

3 дугаарт, вагоноор очсон ачааг цааш нь гаргаж байгаа тээврийн үнэ тарифын асуудал ёстой замбараагүй үнэтэй юм байна лээ. Нэг цуваа вагоныг цааш нь гаргаад, гаргасан тэр компани нь 195 сая төгрөгийн нэхэмжлэх өгч байна гэж яриад байгаа. Энэ арай дэндэж байгаа юм биш үү? Уул нь арваадхан километр газар юм шиг байна лээ. Тэгэхээр энэ асуудлыг ер нь яаж шийдэх юм бэ? Яг хэн нь мэдээд байгаа юм? Энэ дээр хариулт өгөөч. Ерөөсөө гурван бие рүүгээ шидээд зөвшөөрөл нь байхгүй 40 хоночихдог асуудлыг яаж шийдэх юм бэ?

Д.Амарбаясгалан: - Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулъя.

Б.Дэлгэрсайхан: - Р.Батболд гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт, ер нь Эрдэнэс Тавантолгойн хувьд нүүрсээ экспортлох нь гол үүрэг. Дээрээс нь Тавантолгой төмөр зам барьсан, түүнийг ачиж буулгах терминал барьсантай холбогдуулан бид нар үр ашигтай явуулах үүднээс төмөр замаар тээвэрлэлт хийж байгаа. Харамсалтай нь төмөр замаар хийж байгаа тээвэрлэлт маань шууд холболт хийгдээгүй учраас, ахиад машинаар дамжиж, цаашаа хил гарч байгаа гэдгийг хэлье.

2 дугаарт, таны сая хэлсэн шиг 195 сая төгрөг болж байгаа юм бол байхгүй. Ковидын үед ийм үнэд хүрч байсан гэж яригддаг. Одоо бол машины үнэ, тээвэр нэмэгдсэн юм байхгүй. Харин ковидын үед С зөвшөөрөл Эрдэнэс Тавантолгойд шилжсэнтэй холбогдуулан ийм хүндрэл эргээд гарч байгаа учраас Хятадын тал С зөвшөөрлийг Монгол Улсын төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ хэлэлцээр хийсэн. Тиймээс хэрвээ компани С зөвшөөрлөө цаашдаа олгоод явбал 2025 онд дахиж гэрээ хийхгүй гэж мэдэгдэл ирүүлсэнтэй холбогдуулаад, ирэх 7 хоногийн Засгийн газрын хуралдаанаар энэ асуудлыг шийдвэрлэхээр бэлдэж байгаа гэдгийг албан ёсоор хэлье.

Цаашдаа аль болохоор төмөр замаа хурдан холбох, энэ чиглэлээр сая Монгол Улсын Ерөнхий сайд болон миний бие Хятадын талын төмөр замын

холболтыг хариуцаж байгаа “Чайна Энержи” компанитай уулзаж, энэ асуудал нэлээн урагшилсан. Ямар ч байсан энэ эрчээрээ явж, гэрээ хэлэлцээр эцэслэж, ажлын хэсэг 2 талаасаа тохирсон ёсоороо ирэх хавар бүтээн байгуулалтын ажлаа эхэлнэ гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: - Буяагийн Тулга сайд нэмж хариулъя.

Б.Тулга: - Р.Батболд гишүүний асуултад хариулъя. Тавантолгой төмөр замын шилжүүлэн ачих терминал 2024 оны 8 дугаар сард ашиглалтад орсон. Цаашаагаа Хятадын талтайгаа холбогдоогүй төмөр зам байгаа учраас төмөр зам дээр дахин шилжүүлж ачаад, цаашаа гарахад зардлын хувьд яалт ч үгүй өндөр байгаад байгаа.

Тийм учраас энэ асуудал бол шинээр гарч ирж байгаа юм. Бид нар мөрдөгдөж байгаа түр журмыг цаашдаа шинэчлэхдээ нэгэнт баригдсан байгаа төмөр замыг дэмжих чиглэлийн бодлогыг оруулж тооцож явна гэдгээ хэлчихье. Энэ асуудал 2024 оны 8 дугаар сард төмөр зам ашиглалтад орсонтой холбоотойгоор төмөр замаар тээвэрлэж байгаа аж ахуйн нэгж, компаниудаас гарч байгаа хүсэлтүүд байгаа. Үүнийг шийдэх ёстой. Эцсийн дүндээ энэ асуудал бүрэн хэзээ шийдэгдэх вэ гэвэл яригдаж байгаа төмөр замын холболт бүрэн хийгдчих юм бол заавал ч үгүй дахиж шилжүүлэн ачилгүйгээр, цаашаа явах бололцоо бүрдэх юм.

Д.Амарбаясгалан: - Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Г.Ганбаатар: - Нэг нь мэдээлэл хийсэн болж, нөгөө нь сонссон болоод энэ мэдээлэл хариуцлагагүй л байна. Улсын Их Хурлын дарга цаашдаа энэ тал дээрээ анхаарах хэрэгтэй. Засгийн газар ч гэсэн ажлаа төлөвлөөд Улсын Их Хуралдаа хүндэтгэлтэй хандах хэрэгтэй.

Миний асуулт бол Монгол Улсын Ерөнхий сайдаас өөрөөс нь асуух асуулт байсан юм. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Өмнөговь аймгийн ард иргэдтэй уулзахдаа Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутагт Цагаандэл-Уулын боомтоор шинэ боомт нээх үйл ажиллагааг түдгэлзүүлсэн гэж олны өмнө хэлсэн байдаг юм. Тэр бичлэг, зураг бүгд байгаа. Гэтэл одоо боомтын үйл ажиллагаа нь явагдсаар бараг дуусаж байгаа бололтой. Энэ талаар би 10 дугаар сарын 01-нд Ерөнхий сайдад нэг асуулт тавиад хариултаа авсан юм.

Уг нь өнөөдрийн мэдээллийн цаг дээр өөрөөс нь асууя гэсэн, байхгүй байна. Аль 2022 оны асуудлыг Л.Гантөмөр даргаас асуулттай биш. Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын тэргүүн хүн худлаа яриад байж болохгүй л дээ. Өмнөговь аймгийн иргэдэд худлаа ярьсан. Одоо тэгээд боомт нь бараг ашиглалтад орж байна. Хэрэв үнэхээр боломжгүй байгаа бол уучлалтаа хүсээд боомтын талаар ямар үйл ажиллагаа, ямар бодлого явуулж байгаагаа олон нийтэд хэлэх хэрэгтэй. Өнгөрсөн жил энэ боомттой холбоотойгоор Засгийн газраас ажил хийж чадаагүй. Дутуу юм билээ. Нэг нь Гашуунсухайтын төмөр

замыг холбох, нөгөө нь Цагаандэл-Уулын боомтыг ашиглалтад оруулах асуудал. Б.Тулга сайд нь байна уу, үүнтэй холбоотой Өмнөговь аймгийн ард иргэдэд Ерөнхий сайдын түдгэлзүүлсэн нь худлаа шүү, боомт бараг дуусаж байгаа зэрэг асуудлаар бодитой мэдээлэл өгөх хэрэгтэй.

Нэгэнт боомт нь ашиглалтад ороод дуусаж байгаа бол төр нь ажил төрлөө бодсон нь дээр шүү дээ. Тэгээд Б.Тулга сайд энэ талаарх мэдээллээ энэ мэдээллийнх нь цаг дээр өгчихсөн нь зөв байх.

Д.Амарбаясгалан: - Буяагийн Тулга сайд хариулт өгье.

Б.Тулга: - Г.Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутагт байх Цагаандэл-Уул боомтын асуудал шинэ хэрэгжсэн асуудал биш юм билээ. 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын тогтоолоор энэ боомтыг нээх шийдвэр гарч, Монгол Улсын өндөр дээд түвшний БНХАУ-тай хийсэн уулзалтууд дээр ярьж баталгаажууд 2 талаас тохирсон асуудал юм байна лээ. Энэ боомт ч ялгаагүй. Нөгөө Гашуунсухайт дээр тохирсноосоо Монголын тал ямар нэгэн байдлаар буцах нөхцөл байдлыг үүсгэж болохгүй байгаа.

Монголын Улсын Засгийн газар үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байх ёстой. Тийм учраас 2014 онд, 2018 онд, 2019 онд, 2024 онд Засгийн газрын олон тогтоол шийдвэрүүд гарсан байдаг. Энэ хүрээнд Цагаандэл-Уул боомтыг үйл ажиллагаанд оруулахад байгаль орчинд ээлтэй байх, Гашуунсухайт дээр гарсан алдааг давтахгүйн тулд авто замыг нь түрүүлж барьсны дараа боомтыг ажиллуулах шийдвэрүүдийг гаргасан байдаг. Энэ утгаараа авто замыг барих концессыг 2019 онд зарлаж аж ахуйн нэгж нь шалгараад, үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бэлэн болчихсон байгаа. Ерөнхий сайд 2022 онд хийсэн уулзалт дээр байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл байгаа учраас энэ асуудлыг анхаарч үзээч гэсэн хүсэлтийг нутгийн иргэдээс тавьсан байдаг. Улмаар нутгийн иргэдтэй уулзах, байгаль орчинд нөлөөлөх байдлыг хамгийн багаар байлгах шаардлагуудыг хангахаар боомт руу зам тавьж байгаа аж ахуйн нэгжид үүрэг болгож өгсөн байдаг. Энэ асуудлыг говиос сонгогдсон бүх гишүүд, говийн сумдын төлөөллийг оруулаад хэлэлцэх үүрэг чиглэл өгсөн байгаа.

Тэгээд нарийвчилсан үнэлгээ, бусад зураг төсөл эцэслэн гарахыг бид хүлээж байгаа. Удахгүй Өмнөговийн зөвлөлийг хуралдуулж, энэ асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ. Ер нь бол Монгол Улс (түрүүн Ж.Баярмаа гишүүний үгэнд гарлаа) хөрштэйгөө, түнштэйгээ ярьсан яриа хэлэлцээрээ хэрэгжүүлэх тал дээр байхгүй бол “за” гэж нэг өдөр тохирчихоод хэсэг хугацааны дараа энэ боломжгүй гэх юм бол Гашуунсухайтын алдаа давтагдана гэдгийг та бүхэнд хэлье.

Боомтын бүтээн байгуулалтын талаар мэдээлэл өгөхөд, боомтын бүтээн байгуулалт эхлээгүй, зураг төсөл батлагдаад, байгаль орчны үнэлгээ хийгдээд дууссан байгаа. Боомтын бүтээн байгуулалтыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Цагаандэл-Уул боомтын барилгын ажлыг эхлүүлэх, шийдвэрийг Өмнөговийн зөвлөлөөс гаргаад, цааш нь явуулах нь зүйтэй байх гэдэг зүйлийг хэлье. Ер нь Монгол Улс Эрдэнэс-Тавантолгойн уурхайд түшиглэсэн уул уурхайн бүтээгдэхүүнээ үнэ цэнтэй байлгах тал дээр бодолцох ёстой. Одоогийн байдлаар Эрдэнэс Тавантолгойн нүүрсийг зөвхөн Өвөр Монголын Баяннуур аймгаар дамжуулж БНХАУ-ын зах зээлд бусад мужууд руу хүргэж байгаа.

Цагаандэл-Уулын боомт нь Рашаан аймагтай хиллэдэг боомт байгаа. Бид өөрийнхөө үйлдвэрлэж чадаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүнийг илүү үнэ цэнтэй болгох, биржээр арилжаалахад 2 өөр аймгаас өөр аж ахуйн нэгжүүд орж ирж, манай бүтээгдэхүүнийг худалдаж авч өрсөлдөх чадвартай болох гэдэг үүднээсээ Цагаандэл-Уулын боомт нь онцгой ач холбогдолтой байгаа. Өөрөөр хэлбэл аль нэг аймгийн худалдан авагчаас хамааралтай байдаг. Энэ хамаарлыг байхгүй болгоход маш чухал үүрэгтэй боомт бол Цагаандэл-Уул боомт, Ханги боомт байгаа гэдгийг хэлмээр байна.

Танд асуулгын хариултыг хүргүүлсэн. Шаардлагатай бол бусад мэдээллийг Танд нарийвчлан өгөхөд бэлэн байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: - Батын Батбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Батбаатар: - Боомтын нэвтрэлт бол мэдээж тээвэрлэлт болон зорчигч тээвэр гээд 2 зүйл байж байна. Энэ томоохон корпорацууд болон гаднын хөрөнгө оруулагчдын хажуугаар жижиг, дунд үйлдвэр, мөн арилжаа наймааны шугамаар явж байгаа хүмүүс, тэдгээрийн нэвтрэх боломжийг хязгаарласан харагддаг юм байна. Бөөн уур бухимдал. Тэр чиглэл рүүгээ манай гол гол боомтууд хэр ажиллаж байгаа юм бэ? Ачаа тээвэр бол мэдээж төмөр зам болон машин авто хэрэгслээр явж байна. Иргэдийгээ чөлөөтэй, хурдтай, тогтвортой, их хөнгөн шуурхай нэвтрэх тал дээр юу хийж байна вэ? Үүнийг иргэд илүү их сонирхож асуух байх. Маш олон өрх гэр, айл үр хүүхдийн амьдрал үүний ард явж байгаа.

2-т нь, Засгийн газар боомтыг сайжруулах ажлын үр нөлөөгөө цаг хугацааны явцад хэрхэн хянаж байгаа. Боомтын сэргэлт, сэргээн босгох ажил нь худалдаа эдийн засгийнхаа хөгжлийн зорилтод нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахдаа ямар хэмжүүрийг ашиглаж, уг хэмжүүрээр хэмжихэд хэр нийцэж байна, нийцэхгүй байна гэдэг тухай ярьж байгаа зүйлийг асуумаар байна.

3-д нь, Засгийн газар боомтуудынхаа сэргээн засварлах төслүүд, санхүүжилтүүдээ ямар чиглэлээр хийж байгаа юм. Ялангуяа чөлөөт бүсүүд гэж байж байгаа. Чөлөөт бүсүүдийн идэвхтэй, зөв үйл ажиллагаа нь олон нэвтрэх, олон боомтын асуудлуудыг шийддэг, иргэдэд ээлтэй, иргэдийн амьдралд сайнаар тусгах боломжууд байж байгаа. Сүүлийн 10 хэдэн жил үндсэндээ чөлөөт бүсийн асуудал яригдсан. Манайд Алтанбулаг, Замын-Үүдийн чөлөөт бүсүүдийн асуудлууд бол олигтой үр дүнд хүрээгүй шүү дээ.

4-т нь, дэд бүтцийн дагуу буюу төмөр зам, авто зам дагууд, хил гаалийн шалган нэвтрүүлэхүүдийг нь өгчих юм бол зөвхөн Замын-Үүдэд ачаа чингэлэг

задардаг, үгүй бол Улаанбаатарт задардаг биш, зам дагуу байгаа өртөө, суурин газрууд аль нэг дээр нь, хэд хэдэн терминалуудыг хийчих юм бол ачаа тээврийн хурд болон нэвтрэлтийн чадвар нь өөрчлөгдөнө. Энэ тухай ямар нэг санаачилга байна уу?

Тяньжинд түрээсэлж авсан газар 10 гаран жил гацлаа. Тэр яагаад ашиглагдахгүй байгаа юм? Тэр ашиглагдвал Тяньжин дээр олон ачаа тээвэр гацахгүйгээр Хятадад авто замаар болон бусад замаар хурдан шуурхай тээвэрлэх бол ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: - Буяагийн Тулга сайд хариулт өгье.

Б.Тулга: - Б.Батбаатар гишүүний асуултад хариулья. Тэгэхээр ачаа тээврийн терминалаас гадна жирийн иргэдийн зорчих хөдөлгөөн дээр анхаарал хандуулж байгаа юу гэж асууж байна. Тэгэхээр Замын-Үүд боомт ашиглалтад орсноор зорчигч тээврийн хүч хүчин чадал 6-4 дахин нэмэгдсэн. Одоо та бүхэн анзаарах юм бол манай гол зорчигч тээвэр явдаг Замын-Үүд боомт бол зорчигч тээврийн терминал нь тусдаа, ачаа тээврийн терминал нь тусдаа байгаа. Очоод үзэх юм бол өнөөдөр Монголын тал буюу Замын-Үүд талдаа зорчигч тээвэр дээр ямар нэгэн хүндрэл байхгүй байгаа.

Эрээний тал дээрээ бол хүндрэлүүд гарч байгаа. Яагаад гэвэл Эрээний боомтын хүчин чадлаас хамаараад зарим тохиолдолд Эрээний боомт руу орох хилийн дундын зурвас дээр ачаалал үүсдэг асуудал бол байгаа.

Дээр нь зорчигч тээврүүд жирийн иргэдэд ялангуяа хамгийн ач холбогдолтой байдаг 8-аас доош суудалтай автомашин нэвтрэх асуудал ковидын дараа нэлээн хаалттай байсан. Үүнийг манай Зам тээврийн яам, Гадаад хэргийн яам, Боомтын сэргэлтийн Үндэсний хороо нэлээн ажилласны үр дүнд ихэнх боомтуудаар 8-аас доош суудалтай, ялангуяа ӨМӨЗО-той хиллэдэг бүх боомтуудаар хэвийн зорчиж байгаа. Энэ нь Замын-Үүдэд амьдардаг гэдэг юм уу, боомт дээр амьдардаг иргэдийн хувьд ач холбогдолтой шийдвэр болсон гэдгийг хэлмээр байна.

Таны хэлж байгаа 2 дахь асуултын дэд бүтэц хөгжсөн газрууд дээр чөлөөт бүсийг байгуулах, тээвэр логистикийн төвүүд байгуулах гэдэг дээр бид тодорхой бодлогуудыг гаргаж байгаа. Сая мэдээлэлд дурдсанаар зөвхөн Замын-Үүд, Алтанбулаг дээр чөлөөт бүсүүдийг байгуулах шийдвэр олон улсдаа зөвшөөрүүлсэн байсан бол хуурай боомтыг байгуулах шийдвэрүүдийг дахиж нэмж 6 газар буюу нийтдээ 8 газар дээр хуурай боомтуудыг бий болгох шийдвэрийг оруулж өгсөн байгаа.

Чөлөөт бүс, хуурай боомт байгуулагдах үндсэн нөхцөл нь эрчим хүч, инженерийн байгууламж, ус татуургын байгууламж, дэд бүтэц байдаг. Энэ байгууламжид байхгүй чөлөөт бүсүүдийг төлөвлөөд зөвхөн хоосон хашаа татсан учраас сүүлийн арваад жил Баян- Өлгийн Цагаан нуур, Алтанбулаг, Замын-Үүд дээр байгаа чөлөөт бүсүүдийн үйл ажиллагаа нь идэвхжиж чадаагүй, үр дүн нь гараагүй зүйл байгаа.

Тэгэхээр үүнийг дахиж давтахгүйн тулд хамгийн түрүүнд дулаантай болгох, эрчим хүчтэй болгох, устай болгох, энэ хүрээнд дотоод дэд бүтцийг шийдэж хувийн хэвшлээ оруулж ажиллуулах төлөвлөлтийг хийж ажиллах нь чухал юм.

Замын-Үүдийн чөлөөт бүс дээр гарсан нэг алдаа нь Эрээний чөлөөт бүстэйгээ уялдуулж төлөвлөлтөө хийх ёстой байсан. Харамсалтай нь үүнийг хийж чадаагүй. Ковидын үе таарсан учраас төрийн байгууллагууд хоорондоо уулзах бололцоо гараагүй гэдэг тайлбар байдаг. Одоо үүнийг засаад Замын-Үүдийн чөлөөт бүсийг Эрээний чөлөөт бүстэй уялдуулаад хооронд нь үйл ажиллагааг нь зохицуулж чадсан төлөвлөлтийг хийгээд, эцэслэн гаргасан байгаа гэдгийг энэ ташрамд хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: - Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.9-д заасны дагуу намын бүлэг тус бүрээс 1 гишүүн төлөөлж Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулсан Ерөнхий сайдын мэдээллийн сэдэвтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн асуултыг Ерөнхий сайд, ажлын хэсгээс асууна.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан асуулт асууна. Алга байна.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга ажлын хэсгээс асуулт асууна.

Б.Уянга: - Энэ өдрийн мэндийг хүргэе. D.parliament.mn цахим системд ирүүлсэн иргэдийн асуултыг асууя. Тэгэхээр нийт 3 иргэнээс 5 асуулт ирсэн байна. Тэгэхээр эдгээр асуултуудыг уншиж байхдаа төрсөн мэдрэмжээ хуваалцвал ер нь боомтууд сэргэж байж Монгол Улсад худалдааны эргэлт өснө, дотоодод бий болох ажлын байр нэмэгдэнэ, аялал жуулчлал дагаад өснө. Ер нь олон салбар цэцэглэнэ.

Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өндөр байгаа, зах зээл сайн байгаа үед боломжийнхоо хэрээр экспортлох юм бол бидэнд ашигтай, хэрэгтэй гэдгийг ойлгож байгаа ийм дүр зурагтай байна.

Тэгээд асуултуудаа танилцуулахад, иргэн Сарантуяагаас дараах асуултууд ирсэн байна. Нэгдүгээр асуулт, “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар, Хөшөөт, Бургастай, Шинэжинст, Шивээ хүрэн, Хотгор шанага, Даянгийн боомт зэрэг чиглэлд зам тавих төлөвлөгөө байгаа юу?

2 дугаар асуулт нь, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг ирэх 4 жилийн дотор 100 сая тоннд хүргэхээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт

тусгасан байна. Гэвч гол экспортын гарцууд ачаалалтай байгаа. Гол шийдэх бодлого нь төмөр замын хил холболтуудад найдаж байгаа хэдий ч өнөөдөр БНХАУ-ын талаас хил холболтын асуудалд нааштай хариу өгөөгүй байна. Тэгвэл авто замын бүтээн байгуулалтын ажлуудыг хэрхэн нэмэгдүүлэх вэ? гэсэн байна.

3 дугаар асуулт, Тавантолгой, Цагаандэл-Уул чиглэлийн хүнд даацын авто замын бүтээн байгуулалтын асуудал яах вэ. Авто зам барих ажил иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч саатсан байгаа.

Иргэн Оюунтуяагаас Гашуунсүхайд, Ганц модны боомтыг төмөр замаар холбох асуудал 10 гаруй жил гацлаа. Энэ талаар хариулт өгнө үү гэсэн байна.

Иргэн Мөнхжаргал, Танд ажлын амжилт хүсье. “Шинэ сэргэлтийн бодлого”-оор яг юу юу шийдэж хэлэлцэх вэ гэсэн агуулга бүхий 5 асуулт байна. Энд холбогдох ажлын хэсгийн гишүүд хариулж өгнө үү.

Д.Амарбаясгалан: - Хариулт өгье. Буяагийн Тулга сайдын микрофоныг нээе. Асуулт, хариултын үргэлжлэх хугацаа 20 минут.

Б.Тулга: - Иргэн Сарантуяагийн асуултад хариулъя. Хөшөөт, Бургастай, Шивээ хүрэн, Хотгор шанага, Даянгийн боомт гэсэн 3 боомт руу авто зам тавигдах уу гэж байх шиг байна.

Тэгэхээр авто зам тавигдах ТЭЗҮ-ийг боловсруулаад байгаа. Ер нь аливаа боомт руу авто зам тавих асуудлыг 2 талын худалдаа, аялал жуулчлал хэрхэн яаж хөгжих бололцоотой байна гэсэн судалгааг үндэслэж хийж байгаа. Үүнийг хийхээс гадна аливаа боомт руу хөрөнгө оруулалт хийж, дэд бүтцийг барихын тулд ТЭЗҮ, зураг дуусах ёстой. Тэгэхээр Шивээ хүрэн, Хөшөөт, Бургастай, Хөшөөтөөс Байтаг боомт руу хувийн хэвшлийн түншлэлтэй хамтраад, ТЭЗҮ, зургийг бол хийж байгаа гэдгийг хэлмээр байна. Даянгийн боомт руу мөн ялгаагүй зураг, төслийг хийгээд дууссан. Одоо Даянгийн боомтыг холбох ажлыг хийж байгаа. Гэхдээ Хотгор шанагатай холбоотойгоор Даянгийн боомт руу уул уурхайн бүтээгдэхүүн явуулахгүй. Яагаад гэвэл Даянгийн боомтын байрлал маань өөрөө Монгол Улсын хамгийн үзэсгэлэнтэй Алтай таван богдын тусгай хамгаалалттай газарт байдаг. Яг энэ дунд байгаа боомт. Тийм учраас цаад талдаа ч гэсэн Шинжаан Уйгарын ӨЗО-ны Алтай аймагт илүү аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлэх зорилготой боомт байгаа гэдгийг хэлье.

Тавантолгой, Цагаандэл-Уулын авто замын ажил явах уу гэж байна. Авто замын ажил явна. Түрүүн дурдсан авто замын ажил явахдаа байгаль орчинд хамгийн бага нөлөөлөлтэй, нөлөөлөл үүсгэхгүйгээр авто замын бүтээн байгуулалтыг хийх ёстой. Ингэж чадвал манай уул уурхайн бүтээгдэхүүн 4 жилийн дотор 100 сая тонн хүрч, худалдаа хийж чадах уу гэдэг энэ асуултад хариулт болох учиртай. Өөрөөр хэлбэл Цагаандэл-Уулын боомт, Цагаандэл-Уулын зам орсноор БНХАУ дотор зөвхөн Баяннуур гэдэг худалдан авагчаас дараачийн Рашаан аймгаар дамжиж, худалдаа хийх худалдааны гарц нээгдэх ёстой. Ингэж чадвал Эрдэнэс Тавантолгойн үндсэн бүтээгдэхүүн

болох нүүрс, эрчим хүчний коксын нүүрсийг 2 өөр худалдан авагчид үнэ хүргэн өрсөлдүүлэх бололцоонууд бий болох юм.

2019 онд түүхэнд анх удаа 35 сая тонн нүүрс, нүүрсний чиглэлийн бүтээгдэхүүнийг БНХАУ-д боловсруулж, борлуулж чадаж байсан. Ингээд ковидын дараа үеэр энэ экспортын хэмжээ буурсан. Ингээд 2023 онд экспортын хэмжээг 60 сая тоннд, энэ онд 69 сая тоннд хүргэсэн бөгөөд энэ оныг дуустал хугацаанд 80 сая тоннд хүргэхээр ажиллаж байгаа. Бид Хятадын талын худалдан авагч талыг нэлээн сайн судалж үзсэн. БНХАУ ер нь нэг жилийн хугацаанд ойролцоогоор 1 тэрбум тонн орчим нүүрсийг нийтдээ 8 улсаас импортолж авч хэрэглэдэг байгаа. Тэгэхээр Монгол Улсаас нийлүүлж байгаа нүүрсний хэмжээг 120-140 сая тонн хүргэхэд Хятадын талаас ямар нэгэн квот гэдэг юм уу, хязгаарлалт тавихгүйгээр худалдан авах бололцоотой. Гагцхүү бид эдгээр боомтууд руу тавигдах дэд бүтцээ сайн болгох, уул уурхайнхаа үйл ажиллагааг нэмэгдүүлэх, ингэхдээ мэдээж нутгийн иргэдэд байгаль орчинд нөлөөлөлгүй байхаар хийж чадах юм бол нүүрс худалдах, бүтээгдэхүүн худалдах боломжтой байгаа гэдгийг энэ ташрамд хэлье. Хил холболтын төмөр замын асуудал дээр Б.Дэлгэрсайхан сайд хариулах байх.

Д.Амарбаясгалан: - Борхүүгийн Дэлгэрсайхан сайд асуултад хариулъя.

Б.Дэлгэрсайхан: - Б.Уянга гишүүний асуултад хариулъя. Их хэрэгтэй асуулт асуулаа. Ер нь бол Гашуунсухайт Ганц модны боомтын төмөр замыг холбох асуудал бол 3 жил гаран бид ярьж байгаа. Сүүлийн 3 удаагийн уулзалтаар ялангуяа өнгөрсөн 7 хоногт Ерөнхий сайд Шанхайн хамтын ажиллагааны орнуудын Ерөнхий сайд нарын уулзалтад Бээжингээр дамжиж явахдаа “Чайна Энержи” гэдэг компани дээр бид очиж уулзсан. Энэ компани жилдээ 960 саяас 1 тэрбум тонн нүүрс хэрэглэдэг том компани байна. Энэ компани бол манай Гашуунсухайт Ганц модны Хятад талын холболтыг хариуцаж байгаа ганц компани.

Тийм учраас цаашдаа бид энэ компанийн асуудлаар Засгийн газар дээрээ шийдээд Улсын Их Хурал дээр оруулж ирнэ. Энэ замыг холбоход манай Улсын Их Хурлын гишүүд дэмжлэг үзүүлнэ байх гэж бодож байна. Тэгж байж сая Б.Уянга гишүүний ярьдгаар нүүрс экспорт 100 сая тоннд хүрэх боломжтой. Бид аль болох стратегийн ирээдүйн хамтрагч, олон жилийн хугацаандаа их хэмжээний нүүрс авах ач холбогдолтой. Төмөр замын холболт болоод нүүрс авах компаниудтай холбогдож ажиллаж байгаа. Үүнийхээ үр дүнг удахгүй үзнэ ээ гэдэгт итгэлтэй байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: - Цагаандэл-Уул чиглэлийн авто зам, хүнд даацын авто замын талаар асуулт ирсэн байгаа. Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулъя.

Б.Дэлгэрсайхан: - Цагаандэл-Уулын авто замын талаар өнгөрсөн 7 хоногт Засгийн газрын тэргүүнээс үүрэг өгсний дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон Зам тээврийн яамнаас ажлын хэсэг гараад, Цагаандэл-Уулын боомт

руу ажлын хэсэг ажиллаж байна. Энэ ажлын хэсэг дүгнэлтээ гаргасны дараа Боомтын сайд Б.Тулга сайдын ярьснаар бол авто зам болоод төмөр зам тавих асуудал яригдаж байгаа. Хэрэв эхлээд дэд бүтцээ хийчихвэл дараа нь нээнэ гэдэг асуудал яригдаж байгаа гэдэг энэ ташрамд хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: - Баярлалаа. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

---oO---

1.2. 2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДРИЙН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД 2024-2025 ОНЫ ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН БЭЛТГЭЛ АЖЛЫН ЯВЦЫН ТАЛААР ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ



С.Амарсайхан: - Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх гол үйл ажиллагаа 2024-2025 оны өвлийг өнөтэй давахаас эхэлж байна. Засгийн газар эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хөдөө аж ахуй, эрчим хүч, хот суурин газрын орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг ханган, өвөл, хаврын улирлын эрсдэлтэй нөхцөл байдлыг даван туулах талаар дараах гол бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Нэг. Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын талаар

Зохион байгуулалтын арга хэмжээний талаар: - Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн “Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 28 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн “Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 он өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажил эрчимжүүлэх тухай” 02 тоот албан даалгаврын хүрээнд улсын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг зохион байгуулан ажиллалаа.


Дээрх шийдвэрүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр орон нутагт бүх шатны Засаг даргын захирамж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол гаргаж, хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөөг баталж ажлын хэсэг байгуулагдан ажилласан.

Салбарын яамнаас хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах ажлын явц, цаг үеийн асуудлаар аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын холбогдох албан тушаалтнуудтай 3 удаагийн цахим хурал зохион байгуулж, зарим шаардлагатай аймгуудад газар дээр нь ажиллаж цаашид анхаарах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Зуншлага, бэлчээрийн даацын талаар: - Агаарын дундаж температур 2024 оны 6 дугаар сараас 8 дугаар сарын хооронд олон жилийн дундажтай харьцуулбал нийт нутагт 1.5°C градусуар дулаан байв.


Хур тунадас: - Монгол орны хэмжээнд дунджаар 172.3 мм хур тунадас орсон нь олон жилийн дунджаас 25.9 хувиар илүү байсан. Хур тунадас нийт нутгийн 56 хувьд олон жилийн дунджаас ахиу, 14.7 хувьд дунджийн орчим, 28.7 хувьд бага хур тунадас орсон бөгөөд төвийн нутгийн ихэнх, зүүн аймгуудын зарим сумдын нутгаар 200.1-300.0мм, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Төв, Хэнтий аймгуудын зарим сумын нутагт 300.1-529.6 мм орсон. Харин Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Завхан, Баянхонгорын зарим, Өмнөговь, Дорноговийн ихэнх нутгаар гандуу байсан.

2 дугаар зураг. 2024-2025 оны өвөл-хаврын бэлчээрийн даац, хувиар /багийн нутгаар/



Бэлчээрийн ургамал энэ оны 6 дугаар сарын дунд үеэс сайжирч 8 дугаар сарын 25-ны байдлаар нийт нутгийн 70 орчим хувьд сайн, 20 гаруй хувьд дунд, 10 орчим хувьд буюу Ховд, Өмнөговийн зарим, Говь-Алтай зарим сумдын нутгаар муу байлаа.

3 дугаар зураг. Зуншлалын байдал ба бэлчээрийн ургамлын ургац /2024 оны 3 дугаар улирлын байдлаар/



Төвийн нутгийн ихэнх, зүүн аймгуудын зарим сумдын нутгаар 4.1-15.7 ц/га, тал хээр, говийн нутгаар 0.1-4.0 ц/га байв.

Өвөл-хаврын бэлчээрийн даац: - Ус, цаг уур, орчны шинжилгээний хүрээлэнгээс гаргасан судалгаагаар өвөл, хаврын улирлын бэлчээрийн даац 47 хувьд бэлчээрийн нөөцтэй, 20 хувьд бэлчээр хүрэлцээтэй, 21 хувьд бэлчээр 1-3 дахин хэтэрсэн, 4 орчим хувьд 3-5 дахин хэтэрсэн, 8 орчим хувьд бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн дүн гарч байна. Аймгийн дүнгээр авч үзвэл Баянхонгор, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Өвөрхангай, Завхан, Увс, Хөвсгөл аймгуудын ихэнх сум, багийн нутгаар даац олон дахин хэтэрсэн дүн гарч байна.

Өвөлжих малын тоо, мал, махны экспорт: - Улсын хэмжээнд 15.4 сая толгой төл хүлээн авч, 189.2 мянган малчин өрхөд 60.2 сая, хонин толгойд шилжүүлснээр 111.7 сая толгой мал өвөлжих урьдчилсан дүн гарч байна. Үүнээс 17.9 мянган малчин өрхийн 7.3 сая мал отроор өвөлжиж, хаваржих зохион байгуулалт хийгдсэн нь өмнөх оноос 0.6 сая толгойгоор буурлаа.

Оторлох малыг байршлаар нь авч үзвэл 36.0 хувь нь улсын тусгай хамгаалалттай газарт, 22.9 хувь нь өөрийн аймгийн бусад сумын нутагт, 14.4 хувь нь хилийн зурвас газарт, 8.7 хувь нь өөр аймагт, 16.2 хувь нь аймаг дундын отрын бүс нутагт, 1.8 хувь нь сум дундын отрын бүс нутагт өвөлжих зохион байгуулалт хийгдсэн байна.

1 дүгээр хүснэгт. 2024-2025 оны өвөл, хавар оторлох өрх, малын судалгаа

№	Отрын бүс	Оторлох	
		Малчин өрхийн тоо	Малын тоо /мян.тол/
1.	Өөр аймгийн нутагт	2,098	638.3
2.	Өөрийн аймгийн бусад сумын нутагт	5,188	1678.0
3.	Сум дундын отрын бүс нутагт	181	132.6
4.	Аймаг дундын тусгай хэрэгцээний нутагт	1,099	1186.4
5.	Хилийн зурвас бүс нутагт	2,975	1054.6
6.	Байгалийн тусгай хамгаалалттай бүс нутагт	6,372	2639.5
	Нийт	17,913	7329.4

4 дүгээр зураг. Отор нүүдлийн байдал



Орон нутгаас ирүүлсэн мэдээгээр энэ онд нийт 16.0 сая толгой малыг хэрэгцээлэх судалгаа гарч зохион байгуулалтын ажил хийгдэж байна. Зуншлага тааруу байсан Говь-Сүмбэр, Дархан-Уул, Хөвсгөл, Увс, Төв зэрэг аймгууд нийт малын 30-аас дээш хувийг эдийн засгийн эргэлтэд оруулахаар төлөвлөлт, зохион байгуулалт хийж байна.

Улсын хэмжээнд 2023 онд 80.4 мян.тонн мах /түүхий ястай маханд шилжүүлэн тооцвол 120.0 мян.тонн/, 2024 онд 45.5 мян.тонн мах, махан бүтээгдэхүүн тус тус экспортолсон. Мах, махан бүтээгдэхүүний экспортын гүйцэтгэлээр 2023 онд 80 хувийг БНХАУ, нэг хувийг ОХУ, 12 хувийг Иран, 2 хувийг Хонконг, хувийг бусад улс руу экспорт хийсэн бол 2024 онд 63 хувийг БНХАУ, 30 хувийг Иран, Ирак зэрэг булангийн орнууд, 7 хувийг бусад улсруу экспортолсон тооцоо судалгаа гараад байна.

Мөн Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан бэлтгэн нийлүүлэгчид болон эцсийн хэрэглэгчид хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэзээ ч, хаанаас ч худалдан авах, худалдах захиалга өгөх боломж бүхий нээлттэй, хялбар дуудлага худалдааны систем /cloud.mse.mn/ болон мал, махны зарын платформ /ariljaa.mse.mn/-ыг бий болгож мал, махыг дундын зуучлалгүйгээр арилжих нөхцөлийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн бүрдүүлж, арилжааг эхлүүлэн, үйл ажиллагааг тогтмолжуулаад байна.

Үүний хүрээнд нийт 542 хэлцлээр, 466.4 тонн хонины, 517.7 тонн үхрийн, 303.3 тонн ямааны, 189.4 тонн адууны, 31.0 тонн тэмээний, нийт 1,504.9 тонн махны, 34,744 толгой амьд малын /хонь / арилжааг 399 малчин, иргэн 22 аж ахуйн нэгжийн хооронд зохион байгуулсан.

Хадлан, тэжээл бэлтгэлийн тухай: - Улсын хэмжээнд хадлан бэлтгэх ажилд нийт дугуйт трактор 4,280, үүнээс бага оврын 3,216, ангилан хадагч 1,894, морин хадуур 856, гар хадуур 36,067, тармуур 3,027, хаман боогч 828, нуруулдагч 95, тракторын чиргүүл 1,922 тус тус техник, тоног төхөөрөмжүүд ажилласан байна.

Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоолын хүрээнд аймаг, сумын аюулгүй нөөцөд нийт 18.7 мянган тонн өвс, 12.4 мянган тонн тэжээлийг бэлтгэхээр төлөвлөснөөс 16.2 мянган тонн өвс, 8.0 мянган тонн тэжээл бэлтгэж, өвс, тэжээл бэлтгэл 75.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Харин малчдын түвшинд 1.2 сая тонн хадлан, 9.4 мянган тонн сүрэл, 91.0 мянган тонн ногоон тэжээл, 59.1 мянган тонн үйлдвэрийн тэжээл, 48.9 мянган тонн гар тэжээл, 8.0 мянган тонн дарш, 73.8 мянган тонн давс, хужир бэлтгэж шаардагдах өвс, тэжээлийн 96.2 хувийг бэлтгэсэн.

2 дугаар хүснэгт. 2024-2025 оны өвс тэжээлийн бэлтгэлийн судалгаа

Төрөл		Бэлтгэвэл зохих /мян.тн/	Бэлтгэсэн /мян.тн/
Малчдын түвшинд	Өвс	1,346.4	1,205.1
	Сүрэл	3.2	9.4
	Ногоон тэжээл	51.3	91.0
	Хүчит тэжээл	62.4	58.3
	Гар тэжээл	53.7	48.5
	Дарш	6.5	8.0
	Хужир шүү	106.4	72.3
Аймаг, сумын аюулгүй нөөц	Өвс	18.7	16.1
	Тэжээл	12.3	7.9

Иргэн, аж ахуйн нэгжүүд арилжааны зориулалттай 56.8 мянган тонн өвс, 1.8 мянган тонн ногоон тэжээлийг орон нутгийн зах, худалдааны төвүүдэд худалдан борлуулж байна.

Малын тэжээлийн импорт: - Монгол Улс 2024 онд ОХУ болон БНХАУ-аас 71.2 мян.тонн малын тэжээл импортоор худалдан авснаас баруун бүсэд 15.2 мян.тонн тэжээл импортолсон байна.

Газар тариалангийн салбарт 2024 онд улсын хэмжээнд 94.9 мянган га-д малын тэжээл тариалж, 246.9 мян.тонн малын тэжээлийн ургамал хураан авах, үр тарианаас малын тэжээлд 50.0 мян.тонн улаанбуудайг тэжээлийн будаанд шилжүүлж 2024-2025 онд мал аж ахуйн салбарт 289.8 мян.тонн тэжээл нийлүүлэхээр байгаа бөгөөд шаардлагатай тэжээлийн хэрэгцээг хангах, цаашид өвөлжилт, хаваржилт хүндэрвэл импортоор тэжээл нэмж авахаар байна.

Бэлчээрийн усан хангамж: - Улсын хэмжээнд 51.5 мянган уст цэг бүртгэгдсэнээс инженерийн хийцтэй худаг 17.1 мянга, энгийн уурхайн худаг 33.9 мянга, усан сан 463 байна. Энэ онд улсын төсвийн 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 68, гадаадын төсөл, хөтөлбөрийн 1 тэрбум төгрөгөөр 43, орон нутгийн төсвийн 7.0 тэрбум төгрөгөөр 290, малчдын өөрсдийн санаачилгаар 81 гар худаг, нийт 482 худгийг ашиглалтад оруулснаар 682.5 мянган га бэлчээр, 2,167 малчин өрхийн 1.2 сая малыг усаар хангасан дүнтэй байна.

Малчдын хашааны хангамж: - Энэ онд бод малын 1,048, бог малын 2,545 хашаа саравч шинээр барьж, улсын хэмжээнд бодын 90.3 мянган хашаа, богийн 166.2 мянган хашаатай болсон нь малын хашааны хангамжийг 97.3 хувьд байна.

Бэлчээр хамгааллын арга хэмжээ: - Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг 8 аймгийн 53 сумын 156.0 гаруй мянган га бэлчээрийн талбайд зохион байгуулж, бэлчээрийн ургамлыг ургаж эхлэх үед буюу хаврын технологит хугацаанд зохион байгуулж, мэрэгч амьтдын хөнөөлд өртөхөөс сэргийлж, бэлчээрийн 95.2 мянган тонн тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтдын тархалт, олшролтыг тодотгох судалгааг Архангай, Булган, Баянхонгор, Өвөрхангай, Төв, Дундговь, Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Завхан, Дархан-Уул зэрэг 12 аймгийн 102 сум, Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын нөөц 4 бэлчээрийн нийт 35.1 сая га талбайд, шавжийн тархалт, олшролтыг тодорхойлох судалгаа хийгдсэн.

Өрхийн бэлтгэл: - Малын тарга хүч авалт, малчдын өвс, тэжээлийн бэлтгэл, хашаа саравч засаж тохижуулсан байдал, ариутгал халдваргүйтгэл хийсэн талбайн хэмжээ, хоол хүнс, түлээ түлшний нөөц, хүн, мал эмнэлгийн эмийн сан, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан байдлаар дүгнэхэд улсын хэмжээнд 91.5 хувьтай хангасан дүн гарсан байна.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар: - 2024 он гарсаар мал, амьтны гоц халдварт 3 нэрийн өвчний нийт 100 голомт бүртгэгдсэн (хонины цэцэг 91, бог малын мялзан 11, гахайн африкийн мялзан). Мал, амьтны гоц халдварт өвчний 2023 оны дэгдэлтийн үзүүлэлтийг 2024 оныхтой харьцуулж, дараах хүснэгтэд харуулав.

3 дугаар хүснэгт. Мал, амьтны гоц халдварт өвчний судалгаа

Он	Аймгийн тоо, давхардсан	Сумын тоо, давхардсан	Голомтын тоо	Малчин өрхийн тоо	Өвчилсөн мал, амьтны тоо
2023	30	112	213	668	28,287
2024	18	89	107	464	13,489

5 дугаар зураг. Дэглэм хэрэгжиж байгаа аймаг, сумын хязгаарлалт



Өнөөдрийн байдлаар мал, амьтны гоц халдварт өвчний улмаас нийт 1 аймгийн 2 сумын 2 голомтод хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм үргэлжилж байна.

Гоц халдварт хонины цэцэг өвчний талаар: - Улсын хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын

01-ний өдрөөс хойш 12 аймгийн 71 суманд 91 голомтод 401 өрхийн нийт 11951 толгой мал өвчилж, 91 голомтод хорио цээрийн дэглэм хэрэгжиж байсан бөгөөд одоогийн байдлаар бүрэн цуцлагдаж, гоц халдварт хонины цэцэг өвчин улсын хэмжээнд тайван, урьдчилан сэргийлэх арга хэмжээ хийгдэж байна.

Гахайн африкийн мялзан өвчний талаар: - Улсын хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш 2 аймгийн 5 сумын 5 голомтод 12 өрхийн 241 толгой гахай өвчилж, өвчилсөн бүх гахайг устгасан. Өмнөговь (1) аймгийн Цогтцэций (1) сумын, Сэлэнгэ (1) аймгийн Сайхан (1), Орхонтуул (1) Сант (1), Сүхбаатар (1) сумын нийт 3 аймгийн, 5 сумын, 5 голомтын хорио цээрийн дэглэм бүрэн цуцлагдсан байна.

Бог малын мялзан өвчний талаар: - Улсын хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс хойш 4 аймгийн 8 суманд 8 голомтод 26 өрхийн 564 толгой мал өвчилж, 129 толгой мал устгасан байна. Хэнтий (1) аймгийн Дархан (1), Баянхонгор (2) аймгийн Баянлиг (1), Богд (1), Сүхбаатар (1) аймгийн Дарьганга (1), Эрдэнэцагаан (1) Өвөрхангай аймгийн Нарийнтээл(1) сум, Хайрхандулаан, Баруунбаян-Улаан (1), Сант (1), нийт 4 аймгийн 9 суманд 69 голомт бүрэн цуцлагдсан байна. Өвөрхангай аймгийн Богд (1), Баянгол (1) нийт 1 аймгийн суманд 2 хязгаарлалтын дэглэмтэй байна.

Гоц халдварт өвчний дархлаажуулалтын талаар: - Шүлхий өвчний дархлаажуулалтад 4.5 сая толгой мал хамруулахаас 4.2 сая толгой мал хамруулж 93.6 хувийн, үхрийн арьс товруутах өвчний дархлаажуулалтад 34.2 мянган толгой үхэр хамруулж 100 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар: - Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 32.0 сая толгой мал хамруулахаас 25.0 сая толгой мал хамрагдаж 83 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.

Вакцины нөөц худалдан авалтын талаар: - Гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэх вакцин 11,6 тэрбум төгрөгөөр 10.5 сая тун, бог малын мялзан сэргийлэх вакцин 2.8 тэрбум төгрөгөөр 18.2 сая тун, үхрийн арьс товруутах өвчнөөс сэргийлэх вакцин 2.4 тэрбум төгрөгөөр 2.2 сая тун, хонины цэцэг өвчнөөс сэргийлэх вакцин дотоодоос 1.3 тэрбум төгрөгөөр 9.5 сая тун, 6 нэрийн халдварт өвчин болон архаг халдварт өвчин болох бруцеллөз өвчнөөс сэргийлэх вакциныг 2.5 тэрбум төгрөгөөр 11.3 сая тунг тус тус худалдан авах ажлыг зохион байгуулж, вакцины нөөцийг бүрдүүлэн 2024 оны арга хэмжээнд хэрэглэж байна.

Малжуулах хөтөлбөрийн талаар: - Малжуулах арга хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны төсвийн хуваарийн дагуу 21 аймаг, нийслэлийн 3 дүүргийн нийт 3419 өрхөд 27.0 тэрбум төгрөгийг зарцуулж, хонин толгойд шилжүүлснээр 132,614 толгой мал худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн.


Одоогийн байдлаар малжуулах арга хэмжээнд хамрагдахаар 21 аймаг, нийслэлийн 3 дүүргээс 4,957 өрх хүсэлт ирүүлснээс 3,363 өрхийн хүсэлтийг аймаг, сумын амьжиргааг дэмжих зөвлөл дэмжиж, 2,596 өрхийн хүсэлтийг Хөдөлмөр эрхлэлтийг байгууллагаас шийдвэрлэн 20.7 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий малаар малжуулаад байна.

Малын даатгалын талаар: - Малын индексжүүлсэн даатгалд 21 аймаг, нийслэлийн 3 дүүргийн хэмжээнд 21.4 мянган малчин 4.3 сая толгой малыг 3.7 тэрбум төгрөгөөр даатгалд хамруулсан байна.

2023-2024 оны өвөл, хаврын улиралд даатгалд хамрагдсан малчин өрхийн буцаан олголтыг Үндэсний статистикийн хорооноос гаргасан хагас жилийн мал, тэжээвэр амьтны тооллогын албан ёсны дүнд үндэслэн нөхөн төлбөрийн тооцоолол хийж 21 аймгийн 218 сум болон Улаанбаатар хотын 3 дүүргийн 22.0 мянган малчин өрхөд нийт 16.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.

Хамгийн өндөр нөхөн төлбөрийг Сүхбаатар аймагт нийт 4.1 тэрбум төгрөгийг бүх даатгуулсан малчид болох 2,382 малчин өрх авч байна.

6 дугаар зураг. Даатгалд хамрагдсан малын тоо ба даатгуулсан малчин



Ургац хураалтын дүнгийн талаар: - Газар тариалангийн салбарын технологит ажлыг хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр холбогдох олон арга хэмжээг хэрэгжүүлж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллав.

Ургац хураалтын өмнө салбарын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн ажлын хэсгийг тариалангийн бүс нутагт ажиллуулж цаг уурын төлөв байдалтай холбогдуулан ургацыг хаягдалгүй хураах технологийн зөвлөмжийг боловсруулж тариаланчдад хүргэсэн ба ургац хураалтын ажлыг шуурхай зохион байгуулахад орон нутгийн удирдлагын зүгээс анхаарах, хэрэгжүүлэх асуудлуудын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын албан даалгавар гарган үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Ургац хураалтын дүнгээр 336.1 мянган га талбайгаас 430.0 мянган тонн үр тариа, үүнээс 386.4 мянган тонн улаанбуудай, 18.6 мянган га-гаас 250.8 мянган тонн төмс, 17.2 мянган га-гаас 267.3 мянган тонн хүнсний ногоо, 96.1 мянган га-гаас 246.9 мянган тонн тэжээлийн ургамал, 115.2 мянган га-гаас 53.3 мянган тонн тосны ургамал тус тус хураан аваад байна.

Энэ онд аж ахуйн нэгж, иргэд 288.1 мянган га-д чанар сайтай уринш бэлтгэсний 150.7 мянган га талбайг нь дэвшилтэт технологиор боловсруулсан. Хураасан ургацын хэмжээг өмнөх онтой харьцуулахад улаанбуудай 13.1 хувь, тосны ургамал 3.7 хувь буурсан бол төмс 37.0 хувь, хүнсний ногоо 20.0 хувиар тус тус нэмэгдсэн дүнтэй байна.

Улсын хэмжээнд үр тариа хадгалах 611.8 мянган тоннын багтаамжтай элеватор байгаагаас “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-д 182.0 мянган тонн, гурилын үйлдвэрүүдэд 304.8 мянган тонн, тариалангийн аж ахуйн нэгжүүдэд 125.0 мянган тонн элеватор ашиглагдаж байна.

Энэ намрын ургац хураалтаас стратегийн нөөцөд “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК 46.3 мянган тонн, гурилын үйлдвэрүүд 160.8 мянган тонныг тус тус худалдан авснаар 207.1 мянган тонн улаанбуудай гурилыг үйлдвэрлэлийн зориулалттай нийлүүлсэн.

Түүнчлэн спиртийн үйлдвэрт 15.6 мянган тонн, малын тэжээлд 56.0 мянган тонн улаанбуудай нийлүүлсэн бол “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК үрийн шинэчлэл хийх зорилгоор 5.0 мянган тонн үрийн буудай, тариалан бүхий аж ахуйн нэгжүүд дараа оны тариалалтад зориулж 40.2 мянган тонн үрийн буудай нөөцөлсөн дүн мэдээтэй байна.

Нэгдсэн дүнгийн талаар: - Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан байдлыг малчдын өвс, тэжээл бэлтгэл, аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт, ус, хашааны хүрэлцээ хангамж, малчин өрхийн бэлтгэл зэрэг үндсэн үзүүлэлтээр дүгнэхэд улсын хэмжээнд 86.7 хувьтай бэлтгэл хангагдсан байна.

4 дүгээр хүснэгт. Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц

Д/Д	Аймгийн нэр	Төлөвлөгөө /Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоол/		Бэлтгэсэн /тн/		Биелэлт /хувь/		Өвс, тэжээлийн дундаж хувь
		Өвс	Тэжээл	Өвс	Тэжээл	Өвс	Тэжээл	
	А	1	2	3	4	5	6	7
1	Архангай	860	515	817.1	361.1	95.0	70.1	82.6
2	Баян-Өлгий	490	425	133.4	86.0	27.2	20.2	23.7
3	Баянхонгор	800	700	1058.7	323.5	132.3	46.2	89.3
4	Булган	740	520	911.5	373.5	123.2	71.8	97.5
5	Говь-Алтай	1100	590	940.9	421.1	85.5	71.4	78.5
6	Говьсүмбэр	175	85	145.0	200.0	82.9	235.3	159.1
7	Дархан-Уул	260	140	260.0	126	100.0	90.0	95.0
8	Дорноговь	660	500	1102.8	691.4	167.1	138.3	152.7
9	Дорнод	800	460	1640.7	333.0	205.1	72.4	138.7
10	Дундговь	800	510	656.1	273.6	82.0	53.6	67.8
11	Завхан	2070	770	119.5	312.3	5.8	40.6	23.2
12	Орхон	130	85	160.0	75.0	123.1	88.2	105.7
13	Өвөрхангай	1100	860	824.0	370.0	74.9	43.0	59.0
14	Өмнөговь	750	550	903	552.5	120.4	100.5	110.4
15	Сүхбаатар	930	450	776.0	443.7	83.4	98.6	91.0
16	Сэлэнгэ	950	710	941.4	560.0	99.1	78.9	89.0
17	Төв	1500	1400	1153.0	365.1	76.9	26.1	51.5
18	Увс	1100	620	874.5	499.9	79.5	80.6	80.1
19	Ховд	1000	560	706.0	918.5	70.6	164.0	117.3
20	Хөвсгөл	1300	1000	1040.4	324.5	80.0	32.5	56.2
21	Хэнтий	1000	760	799.5	227.5	80.0	29.9	54.9
22	Улаанбаатар	280	210	239.8	185.6	85.6	88.4	87.0
	Нийт дүн	18,795	12,420	16,203	8,024	86.2	64.6	75.41

Хоёр. Эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар

2.1. Салбарын 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын талаар:

Монгол Улсын Эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөсөн хугацаанд хийж дуусгах, ажлын явцад хяналт тавих, шаардлагатай

тохиолдолд гарсан хүндрэлийг шуурхай зохицуулах, мэдээллээр хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Эрчим хүчний сайдын 2024 оны А/81 дүгээр тушаалаар байгуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Дулааны цахилгаан станцуудын үндсэн тоноглол болох 65 зуух, 45 турбогенератороос 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар ажилд 47 зуух, 34 турбогенератор, бэлтгэлд 10 зуух, 6 турбогенератор, засварт 8 зуух, 3 турбогенератор байгаа бөгөөд системийн горим ажиллагаа хэвийн байна.

2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангахад нийт 44 үйлдвэр, компаниудын үндсэн болон туслах тоноглолын их засварт 860 нэр төрлийн ажил төлөвлөж 96 хувь, техник зохион байгуулалтын арга хэмжээ /ТЗБАХ/-ний 441 ажил төлөвлөж 93 хувь, хөрөнгө оруулалтаар 616 ажил төлөвлөж 92 хувь, салбарын хэмжээнд дунджаар 94 хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2 хувиар илүү гүйцэтгэлтэй байна.

2023-2024 оны өвлийн их ачааллын горим ажиллагаанд “Сонгино 80 МВт-ын хүчин чадалтай батарей хуримтлуур”-ыг 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр, “Амгалан дулааны станцыг 116 МВт-ын хүчин чадалтай нэг зуух шинээр суурилуулах” төсөл, арга хэмжээг 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдөр тус тус ашиглалтад оруулсан бол 2024-2025 оны өвлийн их ачааллын горим ажиллагаанд “Чойбалсангийн дулааны цахилгаан станцыг 50 МВт-аар өргөтгөх” төслийг 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдөр улсын комисс ажиллаж, ашиглалтад оруулсан.

Цаашид Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 150 МВт-ын хүчин чадалтай эхний ээлжийн блокыг хуваарьт хугацаанд, Багануурын 50 МВт-ын хүчин чадалтай батарей хуримтлуурыг 2024 оны 12 дугаар сард, БНХАУ-аас 80 МВт хүртэлх чадлыг импортоор авах хуваарилах байгууламжийг 2025 оны 1 дүгээр сард тус тус ашиглалтад оруулахаар холбогдох зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

Өвлийн их ачааллын горим ажиллагаанд эх үүсвэрийн хүчин чадлын дутагдал үүссэн үед Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд БНХАУ-аас 80 МВт хүртэлх чадлыг импортоор авах ажлын хүрээнд 220 кВ-ын хуваарилах байгууламжийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг “Оюутолгой” ХХК, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-тай 2024 оны 8 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан бөгөөд барилга угсралтын ажлыг 2025 оны 1 дүгээр сард дуусгаж, ашиглалтад оруулахаар холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголоор нийт 131 тэрбум төгрөгийн татаасыг шийдвэрлүүлсэн бөгөөд Эрчим хүчний сайдын 2024 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн А/200 дугаар тушаалаар баталсан санхүүгийн дэмжлэгийг өвөлжилтийн бэлтгэл ажлын биелэлтийг бүрэн хангах, нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, импортын эрчим хүч худалдан авах, тарифын алдагдлыг бууруулах, бэлтгэн нийлүүлэгчид төлөх төлбөр, татвар, нийгмийн даатгалын шимтгэл

болон бусад хуримтлагдсан өр төлбөрийг үе шаттай барагдуулах, санхүү, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх үндсэн үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулахаар шийдвэрлэв.

Ингэснээр өвөлжилтийн бэлтгэл хангах их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлтэй холбоотой бэлтгэн нийлүүлэгчид үүссэн өр, төлбөрийг барагдуулахад 58.3 тэрбум төгрөг, нүүрсний аюулгүй нөөц бүрдүүлэх, эрчим хүчний компаниудаас нүүрсний уурхайд төлөх хугацаа хэтэрсэн өр төлбөр болон нүүрс олборлолтын бодит өртгөөс бага тогтоосон үнийн зөрүүгээс 9, 10 дугаар сард үүсэх алдагдлыг арилгахад нийт 32.0 тэрбум төгрөг, импортын эрчим хүчний тарифын зөрүүгээс үүсэх алдагдал, өр төлбөрийг барагдуулахад 16.5 тэрбум төгрөг, зарим компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж буй нийгмийн даатгалын шимтгэл болон татварын өглөгийг барагдуулахад 3.9 тэрбум төгрөг, Эрчим хүчний салбарт 2025 оноос төсвөөс татаасгүй ажиллах зорилтыг хангах бэлтгэл ажлын хүрээнд “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК болон “Алтай Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-иудын богино хугацаат өр, төлбөрийг барагдуулж, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэхтэй холбоотойгоор 4.5 тэрбум төгрөг, компани бүрийн үйл ажиллагааны онцлогоос хамаараад бусад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд 14.0 тэрбум төгрөг тус тус хуваарилав.

Дээрх тушаал, шийдвэрийн дагуу өвөлжилтийн бэлтгэл хангах, хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг болгон 2024 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар нийт 27 төрийн өмчит үйлдвэр, компаниудад 125.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шилжүүлсэн.

2.2. Цахилгаан эрчим хүчний хэрэглээ, импорт, экспортын талаар:

Эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын ерөнхий инженерүүдийн 2024 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн зөвлөгөөнөөр 2024-2025 оны өвлийн их ачааллын горим ажиллагааг хэлэлцэн баталсан бөгөөд 2024 оны 9 дүгээр сарын 16-ны өдрөөс 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд өвлийн горимыг мөрдөн ажиллана. 2024-2025 оны өвлийн оргил ачаалал урьдчилсан байдлаар өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 12 хувиар нэмэгдэж 1824 МВт хүрэх тооцоололтой байна.

Төвийн эрчим хүчний нэгдсэн системийн эх үүсвэрүүд бүрэн чадлаар ажиллах бөгөөд аль нэг тоноглолд гэмтэл, саатал гарсан тохиолдолд цахилгаан эрчим хүчээр хязгаарлах нөхцөл байдал үүснэ.

Эх үүсвэрийн хүчин чадлын дутагдал үүсэх үед хөнгөлөлт болон хязгаарлалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж байна. Хөнгөлөлтийн хөтөлбөрт нийт 365.5 МВт-ын ачаалал бүхий хэрэглэгчидтэй урьдчилсан тохиролцсоны дагуу 17-21 цагийн хооронд 100.3 МВт хүртэл ачааллыг бууруулахаар төлөвлөсөн.

Хязгаарлалтын хөтөлбөрийг Улаанбаатар хотод 11, орон нутагт 3, нийт 14 багцад хуваан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Улсын хэмжээнд 2024 оны эхний 10 дугаар сарын гүйцэтгэлээр 9,254.2 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч боловсруулж, 8,464.1 сая кВт.цаг цахилгаан эрчим хүчийг түгээсэн байна. Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад боловсруулалт 5.7 хувь буюу 494.9 сая кВт.цагаар, түгээлт 6.0 хувь буюу 476.8 сая кВт.цагаар тус тус өссөн байна.

Нийт хэрэглээний 75.6 хувь буюу 6,988.5 сая кВт.цаг цахилгаан эрчим хүчийг дотоодын эх үүсвэрээс, 24.4 хувь буюу 2,265.6 сая кВт.цаг цахилгаан эрчим хүчийг импортоор хангасан. Дотоодын эх үүсвэрийн боловсруулалтын 90.3 хувь буюу 6,308.1 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг дулааны цахилгаан станцаас, 6 хувь буюу 422.6 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг салхин цахилгаан станцаас, 2.9 хувь буюу 201.4 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг нарны цахилгаан станцаас, 0.8 хувь буюу 56.3 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг усан цахилгаан станцаас тус тус хангасан байна.

Импортоор авсан цахилгаан эрчим хүчний 1,003.3 сая кВт.цаг буюу 44.3 хувийг Оросын Холбооны Улсаас, 1,262.3 сая кВт.цаг буюу 55.7 хувийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас тус тус импортлосон. Импортлосон цахилгаан эрчим хүчний хэмжээ өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 14.9 хувь буюу 293.8 сая кВт.цагаар нэмэгдсэн.

Гурав. Орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 2024/02 дугаартай “Орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай” албан даалгаврын хүрээнд мэдээ, тайлан ирүүлсэн 100 байгууллага “Салбарын 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг 8 багц ажлын хүрээнд нийт 45163 ажилд 55.3 тэрбум төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар 44821 ажилд 42.3 тэрбум төгрөгийг зарцуулсан.

Салбарын өвөлжилтийн бэлтгэл 93 хувийн биелэлттэй байна. Салбарын өвөлжилтийн бэлтгэл 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар 8 багц ажлын хүрээнд хийгдсэн ажлыг дараах хүснэгтэд харуулав. Үүнд:

5 дугаар хүснэгт. Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн ажил

№	Ажлын нэр төрөл	Хэмжих нэгж	Орон нутаг	Нийслэл	Нийт
1	Шинээр өргөтгөж, шинэчлэх шугам сүлжээ	у/м	28655	14334	42989
2	Засвар үйлчилгээ хийгдэх шугам сүлжээ	у/м	114068	28813	142881
3	Угаалга шахалт хийгдэх шугам сүлжээ	у/м	427061	570217	997278
4	Шинээр өргөтгөж, шинэчлэх барилга байгууламж	ш	49	8	57

5	Засвар үйлчилгээ хийгдэх барилга байгууламж	ш	153	4345	4498
6	Шинээр өргөтгөж, шинэчлэх тоног төхөөрөмж	ш	178	1266	1444
7	Засвар хийх тоног төхөөрөмж	ш	229	37920	38149
8	Нүүрс нөөцлөлт	тонн	79551,5	4611	84162,5

6 дугаар хүснэгт. Орон нутгийн орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын гүйцэтгэсэн шугам сүлжээний ажлын биелэлт

д/д	Байгууллагын нэр	Төлөвлөсөн ажил	Биелэгдсэн ажил	Биелэлт					Бэлтгэл ажлын биелэлт (%)
				Шугам сүлжээ	Барилга байгууламж	Тоног төхөөрөмж	Нүүрсний хангалт	Бусад	
1	Архангай аймаг "Ар Ус Ундарга" ХХК	29	26	3	6	17	180	0	91
2	Архангай аймаг "Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ	4	4	3	0	1	76	0	82
3	Баян Өлгий аймаг "СУАТ" ХХК	13	12	3	3	6	297	0	93
4	Баянхонгор аймаг "Чандмань Баянхонгор" ХХК	22	13	8	1	2	2100	2	77
5	Булган аймаг. "Булган мээж" ХХК	21	20	8	6	6	0	0	99
6	Говь Алтай аймаг "Ундарга алтай" ОНӨҮГ	21	18	3	5	9	0	1	81
7	Говьсүмбэр аймаг "Ус-Ду" ОНӨҮГ	12	12	6	2	1	7100	3	98
8	Говьсүмбэр аймаг "Илчлэг шивээ" ОНӨААТҮГ	9	9	4	2	1	0	2	89
9	Дархан Уул аймаг "Дархан ус суваг" ХК	24	23	5	5	11	0	2	96
10	Дархан Уул аймаг "Дулаан шарын гол" ТӨХК	30	30	9	2	16	8984	3	97
11	Дархан-Уул аймаг "ЭМТ Наран" ОНӨААТҮГ	12	10	3	2	1	263	4	94
12	Дорнод аймаг "Дорнод НАА" ХХК	73	67	4	17	35	700	11	93
13	Дорноговь аймаг "Чандмань Илч" ХХК	18	17	5	1	2	6000	9	85

14	Дорноговь аймаг "Замын-Үүд Дулааны станц"	153	136	5	0	1	7300	130	95
15	Дундговь аймаг "ДундговьУс" ОНӨААТҮГ	9	9	8	1	0	1000	0	80
16	Завхан аймаг "Амь Ус Трейд" ХХК	29	27	5	8	14	0	0	91
17	Завхан Тосонцэнгэл сум "Тосон Очирт хайрхан" ОНӨААТҮГ	38	37	7	9	8	1100	13	100
18	Орхон аймаг "Эрдэнэт УДТС" ОНӨХК	50	49	6	10	22	0	11	87
19	Өвөрхангай аймаг "Онги ус суваг" ОНӨҮГ	36	31	9	4	18	0	0	90
20	Өвөрхангай аймаг "Хархорин ус суваг" ОНӨХК	11	10	3	1	1	5000	5	80
21	Өмнөговь аймгийн "Гүнийн Ус" ХХК	20	17	5	7	5	0	0	82
22	Өмнөговь аймгийн "Цог өрнөх" ОНӨААТҮГ	10	10	2	3	5	0	0	80
23	Өмнөговь аймгийн "Хандизель" ОНӨААТҮГ	15	13	6	1	6	0	0	83
24	Өмнөговь аймгийн "Шугшаа уул" ОНӨААТҮГ	63	63	0	0	0	550	63	100
25	Сүхбаатар аймаг "Дөрвөлж" ХХК	88	77	5	8	58	0	6	86
26	Сэлэнгэ аймаг "Цэнгэг Ус" ХХК	266	97	0	9	38	5	50	80
27	Сэлэнгэ аймаг Зүүн хараа тосгон "Цант Орхон" ХХК	40	40	3	10	27	5	0	100
28	Сэлэнгэ аймаг Сайхан сум "Гавшгай ус" ОНӨААТҮГ	61	52	5	19	18	1100	10	90
29	Сэлэнгэ аймаг "Мандал энерго" ОНӨААТҮГ	7	7	3	4	0	1040	0	100
30	Төв аймаг "Төв Чандмань ДЭХГ" ОНӨААТҮГ	84	79	1	14	16	35983	48	94
31	Увс аймаг "Чандмань Увс" ХХК	34	34	4	14	13	1	3	95
32	Ховд аймаг "Шим ус" ОНӨААТҮГ	63	63	4	5	15	0	28	92
33	Хөвсгөл аймаг "Хөвсгөл ус суваг" ХХК	50	31	2	8	18	767.5	3	81
34	Хэнтий аймаг "Хэнтий ус" ХХК	43	40	4	15	21	0	0	81
	Нийт	1458	1183	151	202	412	79551.5	407	90

Орон нутгийн орон сууц, нийтийн аж ахуйн 34 байгууллага өвөлжилтийн бэлтгэл ажилд 26.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 1458 нэр төрлийн ажил гүйцэтгэхээр төлөвлөснөөс 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар 19.6 тэрбум төгрөг зарцуулан 1183 нэр төрлийн ажил бүрэн гүйцэтгэсэн.

Орон нутгийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай байна.

7 дугаар хүснэгт. Улаанбаатар хотын орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын гүйцэтгэсэн шугам сүлжээний ажлын биелэлт

Д/д	Байгууллагын нэр	Төлөвлөсөн ажил	Биелэгдсэн ажил	Үүнээс					Бэлтгэл ажлын биелэлт (%)
				Шугам сүлжээ /ш/	Барилга байгууламж /ш/	Тоног төхөөрөмж /ш/	Нүүрсний татан авалт /тн/	Бусад ажил /ш/	
1	"УСУГ" ОНӨААТҮГ	155	126	5	40	71	0	10	84
2	"ОСНААУГ"	41817	41817	6	4002	37796	0	5	100
3	"Багануур ус" ААТҮГ	43	41	9	11	21	0	0	97
4	"Чандмань Налайх" ОНӨААТҮГ	140	140	6	9	121	4611	0	90
5	"Стандарт хийт" ХХК	4	4	3	1	0	0	16	100
6	"Ханжаргалант өргөө" ХХК	12	12	2	5	5	0	55	94
7	"Пюр хаус" ХХК	16	16	4		12	0	42	100
8	"Гангар орд" ХХК	53	53	1	6	46	0	0	100
9	"Жинст өргөө" ХХК	8	8	5	1	2	0	0	100
10	"Богд асар инженеринг" ХХК	11	11	5	2	4	0	0	100
11	"Опен хаус ӨНӨ" ХХК	43	43	5	10	28	0	0	100
12	"Баянмонгол" ХХК	6	6	4	2	0	0	0	100
13	"Таван өндөр" ХХК	36	36	2	6	26	0	0	100
14	"Туул арвижих өргөө" ХХК	10	10	0	0	10	0	0	100
15	"Аж богд инженеринг" ХХК	10	10	2	0	8	0	0	100
16	"Монватер" ХХК	17	17	4	0	13	0	0	100
17	"Хүрээ хаус" ХХК	32	32	5	4	23	0	0	100
18	"Ганбиж" ХХК	31	31	4	1	26	0	0	100
19	"Бьюдинг мэйнтэнэнс сервис" ХХК	14	14	4	2	8	0	0	100
20	"Эс жи ливинг" ХХК	8	8	4	0	4	0	0	100
21	"Хаусинг холд" ХХК	67	67	6	10	51	0	0	100
22	"Хүрд" ХК	10	10	5	2	3	0	0	100
23	"Монтс" ХХК	15	15	5	7	3	0	0	100

ЕРӨНХИЙ САЙДЫН ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ

24	"ЖИ ЭЙ БИ ӨУ ТИ" ХХК	51	51	3	7	41	0	0	100
25	"Смарт план" ХХК	108	108	1	7	100	0	0	100
26	"Зүмбэр орд өргөө" ХХК	22	22	4	6	12	0	0	100
27	"Лхатаном сервис" ХХК	13	13	2	2	9	0	0	100
28	"Тэлмүүн орд" ХХК	15	15	3	9	3	0	0	100
29	"Баатар дулаан хан" ХХК	39	39	3	8	28	0	0	100
30	"Цэнгэлдэх ОСНААК"	12	12	2	2	8	0	0	100
31	"Дунд мандал" ХХК	25	25	2	2	21	0	0	100
32	"Адтай ноён" ХХК	37	37	1	0	36	0	0	81
33	"Арга мэргэн" ХХК	10	9	3	1	6	0	0	100
34	"Бадамлах нар" ХХК	47	47	4	0	23	0	20	100
35	"Батбаян-Дулаан" ХХК	37	37	6	0	31	0	0	100
36	"Баянгазрын хишиг" ХХК	5	5	3	0	2	0	0	100
37	"Булнайн ар" ХХК	4	4	3	0	1	0	0	100
38	"Голдкомпас" ХХК	31	30	5	20	5	0		88
39	"Гурван оргил таун" ХХК	23	23		15	5	0	0	73
40	"Грийн проперти" ХХК	8	8	2	0	6	0	0	100
41	"Грийтлак" ХХК	7	5	3	0	2	0	0	80
42	"Дай цэцэн" ХХК	79	79	7	0	72	0	0	74
43	"Ди ди прогресс" ХХК	14	12	3	0	4	0	5	85
44	"КСИМС" ХХК	24	24	6	2	16	0	0	100
45	"Комфорт Монгол Нэтворк" ХХК	22	20	3	0	17	0	0	92
46	"Маршал комфорт" ХХК	5	5	2	0	3	0	0	100
47	"Монхаус сервис" ХХК	10	4	2	0	7	0	0	95
48	"Морьтүнгэ" ХХК	11	11	4	0	7	0	0	100
49	"Өөдөө байгаль" ХХК	3	3	1	0	2	0	0	100
50	"Сод Эгшиг" ХХК	24	19	5	12	2	0	0	88
51	"Тохилог шинэ ертөнц" ХХК	63	63	5	0	58	0	0	94
52	"Тэргүүн чансаа" ХХК	88	84	5	0	79	0	0	97
53	"Тэргэл мөнх" ХХК	12	12	7	0	5	0	0	85
54	"Трю эл менежмент" ХХК	27	15	3	8	4	0	0	75
55	"Хайспийд" ХХК	66	66	4	1	59	0	2	94
56	"Хүннү хотхон" ХХК	11	11	1	0	1	0	9	100
57	"Эрчим скай стар" ХХК	4	4	3	0	1	0	0	100
58	"Эрин барилга" ХХК	46	46	6	0	40	0	0	100
59	"Чандмань хүрд" ХХК	25	25	2	0	9	0	14	100
60	"Биг Кастель" ХХК	9	8	4	0	4	0	0	77
61	"Ган инженеринг" ХХК	31	31	6	0	25	0	0	87
62	"Вайз майнд солюшн" ХХК	48	48	9	3	8	0	28	100
63	"Оч гялс өргөө" ХХК	9	9	2	0	7	0	0	100
64	"Тунгалаг Буянт туул" ХХК	4	4	4	0	0	0	0	100
65	"Баганат харш" ХХК	13	13	7	1	5	0	0	100
66	"Эрч хишиг" ХХК	5	5	3	0	2	0	0	100
	Нийт	43705	43638	250	4227	39057	4611	206	96

Улаанбаатар хотын орон сууц, нийтийн аж ахуйн 66 байгууллага байгаагаас орон нутгийн өмчит 4, хувийн орон сууцны ашиглалтын 62 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Мэдээ ирүүлсэн 66 аж ахуйн нэгж өвөлжилтийн бэлтгэл ажилд 28.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 43705 нэр төрлийн ажил гүйцэтгэхээр төлөвлөснөөс 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар 22.7 тэрбум төгрөг зарцуулан 43638 нэр төрлийн ажил гүйцэтгэсэн. Улаанбаатар хотын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлт 96 хувьтай байна.

Анхаарал хандуулсан Та бүхэнд баярлалаа.

--oOo--

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДРИЙН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД 2024-2025 ОНЫ ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН БЭЛТГЭЛ АЖЛЫН ЯВЦЫН ТАЛААР ХИЙСЭН МЭДЭЭЛЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААР

Чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Шадар сайд, УОК-ын дарга С.Амарсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С. Батболд, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Шадар сайдын Ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил, УОК-ын Нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү, ОБЕГ-ын Тэргүүн дэд дарга бөгөөд Штабын дарга, хурандаа Ц.Ганзориг, “Шинэ Хоршоо” хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны ажлын албаны дарга Ё.Азжаргал, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын газрын дарга О.Мөнхбаяр, Зам, тээврийн яамны Салбарын хяналтын газрын дарга М.Энхболд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Малын генетик нөөцийн хэлтсийн дарга Ж.Цогтбаатар, Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Насантогтох, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга И.Лувсанцэрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Нийслэлийн засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Улаанбаатар хотын Захирагчийн албаны Хотын инженерийн дэд бүтцийн газрын дарга М.Балдандорж, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Д.Мөнхбаатар, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга П.Эрхэмбулган, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-ын Сайжруулсан түлшний хяналтын хэлтсийн дарга Ч.Буянжаргал, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Ерөнхий инженер Т.Мөнхболд, “Тавантолгой түлш” ХХК-ийн Санхүү, эдийн засгийн газрын дарга А.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ү.Амарбат, Хяналт шалгалтын газрын дарга Т.Нармандах, мөн газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг нар байлцав.

Монгол Улсын Шадар сайд, УОК-ын дарга С.Амарсайхан “2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын явцын талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, ХҮН намыг Ж.Золжаргал, Үндэсний эвслийг А.Ундраа, Иргэний Зориг Ногоон Намыг Б.Батбаатар нар төлөөлж үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.6-д заасны дагуу цөөнхийн төлөөллөөс Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Л.Мөнхбаясгалан, П.Батчимэг, Г.Ганбаатар,

С.Цэнгүүн, С.Эрдэнэболд, М.Нарантуяа-Нара, Да.Цогтбаатар, Ж.Золжаргал, Д.Жаргалсайхан нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд, УОК-ын дарга С.Амарсайхан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Насантогтох, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, УОК-ын Нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.11-д заасны дагуу цахим хуудсанд 2 иргэнээс ирүүлсэн 15 асуултыг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нар асууж, хариулт авав.

Х.Булгантуяа: - Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын дахь цөөнхийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл таныг индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: - Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс эдийн засгаа төрөлжүүлж, уул уурхайн бус салбарын хөгжилд анхаарч, өрөөсөн хөлөөс өрсөлдөх чадвараа тэмүүлэхээр “Алсын хараа-2050”, “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгасан.

Үүний томоохон хэсгийг хөдөө аж ахуй болон эрчим хүчний салбарын зорилтууд эзэлж байгаа. Бид уламжлалт ахуйн соёл, урд, хойд хөршийн нөхцөл байдлыг тооцож үзэхэд эдийн засгийг төрөлжүүлж чадах стратегийн ач холбогдолтой салбар бол хөдөө аж ахуй, эрчим хүчний салбар мөн.

Гэвч Монгол Улсын Ерөнхий сайдын Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хийсэн уг мэдээлэлд эдгээр салбарын бодлого, зорилтот хөтөлбөрийн хүрээнд өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрсдэл багатай даван туулах урт хугацааны бодлого, хөтөлбөрийн талаар мэдээлэл тусгагдаагүй байгаа нь тун харамсалтай.

Энэ мэдээлэл, тайлан нь бүхэлдээ аймаг, сумын Засаг даргын хэмжээний ажил статистикийн байгууллагуудын тоон үзүүлэлт, салбарын яамны хэлтэс, газрын мэргэжилтний улирлын тайлан төдий нэг удаагийн гал намжаах агуулгатай байгаа нь хангалтгүй гэж Ардчилсан намын бүлгийн зүгээс үзэж байна.

Өмнөх жилүүдийн уг салбарын мэдээллийн адил газар тариаланд гарах дэвшил, усалгаатай талбайн хэмжээ, нэгж талбайгаас авах ургацын хэмжээ, малын тэжээл, тариалан, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар малын чанарыг дээшлүүлэх, нэгж малаас авах ашиг шимийг өсгөн хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, дотоодын нийт валют бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг дээшлүүлэх, эрчим хүчний үнэ чөлөөлөлт либералчлал, эх үүсвэрийн

тэлэлт, сүлжээний бодлого зэрэг бодлогын томоохон ажлууд хийгдээгүй, ахиц гараагүй нь мэдээллээс харагдаж байна.

2 жилийн өмнө Ардчилсан намын бүлгийн дүгнэлтээр жинхэнэ зуд малчны хотонд биш Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд байна. Жинхэнэ ган тариан талбайд биш Засгийн газрын хөдөөгийн хөгжлийн бодлогод байна гэж дүгнэлт танилцуулж байсан. Бүтэн 2 жил өнгөрөхөд яг өмнөх шигээ хүнээ мартаж, мал, буудайг чухалчилсан алдаатай бодлогоо хэрэгжүүлж, татаас, урамшууллын бодлогоор амь зогоосоор байна.

Ардчилсан намын байр суурь, экспортын зорилго, амбицын талаар олон бүтээлч шийдлүүдийг санал болгодог. Аль ч салбарын бодлогод суусангүй, ажил хэрэг болж чадсангүй. Улам бүүр өтгөрч буй хотын утаа шиг хөдөө аж ахуй, мал аж ахуй, газар тариалан, эрчим хүчний салбарын асуудлууд улам бүүр ужгирсаар байна. Өвөлжилтийн бэлтгэл нэрийн доор малчид, аймаг, сумд болон улсын өвс тэжээлийн нөөцөд бэлтгэсэн нийт тоо хэмжээг дурдаж байгаа хэдий ч бэлтгэхээр тавьсан тоо хэмжээ нь өвлийг давах хэмжээнд хүрэлцэхүйц байхаар биш, зөвхөн мал хөлдөж хорогдохын өмнө үргүй зардал нэмж гарах хэмжээнд байгаа нь Засгийн газрын мэдээлэл, салбарын яамны үйл ажиллагааны тооцоолол гэхэд харамсалтай.

Засгийн газрын тогтоолоор бэлтгэсэн өвс, тэжээлийн хэмжээ нь өнөөдрийн байдлаар манай улсын нийт малд шаардлагатай хоногийн өвс тэжээлийн хагас өдрийн ч хэрэгцээг хангахааргүй хэмжээний тоо тавиад өвөл, хаврын бэлтгэл хангагдсан гэж ярих нь нэн хариуцлагагүй асуудал. Социалист маягийн төлөвлөгөө, тоо нэгтгэдэг ажлаа орхиж, бодлого зохицуулалтын ажил руугаа орохыг дахин сануулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам гэдэг трактор, техник, үрийн буудай худалдаа хийдэг арилжааны яам биш, бодлого гаргадаг, инновац руу хөтөлдөг, зохицуулалт хийдэг төрийн захиргааны төв байгууллага юм.

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны хавар Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн өмнө төсвийн мөнгийг зарлагадан, төрийн албан хаагчдыг дайчлан байж, татаас дэмжлэгтэй хямд эх үүсвэрээр малчдын хоршоодод олгосон “Шинэ Хоршоо” хөтөлбөрийн үр дүн, олгосон зээл, зээл авсан малчид, тус хоршооны талаарх мэдээлэл огт дурдагдаагүй байгаа нь уг хөтөлбөрөөс үр дүн гарсангүй юу гэж эргэлзэхэд хүрч байна.

Уг хөтөлбөр хэрэгжсэн олон аймагт зуншлага тааруу байснаас өвлийг өнөтэй давахгүй нөхцөл байдал үүссэн тул аймгуудын нийт малын 30-аас дээш хувийг төхөөрөх байдлаар хохирлыг бууруулахаар Засгийн газрын хэмжээнд яригдаж байгаа нь мал аж ахуйн салбарт ямар ч бодлого, үр дүн байхгүй байгааг шууд илтгэн харуулж байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль 2011 онд батлагдаж, Хөдөө аж ахуйн бирж 2013 онд байгуулагдсанаас хойш 10

гаруй жилийн хугацаанд уг салбарт нэмүү өртгийн дотоодын сүлжээ, худалдаа ложистикийн тогтолцоо үүсэж бэхжээгүй, биржээр дамжих худалдаа өсөн нэмэгдээгүй, нэр төдий байгаа нь 2024 онд Хөдөө аж ахуйн биржээр нэг сумын, нэг багийн малчдын малын мах боловсруулах үйлдвэрийн бэлтгэх хэмжээний махны худалдаа хийгдсэн байгаагаас харагдаж байна.

Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй Хүнсний хувьсгалын талаар ч дурдаагүй байгаа нь төрийн байгууллагууд, институт хоорондын уялдаа ямар байгаад эргэлзэхэд хүргэж байгааг дуулгая.

2024-2025 оны өвлийн оргил ачаалалд цахилгаан эрчим хүчний хэрэглээ 1824 МВт-д хүрэх бөгөөд цахилгаан эрчим хүчний доголдолд орж ноцтой эрсдэл үүсэхээр байгаа тухай мэдээлэлд дурджээ. Орон нутгийн сонгуулийн өмнө хэвлэлээр нээлттэй хийсэн мэдээллээр зарим цахилгаан станцад гарсан үл тохирол, ослыг завсарлахгүй бол 21 дүгээр зуунд хотоороо лаа барьж, идэр есийн хүйтнийг давна гэсэн үг. Юун сансрын хиймэл дагуул вэ?

Эрчим хүчний салбарын реформ гэх сүржин нэртэй даржин ажиллагаа мухардчих уу? Монопол салбарт хүн чөлөөлөх нэрээр жижиглэнгийн үнийг нэмж, нийлүүлэх зарим станцаа хэт өндөр үнэ, хэтэрхий урт хугацааны гэрээг байгуулж байгаа нь уг салбарыг улам бүр чөтгөрийн тойрогт оруулж байгааг Ардчилсан намын бүлгийн зүгээс сануулдаг.

Уг салбарыг либералчилж, хувийн хэвшлийг оруулж, төрийн дэмжлэг, тусламжийг тодорхой тунхагласан бодлогын баримт бичгээ нэн даруй Улсын Их Хуралд танилцуулах замаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад ил тод болох учиртайг сануулъя.

Засгийн газраас жил бүр давтагддаг асуудлын эх үүсвэр, шалтгааныг арилгахад анхаарах бус өвлийг л давчихвал гэдэг хандлагаар аргацаасан байдлаар хандаж ирсэн нь хөдөө аж ахуйн бодлогын цаана эрчим хүчний салбарыг эрсдэлийн хэмжээнд хүргэж, асуудлыг улам хуримтлуулаад байна.

Иймд хууль тогтоогчдыг болон ард иргэддээ салбартаа буг болсон дарга нарын статистикийн тоогоор хуурах бус, бодит нөхцөлд үнэлгээ хийж, хавтсанд шургуулж, тоосонд дарагдан хэвтэх урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг жил жилээр ханган ахиулж, ахиц дэвшил гарган ажиллахыг шаардаж байна. Хоёр жилийн өмнө эдгээр салбаруудын талаар Ардчилсан намын бүлгийн өгсөн санал, дүгнэлтүүдийг эргүүлэн харахад өнөөдөр өмнөх жилүүдтэй адил нөхцөл байдалтай байна.

Монгол Улсын хөдөлмөрийн насны нийт хүн амын дөрөвний нэгийг эзлэх малчдаа анхаарах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэх, зудын гамшиг, эрсдэлийн хэмжээнд тохиолдох үед хүнээ бодсон авах арга хэмжээний төлөвлөгөөг бэлтгэн ажиллах шаардлагатай байна. Уул уурхайн бус, хөдөө аж ахуйн салбарын хөгжилд 200 орчим мянган малчин өрхөд аж амьдралаа залгуулан буй 300 орчим мянган малчдын аж амьдралын эх үүсвэр болох мал

аж ахуйн салбарын бодлогод анхаарал хандуулж олон сая мал, олон 100 мянган ажиллах хүч өргөн уудам бэлчээрийн давуу талд тулгуурласан бэлчээрийн мал аж ахуйд сэргэлт хийх замаар эдийн засгийн өсөлт хийх, экспортын боломжийг эрэлхийлэхэд нүдээ нээж, бодлогоо чиглүүлэн ажиллахыг сануулъя.

Эрх баригчид хэт олуулаа засагласан олон жилийн эцэст эрчим хүч, хөдөө аж ахуйн салбарт эдийн засгийг төрөлжүүлэх, та биднийг балчиг намгаас суга татах учиртай тэргүүлэх салбарууд гэж үздэгээ Ардчилсан намын бүлэг дахин тодотгож байна.

Засгийн газарт хүч биш оновчтой бодлого юу юунаас илүүтэй дутагдаж буйг дахин сануулъя.

Анхаарал хандуулсан Та бүхэнд баярлалаа.

Х.Булгантуяа: - Улсын Их Хурлын дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэллээ.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Агваанлуvsсангийн Ундраа таныг индэрт урьж байна.

А.Ундраа: - Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын явцын талаарх Ерөнхий сайдын мэдээллийг сонсож дараах байр суурийг илэрхийлж байна.

Ерөнхий сайдын мэдээллээс харахад улсын хэмжээнд хөдөө аж ахуйн салбар 86.7, эрчим хүчний салбар 94, орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагууд 93 хувийн гүйцэтгэлтэйгээр өвөлжилтийн бэлтгэлийг тус тус хангаснаар улсын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажил дунджаар 91.2 хувийн гүйцэтгэлтэй байна гэж дүгнэж болохоор байна. Гэвч энэхүү тоон үзүүлэлт эргэлзээ төрүүлж байна.

Учир нь хөдөө аж ахуйн салбар, эрчим хүчний салбар, орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлаар 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтыг хэт ерөнхий дүгнэсэн нь учир дутагдалтай байна.

Өөрөөр хэлбэл, материаллаг талаас нь илүү дурдаж, улмаар хүн ардын, хүүхдүүдийн, эмэгтэйчүүдийн малчин өрхүүдийн, иргэдийн эрүүл мэндийн болон сэтгэл санааны учирч болзошгүй хохирол, амь нас, эрүүл мэндэд учирч болох аюулаас урьдчилан сэргийлэх түүнийг даван туулах арга хэмжээний талаар салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хэрхэн хийгдэх талаар дурдсангүй.

Тухайлбал, нэгдүгээрт цаг агаарын хүндрэлтэй үед нийтийн тээврийн хүртээмж, авто замын аюулгүй байдлыг хэрхэн хангах, зорчих хөдөлгөөн саадгүй байх, аврах болон тусламжийн үйл явцын төлөвлөгөө зэрэг бэлтгэл ажлын талаар дурдаагүй байна. Нэг жишээ дурдахад улсын хэмжээнд хадлан бэлтгэх

ажилд нийт дугуйт 4280 трактор ажилласан гэх хэдий ч үүнийг 330 сумд хувааж тооцвол 1 сумд ойролцоогоор 10 гаруй трактор ногдож байна.

Гэтэл өнгөрсөн өвлийн зуднаар олон сумд малын бэлчээр зам гаргах трактор байхгүй гэж иргэд олноор гомдол гаргасан тохиолдол бүртгэгджээ. Үүний улмаас дээрх хөдөө аж ахуйн салбарын тоо баримтад эргэлзэж байна. Хянан баталгаажуулах шаардлагатай гэж үзэж байна.

Хоёрдугаарт, хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэлийг дурдахдаа иргэд рүүгээ чиглэсэн бэлтгэл ажлын талаар дутмаг байна. Ялангуяа малчид, малчдын хүүхдүүдэд цаг агаарын эрс хүйтрэлийн нөлөө нь урт хугацаанд үргэлжилдэг, малаа алдсан малчид сэтгэлээр унах, стрессээс үүдэлтэй сэтгэл зүйн гэмтлүүд илрэх, мөн хүүхдүүдийн хувьд сургууль, цэцэрлэгээсээ завсардах, хоол тэжээлийн хомсдолд орох, тээвэрлэлтийн хүрэлцээгүйн улмаас шим тэжээлийн дутагдал, эрүүл ахуйн асуудал, эх, нярайн эндэгдэл зэрэг эрүүл мэнд, боловсролын нэн шаардлагатай үйлчилгээг тэд авч чадахгүйд хүрдэг. Байгалийн давтагдашгүй хүчин зүйлд өртсөн тохиолдолд ямар арга хэмжээ авах, эдгээр эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх бэлтгэл ажлын явцын талаар тодорхой дурдсангүй.

Иймд хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг 86.7 хувь гэж үнэлж байгаа нь эргэлзээ төрүүлж буй юм.

Гуравдугаарт, утаа хийгээд, агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл байсангүй.

2023 онд улсын хэмжээнд угаарын хийн хордлогын улмаас 3000 гаруй хүн эмнэлгийн тусламж авч, 61 хүн нас барсан. 2024 оны эхний 4 сарын байдлаар 1000 орчим хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч, 20 хүн нас барсан тоон мэдээ байна.

Эх нярайн эндэгдлийн хувьд 2023 онд 63,915 эх амаржсанаас төрөлхийн гажигтай төрсөн 456, 2500гр-аас доош жинтэй төрсөн 4804, амьгүй төрсөн ураг 344 байна гэх мэдээ сэтгэл түгшээж байна.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс агаарын бохирдлын хөрөнгө оруулалтын жишиг судалгааны дүнгээс үзэхэд Монгол Улсад жил бүр гадаад орчны агаарын бохирдлын нөлөөгөөр 2839, дотоод орчны агаарын бохирдлын нөлөөгөөр 4300 хүн нас барсан гэсэн мэдээ байна. Мөн гадаад орчны бохирдлоос үүдэлтэй цаг бус эндэгдэл 881 тэрбум төгрөг, дотоод орчны агаарын бохирдлоос үүдэлтэй цаг бус эндэгдэл 3.5 их наяд төгрөгөөр хэмжигдэх эдийн засгийн алдагдал хүргэж байгаа зэргийг анхаарч үзэх нь зүйтэй.

Дөрөвдүгээрт, зам тээврийн халтиргаа гулгааны улмаас сэргийлэх бэлтгэл хэрхэн хангагдсан, эдгээрийн улмаас эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийн бэлтгэл ажлын талаар тодорхой мэдээлэл дурдагдаагүй байна.

Жишээлбэл, 2023 оны 12 дугаар сарын 14-20-ны өдрийн хооронд Гэмтэл согогийн Үндэсний төвд халтиргаа гулгаанаас үүдэлтэй бэртэл авсан 665 хүн үйлчлүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан ба түүнчлэн осголт, хөлдөлтийн 67 тохиолдол бүртгэгдсэн байна.

Тавдугаарт, өвлийн хүйтэнд гадаа ажилладаг тохижилт үйлчилгээний ажилтнууд болон онцгой байдлын ажилтнууд, цагдаа, цэрэг хүчин, эрүүл мэндийн шуурхай байгууллагын албан хаагчдын аюулгүй байдал, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийн хүртээмж хэрхэн хангагдсан, үндсэн ажлаа явуулах нөхцөл бүрэн хангагдсан эсэх нь тодорхойгүй байна.

Цаашлаад онцгой үед ажиллах мэдээлэл шуурхай дамжуулах зохион байгуулалт, техник технологийн бэлэн байдал хангагдсан эсэхийг тодруулах шаардлагатай байна.

Зургаадугаарт, түлээ, нүүрс, түлш, шатахууны бэлтгэл ажил хэрхэн хангагдсан талаар дэлгэрэнгүй дурдах хэрэгтэй байна. Улаанбаатар хотын гэр хорооллын 200 мянга орчим өрх сайжруулсан шахмал түлшээр халаалтаа шийддэг. 1 өрх ойролцоогоор 2.8 тонн шахмал түлшээр өвлийг давдаг. Монгол Улс 2024 оны байдлаар нэг жилд ойролцоогоор 2 сая тонн шатахуун хэрэглэдэг зэрэг статистик байна. Иймд түлш шатахуунаар тасралтгүй хангах бэлтгэл ажил бүрэн хангагдсан эсэх нь эргэлзээтэй.

Долоодугаарт, цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийн дутагдал үүсэх үед хөнгөлөлт болон хязгаарлалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч байгааг дурджээ. Бодит байдлаас харахад цахилгааны хязгаарлалтын мэдээлэл түүний төлөвлөгөөг эрд иргэдэд урьдчилан хангалттай мэдээлдэггүй, мэдээлсэн ч төлөвлөгөөнийхөө дагуу байдаггүй зэрэг нь олон нийтийг бухимдуулах олон тохиолдол гарч байсныг дурдах нь зүйтэй.

Наймдугаарт, цаг агаарын цочир хүйтрэл, зудын эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх, түүнийг хэрхэн даван туулах талаар төлөвлөгөө нь шинжлэх ухаанч бус байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангахдаа холбогдох ямар мэргэжлийн байгууллага, олон улсын ямар байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг тусгасан талаар дурдаагүй, мөн шинжлэх ухааны үндэслэлтэй бус, бодлогын шийдэл болохуйц бус дутмаг төлөвлөгөө байна гэж дүгнэхэд хүрч байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Булгантуяа: - Одоо Улсын Их Хурлын гишүүн Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн үг хэлнэ. Таныг индэрт урьж байна.

М.Нарантуяа-Нара: - Эрхэм Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.2-т заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж буй 2024-2025 оны өвөлжилт, хавар хаваржилтын бэлтгэл ажлын явцын талаарх Ерөнхий сайдын мэдээлэлд сөрөг хүчний хувьд Иргэний Зориг Ногоон Намын төлөөлөн байр сууриа илэрхийлье.

2024-2025 оны өвөлжилт, хаваржилтыг өнөтэй давах нь Улсын Их Хурал, Засгийн газрын макро, микро эдийн засгийн шокоос урьдчилан сэргийлж төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хөдөө аж ахуй, эрчим хүч, хот суурин газрын орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг ханган өвөл, хаврын улирлын эрсдэлтэй нөхцөл байдлыг даван туулах талаар бодлогын оновчтой шийдэл гаргаж, богино хугацааны зөв менежменттэйгээр ажиллахаас их зүйл хамаарна гэж Иргэний Зориг Ногоон Нам үзэж байна.

Аливаа ажил, асуудалд бүх цаг үеийн бэлтгэлийг бодолцож ажиллах нь тухайн цаг үеийн шийдлийг агуулж байдаг. Иймээс өвөлжилт, хаваржилтын бэлтгэл цаашлаад хөдөө аж ахуй, эрчим хүчний салбарын талаар төрөөс баримталбал зохих бодлогод Иргэний Зориг Ногоон Нам дараах 3 саналыг дэвшүүлж байна.

1. Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын талаар:

Хөдөө аж ахуй гэдэг мал, амьтан өсгөн үржүүлэхээс гадна тэдгээрээс авч болох, түүхий эдийг боловсруулах, хүнс тэжээл, цардуул үйлдвэрлэх бүхий л үйл ажиллагааг хамруулан ойлгодог билээ. Тухайлбал, энэ салбарыг нийгэм, эдийн засгийн агуулгаар нь харвал Монгол Улсын ДНБ-ий 20.6 хувь бөгөөд ажиллах хүчний 42 хувийг эзэлдэг.

Тиймээс уг асуудал, шийдлийг зөвхөн зуншлага, бэлчээрийн даац, хадлан тэжээлийн бэлтгэл зэрэг талаар мэдээлж ярихаас гадна ДНБ-д эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх, ажиллах хүчний баталгаат ажлын байр бий болгох талаар бодлого боловсруулж энэ салбарын эрсдэл, менежментийг сайжруулах, ашигт ажиллагааг дээшлүүлэх зэрэг нийгэм, эдийн засгийн үр нөлөө, үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч бүх цаг үеийн бэлтгэл ажил болгож, бодлого болгож судлах, зорилго болгох, хэлэлцэх, хэрэгжүүлэх нь зүйтэй гэж Иргэний Зориг Ногоон Нам үзэж байна.

2. Эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар:

Эрчим хүчний салбар бол улс орны хөгжлийн тулгуур, түрүүлж хөгжих шаардлагатай суурь салбар байдаг билээ. Ерөнхий сайдын мэдээллээс үзэхэд манай улс 2024 оны эхний 10 дугаар сарын байдлаар нийт хэрэглээний 75.6 хувь цахилгаан эрчим хүчийг дотоодын эх үүсвэрээс, 24.4 хувь цахилгаан эрчим хүчийг импортоор хангасан байна.

Энэ өвөл 2024-2025 оны өвлийн оргил ачаалалд урьдчилсан байдлаар өмнөх оны үеийн гүйцэтгэлээс 12 хувиар нэмэгдэх тооцоололтой. Мөн эх үүсвэрийн хүчин чадлын дутагдал үүсэх үед хөнгөлөлт, хязгаарлалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх юм байна.

Хязгаарлалтын хөтөлбөрийг Улаанбаатар хотод 11, орон нутагт 3, нийт 14 багцад хуваан хэрэгжүүлэхээр төлөвлөж, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж байна. Гэвч өнөөдөр 2024 онд тог цахилгааны асуудлаа бүрэн шийдвэрлэж чадаагүй. Тог цахилгаанаар тасалдуулдаг эрс тэс уур амьсгалтай манай улсын хувьд хэзээ мөдгүй тог цахилгаангүй болох эрсдэлтэй өвөлжихөөр байгаа нь мөн өмнөх жилүүдэд ч гэсэн ийм нөхцөл байдалд байсаар ирсэн нь эмгэнэлтэй зүйл билээ.

Цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээ жилээс жилд тогтмол өсөж байгаа, цаашид ч өссөөр байх болохыг, түүнчлэн эрчим хүчний асуудал зөвхөн өвөл бий болдог цаг үеийн шинжтэй асуудал биш болохыг бид бүхэн маш сайн мэдэж байгаа.

Иймд богино хугацаандаа олборлодог эрчим хүчнээс цэвэр ногоон сэргээгдэх эрчим хүч рүү шилжих нь дээрх хүндрэлээс гарах зам гэж манай нам үзэж байна. Иймд дэлхийн улс орнууд ч гэсэн эрчим хүч гаргаж авдаг түүхий эд, эх үүсвэрийнхээ тоог нэмэгдүүлэхэд анхаарч нар, салхины эрчим хүчний үйлдвэрлэлээ нэмэгдүүлж байгаа билээ.

Тиймээс бид энэ салбарт шинэчлэлийг яаралтай, анхааралтай хийх шаардлагатай. Энэ шинэчлэлийг монопол нөхцөлд хийж болохгүй бөгөөд эхлээд тусгай зөвшөөрлийг цуцлах, чөлөөт өрсөлдөөнийг бий болгох хэрэгтэй. Хийж чаддаг нь хийгээд, бүтээгээд, оролцоод явах нөхцөл, боломжоор хангах хэрэгтэй гэж бид үзэж байна.

Дараа нь шинэчлэл хийх замаар хэрэглэгчээ ч бодсон, үнийн өсөлтөө ч бодсон хамгийн оновчтой бэлтгэл ажил байна гэж бодож байна. Өөрөөр хэлбэл, эрчим хүч бол цэвэр хувийн хөрөнгө оруулалтаар хөгжиж явах боломжтой бөгөөд зах зээлийн харилцаанд бүрэн шилжвэл төрийн оролцоо багатайгаар хөгжих боломжтой салбар юм. Энэ тухай олон шинжилгээ, судалгаанууд гарсан байгаа.

Цаашлаад дунд, урт хугацаандаа Монгол Улс эрчим хүч экспортлогч орон болох зорилгоор сэргээгдэх эрчим хүчний мега төслийг эхлүүлж байгалийн сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашигласан цэвэр эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, цаашид экспортлох боломжийг бүрдүүлэх тал дээр анхаарч ажиллах нь өвөлжилтийн чухал ажлын бэлтгэл болно гэж үзэж байна.

3. Орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар:

Улаанбаатар хотын орон сууц, нийтийн аж ахуйн нийт 66 байгууллага байгаагаас орон нутгийн өмчит 4, хувийн орон сууцны ашиглалтын 62 байгууллага

үйл ажиллагаа явуулж байна. Өвөлжилтийн бэлтгэл ажилд 28.9 тэрбум төгрөгийн санхүүжилт төсөвлөснөөс 22.7 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Улаанбаатар хотын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлт 96 хувьтай байна гэж мэдээлсэн. Гэвч энэ их мөнгө, хэрэгжилтийн өндөр үнэлгээг өнөөдрийн бодит байдалтай харьцуулахад Улаанбаатар хотын өвөлжилтийн бодит байдалд зөв дүгнэлт, үнэлгээ өгч ажиллах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, өвөлжилтийн бэлтгэл ажилд зайлшгүй байх анхаарах асуудлууд байна. Иймд 4 асуудлуудыг бид дэвшүүлж байна.

Утааны асуудлын хувьд шахмал түлшний бодит хор хөнөөлийг тогтоох, чанар стандартыг нягтлах, бодит байдалд зөв үнэлэлт, дүгнэлт өгөх хэрэгцээ, цаг нь болсон байна.

4. Цаг агаарын аюултай үзэгдлийн үед хүн ам, эд хөрөнгийн эрсдэлээс хамгаалах учирсан хохирлыг цаг алдалгүй түргэн, шуурхай үнэлэх, хариу арга хэмжээ авах, төлөвлөлт, бэлтгэлд урьдчилан онцгойлон анхаарч ажилламаар байна.

5. Цаг агаарын хүндрэлтэй нөхцөлөөс шалтгаалж зам даваа хаагдах, халтиргаа гулгаа үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг зохион байгуулах, автомашин, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах ажил чухал байна.

6. Халтиргаа гулгаа, цас мөсний асуудалд шинэчлэл, шийдэл хийсэн байгаа юу, давс бодисын нөөц хэр байгаа вэ? Түүнийгээ цацах техник хэрэгсэл гээд хүрэлцээ хангагдсан эсэх талаар бид бүхэн анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Энэ мэтчилэн хот тойрсон жил бүрийн өвөл тулгардаг олон асуудал, шийдэл, бэлтгэл ажлыг нарийн тооцох, хангах цаг нь одоо болсон. Эдгээрийн бэлтгэл ажил болон нийт өвлийн бэлтгэл бүрэн хангагдсан уу гэх мэт асуудалд бодитоор хандаж бэлтгэл байдлыг хангах цаг болсон. Энэ нь зөвхөн хотын асуудал биш бөгөөд Монгол Улсын хүн амын тал хувь нь амьдарч байгаа нийслэлийн өвөлжилтийн асуудалд мөн анхаарах хэрэгтэй байна.

Энэ бүгдийг төр засгаас анхаарч оновчтой бодлого хэрэгжүүлэх ёстой гэж бид бүхэн үзэж байна. Тийм учраас Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ та 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажилдаа сөрөг хүчин болох Иргэний Зориг Ногоон Намын байр суурийг хүлээн авч ажиллахыг хүсэж байна.

Х.Булгантуяа: - Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүндээ баярлалаа.

Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн дагуу Ерөнхий сайд мэдээлэл хийж, цөөнхийн төлөөлөл үг хэлнэ. Ингээд асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү.

Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан асуултаа асууя.

Л.Мөнхбаясгалан: - Намайг жоохон байхад л ийм мэдээлэл радиогоор явдаг байсан. Тэдэн трактор, тэдэн өвс бэлдлээ, тийм ургац хураалт хийлээ гэсэн тэр уламжлал ёсоороо дахиад орж ирлээ. Хөдөөгүүр ялангуяа уул уурхайн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа малчдын асуудал үнэхээр хүнд байгаа. Жишээ нь, хэдэн үе дамжиж амьдарч байсан газар нь гэнэтхэн лиценз хэлбэрээр олгогдчихсон байдаг. Тэндээсээ нүүх болдог, нөлөөллийн бус та нүү гэдэг, нөхөн олговор нь өвөлжөө, хаваржааны мөнгө өгдөг. Малчдынхаа бэлчээрийг нь яах юм? Бэлчээрийн нөхөн олговор гэж ойлголт байгаа юу? Малчин хүний бизнес бол мал. Гэтэл өнөөдөр хүний амбаар пингийнх нь мөнгийг өгөөд, хөөж нүүлгээд, шилжүүлж суурьшуулаад байгаа.

Гэтэл малчинд бизнесээ хийх боломж, бэлчээрийн нөхөн олговор байдаггүй. Энэ тал дээр ямар бодлого боловсруулж ажиллаж байгаа вэ?

Өнгөрсөн жил зуд болсон. “Шинэ Хоршоо” бодлого гаргасан. Малчдын зээлийг тэглэнэ л гээд яриад байдаг. Зуд тэртээ тэргүй байнга л болдог, цаашдаа ч болно. Тэгэхээр зудаас гарахын тулд малчдыг орлоготой болгох. Өнөөдөр малчид амьдрах орчингүй, малаа бэлчээх газаргүй болоод хот суурин барааддаг. Тэгээд шууд ажилгүйчүүдийн тоо, ядуурлын тоог нэмдэг. Монгол Ардын намын зүгээс малчид руу чиглэсэн “Шинэ Хоршоо” мундаг бодлого явууллаа. “Цагаан алт” хөтөлбөр гээд яриад байдаг. Гэтэл саяхан авсан тоогоор 30 гаруй малчин өрхийн хүүхдүүдээс ямар мэргэжилтэй болох вэ гэж асуухад бүгд хот руу орж их, дээд сургуульд орно гэж байгаа. Нөгөө уламжлалт малчин гэдэг чинь байхгүй болж байна. Хэрвээ энэ бодлого нүдээ олоод, цагаа олоод малчдадаа очиж байгаа бол яагаад малчин удам тасрах гээд байна вэ? Яагаад малчид ядуурлаас гарч чадахгүй байгаа вэ? Энэ чиглэлээр ямар бодлого боловсруулж байгаа вэ?

Дээрээс нь эрчимжсэн мал аж ахуй гэж ярьдаг. Өнөөдөр малаа олон болгохоор мянгат малчин гэдгээр шагнадаг. Тэрний ач тус гэж юу ч байдаггүй. Үүний оронд цөөн тооны чанартай мал байх ёстой, малынхаа ашиг шимийг борлуулж мөнгө олох ёстой гэдэг дээр ямар соён гэгээрүүлэх ажил хийсэн бэ? Яг тодорхой хариулт авъя.

Х.Булгантуяа: - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Ц.Болорчулуун дарга хариулах уу?

Ц.Болорчулуун: - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулья.

Хөдөө аж ахуйн салбарын бодлогод тариалангийн бүс нутгийг түшиглэж, эрчимжсэн мал аж ахуйгаа хөгжүүлэх талаар тусгагдсан. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх хүрээнд тариалан тэжээлийн бааз суурийг бий болгоход тариалангийн бүс нутгаа түшиглэхээс өөр гарц байхгүй байгаа.

Тийм учраас эрчимжсэн мал аж ахуйг дэмжих бодлого, тариалангийн бүс нутагт хөгжүүлж өндөр ашиг шимтэй мал үржүүлэх, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, тухайлбал олон улсын түвшинд нэг үхрээс өгч буй сүүний хэмжээ 9-10 тонн байхад манай Монголын сүүний чиглэлийн нутгийн үнээнээс 2 тонн сүү өгч байна. Тэгэхээр олон улсын жишигт дөхүүлэхэд эрчимжсэн мал аж ахуйг тариалангийн бүс нутагт түшиглэн хөгжүүлэх бодлогыг баримтлаад, энэ хүрээнд аж ахуйн нэгжүүд тодорхой үр дүнгээ өгсөн.

Нийт малчид руу чиглэсэн ажлын хүрээнд малчдын бэлтгэж байгаа арьс шир, ноосонд тодорхой хэмжээний мөнгөн урамшууллыг олгож байгаа. Энэ нь нэг талаасаа малчдын орлогыг нэмэгдүүлэх, нөгөө талдаа үндэсний үйлдвэрийг түүхий эдээр хангах гэсэн 2 бодлогыг хоршиж хэрэгжүүлэх хүрээнд мөнгөн урамшууллын олгож байна.

“Цагаан алт” хөтөлбөр нь хөнгөн үйлдвэрийн 3 салбарт буюу ноос, ноолуур, арьс ширний салбарт чиглэсэн боловсруулах үйлдвэрлэлийн түвшнийг нэмэгдүүлэх зорилготой хөтөлбөр хэрэгжиж байна.

“Шинэ Хоршоо” хөдөлгөөний хүрээнд малчдаа хоршиж, нэгдэж ажиллахад анхаарч байна. Малчин тус бүрд хүрсэн бодлого хэрэгжүүлэхээс илүү малчид хоршвол малын гаралтай түүхий эдийн бүтээгдэхүүний үнэ цэн нэмэгдэх, анхан шатын боловсруулалт хийх боломж, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор малчдын “Шинэ Хоршоо” хөдөлгөөнийг өрнүүлээд, хэрэгжилтийг хангаад ажиллаж байна.

Х.Булгантуяа: - Л.Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: - Бэлчээрийн нөхөн олговрын талаар асуусан. Уул уурхайн бүсэд амьдарч байгаад нүүхэд төрөөс малд нь, бэлчээрт нь ямар нөхөн олговор өгч байгаа вэ? Энэ талын бодлого байгаа юу?

Малчин бүр малаа л олон болгоод мянгат малчин болох биш, чанартай цөөн тооны малыг яаж үржүүлэх вэ? Яаж өрх бүр эсвэл хоршоолол нийлээд орлоготой байх вэ гэдэг дээр соён гэгээрүүлэх ямар ажил хийж байгаа вэ? Энэ авч хэрэгжүүлж буй ажил тань байгаа онож байгаа юм уу? Хэрвээ онож байгаа бол өдийд яагаад залуу малчдын халаа тасраад байгаа юм бэ? Яагаад малчид малаа маллаж хэдэн мянган жилээр амьдарч ирсэн амьдралаасаа залхаад орхиод байгаа юм бэ? гэсэн 3 асуулт байна.

Х.Булгантуяа: - Шадар сайд С.Амарсайхан хариулах уу?

С.Амарсайхан: - Энэ өвөлжилтийн бэлтгэл ажил ямар түвшинд байна вэ гэдэг асуулт орж ирсэн учраас холбогдох байгууллагууд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажилтай холбоотой танилцуулгыг хийж байгаа. Хэрвээ ямар бодлого, ямар стратеги, ямар төсөл, хөтөлбөрийг ямар хугацаанд хэрэгжүүлсэн, түүний үр дүнг тодорхой тайлагнана гэдэг асуудал орж ирсэн бол холбогдох бодлого, хөтөлбөрийг дэлгэрэнгүй танилцуулахад бэлэн байгаа.

Асуудлын агуулга, сэдэв өөрөө энэ өвөл, хаврыг хэрхэн давах юм бэ гэдэг л асуулт байгаа. Тэгэхээр цаг үетэй нийцсэн улирлын шинж чанартай бэлтгэл ажлын мэдээллийг та бүхэнд өгч байгаа.

Гэхдээ Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны бодлого бол өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдлыг даван туулж, эсвэл аргацаах маягаар биш дасан зохицох.../минут дуусав./

Х.Булгантуяа: - С.Амарсайхан Шадар сайдад нэмэлт минут өгье.

С.Амарсайхан: - Даван туулж, дасан зохицох урт хугацааны стратегийг олон төсөл, хөтөлбөр, бодлоготойгоо уялдуулж байгаа.

Нэгдүгээрт нь бүсчилсэн хөгжлийн бодлогыг Улсын Их Хурлаар баталсан. Энэ бодлогын үзэл баримтлалд улирлын шинж чанартай, зуд турхан, ган гамшиг, аюулт үзэгдэл, гал түймэр, зовлон бэрхшээлээс үндэстнээрээ салах асуудал хамгийн чухал хэсэг юм. Тийм учраас хангайн бүсээ эрчимжсэн мал аж ахуй болгоё, хөдөө аж ахуйн дэд бүс болгоё, газар тариалангийн бүс болгоё гээд 6 дэд бүсийн ажил бүсчилсэн хөгжлийн хүрээнд явагдаж байна.

Хоёрдугаарт нь “Шинэ Хоршоо” хөтөлбөр. Энэ бол хөдөө аж ахуй тэр дундаа үндэсний үржих баялаг болсон мал аж ахуйн салбар таван хошуу малыг өсгөж үржүүлэх, үржил шимийг нь нэмэгдүүлэх, эдийн засгийн өгөөжийг нь дээшлүүлэх, малчдын амьжир.../минут дуусав./

Х.Булгантуяа: - Пүрэвийн Батчимэг гишүүн асуултаа асууя.

П.Батчимэг: - Өвөлжилтийн тухай асуудлыг өнөөдөр Улсын Их Хурлаар Ерөнхий сайд мэдээлэл хийнэ гэсэн энэ асуудлын дагуу гишүүд асуулт тавьж байна.

Өвөлжилтийн тухай асуудлыг дагавар байдлаар хандах юм уу, эсвэл бүүр даацтай ярилцах юм уу гэдэг их зөрүүтэй асуудал үүсэж байна.

Эрчим хүчний салбарын өнөөгийн хүндрэлтэй асуудал, үнэ тарифын нэмэгдэлтэй холбоотой яаж энэ өвлийг Улаанбаатарчууд давж гарах вэ гэдэг нэн тэргүүний тулгамдсан асуудал болоод байна. Цахилгааны хязгаарлалтыг хийнэ гээд бүүр төлөвлөгөө гаргачихсан байгаа. Энэ асуудлаа хэрхэн шийдэж давж гарах юм бэ? Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай холбоотой асуултууд байна. Газар тариалангийн хувьд энэ жил гантай байсан аймгуудад тариалалт маш муу, ургац алдсан. Үүнтэй холбоотойгоор улаан буудайн нөөц, хадгалалтын байдал ямар байгаа вэ? Малын гоц халдварт өвчин гараад л байдаг. Вакцинжуулалтын асуудал удаа дараа яригддаг. Тэр вакцины нөөц, түүнийг 70 сая малтай харьцуулахад вакцины тунгийн асуудал, вакцинжуулалт 73 хувьтай байсан.

Тэгэхээр энэ асуудлыг мэргэжлийн байгууллагууд юу гэж хүлээж авах вэ? Гурилын импортын татварыг тэглэсэнтэй холбоотой дотоодын гурил

үйлдвэрлэгчид тэдний бизнесийг шахсан байдалд хэрхэн дүгнэлтээ хийж байгаа юм? Өнөөдөр импортоор орж ирж байгаа ямар чанартай гурил ард иргэд хэрэглэж байгаа вэ? Хүнсний ногооны хадгалалт байна. Улаанбаатар хотод өнөөдөр хүнсний ногооны зоорь нэмэгдсэн үү? Хот тойрсон хүнсний ногоо, хувиараа эрхэлж байгаа хүмүүсийн борлуулалт, түгээлт, хадгалалт, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа, бизнес эрхэлж байгаа, хүнсний ногоо чадан ядан тарьж тоос шороонд дарагдсан иргэдийн эрхэлж байгаа бизнесийг хэр.../минут дуусав./

Х.Булгантуяа: - Эрчим хүчний яам хариульъя. Дараа нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хариулахад бэлдэж байгаарай.

Б.Насантогтох: - Эрчим хүчний яамны Хэрэгжилтийн газрын дарга Б.Насантогтох, П.Батчимэг гишүүний асуултад хариульъя.

2024-2025 оны эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажил 94 хувьтай явж байгаа. Нийтдээ улсын хэмжээнд 45 эрчим хүчний үйлдвэр, систем, түгээх компаниудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна.

Өвлийн горимын хувьд хэд хэдэн хүчин зүйлийг тооцоолсон. Өнөөдрийн байдлаар манай системийн хувьд 5 бүсэд хуваагдаж байна. Алтай, Улиастай, баруун бүс, зүүн бүс, өмнөд бүсийн 4 системд хүчин чадлын дутагдал, хязгаарлалтын горим хийгдэхгүй. Төвийн бүсэд үндсэн өсөлтөөс хамаарсан төлөвлөгөө гаргасан. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний хувьд өнгөрсөн оны мөн үеэс 12 хувь буюу 196 МВт-аар өснө гэж тооцоолсон. Төвийн бүсэд хэрэгжиж байгаа эх үүсвэрийн ажлын явцыг товчхон хэлэхийг хүсэж байна. Үндсэндээ зүүн бүсэд 50МВт-ын шинэ эх үүсвэр орсон нь төвийн бүсийг 30 МВт-аар дэмжиж ажиллах юм.

Дээр нь Эрдэнийн батарей хуримтлуур, Багануурын батарей хуримтлуур буюу эдгээр хуримтлуур нь орой оргил ачаалалд 50, 20 буюу 70 МВт-аар дэмжиж ажиллана.

Тосонцэнгэлийн цахилгаан станц, Бөөрөлжүүтийн цахилгаан станц нийтдээ 168 МВт. Эдгээр 5 төслүүд 2024 оны 12 дугаар сарын 01, 12 дугаар сарын 15, сүүлийн Бөөрөлжүүтийн станцыг сая гарсан гэмтэлтэй холбоотой 12 дугаар сарын 30-нд төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд залгахаар төлөвлөсөн.

2025 оны 01 дүгээр сард тооцож төлөвлөснөөр Өвөр Монголын эрчим хүчний системээс 60 МВт-ын импортын эрчим хүчний дэмжлэг авна. Ингээд Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд саяын 6 төсөл нь 328 МВт-ын нөөц чадлыг бий болно.

Тэгэхээр хязгаарлалтын төлөвлөгөөг ямар тохиолдолд хэрэгжүүлэх вэ гэвэл 2 үндсэн шалтгаантай. Одоо ажиллаж байгаа манай 7 ДЦС-ууд бүх тоноглол ажиллагаанд байгаа, бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна. Эдгээр станцуудад, тоноглолд гэмтэл гарвал хязгаарлалтын нөхцөл үүснэ. Хоёрдугаарт, дээрх 6 төсөл цаг хугацааны хувьд тодорхой хэмжээгээр өөрчлөлт орох бол

хязгаарлалтын нөхцөл үүснэ. Энэ 2 хүчин зүйлээс хамаараад нарийвчилсан төлөвлөгөө гаргасан. Гэхдээ өнөөдрийн байдлаар Эрчим хүчний яам холбогдох төрийн өмчийн компаниудын нарийн мэргэжлийн хүмүүс хотын болоод хувийн хэвшлийн эх үүсвэрийн төслүүд дээр хамтран ажиллаж байна. Сүүлийн төлөвлөсөн тооцооллоор 12 дугаар сарын 01-30-ны дотор эдгээр эх үүсвэрүүд төвийн бүсэд холбогдоно гэж тооцоолж ажлаа зохион байгуулан ажиллаж байна.

Х.Булгантуяа: - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хариулт өгье.

Ц.Болорчулуун: - Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, П.Батчимэг гишүүний асуултад хариулт өгье.

2024 оны ерөнхий ургацын байдлын хувьд төлөвлөж байсан хэмжээнээс 56 орчим мянган га-гаар хаврын тариалалт буурсан. Тэгэхдээ энэ жилийн гарсан ургац бол харьцангуй чанартай байсан.

Тариалангийн гол бүс нутгуудаар 7 дугаар сард буюу наадмаас хойшоо 20 хоногийн үргэлжилсэн нартай байсны улмаас чанарт тодорхой хэмжээний асуудлууд үүссэн хэдий боловч ерөнхий хураалтаа төлөвлөж байсан ургацаа хурааж авч, ургацынхаа дүнг сая өнгөрсөн 7 хоногт Засгийн газарт танилцуулсан байгаа.

Тэгэхээр улсын хэмжээнд нийтдээ 430 мянган тонн үр тариа хурааж авсан. Үүнээс 368 мянган тонн хүнсний улаан буудай, 250.8 мянган тонн төмс, 267.3 мянган тонн хүнсний ногоо хурааж авсан байгаа. Хурааж авсан улаанбуудайн хуваарилалтууд ерөнхийдөө борлуулалтад гаргаж байна. Тэгэхээр Хөдөө аж ахуйн корпорац ТӨК-д 46 мянган тонн хүнсний улаан буудайг тариаланчдаас авлаа. Гурил үйлдвэрлэлд 160.4 мянган тонн, нийтдээ гурил үйлдвэрлэлд 2005 мянган тонн буудай нийлүүлэгдсэн. Зарим аж ахуйн нэгжүүд борлуулалтаа хийж амжаагүй байгаа, өөрийн агуулах киловатт-аас хамаараад хадгалчихсан байна. Ингээд 40 гаруй мянган тонн буудай аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын шатанд байна. Жилдээ 305 мянган тонн хүнсний улаанбуудайн хэрэгцээтэй. Тэгээд гурил үйлдвэрлэлд шаардлагатай улаанбуудайн хэмжээ нь борлуулалтын үе шатанд байгааг тооцвол цаана нь 60 орчим мянган тонн буудай дутахаар байгаа.

Нөгөө талдаа 2024 оны 4 дүгээр сарын 19-нд батлагдсан хуулийн хүрээнд импортоор тодорхой хэмжээний гурилууд орж ирсэн. Он гарсаар нийтдээ улсын хэмжээнд 57.4 мянган тонн гурил импортоор орж ирсэн байна.

Орж ирж байгаа гурил бол ОХУ-ын “ГОСТ” гээд стандартын чанарын шаардлагыг хангасан гурилууд орж ирж үйлдвэрүүдэд нийлүүлэгдэж байгаа. Нөгөө талдаа “ТУ” гэж стандарт байгаа. Үүнийг хангасан гурил гээд үндсэндээ 2 янзын чанартай гурил орж ирж хэрэглэгчдэд хүрч байгаа гэдгийг хэлье.

Хүнсний ногооны агуулах, зоорины хэмжээний хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал” хөдөлгөөний хүрээнд Улсын

Их Хурлын 36 дугаар тогтоолд хүнсний ногооны зорь, агуулахын хэмжээг 55 мянган тонноор нэмэгдүүлж, дотооддоо хүнсний ногоо хадгалах боломж үүсэх зорилтыг дэвшүүлсэн.

Үүнтэй холбоотойгоор УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд тодорхой хэмжээний хөнгөлөлттэй зээлийг аж ахуйн нэгжүүдэд олгож байгаа. Аж ахуйн нэгжүүд Засгийн газрын хүүгийн татаастай банкны зээлийн эх үүсвэрийг түшиглээд 2023 онд 29.4 мянган тонноор, 2024 онд 7.7 мянган тонноор өөрийн зорийг нэмэгдүүлж байгаа. Тэгэхээр уг тогтоолын тавьсан зорилт 50 орчим хувьтай биелээд явж байгаа.

Хүнсний ногооны хамгийн чухал асуудал бол хадгалалтын асуудал. Сүүлийн 2 жилийн хугацаанд томоохон аж ахуйн нэгжүүд банкны зээлийг түшиглээд зорины агуулахын бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа. Дээрээс нь хүнсний чиглэлээр масс үйлдвэрлэл эрхэлж байгаа томоохон аж ахуйн нэгжүүд өөрсдөө зорь агуулахынхаа хэмжээг нэмэгдүүлж байгаа гэдгийг Танд хэлье.

Х.Булгантуяа: - Мал эмнэлгийн ерөнхий газраас нэмж хариулъя.

А.Нарантуяа: - П.Батчимэг гишүүний асуултад Мал эмнэлгийн ерөнхий газраас мэдээлэл өгье.

Монгол Улсад худалдааны хорио цээрт гоц халдварт гол өвчнүүд ялангуяа эрсдэлт бүхий 4 өвчин байдаг. Үүнээс үхрийн арьс товруутах өвчин Дорнод аймагт гарч байсан, бог малын мялзан, Шүлхий өвчин, хонины цэцэг өвчин байна. Сая нэмээд 72 жилийн дараа ямааны годрон өвчин хилийн бүсээр орж ирсэн.

Тэгээд үүнтэй холбогдуулан мал эмнэлэг эрсдэлд суурилсан тархвар зүйн шинжлэх ухаан дээр тулгуурлаж тодорхой бүс нутагт бүх малд биш, тодорхой хувьд вакцинжуулалт, дархлаажуулалтыг явуулдаг. Өнөөдөр дархлаажуулалтын байдал цэцэг өвчний хувьд 97.4 хувь, бог малын мялзан өвчний дархлаажуулалт 95 хувьтай байна. Шүлхий өвчнийг 2 удаа буюу хаврын болон намрын дархлаажуулалт явуулдаг. Хаврын дархлаажуулалт 93 хувьтай, намрын дархлаажуулалт 2024 оны 11 сарын 14-өөс эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 35 хувийн дархлаажуулалт явагдаж байна.

Нөөцийн хувьд арьс товруутах өвчний вакцин 2.2 сая тун, бог малын мялзан өвчний вакцин 13 сая тун, шүлхий өвчний вакцин 9.8 сая тун, цэцэг өвчний вакцин 1 сая тунгийн нөөцтэй. Энэ вакциныг манай биобэлдмэлийн үйлдвэр өөрөө үйлдвэрлэдэг. Бусад 3 төрлийн вакциныг импортоор авдаг. Уул нь сая годрон өвчин гараагүй бол сүүлийн 2 жил Монгол Улс гоц халдварт өвчингүй тайван бүс нутаг гэсэн статустай байх байлаа. Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагад шүлхий өвчинтэй тэмцэх хяналтын хөтөлбөрөө илгээсэн.

Х.Булгантуяа: - П.Батчимэг гишүүн тодруулъя.

П.Батчимэг: - Сүүлийн үед гараад байгаа ямааны годрон, хонины цэцэг өвчин их түгээмэл болоод байна. Тэгэхээр шинэ төрлийн тархаж буй малын гоц халдварт өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх вакциныг ямар орноос нийлүүлж байгаа вэ? Жилдээ хэчнээн сая тун, хэдий хэмжээний төсвийг вакцинд зарцуулж байгаа вэ?

Х.Булгантуяа: - 2 номерын индрийн микрофон өгье.

А.Нарантуяа: - Мал эмнэлгийн ерөнхий газар УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, дархлаажуулалт, вакцинжуулалттай холбоотойгоор төсөв нэмэгдүүлсэн. Нийт төсвийн 20 тэрбумаар гаднын 3 вакциныг авдаг, 43 орчим тэрбум төгрөг нь тарилгын үйлчилгээний хөлсөнд явдаг. Малын гоц халдварт 4 гол өвчний 3 вакциныг Дэлхийн мал амьтны байгууллагын зөвлөмжийн дагуу олон улсын лавлагаа лабораториор баталгаажсан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын эрх бүхий вакцин үйлдвэрлэгч орноос авч байгаа.

Энэ жилийн тухайд Худалдан авах ажиллагааны хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан малын гоц халдварт өвчинтэй тэмцэх 3 вакциныг дундын зуучлагчгүйгээр тухайн эрх бүхий улсын үйлдвэрлэгчээс олон улсын тендерээр нийлүүлсэн. Үүний үр дүнд нийлүүлэгдэх вакцины хэмжээ нэмэгдсэн учраас... /минут дуусав./

Х.Булгантуяа: - Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: - Энэ тараасан мэдээлэлтэй нь холбоотой 2 асуулт байна. Хөдөө аж ахуйтай холбоотой, өвөлжилтийн бэлтгэлтэй гэхээсээ илүү танай оруулж ирж байгаа материалтай холбоотой, малжуулах хөтөлбөртэй, даатгалтай холбоотой асуулт байна.

Өнгөрсөн жил үнэхээрийн хүнд өвөл болсон, ялангуяа зүүн аймгуудад гамшиг болсон. Тэгээд малжуулсан арга хэмжээний хүрээнд нийтдээ 21 аймгийн 3419 өрхөд 27 тэрбум төгрөг зарцуулсан гэж байна. Үүнийг 100 хонин толгойд нь хуваагаад үзэхэд айлд 30 толгой, 30 бог мал ногдож байгаа. Гэтэл өнгөрсөн жил 8.1 сая толгой малаа алдчихсан. Хонин толгойд шилжүүлбэл 12 сая 700 мянган мал хоргодсон байна. Эдийн засгийн хохирол нь 2.4 их наядаар хэмжигдэхээр байсан. Энэ чиглэлээр төсөв мөнгө хэцүү байж болно, олон улсын төсөл, хөтөлбөрт хандаж малгүй болсон малчдаа малжуулах чиглэлээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хийж байгаа ажил байна уу? БОХХААБХ-ны хурал дээр би асуусан. Одоо зээлийнх нь үндсэн төлөлтийг хойшлуулсан ч гэсэн Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговийн зүүн талд малчид хуучин портер, Хятад мотоцикл хоёроос өөр төлөх юмгүй болсон. Тэгэхлээр малжуулах, цаашид банкных нь үндсэн зээлийн төлөлттэй холбоотой ямар бодлого Засгийн газраас баримталж байгаа юм бэ?

Хоёр дахь асуулт даатгалтай холбоотой. 21 аймгийн 21.4 мянган малчин 3.7 тэрбум төгрөгөөр малаа даатгуулсан байна. Нөхөн олговорт 4.1 тэрбум

төгрөгийг 2382 малчинд олгосон байна. Нэг малчин өрхөд ногдож байгаа нь дунджаар 1.7 сая төгрөг буюу 170 мянгаар тооцоход 10 хонь байх юм байна.

Тэгэхлээр зуд үеийн үед болно. Нөгөө талдаа хүн төрөлхтөн олон жилийнхээ хугацаанд эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ганцхан арга бодож олсон нь даатгал юм. Мал аж ахуйн салбарт эрсдэлээс сэргийлдэг, өөрөөр хэлбэл төрд ачаалал болохгүйгээр, малжуулах гэж ярихгүйгээр, даатгалын системийг нэвтрүүлэх ямар бодлого явж байгаа юм бэ?

Х.Булгантуяа: - Эхлээд Шадар сайд С.Амарсайхан хариулъя.

С.Амарсайхан: - Засгийн газрын тухай хуулиар Ерөнхий сайдыг Шадар сайд орлодог. Өвөлжилт, хаваржилтыг асуудлаар Шадар сайд шууд мэдээлэл хийх хуулиар хүлээсэн эрх, үүрэгтэй.

Хоёрдугаарт, өвөлжилт, хаваржилтын асуудлыг түрүүн ярьсан. Бүсчилсэн хөгжил, “Шинэ Хоршоо” хөдөлгөөн, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, дасан зохицох, байгалийн таашгүй гамшиг, эрсдэлийг даван туулах гэдэг бол зөвхөн нэг салбарын асуудал биш, нэг аймаг орон нутгийн ч асуудал биш. Энэ өөрөө байгаль орчин, эдийн засаг, дэд бүтэц, нийгмийн хэрэгцээ шаардлага, эрүүл мэнд, боловсрол гээд бүх салбарын оролцоог шаардсан цогц асуудал. Мэдээж өвлийг өнөөдөр яриад маргааш хавар нь мартдаг, намар нь санадаг байж болохгүй. Тэгж явсан ирсэн гашуун туршлагауд бий.

Засгийн газар “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Бүсчилсэн хөгжлийн бодлого” зэрэг бодлогын хүрээнд урт хугацаанд тогтвортой орчин, нөхцөлийг бүрдүүлэхийг зорьж байгаа. Ялангуяа үндэсний үржих баялаг болсон мал сүргийг өсгөж үржүүлэх, бэлчээрийн доройтол, түүний зохицуулалт, бэлчээр ашиглалт, нөхөн сэргээлт гээд олон асуудлуудтай уялдуулж шийдэх ёстой.

Энэ уур амьсгалын өөрчлөлт цаг уурын нөхцөл байдалтай холбоотой үүсэж байгаа хүндрэл, бэрхшээлийг зөвхөн өвс тэжээл өгснөө тоолдог, авснаа ярьдаг, ард нь тэр айлын амьдрал, эдийн засгийн чадавх, өрхийн орлого, хүүхдийн эрүүл мэнд, боловсрол гээд олон нийгмийн сөрөг үр дагавруудыг ерөөсөө орхичихсон явж ирсэн гашуун туршлагауд бий.

Харин сүүлийн жилүүдэд нийгмийн сөрөг үр дагаврыг тухайн цаг үеийн хохирол, ирээдүйд гарах эерэг, сөрөг үр дагавартай хамтад нь тооцдог эрсдэлийн үнэлгээг хийдэг болсон. Урьдчилж зудын үнэлгээг хийдэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авдаг болсон. Өнгөрсөн жил малжуулах хөтөлбөрийг эрчимтэй хэрэгжүүлэх, үүнийг аймаг, орон нутгийн түвшинд малчид орон нутгийн дундын зохицуулалтаар малын үржил шимийг дээшлүүлэх, тарга тэвээрэг нэмэгдүүлэх, стандарттай нийцсэн саравч, хашаа барих, өвс тэжээл бэлдэж авах зэрэг олон ажлуудад анхаарч зохион байгуулалтын хүрээнд “Шинэ Хоршоо” хөдөлгөөн өрнөсөн. Өнөөдөр 66,000 гишүүнтэй 6,500 гаруй хоршоод байгуулагдсан, 3,400 гаруйд нь хоршооны 14,000 гаруй гишүүд нийтдээ 517 тэрбум төгрөгийн хөрөнгө

оруулалт авч эхнээсээ өвс тэжээлээ базаагаад авчихсан. Дээрээс нь хашаа хороогоо янзлаад эхэлчихсэн.

Малынхаа үржил, селекцийг сайжруулах замаар хийж байгаа өөрчлөлтүүд нь хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг шинэ шатанд гаргах, эрсдэлийг бууруулах, эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх, эцэст нь хөдөө орон нутгийн айл өрхийн орлого нэмэгдэж, үндэсний баялгаасаа өөрсдөө өгөөжөө хүртдэг байх тогтолцоо шилжих юм.

Гэтэл нөгөө талдаа асар хүндрэлтэй нөхцөл байдлууд байна. Ажиллах хүчин дутагдаж байна. Цаг уурын өөрчлөлт өөрөө асар таашгүй нөхцөл байдлыг бий болгож байгаа. Манай малчид хөдөө орон нутагт, алс хязгаар нутагтаа эзэн нь болж эх орон, ард түмнийхээ өмнөөс газар нутгаа харж байгаа. Өөрийгөө болон бусдыг ажлын байраар хангаж байгаа, нийт хүн амын хүнсний хэрэгцээний бараг 80 хувийг хангаж байгаа хүмүүс.

Тэгэхээр эдгээр хүмүүсийн бэлчээрийн асуудал, нийгмийн асуудлыг хэрхэн шийдэх цогц бодлогыг салбар бүрийн оролцоотой Засгийн газрын мөрийн хөтөлбөрт үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг дээшлүүлэх стратегийг тусгаж, хэрэгжүүлж бүх шатад дорвитой өөрчлөлт хийхээр төлөвлөж байгаа. Бүх зүйл сайхан болчихсон зүйл байхгүй. Манай гишүүдийн хэлж байгаа анхаарах асуудлууд их бий. Ингээд өнгөцхөн харахад өвс тэжээл яриад байгаа юм шиг мөртлөө яг цагаа тулахад ярихаас өөр аргагүй нөхцөлд манай малчид, иргэд маань өв соёл, үнэт зүйлээ тээж тэнд өвлийн хүйтэн, хөр цас, хаврын шуурга, намрын.../минут дуусав./

Х.Булгантуяа: - Даатгалын тогтолцоо холбоотой асуултад Шадар сайд нэмж хариулъя.

С.Амарсайхан: - Эрсдэлийн даатгалын сан гэж бий. Даатгалын тогтолцоог сайжруулахгүйгээр хохирлыг барагдуулах, эрсдэлийг бууруулах гэдэг асуудал байхгүй. Тэгэхээр даатгалын тогтолцоонд өөрчлөлт оруулах хэрэгтэй. Индексжүүлсэн даатгал гэж хөдөө орон нутагт малчид, ялангуяа банк, санхүүгийн байгууллагаас зээл авахдаа хүртэл нэг хэсэг нь хамрагддаг, нэг хэсэг нь хамрагддаггүй.

Тэгэхээр “Шинэ Хоршоо” хэрэгжүүлэх хүрээнд нэгдүгээрт даатгалын тогтолцоонд хүн бүр оръё. Дээрээс нь хөдөө аж ахуй, мал аж ахуй бизнес эрхлэгчид аж ахуйн үйл ажиллагаагаа даатгадаг болъё. Эцэстээ төр нь ч эрсдэлгүй, аж ахуйн нэгж нь ч эрсдэлгүй, малчин ч хохиролгүй байх боломж нөхцөлийг хангах тогтолцоог бүрдүүлэхээр даатгалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах судалгаанууд хийгдээд явж байгаа. Энэ талаар удахгүй Засгийн газрын хуралдаанаар танилцуулж, УИХ-д хуулийг өргөн барих, улмаар гишүүдэд мэдээлэл хүргэгдэх байх. Та бүхэн маань энэ дээр .../минут дуусав./

Х.Булгантуяа: - Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн асуулт асууя.

С.Цэнгүүн: - Оройн мэнд хүргэе. Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл дунд эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажил 94 хувьтай гээд сая бүх гишүүдийн өмнө, ард түмний өмнө ингээд уншаад танилцуулж байна. Үндсэндээ Эрчим хүчний үндэсний хороо дээр танилцуулагдаж байгаа мэдээлэл дээр ч бодит байдлаа хараад үзэхээр 94 хувийн бэлтгэл ажил хангаж чадаагүй. Яагаад ингэж 94 хувьтай байна, эрчим хүчний салбарт ямар ч асуудал байхгүй, байхгүй юм шигээр ийм тоо тавьж байгаа юм бэ? Ер нь энэ танилцуулгад яамнууд тоонуудаа танилцуулахдаа Монгол Улсад ямар ч асуудал байхгүй, яамнууд бүх ажлаа хийж чадаж байгаа юм шиг танилцуулдаг.

Гэхдээ бодит нөхцөл байдал дээр тэнд хүний амь нас эрсдэж байдаг, тог тасарч байдаг энэ асуудлууд нь байсаар л байгаа. Ер нь зүгээр энэ тоогоо яаж гаргаж ирж тавьж байгаа гэдгээ хармаар байна.

Дээрээс нь худлаа мэдээлэл тавьчихаад энэ дээрээ хариуцлага хүлээдэг байхгүй бол ингээд хуурамч тоонууд сонссон болоод тэгээд 94 хувийн өвөлжилтийн бэлтгэл ажил сайн хийгдсэн талаар Ерөнхий сайдын мэдээлэлд орсон тул асуудалгүй энэ өвлийг давж чадах юм байна гэсэн ойлголтыг ард иргэддээ өгөх гээд сууж байна. Бид нар бодит байдлаа мэдэж байгаа. Эрчим хүчний үндэсний хороо байгуулагдаад реформын ажил хийнэ гэж зарласан. Хэдхэн долоо хоногийн дотор шийдэгдчих асуудал биш, 30 жил шийдэгдээгүй асуудал учраас маш их цаг хугацаа орно.

Бодитойгоор асуудлаа гаргаж ирж тавьдаг баймаар байна. Эрчим хүчний яамны мэргэжилтнүүд, ажилтнууд бүгдээрээ салбарынхаа асуудлуудыг бодитоор харуулж, ярьж, дээрээс нь Ерөнхий сайдад бодит мэдээлэл өгмөөр байна. Яагаад ийм худлаа мэдээлэл өгч байгаа юм бэ гэдгийг асуумаар байна та бүхнээс?

Х.Булгантуяа: - Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн.

Б.Чойжилсүрэн: - С.Цэнгүүн гишүүний асуултад хариулья.

Нэг талаас шударга шүүмжлэл мөн. Гэхдээ дандаа хүнд юм яриад, хүндрэл яриад байх юм бол бүр хүнд байдалд орох юм. Тийм учраас 2024 оны зорилтот түвшнийг батлахдаа тодорхой байгаа орлогынхоо хэмжээнд хэд хэдэн ажлуудыг хийнэ гэдгээ эрэмбэлээд, түүний гүйцэтгэлийг шалгаад үзэхээр 94 хувьтай гарч ирж байгаа. Түүнээс биш яг том утгаараа таны яриад байгаа эрчим хүчний салбарт асуудал их байна, зовлон их байна. Эрчим хүчний салбарын 20-иод мянган албан хаагчид бол байгаа нөөц боломждоо бүх боломжоо шавхаад ажиллаж байгаа.

Улсын Их Хурлын гишүүдэд нэг зүйлд талархал илэрхийлье. 2024 оны улсын төсвийн тодотголоор 131 тэрбум төгрөгийн татаасыг эрчим хүчний сайдын багц дээр нэмэгдүүлж баталж өгсөн. Үүний хүчинд энэ өвөл хуучирсан тоноглолуудаа засаад, зогсоочихгүй аваад гарах бэлтгэл хангасан гэж ойлгож болно. Огт шалгуур үзүүлэлтгүй болчихвол асуудал бүүр хүндэрчих

учраас байгаа боломждоо тохируулаад өвөлжилтийн бэлтгэл ажил 2024 оны зорилтот түвшнээ батлаад, үүнийхээ биелэлтийг хянаад, гүйцэтгэх захирлууд ТУЗ-уудтай нь үр дүнг нь тооцоод явж байгаа.

Х.Булгантуяа: - Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд асуулт асууя.

С.Эрдэнэболд: - Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл гэдэг нэг талаас өвөл хот дулаахан байх, нөгөө талаас малчид маань өнөтэй өвөлжих, өвлийг эсэн мэнд давах гэдгээс гадна үндэсний аюулгүй байдлын том шалгуур байгаа.

Өчигдөр Шадар сайдтай хамт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр Дархан-Уул аймагт бүсийн чуулганы үеэр очсон. Тэндээс авсан мэдээллээр өнгөрсөн жил 8.1 сая мал хорогдсон. Эдийн засгийн үнэлгээгээр ойролцоогоор 1 тэрбум ам.доллар буюу 3.4-5 их наяд төгрөгийн хохирол Монгол Улсад учирсан байна.

Гэхдээ иргэдийн хөрөнгө гэсэн үг. Тэнд нэг зүйл ажиглагдсан нь ноднин, уржнан Ц.Туваан сайдтай хамт Төв аймгийн, төвийн бүсийн сумдаар яг зудын үеэр их явсан. Тэгэхэд шатахуун тасалчихсан. Том чиргүүлтэй өвс ачсан машинууд шатахуун тасарчихсан учраас өвөлжилтийн бэлтгэл тэр чигтээ тасарчихсан. Өвс, тосоо базааж чадаагүй.

Энэ бол зудын хохирол, бэлэн байдал хангагдахгүй байхад ноцтой цохилт өгсөн гэж үзэж болно. Тэр 8.1 сая малын үлэмж хувьд нь шатахууны тасалдал нөлөөлсөн гэж ойлгож байгаа. Тэгэхээр иргэдийн хувьд бол хамгийн их асуухыг хүсэж байгаа зүйл бол энэ өвөл дахиад ноднингийнх шиг бензин, шатахуун, түлш тасарчихгүй биз дээ? Энэ дээр Засгийн газар нөөцийн ямар бодлого барьж байна вэ? Өнөөдрийн байдлаар нөөц ямар байна вэ? Өвөл хүндрээд цагийн байдал хатуурахад энэ асуудал дээр Засгийн газар найдвартай байдлыг авч гарч чадах уу? Өчигдрийн байдлаар мэдээлэл авахад энэ өвөл дахиад хүйтэн болно гэсэн судалгаа байна.

Тэгэхээр уржнан жилийн өвөл чанга байсан, ноднин жилийн өвөл 11 дүгээр сард манай Төв аймгийн Эрдэнэсант сумд шуурганд уруудаад 7 хүн амь нас алдсан. Ноднин жил иргэдийн амь нас алдсан. Энэ жил шатахуунтай холбоотой асуудлууд дээр та бүхэн иргэдэд мэдээлэл хийж өгөөч.

Хоёрдугаарт нь ноднингийн 8.1 сая мал тэрбум ам.долларын үнэлгээтэй хохирлыг малчид авчихсан байна. Энэ жил цагийн байдал хүндэрлээ гэхэд үүнийг бодитоор бууруулах ямар эрсдэлийн менежментийг Засгийн газраас барьж байгаа вэ гэсэн 2 асуултыг асууя.

Х.Булгантуяа: - Шадар сайд С.Амарсайхан хариулах уу?

С.Амарсайхан: - Өнгөрсөн жил бензин шатахуунтай холбоотой асуудал бүх салбарт байсан, бүгдээрээ мэдэж байгаа. Үүнээс шалтгаалж тодорхой ажил, амьдралд учирсан хохирол, эрсдэлүүд байсан гэдгийг үгүйсгэхгүй.

Гэхдээ салбарын мэргэжилтэн, боловсон хүчнүүдийн судалгаагаар өнгөрсөн жилийн өвөл сүүлийн 40, 50 жилд тохиолдоогүй хүйтэн болсон тухай дүгнэлт гарсан.

2021 оноос хойш Шадар сайдын тушаалаар өвлийн зудын эрсдэлийн үнэлгээг хийдэг болсноос хойш жил бүхэн эрсдэлийн үнэлгээ дээр тулгуурлаж урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд авч хэрэгжүүлдэг. Өнгөрсөн жилийн зудын эрсдэлийн үнэлгээгээр энэ өвлийн хүндрэлээс болж 10 дугаар сарын сүүлээр нийтдээ 26 сая толгой мал хоргодох эрсдэлтэй гэсэн судалгааны дүн гарсан. Үүний мөрөөр урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, малчид, иргэддээ уриалж нэгдүгээрт махыг хэрэгцээлэх буюу зах зээлийн эргэлтэд оруулах.

Хоёрдугаарт, өвс тэжээл бэлтгэл ажлаа сайтар хангах.

Гуравдугаарт, аливаа гарч болзошгүй эрсдэлээс амь нас, эрүүл мэндээ хамгаалж явах гэдэг арга хэмжээг хэрэгжүүлж олон улсын байгууллагууд, Засгийн газар ч үе шаттай арга хэмжээ авч, түүний нэг нь энэ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн хохирлыг багасгах хууль тогтоомжийг хүртэл гаргаад ажилласны үр дүнд хохирол 2 - 3 дахин буурч чадсан.

Гэхдээ 8.4 сая толгой мал сүрэг гэдэг бол асар өндөр тоо. Тэгэхээр энийг дахиж давтаж гаргахгүй байх боломж нөхцөлийг иргэн, аж ахуйн нэгжүүд, малчид, орон нутгийн удирдлагууд, Засгийн газрын харьяа байгууллагууд бүгдээрээ хамтарч ажиллаж үүнийг бууруулна. Үүний тулд өнөөдөр хүртэл Шадар сайдын удирдамж, зааврын дагуу аймаг, орон нутагт шуурхай бүлгүүд гарч, өвөлжилтийн нөхцөл байдлыг газар дээр нь дүгнэх, малчид, иргэдэд зөвлөгөө өгөх, урьдчилан сэргийлэх, бодлого, санаагаа хуваалцах, анхаарах асуудлууд байвал газар дээр нь шийдвэрлэх, нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд асуудлыг нэгтгэж, Улсын Их Хурал, Засгийн газраар хэлэлцүүлэх хүртэл төлөвлөгөөтэй ажиллаж байгаа.

Энэ салбарт бензин шатахуунаас эхлээд нүүрс, түлээ түлш, дулаан цахилгааны станцуудыг хэвийн ажиллуулахтай холбоотой, зам тээврийн салбар, дэд бүтцийн бусад салбарын үйл ажиллагаанууд гээд орхигдож, хаягдах зүйл байдаггүй учраас бүх салбарын оролцоо чухал.

Эрдэс баялаг, аж үйлдвэрийн яамныхантай ярьж аж ахуйн нэгжүүдтэйгээ хамтарч бензин шатахууныхаа нөөцийг урьдчилж сайтар бүрдүүлэх, аймаг орон нутаг, сум багийн түвшинд хомсдол үүсгэхгүй байхтай холбоотой зохицуулалт зохион байгуулалтын ажлууд УОК-ын шуурхай штаб дээр мөн яамдын холбогдох албан тушаалтнуудтай хийгдээд явж байгаа. Энэ хүрээнд тодорхой шаардлагуудыг тавьж байгаа. Аж ахуйн нэгжүүдтэйгээ нөөцийг сайтар бүрдүүлэх тал дээр хамтран ажиллаж байна. Зам хаагддаг, автомашин явдаггүй, очих гэж байна гэсээр байтал нөөц нь дуусдаг. Ингээд энэ хооронд хүний амь нас, эрүүл мэндээр хохирох асуудал гардаг учраас үүнийг анхаарч ажиллах хэрэгтэй байгаа.

Энэ өвлийн нөхцөл байдал цаашаа зөвхөн өвөл, хавар гэлтгүйгээр цаг уурын өөрчлөлт асар хурдацтай явагдаж байгаа нь өдөр тутам бидний амьдрал

дээр бодитойгоор нүүрлэж байгаа нь эрсдэлүүдээс харагдаж байгаа. 2030 он гэхэд өнөөдрийн нөхцөл байдал 40 хувиар, цаг уурын аюулт үзэгдлүүд 3 дахин нэмэгдэнэ гэж байгаа. Тэгэхээр цорын ганц арга бол бэлэн байдлыг хангах, бэлтгэл ажлыг сайтар хийх.

Өвөлжилтийн бэлтгэл ажил гэдэг бол эрчим хүчний салбар дээр ярьсан асуудал, одоо байгаа эх үүсвэр, тоног төхөөрөмж, шугам сүлжээний найдвартай байдлыг хангахтай холбоотой бэлтгэл ажлын тухай ярьж байгаа.

Нөгөө талдаа мэдээж хүрэлцээ шаардлага хангахгүй байгаа эрэлт, хангалт нийлүүлэлттэй холбоотой бодлого, хууль, эрх зүйн орчны өөрчлөлт шинэчлэлт, үнэ тарифын асуудал, зах зээлийн зарчмаар нь явуулах, тасалдалгүй, тогтвортой, найдвартай эх үүсвэрийг бий болгож салбарын хөгжлийг дэмжих эрчим хүчний, эдийн засгийн хөгжил, эрчим хүчний салбарын шинэчлэлттэй холбоотой олон асуудлууд байгаа. Тэгэхдээ өнөөдрийн асуудал бол байгаа нөөц бололцоо дээрээ гал алдахгүй, тасалдуулахгүй, дээрээс нь салбарын онцлогт... /минут дуусав./

Х.Булгантуяа: - Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл асуултаа асууя.

О.Цогтгэрэл: - Өвөлжилтийн бэлтгэл гээд нэг сонсохоор ажил хэрэгч ч юм шиг. Нөгөө талаасаа Монгол нутаг мянга мянган жил дөрвөн улиралтай л байсан. Өвөл болохлоор хүйтэн болдог гэдэг шиг байдаг л зүйл байх нөгөө талаас.

Тэгээд өвөлжилтийн бэлтгэлийн тухай ярихаар өвс тэжээл, баахан статистикийн тоонууд. Яг үнэндээ энэ өвөлжилтийн бэлтгэл гэдэг зүйл тухайн салбарын дотоод чадвар, чадавх, дархлааг нь хэр бэхжүүлсэн бэ, дархлаа нь ямар түвшинд очив гэдэг зүйлийн тухай уг нь яривал хамгийн зүй зохистой байх. Гэтэл өнөөдрийн сэдэв танилцуулагдаж байгаа зүйлс бол үнэхээр өрөвдөлтэй байна.

Хүнээр бол бодит биеийн дархлаа нь ер нь ямар байгаа юм, ханиад, томуу тусахад эрдэс витаминаа авч байгаа юм уу, агаар салхиндаа гарч байгаа юм уу тэр хүүхэд гэдэгтэй адилхан. Гэтэл бид нарын хувьд хүүхэд нь шалдан, нүцгэн гүйчихсэн, эрдэс витаминаа авдаггүй, тэгээд их нэг л баахан өвчин, зовлон ярьсан ийм айл шиг л зүйл жил жилд ярьж байдаг.

Тэгэхлээр хөдөө аж ахуйн салбарын дархлаа өнөөдөр ямар байна вэ гэвэл хэцүүхэн л тоо гарна. Улсын дунджаас хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа хүний олж байгаа орлого 2-3 дахин бага, орлоготой салбаруудынхаас 5 дахин бага орлоготой. Хөдөө аж ахуйн салбарын олж байгаа зүйл, үнэндээ ахуй амьдрал, олж байгаа зүйл, орлого, ашиг, найдвартай өрсөлдөх чадвар, технологи дээр ямар ч өөрчлөлт, хөгжил дэвшил байхгүй байна.

Энэ өвөлжилтийн цаана эрсдэл гэдэг зүйлийг яриад байх шиг байгаа юм. Эрсдэл гэдэг зүйл чинь уг нь зүй зохистой улс оронд бизнес юм гэнэ лээ.

Хаа ч эрсдэл байна. Эрсдэлийг шийддэг арга замыг нь даатгалын тогтолцоо гэдэг. Үүгээрээ бизнес хийгээд харилцан ашигтай ажиллачихдаг эдийн засгийн механизмууд, арга замууд бүрэн дүүрэн байх тухай л яриа энэний цаана байдаг байх.

Тэгэхлээр зүй зохистой дархлааны систем болон эрсдэлийн системийг ажиллахад өнгөрсөн хугацаанд юу хийсэн бэ, юу хийх гэж байгаа вэ гэдэг бодлогын том шилжилт рүү орж байж энэ өвөлжилтийн ярианаас гарцгаах ёстой байх. Яг одоо энэ тайлан дээр байгаагаар мал аж ахуйн салбарт сая өнгөрсөн хавар.../минут дуусав./

Х.Булгантуяа: - Шадар сайд С.Амарсайхан хариулъя.

С.Амарсайхан: - О.Цогтгэрэл гишүүний тайлбарт тодорхой хариулт өгье.

Өвөлжилтийн асуудлыг танилцуул гэсэн учраас ярьж байгаа. Тэгээд өвөлжилтийн асуудал бидний амьдралаас хэзээ ч салахгүй байсаар байна. Өвөл хэзээ алга болно тэр цагт ярихгүй байж магадгүй байх.

Энэ цаг уурын нөхцөл байдал, амьдралын хувь заяаны эрхээр учирсан энэ дөрвөн улиралтайгаа бид зохицож амьдрах, дасан зохицох, дээрээс нь даван туулах ард иргэд, өвөг дээдсийн хэлдэг шиг урьдчилж мэдээд, тосож бэлдээд, тэсэж гаргадаг цаг үед нөхцөл байдлаа сайн тооцохоос өөр аргагүй байдал, өөрөөр хэлбэл хүний хүчин зүйлээс үл хамаарсан байгалийн давагдашгүй хүчин зүйлүүд биднийг сорьж байна. Энэ сорилтод унаж болохгүй.

Таны хэлж байгаа зүйлүүдийг маш сайн ойлгож байна. Мэдээж анхаарах асуудлууд бий, салбарын хэмжээнд дорой байгаа зүйлүүд бий, өөрчлөлт шинэчлэлт хийх шаардлага бий. Энэ бодлого шийдвэрийг гаргах процессыг гүйцэтгэдэг, хянадаг, зохион байгуулдаг нөхдүүд хүртэл анхаарах асуудлууд бий. Уламжлалт сэтгэлгээнээсээ салах ёстой.

Гэхдээ уламжлалт түүх, үнэт зүйл болох оршин тогтнохуйн суурь болсон мал аж ахуйн салбараа үгүйсгэж болохгүй. Үүний цаана малчид гэдэг Монголын асар том амьд өв сан, үнэт зүйл, үнэ цэн бий.

Тийм учраас хүссэн, хүсээгүй хүндрэлтэй үед нь Засгийн газар, Монгол төр тусламжийн гараа сунгаж хамтарч ажиллаж байгаа. Жил бүрийн өвөлжилтийн бэлтгэл ажилд ярьдаг шалтгаан нь тухайн салбартай наад захын засвар, шинэчлэл, нөөц бүрдүүлэлтийг анхаарах асуудлууд байдаг юм.

Засгийн газар өвөлжилт, хаваржилтын асуудлыг урьдчилан сэргийлэх стратеги болгон цогцоор нь шийдвэрлэж хөгжүүлэх тал дээр анхаарч ажиллаж байгаа олон бодлогыг гаргаад явж байгаа. Өчигдөр Дарханд очихдоо “Шинэ Хоршоо” хөдөлгөөний 18 гишүүнтэй уулзахад бүгдээрээ зээл, тусламжаа авчихсан, өвс тэжээлээ базаачихсан, энэ өвлийг өнөтэй давна гэсэн. Жишээ нь Дархан-Уул аймгийн 18 хоршоологчид өөрсдийнх нь асуудлын шийдсэн ажил

хэрэгч, бүтээлч байх боломжийг бүрдүүлсэн хөтөлбөр болж байгаа гэдгээ хэлээд байж байхад бид тэрийг үгүйсгэх боломж байхгүй. Үр дүнгээ өгч байна гэж үзэж байгаа. Гэхдээ энэ үр дүнг тодорхойлоход эрт байгаа.

Өвөлжилтийн бэлтгэл, санхүүжилтийн асуудлууд Улсын Их Хурал, Засгийн газраас төсөв, хөтөлбөртэй холбоотой асуудлууд ч хүртэл байж байгаа. Цаашдаа урт хугацааны стратеги бодлого төлөвлөлт жишээ нь, энэ малын асуудлууд, мал, хөдөө аж ахуй газар тариалангийн асуудлуудаа яах юм, үр дүнг нь яаж тооцох юм? Энэ малчдынхаа амьдрал ахуйтай холбоотой асуудал ялангуяа эдийн засгийн гол тулгуур салбар болсон хөдөө аж ахуйн салбарын бодлого шийдвэрээ цогцоор нь ямар хэмжээнд илүү оновчтой бөгөөд зүй зохистой төлөвлөж авч явах юм бэ гэдэг талаар Улсын Их Хурлын дээр дахиж нээлттэй ярилцах, хэлэлцэх асуудлууд нээлттэй гэж бодож байгаа.

Х.Булгантуяа: - О.Цогтгэрэл гишүүн тодруулъя.

О.Цогтгэрэл: - Би бараг 5 дахь жилдээ өвөлжилтийн бэлтгэл гээд нэг форматын цаасыг уншиж байна. Хамгийн гол нь эрсдэлээс хамгаалах шалгарсан арга, механизмуудыг оруулах, төр хамгаална гэхээс урьдаар систем өөрийгөө хамгаалдаг болгох бодлогын өөрчлөлтүүд алга байна. Өвөл болохоор хүйтэн болдог гэдэг шиг байгалийн нөхцөл байдал, нэгэнт ирэх цаг хугацааны зүйлийг яагаад урьдчилан тооцон шийдэл гаргахгүй байна вэ? Яагаад энэ олон жилд өөрчлөлт гардаггүй юм бэ? Ингээд 10 жил, 100 жилээр энийгээ яриад сууж байх уу? Би энийг буруу л гэж бодож байна.

Х.Булгантуяа: - Өвөлжилтийг ярихгүй бол болохгүй. Үнэхээр хүнд өвөлтэй нь үнэн. Өнөөдрийн мэдээлэлд өвөлжилтийн бэлтгэл 80, 90 хувьтай хангасан гэж дурдсан нь өнөтэй сайхан өвөл болох юм шиг мэдээлэл тавьсанд зарим гишүүд шүүмжлэлтэй хандаж байна.

М.Нарантуяа-Нара гишүүн асуулт асууя.

М.Нарантуяа-Нара: - Монгол Улс дөрвөн улиралтай байна гэдэг бурхны бэлэг юм уу. Өвөл угаасаа хүнд хэцүү болдог. Сүүлийн үед ялангуяа дэлхийн цаг уурын өөрчлөлт, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор өвөл, зун нь ямар байх нь тодорхойгүй байдлууд үүсдэг болсноос шалтгаалаад өвөлжилтийн бэлтгэлийг онцгой хангах нь зүйтэй.

Ялангуяа Улаанбаатарын өвлийн асуудлын талаар зайлшгүй ярихгүй бол болохгүй. Энэ утааны асуудал. Иргэд өвлийн хүйтэнд жагсаад байна гээд шүүмжилж байгаа.

Гэвч яг үнэндээ иргэд бодит зовлон бэрхшээлтэй тулаад ирэхээр эсэргүүцэж байгаа. Аргагүй олон жил утааны эсрэг арга хэмжээ гээд зохиомол жагсаалын золиос болсон иргэд одоо бүүр уур уцаартай болох нь аргагүй. Одоо утаатай холбоотой асуудлын хүрээнд утааны хор хохирлыг эрүүл мэндийн байгууллагууд, эмнэлгийн байгууллагууд, судалгааны байгууллагууд үнэлээд

хүний эрүүл мэнд, амь насанд ямар хор хөнөөлтэй байна гэдгийг тодорхойлж байна. Тухайлбал, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс утааны асуудал, түлшний хор нь эрүүл мэндэд, ургийн жинд хэрхэн нөлөөлж байгааг судалсан байна.

Өөрөөр хэлбэл, утаанаас болоод эхийн хэвлийд бойжиж байгаа ураг хүртэл мэндлэхдээ жингийн дутагдалд орчихсон байгаа тухай мэдээлж байна.

Дээрээс нь аутизм гэдэг зүйл 2014 онд 30 бүртгэл байсан бол 2023 онд 1700 гартлаа бүртгэлтэй байгаа нь утаанаас үүдэлтэй гээд эрүүл мэндийн шат дараалсан байгууллагын судалгааны байгууллагууд хэлээд байна.

Энэ утаан дээр ямар асуудал, ямар ажлыг гол чиглэлээ болгох юм бэ? Түлшнийхээ чанар стандартыг үнэхээр хангаж, шалгаж, нягталж чадаж байгаа юм уу? Урд хөршөөс зарим нэгэн бодисыг илүү хямд үнээр нийлүүлж байгаа гэсэн иргэдийн яриа яваад байна. Энэ нь хэр үнэний ортой юм бэ? Үнэхээр дотооддоо үйлдвэрлэсэн, дотооддоо олборлосон, дотооддоо бий болгож байгаа нүүрсээ түлж чадаад байна уу? Үгүй бол гаднаас илүү хямд өртөг, үнийн дүнтэй нүүрс худалдаж авч оруулж ирээд байгаа юм уу? гэдгийг яримаар байна.

Нийслэл Улаанбаатарын хувьд халтиргаа гулгаанд бэлдсэн юм уу? Тэгээд ажилчид нь улаан гараараа бээлий өмсөөд давсаа цацаад явдаг байдал энэ жилд ямар түвшинд явагдах юм бэ? Халтиргаа гулгаанаас үүдэлтэй эрүүл мэнд, амь насны хохирол, эд хөрөнгийн хохирлыг барагдуулах ажил байдаг уу? Хүүхдийн өвчлөл нэмэгдэнэ. Хүүхдийн өвчлөлийг бууруулахад чиглэсэн ажлын бэлтгэл хэрхэн хангасан бэ эрүүл мэндийн салбар.../минут дуусав./

Х.Булгантуяа: - Эхлээд Эрчим хүчний яамнаас хариулах уу, Нийслэлээс хариулах уу? Нийслэлээс Засаг даргын орлогч Т.Даваадалай түлшний чанар, гулгаа, халтиргаа гээд хэд хэдэн асуудал, дараа нь Эрүүл мэндийн яам хариулахад бэлдэж байгаарай.

Т.Даваадалай: - М.Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя.

Утааны асуудлыг сууриар нь шийдэх олон улсын жишиг нь орон сууцжуулалт байна. Энэ асуудлын хүрээнд 20 минутын хотыг байгуулахаар орон сууцжуулах хөтөлбөрүүдийг яаралтай холбогдох материалуудыг бэлдээд энэ өвөлд 12 мянган айлын орон сууц дээр төсөл, хөтөлбөрөө зарлаад явна.

Орон сууцжуулалттай холбогдолтойгоор суурь дэд бүтцүүд болох дулаан, цахилгааны эх үүсвэрүүдийг шинээр хийх хүрээнд Эрчим хүчний яам болон бусад яамнуудтай хамтраад судалгаа хийж байна.

Улаанбаатар хотыг орон сууцжуулъя, суурь дэд бүтцүүд, инженерийн хангамжуудаа сайжруулъя гэдэг үндсэн шийдэлд бодлогоо чиглүүлж байгаа. Богино болон дунд хугацаанд түлшийг хийн түлшээр орлуулах агаарын бохирдлыг дунд, богино хугацаанд бууруулах суурь судалгаануудыг хийж байна.

Тавантолгой түлшний газрын дарга удирдлагууд түлшний найрлага, чанар дээр тодорхой мэдээлэл өгөх байх. Тавантолгой түлш дээр урт хугацаанд Улаанбаатар хотын асуудлыг шийдэж байгаа учраас Тавантолгой түлшний үйлдвэрлэлийг цаашид жил бүр үе шаттайгаар бууруулах, агаарны бохирдолгүй болъё, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг суурь дэд бүтцээр үндсээр нь шийдье гэдэг цогц бодлогод Нийслэлийн удирдлагууд чиглэл болгон ажиллаж байна.

Ажлын хэсгийн удирдлагаас Тавантолгой түлшний чанар, түвшин дээр мэдээлэл өгье. Харин гулгаа болон энэ өвлийн бэлтгэл ажлын талаар Нийслэлийн Засаг даргын Захирагчийн алба, хотын инженерийн дэд бүтцийн албаны дарга М.Балдандорж даргаас тодорхой хариулт өгнө.

Х.Булгантуяа: - Тавантолгой түлш компанийн удирдлагаас хариулт авъя.

А.Батзориг: - Сайн байцгаана уу? М.Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя. Тавантолгой түлш компанийн Санхүү, эдийн засгийн газрын дарга А.Батзориг байна.

Сайжруулсан шахмал түлш хэрэглээд бид 6 жил болж байна. Манай түлш бол нүүрсэн шахмал түлш байгаа. Тавантолгойн ордын баяжуулсан нүүрс нь шахмал түлшний үндсэн түүхий эд болж байгаа. Тэгэхээр Багануурын нүүрс, Тавантолгойн нүүрсийг шахмал түлшний үндсэн түүхий эд болгож хэрэглэж байгаа гэсэн үг.

Тийм учраас нүүрсэнд угаарын хий болон бусад элементүүд мөн Тавантолгойгоос татаж авчирч ирж байгаа мидлинг агуулагдаж байгаа. 6 жилийн хугацаанд угаарын хийг мэдрэгчийг айл бүрд тавьж байна, айл өрхүүдэд угаарын хийгээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл судалгаа түгээж байна, айл өрхийн янданг хөөлөх олон арга хэлбэрийг танилцуулж байна.

Шахмал түлшний чанарын тухайд бол стандартын түвшинд үйл ажиллагааг явуулж байгаа. Нийт бүтээгдэхүүний 5 хувьд нь барьцуулагч ордог. Барьцуулагч гэдэг нь 50-60 хувийн байгалийн буюу ургамлын цардуул, тухайлбал, эрдэнэшишийн цардуул байдаг. Үлдсэн 40 хувьд нь байгалийн бентонит, шохойн чулуу, доломит болон каулин гэсэн шаварлаг бодисууд, байгалийн бүтээгдэхүүнүүд байдаг. Барьцалдуулагчийн орц нь ийм найрлагатай байгаа.

MNS 2022-5679 стандартын дагуу түлшээ үйлдвэрлээд явж байгаа. 2019 онд ямар стандарттай бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан өнөөдөр мөн энэ стандартын дагуу үйлдвэрлээд явж байгаа.

Шахмал түлшний хяналтад олон байгууллага, газрууд оролцдог. Олон улсын болон дотоодын аж ахуйн нэгжийн лабораториуд байнгын хяналт тавьдаг.

Х.Булгантуяа: - Халтиргаа гулгаатай холбоотой асуулт. Улаанбаатар хотын захирагчийн ажлын албан инженерийн дэд бүтцийн газрын дарга М.Балдандорж хариулт өгье.

М.Балдандорж: - Хот нийтийн аж ахуй, ялангуяа цэвэрлэгээ, үйлчилгээ, нийтийн эзэмшлийн зам талбайн халтиргаа, гулгаатай холбоотой асуудал олон нийтийн бухимдал дагуулж байгаа. Дан ганц цэвэрлэгээ, үйлчилгээнд анхаарахаас гадна энэ салбарын тогтолцоо, чадавхид анхаарахгүй бол болохгүй байгаа. Улаанбаатар хотын хэмжээнд 16.70 сая м² зам талбай, 1000 гаран километр явган замыг хот нийтийн аж ахуйн болон хувийн хэвшлийн байгууллагууд цэвэрлэгээ, үйлчилгээг нь хариуцаж байна. Нийтдээ 35 байгууллага, 2000 орчим зам талбайн үйлчлэгч нар ажиллаж байгаа.

Өнөөдрийн тулгамдаж буй асуудал бол үндсэн зам талбайдаа хүрч байна уу, хүртээмжийн асуудлыг шийдэж байна уу, давс бодисын нөөцийг бэлдсэнээр энэ асуудал шийдэгдэж байна уу гээд олон асуудал байгаа. Салбарын хэмжээнд үндсэн 2000 хүний ажиллах нөхцөл, боломжийг сайжруулах, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх хүрээнд 2024 онд 110 орчим техник хэрэгсэл, зам талбайн, явган зам дээр ажиллах 80 орчим үлээдэг гар багаж, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн.

Засгийн газрын 340 дүгээр тогтоолоор Улаанбаатарт хотын гол болон төв замын 60 орчим хувийг орон нутгийн өмчит, нийслэлийн өмчит байгууллага хийдэг байсан бол үүнийг хувийн хэвшлийн байгууллагуудаар хийлгэх, замын 80 орчим хувийг нь хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхээр шилжүүлэх ажлыг зохион байгуулаад байна.

Хамгийн гол нь цэвэрлэгээ, үйлчилгээг сайжруулах ажил олон салбар дээр тулгарч байгаа. Нэг давхрын үйлчилгээний аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн үйлчилгээний газраас 50 метр орчмын талбайг цэвэрлүүлэх, СӨХ нь байрны гаднах зам талбайг нь цэвэрлүүлж хэвшүүлэх ажлын хүрээнд хариуцлагын асуудлууд гарч байгаа байна.

Энэ жилийн давс, бодисын нөөцийн хувьд 6,572 тонн давс, 5,117 тонн бодис байгаа нь өнгөрсөн оныхоос 2 дахин илүү хэмжээгээр нөөцлөгдсөн байна. Энэхүү нөөцөд дахиад 1,500 тонн бодисыг нэмэгдүүлэхээр 12 дугаар сарын 10-нд татан авалт хийж нийлүүлэгдэхээр төлөвлөж байна. Энэ бодисыг Иргэний нисэхийн газраас илүү чанартай, өндөр ач холбогдолтой бодисоор нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Х.Булгантуяа: - Эрүүл мэндийн яамнаас өвчлөлтэй холбоотой хариулах уу?

П.Оюунцэцэг: - М.Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя. Өвөлжилтийн хүрээнд хамгийн их тархдаг өвчин бол амьсгалын тогтолцооны өвчин. Тэр дундаа томуу, томуу төст өвчний тохиолдлын тоо байгаа.

Хүүхдүүдийн дунд томуу, томуу төст өвчний хүндрэл нэлээн гардаг, эмнэлгийн орны ачаалал өндөр байдаг олон жилийн туршлага сургамжууд

байгаа. Энэ жилийн хувьд эмнэлгийн орны ачааллын мэдээллийг бодит цагийн горимоор Эрүүл мэндийн яаман дээр өдөр бүр авдаг болсон. Аль дүүрэгт, аль аймагт орны ачаалал хэтрэхээр байгааг бодит цагийн горимоор хянаад явж байна. Үүнтэй холбоотойгоор эмнэлгүүдийн орны ачаалал хэтэрсэн статистикийн тооцоо байхгүй байна. Гэхдээ ор нэмэгдүүлэх төлөвлөгөө, түүнийг дагаж гарах эмнэлгийн ажилчдын нөөц төлөвлөлтүүдийг хийгээд ажиллаж байна.

Эмнэлэгт хэвтэх шаардлагагүй буюу хөнгөн хэлбэрийн томуу, томуу төст өвчин үед бол ӨЭМТ-үүдээс гэрээр эмчлэгдэх боломж бүхий эмийн багцуудыг олгох үйл ажиллагаа эхлээд явж байна.

Энэ жилийн хувьд томуугийн вакцины асуудлыг эрт эхлүүлсэн байгаа. Өнөөдөр вакцинжуулалтын хамрагдалт 90 гаруй хувьтай байна. Одоогоор амбулаторийн үзлэгт томуу, томуу төст өвчин 7,8 хувийг эзэлж байна. Амбулатори болон хэвтүүлэн эмчлүүлэх түвшинд томуу, томуу төст өвчин, өвчлөл хяналтын түвшинд байна гэж үзэж болно.

Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэдээллийг эрүүл мэндийн байгууллагуудаас бодит цагийн горимоор цахимаар хянаад явж байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн хувьд цөөхөн нэр төрлийн эмүүд 26 хоногийн нөөцтэй байна. Дийлэнх эмүүд 3 сараас дээш хоногийн нөөцтэй байна.

Х.Булгантуяа: - М.Нарантуяа-Нара гишүүн тодруулъя.

М.Нарантуяа-Нара: - Тэгэхээр утааг сууриар нь шийдэхээр ажиллаж байгааг ойлгож байна. Угаасаа ингэж байж л бүрэн шийднэ.

Гэхдээ энэ жилийн хувьд 12 мянган өрхийг орон сууцжуулна гэхэд Улаанбаатар хотын хэмжээнд нийт хэдэн айл өрх орон сууцгүй гэр хорооллын бүсэд амьдарч байгаа юм бэ? Энэ утааг сууриар нь шийдэх хүртэл хэдэн жил утаатай байх юм бэ?

Хоёрдугаарт, 5 хувийн барьцалдуулагчийг оруулдаг гээд байна. Тавантолгой түлш Улаанбаатар хотын ард иргэдэд нийлүүлж байгаа шахмал түлшинд гадаадаас ямар нэгэн бодис худалдан авч нийлүүлж байгаа зүйл байна уу гэдгийг асуусан. Энэ дээр би тодорхой хариулт авмаар байна.

Нийслэлийн зүгээс халтиргаа гулгааг аж ахуйн нэгжээр нь өөрийн гадна талбайн 50-100 м орчимд газар, талбайгаа цэвэрлэдэг, үйлчлүүлэгчдээ боддог нийгмийн хариуцлагын хүрээнд цэвэрлэдэг болгох арга хэмжээ авах хэрэгтэй.

Х.Булгантуяа: - Утаатай холбоотой тодруулах асуултад хариулъя.

А.Батзориг: - Барьцалдуулагчтай холбоотой асуултад “Тавантолгой түлш” компанийн Санхүү, эдийн засгийн газрын дарга А.Батзориг хариулъя.

2019 онд “Тавантолгой түлш” компани байгуулагдсан цагаас 2022 он хүртэл барьцалдуулагчийг импортоор БНХАУ-аас оруулж ирж, хэрэглэж байсан.

2022 оноос дотоодын барьцалдуулагчийг 40-50 хувьтай болгоод явж байгаа. Цаашид дотоодын үйлдвэрийн барьцалдуулагчийг үйл ажиллагаандаа ашиглана гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Х.Булгантуяа: - Т.Даваадалай дарга.

Т.Даваадалай: - М.Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Т.Даваадалай байна.

Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр батлагдсан. Үүнтэй холбогдолтойгоор ирэх 4 жил Сэлбэ, Шар хадны төвүүд дээр ойролцоогоор 20 мянган айлын орон сууцжих хөтөлбөр хийнэ гээд тодорхой тусгасан. Одоогийн байдлаар Улаанбаатар хотын гэр хороололд 200-аад мянган өрх, яндан байна. Ирэх 4 жилийн хугацаанд 20 мянган айлын орон сууцыг барьж байгуулаад орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр мөрийн хөтөлбөрт тусгаад, төлөвлөлтүүд болон холбогдох бичиг баримтуудыг цэгцлээд, хөрөнгө оруулалтыг шийдээд явж байгаа.

Х.Булгантуяа: - Хариулт болсон уу? Манай гишүүдээс гарч байгаа асуултаудыг та бүхэн сайн бичиж авч байгаад тоймтой хариулмаар байна.

Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар асуулт асууя.

Да.Цогтбаатар: - Баярлалаа. Бүгдэд нь оройн мэнд хүргэе.

Өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбоотойгоор өвсний нөөцийн талаар тодруулга мэдээлэл авах гэсэн юм. Өвсний нөөцийг улсын нөөц, эсвэл аймгийн нөөц, сумын нөөц бэлддэг. Гэхдээ сумаас цааш эрсдэлтэй бүлгүүдэд хүргэх шинэ арга, технологи гэдэг юм уу өнгөрсөн өвлийн хүндрэл, бэрхшээл дээр үндэслээд шинээр хэрэгжүүлэх бодлого арга, төлөвлөгөө гэж байна уу? Жишээлбэл, өнгөрсөн жил Архангай аймгийн Эрдэнэмандал сумын урд талд 14-хөн километрийн цаана сум харагдаад байдаг малчин цасанд боогдоод явж чадахгүй байж байгаад 500 гаруй хоньтой айл хот нь харлаад хоцорсон жишээ байгаа. Сумаас хойшоо айл нь харагдана, урагшаа айлаасаа сум нь харагдана. Өвс тэжээл хүргэж чадахгүй байж байгаад эрсдэл үүсчихсэн. Энэ дээр шинэ гаргаж байгаа бодлого, төлөвлөгөө байгаа юу?

Хоёрдугаарт, энэ улс төржилт биш. Гэхдээ бодит байдал нь орон нутгийн сонгууль болж дуусаад сар гаруй хугацаа өнгөрчихсэн. Жишээлбэл, Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг дарга томилогдоогүй, өнгөрсөн жил өвсний нөөц бүрдүүлэлттэй холбоотой 80 гаран сая төгрөг тавьсан. Энэ оны 9 дүгээр сарын 20-д гэхэд Баянхонгор аймгийн Галуут суманд 20-30 см цас ороод эхэлсэн. Сүүлд дахиад нэмээд цас орчихсон, оторт гараад эхэлчихсэн байгаа. Энэ сумын Засаг даргаас нь өвөлжилттэй холбоотой өвс тэжээл бэлтгэлтэй холбоотой асуудал байна уу гэхээр байдаггүй. Очсон жоохон өвсийг нь хувьдаа дарж хэвтсээр байгаад гаргаад ирсэн чинь өвс нь бүр мод болчихсон, хэн ч хэрэглэхээргүй болчихсон байгаа. Энэ асуудал дээр ямар арга хэмжээ авах вэ? Өнөөдрийн

байдлаар Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг дарга томилогдоогүй, өвөлжилт хүндэрчихсэн зудын хэмжээнд оччихсон байгаа. Тодорхой хариулт байна уу?

Гуравдугаарт, Нийслэлийн утаатай холбоотой. Аймгууд руугаа орж байгаа. Бага насны хүүхдүүдтэй залуу гэр бүлүүдэд жил болгон нэг асуудал тулгардаг нь өвөл болохоор ханиадны асуудал тулгардаг. Манай хүүхдүүд амьдаараа туршилт болж дууслаа. Эрүүл мэндийн яам жишээлбэл хүүхдүүд ханиад хүрэхгүйгээр яаж өвлийг давах төлөвлөгөө, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар бодлого, арга тактик байдаг уу? гээд ийм 3 асуулт байна.

Х.Булгантуяа: - Эхлээд Шадар сайд хариулах уу? Дараа нь Эрүүл мэндийн яамнаас хариулъя.

С.Амарсайхан: - Аймаг орон нутагт улс орон даяар сонгууль, улс төрийн ажил хууль, журмын хүрээнд яваад дууссан. Тэгэхээр ямар нэгэн байдлаар хууль зөрчиж томилгоо хийхгүй байх, аймаг орон нутгийн засаг захиргааг удирдлагагүй байх асуудал хэнд ч байхгүй.

Тийм учраас энэ асуудал дээр хаана хаана анхаарч ажиллах ёстой. Аймгийн Засаг дарга холбогдох хүмүүсээс тодруулж зохих арга хэмжээнүүдийг авах тал дээр анхааръя.

Хоёрдугаарт, мэдээж зам харгуйтай холбоотойгоор хүндрэлтэй нөхцөл байдлууд үүсдэг. Тэгээд тэр бүхэнд аймаг, орон нутаг өөрөө хүч нөөц бололцоо нь хүрдэггүй учраас өнгөрсөн жил улсын хэмжээнд бүх машин техник, механизмыг, онцгой байдлын алба хаагч, төрийн цэргийн байгууллага, зэвсэгт хүчний алба хаагчдыг, хилийн цэргийнхнийг хүртэл нэмж олон чиглэлд зам гаргасан. Нийтдээ 200 гаруй мянган км зам гаргасан гэж та бүхэн тухайн үед сонсож байсан байх. Энэ бага тоо биш. Да.Цогтбаатар гишүүний хэлдэг бол үнэн. Зам хаагдаж, өвс тэжээлээ авч чадахгүй байсаар байгаад мал нь хорогддог, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээгээ авдаггүй асуудал байгаа.

Тэгэхээр аймаг, орон нутагт шуурхай бүлгүүд гараад ажиллаж байгаа. Энэ ярьсан бүх асуудлуудад газар дээр нь үнэлэлт, дүгнэлт хийж дахиж зохион байгуулалтыг хангах тал дээр анхаарах асуудлууд байвал бид арга хэмжээ авч ажиллана. УОК-ын дэргэдэх шуурхай штаб 24 цагаар аймаг, орон нутгийн штабууд ажиллаж байгаа. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудал бусад энэ асуулт дээр УОК-ын нарийн бичгийн дарга Т.Баярхүү, Эрүүл мэндийн яамныхан нь хариулаад явчих нь зөв байх.

Х.Булгантуяа: - УОК-оос Т.Баярхүү дарга хариулъя.

Т.Баярхүү: - УОК-ын Нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү Да.Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Өвс, тэжээлийн нөөцтэй холбогдуулж сумдын аюулгүй нөөц, аймгийн аюулгүй нөөцийн өвс, тэжээлийн хэмжээ, хадгалах тухай, түүнтэй холбоотой

терессүүдийг тухайн аймаг, орон нутгийн удирдлагууд шийдвэрлээд явдаг. Улсын нөөцийн цэгүүд дээр өвс, тэжээлтэй холбоотой хадгалах агуулахуудад хадгалдаг байгаа.

Улсын нөөц дээр өвс, тэжээлийг эрсдэлтэй, ялангуяа зам даваа хаагддаг, хүрч очиход бэрхшээлтэй цэгүүдэд аль болох байршуулж, төвлөрүүлж хадгалахыг зорьж ажиллаж байгаа. Өнгөрсөн жилийн өвөл болон сүүлийн жилүүдэд гарч байгаа хүндрэл бэрхшээлтэй холбоотойгоор сумын фонд буюу сумын төв дээр өвс, тэжээлийн нөөцийг бэлтгэж хадгалдаг байсан сумууд тараан байршуулах замаар буюу багийн төвүүд дээр эрсдэлтэй, өндөр даваа гүвээтэй эрсдэлтэй цэгүүд дээр хадгалж эхэлж байгаа.

Гол асуудал нь өвс, тэжээлтэй холбоотой агуулах, хадгалалтын асуудлууд байдаг учраас сум, орон нутаг дээр нэлээн хүндрэлтэй асуудлууд үүсэж байгаа гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: - Эрүүл мэндийн яамнаас нэмж хариулна.

П.Оюунцэцэг: - Ерөнхийдөө ханиад томуунаас сэргийлэх өвөрмөц болон өвөрмөц бус урьдчилан сэргийлэх арга гэж байна. Өвөрмөц урьдчилан сэргийлэлтийн арга бол вакцины урьдчилан сэргийлэх арга буюу томуугийн вакцины хамралтын талаар ярьсан.

Өвөрмөц бус, урьдчилан сэргийлэлтээр, харьцангуй бага зардлаар хамгийн энгийн арга амны хаалт зүүх асуудал. Энэ чиглэлээр иргэдэд эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хийдэг. Томуу, томуу төст өвчин, түүний дэгдэлтийн урьдал үе, дэгдэлтийн үед амны хаалт зүүх асуудлаар эрүүл мэндийн байгууллагууд болон бусад аж ахуйн нэгжүүд дээр уриалга, дээрээс нь хяналтуудыг хийгээд явж байна.

Эрүүл мэндийн салбараас эхлээд үлгэрлэж амны хаалтыг хэрвээ өвдсөн л бол заавал хэрэглэдэг байх, өвдөхөөсөө урьдчилан сэргийлээд хэрэглэдэг байх арга бол хамгийн чухал.

Түүнээс гадна бие махбодынхоо дархлааг сайжруулах асуудал чухал байна. Агаарын бохирдлын хэмжээ, агаарын бохирдлоос үүдэлтэйгээр өвлийн улиралд хүн бүрийн дархлаа сулрах асуудал өргөн тархацтай байдаг. Тэгэхээр хувь хүн өөрөө биеийн дархлаагаа сайжруулах, шим тэжээлтэй хоол унд идэх асуудал яригдана. Өвөрмөц урьдчилан сэргийлэлтийн аргууд бол дэлхий нийтэд шалгарсан аргууд байгаа.

Х.Булгантуяа: - Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал асуулт асууна.

Ж.Золжаргал: - Түрүүн өвлийн шатахууны нөөцийн талаар С.Эрдэнэболд гишүүн асуусан. Тэгээд хариулт өгчихсөн учраас санал хэлье гэж бодож байна.

Мэдэж шатахууны хангамжийн эх үүсвэр, байнгын эх үүсвэр олшруулах нэг тусдаа асуудал байгаа.

Хоёрдугаарт, тухайн үед, богино хугацаанд илүү өндөр үнээр ч хамаагүй нийлүүлэх нөөц хувилбарууд байх ёстой. Онцгой байдал, мэргэжлийн байгууллагууд янз бүрийн арга хэмжээг боддог л байх. Тэгэхээр тэр хувилбарууд дээрээ гэнэтийн тохиолдолд яаралтай нийлүүлэх эх үүсвэрүүд тусгасан байдаг юм болов уу? Хэрвээ байдаггүй бол тэр хувилбаруудыг тооцоосой гэж хэлмээр байна.

Өнгөрсөн жилийн зуднаар уул уурхайн компаниуд сайн ажилласан. Хөдөө явж байхад зам боогдчихдог, уул уурхайн компаниуд үүрэг хүлээгээгүй ч Монгол хүнийн жудгаар зуд турхнаар боогдсон зам нээнэ, малчдадаа тусална. Эдгээр үйл ажиллагааны хувилбарт үйл явцыг тодорхой оруулаад цаашид хэрхэн, яаж ажиллаж болох вэ? Магадгүй дараа нь нөхөн төлбөр болон тооцоогоор татвартай холбодог механизм байх ёстой юм болов уу гэсэн ийм санал байна.

Тэгээд 2 асуулт байна. Энэ танилцуулгад өвс, тэжээлийн аюулгүй нөөцийн бэлтгэл дээр зарим аймагт 20 гаруй хувьтай, заримд нь 50 хувьтай байгаа. Баян-Өлгий, Завхан аймгуудад 20 гаруй хувьтай байдаг. Хөвсгөл, Хэнтий, Төв аймаг гээд 50 хэдэн хувьтай байгаа байхгүй юу.

Тэгэхээр өвс, тэжээлтэй газар шүү дээ. Яагаад ийм бага байгаа юм бол бодвол байгалийн бус шалтгаанаас болсон бол хариуцлага тооцдог уу? Энэ дээр хариуцлага тооцсон тохиолдол байна уу?

Хоёрт нь Эрчим хүчний сайд 131 тэрбум төгрөгийн татаасыг тушаалаар батлаад, санхүүгийн дэмжлэг олгосон. Нүүрсний аюулгүй нөөц гэх мэтчилэн. Мөн тарифын алдагдал бууруулах гэж байгаа. Тарифын алдагдал бууруулах дээр хэчнээн төгрөг зарцуулагдаж байгаа юм бэ? Тариф нь өөрчлөгдөхийн өмнөх тарифаар тооцогдчихов уу, дараагаар нь нэгдчих үү? Тэгэхээр дараа нь нэгдэхэд дахиад өөрчлөгдөх үү, үгүй юү? Өвлийн халаалтын хөнгөлөлтөөс хамаарч чадаж байгаа юу? гэсэн 2 асуулт байна.

Х.Булгантуяа: - Б.Чойжилсүрэн сайд хариулья.

Б.Чойжилсүрэн: - Ж.Золжаргал гишүүний асуултад хариулья.

Улсын төсвийн 2024 оны тодотголоор Эрчим хүчний сайдын урсгал зардал дээр 131 тэрбум төгрөг нэмэгдүүлж Улсын Их Хурлын баталж өгсөн. Энэ хөрөнгийн эх үүсвэрийг Эрчим хүчний сайдаар зорилтот түвшин бизнес төлөвлөгөө батлуулдаг 27 аж ахуйн нэгжүүд дээр зориулалтын дагуу сайдын тушаал гаргаж хуваарилж байгаа. Энэ асуудал 2024 онд дуусна. Харин 2025 онд дараагийн төсөв эцэслэн батлагдахаар яригдана.

Тарифын өөрчлөлт нь 2024 оны 11 дүгээр сарын 15-аас цахилгааны эрчим хүчний үнийг Эрчим хүчний зохицуулах хорооноос өөрчилсөн. Улаанбаатар

хотын дулааны тухайд 2025 оны 5 дугаар сарын 16-аас эхэлж мөрдөгдөхөөр шийдвэрүүд гарсан.

Эрчим хүчний салбар 2023, 2024 он гээд бусад урьд жилүүд дээр алдагдалтай ажилласаар байгаад, энэ алдагдал нь төлбөр болоод хувирчигсан. 2023 онд 379 орчим тэрбум төгрөг, 2024 онд 218 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байгаа. Эдгээр алдагдлын нэг хэсгийг нь багасгаж өвлийг даван туулахад өвөлжилтийн бэлтгэлд зориулж 131 тэрбум төгрөгийг холбогдох төрийн өмчит компаниудад шилжүүлсэн байгаа.

Х.Булгантуяа: - Түлштэй холбоотой асуултад Шадар сайд С.Амарсайхан нэмж хариулах уу?

С.Амарсайхан: - Нэгдүгээрт, нөөц бүрдүүлэх хэрэгцээ шаардлага цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалаад харилцан адилгүй байна. Үүнээс үүсэх өндөр эрсдэлүүд бий. Тийм учраас улсын хэмжээнд нөөцийн савыг бүрдүүлэх, ялангуяа аж ахуйн нэгжүүдтэй хамтарч төр, хувийн хэвшлийн чиглэлээр улсын хэмжээний шатах, тослох материалын нөөцийг бүрдүүлэх зайлшгүй шаардлага байгаа учраас яаман дээр энэ ажлыг зохион байгуулан хариуцаж байгаа.

Уул уурхай, эрдэс баялаг, аж үйлдвэрийн яаман дээр импортлогч ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжүүд нөөц бүрдүүлдэг, улсын хэмжээнд улсын нөөц бий. Шаардлагатай үед зохицуулалтыг хийдэг. Жишээ нь, өнгөрсөн өвөл Багануурын уурхайгаас эхлээд түлш, бензин шатахуун тасарсан аймаг, орон нутгуудад хүндрэлтэй байхад улсын нөөцөөс зохицуулалт хийж байсан тохиолдлууд бий. Энэ чиглэлээрээ холбогдох байгууллагууд уялдаа холбоогоо хангах зохион байгуулалтыг ханган ажиллаж байна.

Хоёрдугаарт, өвс, тэжээлийн хангалт, нийлүүлэлттэй холбоотой асуудал ярилаа. Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоолын дагуу аймаг, орон нутгийн удирдлагууд сум, орон нутагтаа аюулгүй нөөцөө бүрдүүлэх ёстой.

Өнөөдрийн байдлаар нийт аюулгүй нөөцийн бүрдүүлэлт 75.4 хувьтай байна. Ж.Золжаргал гишүүний хэлдэг шиг зарим нэг бүрдүүлэлт дутуу байгаа аймаг орон нутаг бий. Хөдөө аж ахуйн салбарт өвс тэжээл ханган нийлүүлэлттэй холбоотой асуудал, өвсний гарц бага, ургамлын гарц муу байсан, гантай байсан газруудад нөхөн бүрдүүлэлтийг хийхдээ тендер сонгон шалгаруулалт, тээвэрлэлт, худалдан авалт зэрэг шалтгаануудаар удааширдаг зүйлүүд байгаа. Алслагдсан аймгуудад тээврийн асуудал буюу татан авах хугацаа тодорхой хугацаагаар хойшилдог, бүрдүүлэлт дутуу байдаг. Энэ асуудлыг цаг алдалгүй аюулгүй нөөцөө бүрдүүлэх даалгавар, чиглэлүүд өгөгдөөд, тодорхой түвшинд хянагдаад явж байгаа.

Энэ 11 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд нийт малчид 1.2 сая тонн хадлан бэлдэж авсан. Дээр нь 91 мянган тонн ногоон тэжээл, 59 мянган тонн үйлдвэрийн тэжээл, гар тэжээл 49 мянган тонныг бэлтгэсэн. Малчид өөрсдөө бэлтгэвэл зохих ёстой өвс тэжээл, хужир, дарш ургамлууд зэрэг нийт 96 хувийн гүйцэтгэлтэй байна гэсэн дүн гарсан.

Орон нутагт малчид холбогдох тогтоол, шийдвэр, дүрэм, журмын дагуу өөрсдөө хангалт нийлүүлэлтээ хийж, татан авалтуудыг хийгээд явж байгаа. Сум, аймгийн нөөцийг бүрдүүлэхэд хяналтыг хийгдээд явна.

Х.Булгантуяа: - Ажлын хэсгээс Т.Баярхүү дарга нэмээд хариулах уу?

Т.Баярхүү: - Ж.Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Өнгөрсөн өвлийн тухайд шатахуунтай холбоотой хүндрэлүүд үүссэн. Тухайн үед Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар болон шатахуун, газрын тосны бүтээгдэхүүн экспортлогч, импортлогч компани, аж ахуйн нэгжүүдтэй хамтран зохицуулалтыг хийж байсан. Тухайн үед шаардлагатай эх үүсвэрээс шатахууны тээвэрлэлт, түүнийг дагасан дэд бүтэцтэй холбоотой хүндрэлүүд Улаанбаатар хот, томоохон суурин газруудад гарч байсан.

Улсын нөөцөөс стратегийн ач холбогдолтой салбарууд буюу уул уурхай, эрчим хүч, зарим аймаг, сумдын онцгой албаны салбарууд, эрүүл мэнд, цагдаа, онцгой байдлын байгууллага зэрэг шаардлагатай байгууллагуудад тухай бүр нөөц зохицуулалтуудыг хийгээд явсан.

Энэ жилийн хувьд УОК-ын даргын тушаалаар холбогдох албаны төлөөлөлөөс бүрдсэн УОК-ын шуурхай штаб үүрэг гүйцэтгэж байгаа. Энэ хүрээнд холбогдох зохицуулалтуудыг хийж ажиллана.

Х.Булгантуяа: - Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Жаргалсайхан асуулт асууна.

Д.Жаргалсайхан: - Та бүхэнд энэ оройн мэндийг хүргэе.

Өвөлжилтийн бэлтгэл ажил хангана гэдэг бол Монгол Улсын хэмжээнд том ажил. Энэ жил юу хийсэн бэ гэдгээ үнэлдэг, цэгнэдэг жил. Тэр тусмаа орон нутагт бэлтгэл ажлыг хангадаг, хоол хүнсээ авдаг, өвөлжөө бууцандаа буудаг, гэр орон гадаа давхарладаг, дулаалдаг, хүүхдээ сургууль, цэцэрлэгт хоол, хүнсийг нь хүргэж өгөх гээд эрүүл мэнд, боловсролыг хамарсан том салбар байдаг.

Тэгээд онцгой байдлын орон нутагт ажиллаж байгаа хүмүүс нэлээн ажлыг бэлддэг. Өмнө жил онц хүндрэлтэй жил байсан. Олон улсын байгууллагуудаас тусламж, дэмжлэгүүдийг их үзүүлсэн. Тэгээд энэ сонгуулийн жилд алдаа гарсан. Орон нутгийн удирдлагууд, сумдын удирдлагууд солигддог, дээр нь төсөв шилжих жил хавар төсвөө ерөнхийд нь өвс, хадлан тэжээлд үрчихдэг. Одоо төсөв хэлэлцэгдээгүй, батлагдаагүй үед, батлагдсаны дараа тендер зарлагдаад он даваад явчихдаг, орон нутагт бэлтгэл ажлууд муу хийгддэг нэг шалтгаан болдог.

УОК түрүү жил ажиллаад энэ шалтгааныг сайн харсан. Малчин өрхүүд маань яг ямар байдалтай байгаа вэ гэдгийг, яваад ороход түлш байхгүй, хоол байхгүй, гэрт нь 1 л хүн байж байгаа. Авгай нь хүүхдүүдээ аваад сум руу орчихсон.

Шадар сайдын хэлж байгаагаар ажлын хэсгүүд гараад сумдад ажиллаж байгаа. 3 аймагт, хангайн бүсийн Архангай, Баянхонгор, Өвөрхангайд өвөлжилтийн талаар бэлтгэл ажлын талаар сумуудтай, аймгийн удирдлагуудтай холбогдсон.

Архангай аймагт 5 хэсэг ажлын хэсэг гараад ажиллаж байна. Баянхонгорт ажлын хэсгүүд гарч байна. Энэ ажил ямар удирдамжаар явж байгаа вэ? Надад ирж байгаа мэдээллээр, сумуудад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх машин хүрэлцэхгүй байна, эвдэрчихлээ гэсэн 2 сум байна. Энэ мэдээ ирсэн үү? Манай нэг сум дээр дотуур байр актлагдчихсан, засвар хийе гэхээр засвар хийлгэдэггүй.

Монгол Улсын төсөв яригдаж байгаа. Актлагдсан, ашиглахыг больчихсон барилгуудыг шинэчлэх ажлыг улсын төсөв дээр суулгах санал Шадар сайд дээр ирдэг үү? Энэ жил ямар ч ажил шинээр оруулахгүй гээд оруулж чадсангүй. Дотуур байрны ажлын 2 асуудал. Мөн дээрээс нь тэр айл өрхөд очиход сая үнэхээр бэлтгэл ажлаас.../минут дуусав./

Х.Булгантуяа: - Эхлээд хариулт авчихаад тодруулчихъя.

Шадар сайд хариулаад, дараа нь эрүүл мэндийн салбарын түргэн тусламжийн машины хүртээмж, дотуур байрны асуудлаар Эрүүл мэндийн яам хариулья.

С.Амарсайхан: - Д.Жаргалсайхан гишүүн чухал асуудлууд болох орон нутгийн зовлон, нөхцөл байдал, хүндрэл бэрхшээлийн үнэн бодит байдлыг хэлж байна. Амаргүй байдаг. Ялангуяа өвс бэлтгэл, тэжээл гэдэг юм уу, улсын орон нутгийн аюулгүй нөөцийг бүрдүүлэхэд аймаг орон нутагт тулгамдаж байгаа асуудал төсөвтэй холбоотой. Заримыг нь нөөцөөс бүрдүүлдэг, өмнөх нөөцөө ашигладаг, он дамжихад төсвөө баталж, төсвөөрөө худалдан авалтыг хийдэг.

Тийм учраас төсөв, гарч болзошгүй сөрөг үр дагавраа тооцож асуудалд хандаж төсвийг батлахад анхаараарай гэж хэлээд байгаа юм.

Хоёрдугаарт, орон нутагт явж байхад хүндрэлүүд их байдаг. Сумын дарга, багийн дарга, эрүүл мэнд, онцгой, цагдаа, боловсрол гээд байр сав, машин тэрэг, дулаан цахилгаан, урсгал зардал, дээврийн засвар, засвар үйлчилгээ гээд их хүсэлтийг тавьдаг. Тэр болгоныг шууд шийдээд байх боломж бага байдаг учраас аймаг, орон нутагт төрийн албыг гүйцэтгэлдүүлнэ. Ард иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой төрөөс баримталдаг бодлогыг бодитой хэрэгжүүлбэ гэвэл эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний автомашинд тавигддаг стандартыг хангуулах, аймаг, орон нутгийн машин тэрэгний хангамжийг шийддэг болбё.

Дотуур байрны сургуулийн асуудлыг Боловсролын яам болон Гэр бүл, хөдөлмөрийн яамдууд анхаарах хэрэгтэй байна. Улсын төсвөөр л энэ асуудлыг шийдэхгүй бол Шадар сайд тухайн орон нутгийн нөхцөл байдалтай танилцаад, асуудлыг сонсоод шууд Засгийн газраар оруулаад шийдчихдэг асуудал биш юм.

Тэгэхээр цаашид зайлшгүй хийх ёстой ажлуудаа ач холбогдлоор нь эрэмбэлж, дараалаад аймаг, бүсээр нь ялгаад, эрүүл мэнд, боловсролын салбарын үйлчилгээтэй холбоотой асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэхэд онцгой анхаарч ажиллахгүй бол аймаг, орон нутгаас ороод ирсэн төсвийг нь энэ ч болохгүй, тэр ч болохгүй гээд, эсвэл өөрсдийнхөө хүслийн жагсаалтаар төсвийг батлах гээд, нэг бол хийрхэж явцуураад бүх юмыг нь хасаад хаячихдаг хандлага бол орон нутагт их хүндрэл учруулж байгаа.

Орон нутгийн асуудлаа бүсийн бодлоготойгоо уялдуулж, цэгцтэйгээр шийдвэрлэх олон асуудлын хүрээнд сургуулийн дотуур байр, эрүүл мэндийн салбарын машин тэрэгний асуудлыг шийдвэрлэх ёстой гэж үзэж байгаа.

Цаашид төсөв, хөрөнгө хэрхэн, ямар түвшинд, ямар бүс нутагт хуваарилагдах тухай саналыг орон нутгаас нь авч, орон нутгийн нөөц бололцоогоор шийдвэрлэх юм. Улсын төсвөөр шийдвэрлэх асуудал, гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламжаар шийдвэрлэх асуудал гэдгээ тодорхой болгож, ангилж ялгаад, хугацааг нь тодорхой тогтоож, шийдвэрлэдэг байх тогтолцоотой байх чухал. Тийм учраас гишүүд маань энэ дээр анхаарах байх гэж бодож байна.

Х.Булгантуяа: - Эрүүл мэндийн яамнаас нэмж хариулах уу?

П.Оюунцэцэг: - Д.Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя.

2024 онд Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр Ланд крузер 78 маркийн автомашин 60 ширхгийг сумдын Эрүүл мэндийн төвүүдэд олгоод байна. Дэлхийн банкны төслийн хүрээнд нийт 75 түргэний автомашиныг нийлүүлэхээр гэрээлсэн байгаа. Эхний ээлжид 44 түргэний автомашиныг олгоод байна. Үлдсэн автомашинуудыг энэ онд багтаан сумдын Эрүүл мэндийн төв, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

Цаашид сумдын болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад түргэн тусламжийн автомашин дээр туулах чадвар сайтай том машинуудыг олгохоор шийдвэр гаргаад хангалт хийгээд явж байгаа.

Х.Булгантуяа: - Нэмж тодруулах уу? Улсын Их Хурлын гишүүдээс мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууслаа.

Өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой жил бүр Улсын Их Хурлаар мэдээлэл хийдэг. Өнөөдөр хэд хэдэн гишүүд асууж байгаа асуултууд дээр Засгийн газрын гишүүд анхаараарай.

Нэгдүгээрт, яг өвөлжилт хүндрэхээр гэнэт өвөлжилтийн асуудал ярьдаг биш, эртнээс бэлтгэлийг хангах, хүнс тэжээлийн бэлтгэлээ хангах, түлшний бэлтгэлээ хангах, Улаанбаатар хотын түгжрэл, халтиргаа, утааны чанарын асуудал, эрүүл мэндийн салбар, хүүхдийн өвчлөл, эрүүл мэндийн салбарын тулгамдаад байгаа улс орны асуудал гэх мэтчилэн. Д.Жаргалсайхан гишүүн асууж байна. Эрүүл мэндийн салбар өвөлжилт хүндрээд эхлэхээр яаралтай

горимоор дандаа худалдан авалтуудаа хийж явдаг биш эртнээс төлөвлөөд 330 сумынхаа яаралтай тусламжийн машины асуудлыг төлөвлөж байгаад жил жилээр төсөв дээрээ тодорхой хэмжээгээр тавиад шийддэг байх дээр та бүхэн маань өөрснөө анхаарах хэрэгтэй.

Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс өнөөдөр чуулганы дэгийн тухай 112 дугаар зүйлийн 112.9-д заасны дагуу намын бүлэг тус бүрээс 1 гишүүн төлөөлж, Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулсан Ерөнхий сайдын мэдээллийн сэдэвтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн асуултуудыг асуусан.

Улсын Их Хурлын дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд иргэдээс ирүүлсэн асуултыг асууна. Гишүүд асуулт асуух, хариулт авах хугацааг 20 минутад багтаана.

Х.Булгантуяа: - Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд асуултад асууя.

С.Эрдэнэболд: - Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд зааснаар Улсын Их Хурлын гишүүд асуулт, тодруулгаа авсан бол одоо иргэдээс ирсэн асуултыг сөрөг хүчний зүгээс тавьж байгаа.

Тэгэхээр иргэдээс нийт 15 асуулт цахимаар ирсэн. Энэ асуултуудыг би тоймлоод зарим асуултууд давхардсан учраас нэг дор асуугаад явчихъя. Та бүхэн харьяалагдах асуултуудад хариулаарай. Ингээд иргэдийн асуултыг та бүхэнд тоймлоод уншиж өгье.

Өмнөх парламентын үед Ерөнхий сайд Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар 14 хоног тутам мэдээлэл хийдэг байсан бол, энэ парламентын үед сард нэг удаа хийж байгаа.

Тэгээд асуулт маань Ерөнхий сайдын мэдээлэл олон нийтэд 7 хоногийн өмнө нээлттэй тавигдах ёстой байтал цаг тулгаж энэ мэдээлэл цахим хуудсан дээр тавигдаад байгаа юм. Цаг тулаад тавигдахаар иргэд маань төдийлөн танилцаж амжихгүй байгаад байгаа. Тэр утгаараа Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Тамгын газар хоёрт хандаж хэлэхэд иргэдийн мэдэх эрхийг хангах үүднээс Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотой асуудал дээр иргэд танилцах боломжийг нь түлхүү хангаж байвал процессын хувьд үр дүнтэй байна гэж үзэж байгаа.

Эхний асуулт, хөдөө аж ахуйн салбарт улсын төсвөөс олгох татаас, дэмжлэгийн хэмжээ жил ирэх тусам өсөн нэмэгдэж ирсний зэрэгцээ “Шинэ Хоршоо”нд багагүй хөрөнгө оруулалт оруулж байгаа. Энэ дэмжлэг, хөрөнгө нь малчдыг зудаас сэргийлэх, зудын эрсдэлийг даван туулах чадавхыг бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах боломжтой юу? Энд тодорхой хариулж өгөөч гэж байгаа юм. Тоо баримттай байвал сайн байна.

Хоёрдугаар асуулт нь цаг уурын төлөв байдлын урьдчилсан мэдээгээр энэ өвөл ямар нөхцөл байдалтай байх вэ? Малчдын зүгээс ирж байгаа асуулт.

Үүнтэй холбоотойгоор ямар нэгэн нэмэлт арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна уу? Хэрэв цагийн байдал хүндэрч зуд боллоо гэхэд малчдад бага хэмжээний өвс тэжээл, барааны тусламж өгөх замаар зудын эрсдэлийг даван туулах гэсэн ийм уламжлалт арга барилаа яаж өөрчлөх вэ? Өвөлжилтийн байдал хүндэрч эхэлсэн аймаг, сумдын малыг эргэлтэд оруулж, мах экспортлох талаар хэрэгжүүлсэн бодитой ажил байна уу? Өнгөрсөн өвөл гэхэд өвөлжилтийн бэлтгэл хангах ид ажлын үеэр шатахууны хомсдолд орсон гээд давхацсан асуулт байгаа.

Гурав дахь бүлэг асуулт нь хөдөө аж ахуйн салбарт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхыг нь бэхжүүлэхэд чиглэсэн шинэ технологи, инновац яагаад хангалттай түвшинд нэвтэрч чадахгүй байна вэ? Малын ашиг шим, таримал ургамлын бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн дотоод, гадаад төслүүдийн үр дүн яагаад хангалттай биш байна вэ? Тооноос чанарт шилжиж байж зуд, байгалийн гамшгийг үр дүнтэйгээр даван туулах, хохирол багатайгаар даван туулах ёстой. Тэгээд эмзэг байдлаа бууруулах тал дээр ямар тодорхой алхмууд Засгийн газраас хийх вэ?

Дараагийн асуулт нь нөөцийн мах бэлтгэх, үнийг тогтвортой байлгах гэж оролдох малчид тариаланчдад хавтгайруулан урамшуулал, татаас олгож, төрийн халамж нэмэгдэх, хөдөөд хоршоог компаничлан байгуулах, гурил, улаан буудайн импортын татварыг тэглэх гэх мэтээр хөдөө аж ахуйн салбар дахь төрийн оролцоо ихээхэн өсөх хандлагатай байна. Энэ бодлогыг зөв гэдэгт итгэлтэй байна уу гэсэн асуулт байна.

Дараагийнх нь асуулт давхацсан. Тэгэхдээ иргэдээс ирсэн учраас заавал уншиж өгөх ёстой. ДЦС-уудын нүүрсний нөөц хэдэн хоногийн хэрэгцээг хангах хэмжээнд байна вэ, тоо? Цахилгаан станцуудын их засвар, техникийн бэлэн байдал хэр хангагдсан бэ? Эрчим хүчний системийн ослын нөөц, аваарын нөөц, түүний бэлэн байдал ямар түвшинд байна вэ? Өмнөх жилүүдэд гарч байсан алдаа, дутагдлуудыг засаж сайжруулах чиглэлээр ямар арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байна вэ гэсэн. 90 гаруй хувийн бэлтгэлтэй байгаа гэсэн. Энэ дээр бол тодорхой арга зүйн хувьд ямар бэлтгэлтэй байна вэ гэдгийг нь асууж байна.

Мөн Улаанбаатар хотын дулаан хангамжийн системийн бэлэн байдал хэр хангагдсан бэ? Онцгой нөхцөл байдал үүссэн үед ашиглах нөөц сангийн хөрөнгө хэдий хэмжээнд бэлтгэгдсэн бэ гэсэн асуултууд байна.

Иргэдээс ирсэн асуултыг Ардчилсан намын бүлгийг төлөөлж асууж дууслаа.

Х.Булгантуяа: - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам “Шинэ Хоршоо”-той холбоотой, дараа нь цаг уурын мэдээлэл, зуд болбол яах вэ гэдэгтэй холбоотой бүх асуултад хариулчихаарай.

Ё.Азжаргал: - “Шинэ Хоршоо” хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны нарийн бичгийн дарга Ё.Азжаргал С.Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя.

“Шинэ Хоршоо” хөдөлгөөний хөрөнгө оруулалтын зээл малчдыг зудын эрсдэлд бэлдэж чадах уу гэж асуусан. Өнгөрсөн хаврын чуулганаар уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсан. Дараа нь Засгийн газрын 166 дугаар тогтоол гарч “Шинэ Хоршоо” хөдөлгөөн өрнөж эхэлсэн. Өнгөрсөн хугацаанд нийт 68,500 орчим малчид хоршооны гишүүнээр элссэн тоо байна. Нийт 17 мянга орчим малчин 558 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авсан. Сүүлийн сар гарангын хугацаанд 8 аймгаар явж малчидтайгаа уулзаж мониторинг хийсэн. Малчид нийт зээлийнхээ 40 гаруй хувийг өвөлжилтийн бэлтгэл ажлаа хангахад, хашаа хороогоо сайжруулахад, хадлан өвс, ногоон тэжээлээ бэлтгэхэд, орлогоо нэмэгдүүлэх чиглэлд зарцуулсан байна гэсэн судалгааны дүн гарсан.

Өөрөөр хэлбэл, “Шинэ Хоршоо” хөдөлгөөний зээлд хамрагдсан 17 мянган малчин энэ өвлийн болзошгүй эрсдэлд бэлтгэлээ хангасан гэсэн дүгнэлт гарч байгаа. Баярлалаа.

Х.Булгантуяа: - УОК-оос Т.Баярхүү дарга.

Т.Баярхүү: - С.Эрдэнэболд гишүүний асуултад хариульъя.

Энэ жилийн цаг уурын төлөв байдал, өвөл ямар нөхцөл байдал үүсэх төлөвтэй байгаа талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна гэсэн асуултад хариульъя.

Цаг уур, орчны шинжилгээний газрын өгсөн мэдээллээр 2024 оны 12 дугаар сард төв болон зүүн аймгуудын нутаг, баруун аймгуудын хойд хэсгээр олон жилийн дунджаас хүйтэн, хур тунадас, зүүн аймгуудын нутгаар ахиу орно гэсэн цаг агаарын прогнозтой байгаа.

Харин 2025 оны 1, 2 дугаар саруудад ихэнх нутгаар олон жилийн дунджаас хүйтэн. Ялангуяа 1 дүгээр сард нутгийн баруун хойд хэсгээр болон 2 дугаар сард зүүн аймгуудын нутгаар олон жилийн дунджаас ахиу хэмжээний цас орох төлөвтэй байна гэсэн урьдчилсан мэдээ байгаа.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан журмын дагуу, мөн Монгол Улсын Шадар сайдын баталсан ган, зудын үнэлгээ хийх ерөнхий үнэлгээний дүнгээр 21 аймгийн хэмжээнд зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийхэд эрсдэлийн түвшин улсын хэмжээнд дунд байгаа. Үүнээс Баянхонгор, Говьсүмбэр, Өвөрхангай аймгуудад зудын эрсдэлийн түвшин их. Архангай, Баян-Өлгий, Завхан, Сүхбаатар, Төв аймгууд эрсдэл маш их, бусад аймгууд дунд гэсэн дүн мэдээтэй.

Танилцуулга дээр бэлчээрийн даацын талаар тодорхой мэдээллүүд байгаа. Өвөл, хаврын улирлын бэлчээрийн даацын судалгаагаар нийт нутгийн 47 хувьд хүрэлцээтэй, бусад хувьд нь бэлчээрийн даац хэтэрч гарсан байна гэсэн дүнтэй байгаа.

Өнгөрсөн өвлийн зудын туршлага, сургамжтай холбоотойгоор УОК-ын Шуурхай штабыг байгуулж, мөн Монгол Улсын Шадар сайдын тушаалаар зудын гамшгийн хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Энэ жилийн тухайд төлөвлөгөөг тодотгон хэрэгжилтийг хангаж ажиллана. Өвөлжилттэй холбоотойгоор УОК-ын Шуурхай штабыг 6 яам, 4 агентлагийн холбогдох албаны мэргэжлийн байгууллагуудын төлөвлөлттэйгөөр бүрдүүлэн салбар дундын зохицуулалтуудыг хийж шуурхай хариу арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхээр ажиллаж байгааг танилцуулъя. Илтгэж дууслаа.

Х.Булгантуяа: - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хөдөө аж ахуйн салбар шинэ технологийн нэвтрэлт муу байна гэдэг асуудлаар Ц.Болорчулуун дарга хариулт өгье.

Ц.Болорчулуун: - С.Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя.

Хөдөө аж ахуйн салбарын мал аж ахуйн салбарт малыг эдийн засгийн эргэлтэд оруулахад тодорхой арга хэмжээ, ажлуудыг хийж ажиллаж байна. Аймгуудын мэдээг нэгтгэн үзэхэд нийт улсын хэмжээнд 16 орчим сая толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулах тооцоо гарсан. Үүнээс 10 орчим сая нь дотоодын хэрэгцээнд, 6 сая нь экспортод гаргана гэсэн тооцоо гарсан. Өнөөдрийн байдлаар 51.3 мянган тонн мах экспортод гарч байгаа.

Мах экспортлох, импортлох орны тоо тодорхой хэмжээнд нэмэгдэж байна. Өнгөрсөн жилийн экспортын тоо, хувийг авч үзвэл нийт экспортолсон махны 80 хувь нь БНХАУ руу гарч байсан бол энэ жил булангийн орнуудтай экспорт, импортын хорио цээрийн протоколууд тохироод аж ахуйн нэгжүүд гаргаад эхэлсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Вьетнам Монголын Засгийн газрын комиссын хуралд очоод ирэхэд Вьетнамын талтай мах авах хорио цээрийн протокол дээр гарын үсэг зураад ирсэн. Иймд экспортлох орны тоо нэмэгдэж байгаа учраас малыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжууд нээгдэж байна гэж харж байна.

Энэ оны 12 дугаар сард 21 аймгийн түвшинд Улаанбаатар хотод уламжлал болгон жил бүр идэш арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж байгаа. Малчдаас шууд хэрэглэгчдэд өвлийн идшийг бэлтгэж өгөх арга хэмжээнд тодорхой хэмжээний үр дүнтэй байдаг. Хөдөө аж ахуйн салбарын төсөл, хөтөлбөрүүд тодорхой хэмжээнд хэрэгжиж байгаа. Донор байгууллагууд болох Азийн хөгжлийн банктэй усалгаатай газар тариалангийн чиглэлээр төсөл хэрэгжүүлж тухайлбал, нийт 7,000 га талбайгаар усалтын системийг нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлээд байна. Нийт 12 байршилд усалтын систем байгуулж байгаагаас 4 байршил дээр ажил нь 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Ирэх жил 10 усалтын системийг хүлээж авах боломж үүсэж байгаа. Дэлхийн банкин дээр мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслүүд явж байгаа. Нэг төслийн санхүүжилтээр бүх асуудал шийдэгдэхгүй боловч тухайн орон нутагт тодорхой хэмжээний үр дүнгүүд гарч байгаа.

Төсөв мөнгө бага байгаа нөхцөлд олон улсын зээл тусламжууд тодорхой хэмжээний үр дүнгээ өгч байгаа гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: - Хөдөө аж ахуйн салбарт төрийн бодлого их болж, нөөцийн мах бэлтгэл халамж болж байна гэдэг асуудлыг ярьсан.

Ц.Болорчулуун: - Хөдөө аж ахуйн салбарт татаас урамшууллын хэмжээ нэмэгдэж байна. Халамж гэсэн асуудал яригдаж боловч манай яамны зүгээс халамжийн бодлого хэрэгжүүлээгүй. Хүнсний хувьсгал, Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд арилжааны банкны эх үүсвэрийг ашиглаж, аж ахуйн нэгжүүдэд зээл олгох, хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаас дээр дэмжлэг үзүүлэхэд Засгийн газрын оролцоо байгаа. Малчид руу чиглэсэн татаас нь сүүний урамшуулал, ноос, арьс ширний урамшуулал байгаа. Ийм учраас халамжийн бодлого хэрэгжээгүй гэдгийг хэлмээр байна.

Х.Булгантуяа: - Нөөцийн мал бэлтгэлийн талаар Нийслэлээс хариульъя.

М.Балдандорж: - Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Хотын инженерийн дэд бүтцийн газрын дарга М.Балдандорж гишүүний асуултад хариульъя.

Нийслэлийн хүн амын 2024-2025 оны өвөл, хаврын улирлын хүнсний хэрэгцээнд ер нь 5,500-6,000 тонн мах бэлтгэх тооцоо судалгаа гаргасан. Нийслэлийн 2025 оны төсөвт 7.9 тэрбумын хүүгийн татаасыг суулгахаар ажиллаж байна. Нийт нөөцийн мах бэлтгэлтэй холбоотой 13 аж ахуйн нэгжээс материал ирснээс өнөөдрийн байдлаар 8 аж ахуйн нэгжтэй ажлын хэсэг хэлэлцээрт орсон. Одоогийн байдлаар 6 аж ахуйн нэгж энэ шаардлагад нийцсэн, 5 арилжааны банканд зээлийнх нь гэрээ хэлэлцээрийг хийх, судлуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авсан.

Өнөөдрийн байдлаар 2 арилжааны банк болох “Хаан банк”, “Худалдаа хөгжлийн банк” зээлийн хүүгийн хөнгөлөлтийн зардлыг санхүүжүүлэх гэрээг байгуулчихсан. Нөөцийн банк бэлтгэх ажил 80 хувьтай явж байна.

Х.Булгантуяа: - Нүүрсний нөөц, цахилгаан станцуудын бэлэн байдал, аваарын асуудлаар Эрчим хүчний яамнаас хариульъя.

Б.Насантогтох: - Эрчим хүчний яамны хэрэгжилтийн газрын дарга Б.Насантогтох С.Эрдэнэболд гишүүний асуултад хариульъя.

Өнөөдрийн байдлаар ДЦС-уудын нүүрсний нөөц 15-22 хоногийн нөөцтэй буюу өвлийн горимдоо орчихсон ажиллаж байна. ДЦС-уудын засвар, өвөлжилтийн бэлтгэл ажил 94 хувьтай байна. Үндсэндээ хавар, зун, намар хийсэн нийт их урсгал 860 төрлийн ажил, хөрөнгө оруулалтын 640 ажлыг хийж гүйцэтгэсэн. ДЦС-уудын онцлог өвлийн горимд шилжихээс өмнө засварын ажлыг хийж дуусахгүй бол тоноглолуудаа ажиллагаанд залгаж чадахгүй. Иймд бүх засварын ажлаа дуусгаад, 7 ДЦС-ууд бүх тоноглолууд ажиллагаанд бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна.

Улаанбаатар дулааны сүлжээний хувьд энэ жилийн өвөлжилтийн горимд нэг онцлог байгаа. Дэлхийн банкны төсөл, Европын сэргээн босголтын банкны

нийт 5 багц Улаанбаатар хотын дулааны төв магистралыг шинэчлэн өргөтгөх ажлуудыг энэ зун, намар дуусгасан.

Улаанбаатар дулааны сүлжээний хувьд ДЦС салбарын хэмжээнд аваарын нөөц бүрдүүлэлт 90 хувьтай байна. Жагсаалтаар батлагдсан нөөцийг бүрдүүлж 10, 11 дүгээр сард яамны хяналтын газраас бүрэн тооллого хийж баталгаажуулсан байдаг. Улаанбаатар дулааны хувьд засварын ажлыг бүрэн дуусгасан. Улаанбаатар дулааны сүлжээг өвлийн горимоос өмнө бүрэн ажиллагаанд залгах ёстой. Иймд горимоос өмнө засвар дууссан байх ёстой.

Эрчим хүчний салбарын их засвар өвөлжилтийн бэлтгэл ажлын онцлог нь өвлийн горимоос өмнө бүх тоноглолуудыг ажиллагаанд залгах өвлийн горимоос өмнө бүх төлөвлөсөн засварын ажлуудаа хугацаанд нь дуусгах, цаг хугацаанд тооцоолж ажилладаг ба засварын ажлын чанар нь өвлийн горимын ажиллагааны үед шалгагддаг юм.

Х.Булгантуяа: - Улсын Их Хурлын дахь Монгол Ардны намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Ухнаагийн Отгонбаяр асуулт асууна.

У.Отгонбаяр: - Оройн мэнд хүргэе.

Эхний асуулт, өнгөрсөн жил Монгол Улс 8-9 сая орчим малаа зудад алдсан. Өнгөрсөн жилийн үйл явдал зуд гэхээсээ илүүтэйгээр байгалийн гамшиг болсон. Сүхбаатар аймаг гэхэд 1.8 сая, Говьсүмбэр 179 мянга, Дорноговь 600, 700 орчим мянган мал, Хэнтий аймаг гэхэд 1.1 сая мал, Архангай аймаг 1 сая мал алдсан. Үндсэндээ 8, 9 сая малын 4.5 сая орчим нь зөвхөн энэ 5 аймагт байна.

Энэ байгалийн гамшгаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам ямар сургамж авч үлдэв? Энэ жилийн өвөлжилтийн бэлтгэл хангахад ямар ажлуудыг төлөвлөгөөндөө тодорхой оруулж чадав гэдгийг тодруулъя.

Хоёр дахь асуулт, малчдын даатгалын, малын индексжүүлсэн даатгал гэж хэл ам, хэлцэл шуугиан дагуулж байдаг. Үндсэндээ малчид банкнаас зээл авахын тулд малын индексжүүлсэн даатгалд хамрагддаг. Малаа зуд турханд алдвал нөхөн төлбөр авахын тулд даатгуулж байгаа биш, банкнаас зээл авахын тулд зээлийн шалгуурт даатгуулсан байх ёстой гэдэг. Тийм учраас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам малын индексжүүлсэн даатгал дээр ямар бодлого цаашид барьж ажиллах вэ? Энэ асуудалд дорвитой өөрчлөлт, шинэчлэлт хийж цаг үетэйгээ хөл нийлүүлж алхах зайлшгүй шаардлага байгаа. Үүнийг орон нутгаас иргэд их асуудаг тул иргэдийн төлөөлөл болж үүнийг албан ёсоор асууж байна. Өнгөрсөн жил 35 орчим мянган өрх 4.9 тэрбум төгрөгөөр малаа даатгуулсан. Тэгээд буцаагаад 22; 23 мянга орчим өрх 16.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, олговрыг авсан байх жишээтэй.

Өнгөрсөн жилийн хувьд зуд турхантай, байгалийн гамшигтай, малын хорогдол их байсан учраас нөхөн төлбөрийг тодорхой хангалттай хэмжээнд малчид маань авч чадсан. Цаашид нарийн бодлого хэрэгтэй байна.

Гурав дахь асуулт, зуд турхан болдгоороо болно. Энэ бол ойлгомжтой. Байгалийн давтагдашгүй хүчин зүйлийн нөлөө улам их ихсэх нь шинжлэх ухаанаар нотлогдсон зүйл. Өнгөрсөн жил цасанд боогдоод сумынхаа удирдлагуудтай, онцгой байдлынхантай холбогдож чадахгүй олон сар болсон олон айлууд байсан. Мал нь хоргоддог, малчид нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч чаддаггүй.

Дөрөв дэх асуулт, боловсролын асуудал. Олон сараар цасанд боогдоод хүүхдүүд хичээлдээ явж чаддаггүй. Хэрвээ энэ жил айхтар зуд турхан болбол эрүүл мэнд, боловсролын чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна?

Дараагийн асуулт. Өвс тэжээлийн нөөц бэлтгэх асуудал нэлээдгүй яригддаг. Өвлийн бэлтгэл ажлын хүрээнд малд 10 боодол өвс өгөхөөсөө илүүтэйгээр ногоон тэжээл, хүчит тэжээл, даршилсан тэжээл рүү түлхүү анхаарах ёстой. Тийм учраас ногоон тэжээл, хүчит тэжээлийн чиглэлээр тусгайлан хөтөлбөр байна уу? Энэ чиглэлээр өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд ямар ажлуудыг төсөв төлөвлөгөөндөө тусгасан бэ гэдгийг асууж тодруулъя.

Х.Булгантуяа: - Ажлын хэсгийнхэн эхлээд хэн хариулах вэ? Т.Баярхүү дарга.

Т.Баярхүү: - У.Отгонбаяр гишүүний асуултад хариулъя.

Цас ихээр орж зам, даваа хаагдсан өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн, зудад нэрвэгдсэн үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ тулгамдсан асуудал болдог. Үүнтэй холбоотойгоор өнгөрсөн өвлийн зудын үеэр УОК-оос бүс хариуцсан сайд нарыг, мөн томилж ажиллуулах, шуурхай ажлын хэсгүүдийг орон нутагт томилон ажиллуулах үед Улсын нэгдсэн 1 дүгээр эмнэлэг, 2, 3 дугаар эмнэлэг, Гэмтлийн эмнэлэг зэрэг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нараас бүрдсэн хөдөлгөөнт багуудыг тухайн үед аслагдсан зам, даваанд хаагдсан бүс нутгуудад, айл өрхүүд рүү хүргэж ажиллуулах чиглэлээр зохион байгуулалтын ажлуудыг авч хэрэгжүүлсэн. Өвс тэжээлийг хүргэх, зам, давааг нээх явцад давхар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх ажлыг зохион байгуулсан.

Үүний хажуугаар сумын Эрүүл мэндийн төвүүд дээр эмч, мэргэжилтэн дутагдалтай Эрүүл мэндийн төвүүд дээр тухайн үед нарийн мэргэжлээр сурч байгаа резидент эмч нарыг дайчлан сумын төвүүдэд ажиллуулах, мөн аймаг, сумын Эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэг үзүүлэх байдлаар эмнэлгийн тусламж, үйлчилгээг цасанд боогдсон, зудад нэрвэгдсэн, алслагдсан дүүрэг, сум, багуудад байгаа айл өрхүүдэд хүргэх чиглэлээр ажлуудыг зохион байгуулж ажилласан.

Мөн сургуулийн дотуур байранд хүнсний хомсдол үүсэх, цахилгаан эрчим хүчний тасалдах, дэд бүтцийн гэмтэл гарах зэрэг сургуулиуд дээр асуудлууд үүсэж байсан. Энэ асуудлыг Боловсролын яамтай хамтран зохион байгуулалтын арга хэмжээг авч, аймаг орон нутгийн байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар ханган зохицуулалтуудыг хийж ажиллаж байсан.

Тухайлбал, Боловсролын сайдын аймаг орон нутгуудад өгсөн үүрэг чиглэлийн дагуу тухайн аймаг, сумын Засаг дарга нар орон нутгийнхаа нөхцөл байдлыг үнэлээд сурагчдын хичээл, сургалтын график хөтөлбөрт тодорхой зохицуулалтуудыг бие даан хэрэгжүүлэх үүрэг, чиглэлийг өгч тухайн үед нь ажиллаж байсан. Иймд энэ чиглэлээр холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа.

Х.Булгантуяа: - Малын индексжүүлсэн даатгалын талаар Ц.Болорчулуун дарга хариулах уу?

Ц.Болорчулуун: - У.Отгонбаяр гишүүний асуултад хариулъя.

Уламжлалт мал аж ахуй байгаль цаг уурын хүндрэлтэй тулгарах нь тодорхой байгаа учраас Монгол Улсын Засгийн газраас “Шинэ Хоршоо” хөдөлгөөнийг санаачилж, үүнтэй холбоотой тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтын зээлийн асуудлыг шийдэж байгаа. Энэ хүрээнд хөрөнгө оруулалтын зээлийг 14 чиглэлээр зарцуулахаар төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Малчид хоорондоо хоршиж, нэгдэж ажилласнаар эрсдэлийг даван туулах боломж гэж харж байгаа.

Тийм учраас “Шинэ Хоршоо” хөдөлгөөнийг улам өргөжүүлэх, бэхжүүлэх, малчид хоршиж ажиллах боломжийг бий болгоход тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна гэдгийг хэлье.

Эрсдэлийг даван туулах аргыг зөвхөн мал аж ахуй салбарт биш, газар тариалангийн буюу нийт хөдөө аж ахуйн салбар дээр ашиглаж, үүнийг даатгалын тогтолцоотой холбох асуудал байгаа.

Мал аж ахуйн салбарт малын индексжүүлсэн даатгал хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хэдий ч хэд хэдэн шалтгааны улмаас малчид даатгалын тогтолцоонд бүрэн хамрагдаж чадахгүй байгаа.

Нэгдүгээрт, төлбөр, хураамжийн асуудлууд яригддаг.

Хоёрдугаарт нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиараа тухайн сумын малын 6 хувиас дээшээ мал хорогдсон тохиолдолд даатгалын систем үйлчилж байгаа. Сангийн яамнаас санаачлаад малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа. Энэ хувь, хэмжээг тухай бүр нөхцөл байдалтай уялдуулаад Засгийн газар тогтооно гэсэн өөрчлөлттэйгээр хуулийн үзэл баримтлалын төслийг нь батлаад удахгүй Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх гэж байгаа. Улмаар малчид даатгалд хамрагдах хөшүүрэг болно гэж харж байгаа.

Малчид хоршиж дундын үйлчилгээний техниктэй болоод, үйлдвэрлэл явуулах хэмжээнд хүрэхэд малын чанар, үүлдэрлэг байдал дээр анхаарах, тооноос чанарт шилжих асуудал хамгийн гол асуудал болж байна. Улмаар сайн үүлдрийн малтай, чанартай, таваарлаг малтай, нэг малаас авах ашиг шим өндөртэй малтай байхын тулд тэжээлийн асуудлыг шийдэх ёстой байгаа.

Сүүлийн жилүүдэд ган, зудын нөхцөлтэй уялдуулаад таримал тэжээлийн ашиг тусыг малчид ойлгодог болсон. Улсын хэмжээнд эрчимжсэн аж ахуйг хөгжүүлээд, малын үүлдэр угсааг сайжруулахад 200 мянган атар газрыг тариалангийн үйлдвэрлэл, тэр дундаа тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зайлшгүй шаардлага байгаа. Энэ 200 мянган га газрыг эргэлтэд оруулах асуудал “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолд туссан. Аймгууд дээрх атар газрын судалгааг гаргасан. Сонгуультай холбоотойгоор аймгууд шийдвэрээ гаргаж ирээгүй. Энэ 200 мянган га-гаа ирэх жилээс эргэлтэд оруулбал хүчит тэжээл, ногоон тэжээл, шүүслэг тэжээлийг хийх боломж нь бүрдэнэ гэж харж байгаа. Тийм учраас энэ газрын асуудлыг шийдсэнээр цаашдаа таримал тэжээл, тэжээлийн үйлдвэрлэлд анхаарах боломж үүснэ гэж харж байна.

Х.Булгантуяа: - Минут нь болоогүй байгаа учраас Ц.Отгонбаяр гишүүн нэмж тодруулах уу?

У.Отгонбаяр: - Ч.Болорчулуун дарга малчдыг малын индексжүүлсэн даатгалд хамрагдахгүй байгаа гэж хэлж байна.

200 гаруй мянган малчдаас 35 мянга орчим өрх малын индексжүүлчихсэн даатгалд хамрагдаж байгаа. Хамрагдахгүй байгаагийн гол шалтгаан нь малаа даатгуулаад нөхөн олговроо авч чадахгүй байгаа юм.

Учир нь тухайн сумд таван хошуу малын 5 төрөлд хамгийн багадаа 5 хүртэлх хувийн хорогдолтой байвал нөхөн олговор олгож байгаа. Хэрвээ адуу, үхэр, хонь, ямаа гээд 4 төрөлд 5 хувьтай, 1 төрөлд нь 5-аас доош хувьтай бол энэ нөхөн олговор олгогддоггүй.

Малын индексжүүлсэн даатгалын хувь, хэмжээг анхаарах зайлшгүй шаардлага байгаа. Үүнийг малчид байнга ярьдаг. Хэрвээ бизнесийн зарчмаар мал тодорхой хэмжээнд хорогдлоо тэгээд нөхөн олговороо олж авдаг бол малын индексжүүлсэн даатгал хэвийн явах боломж байгаа. Иргэдийн асуултад асуудал гарсан.

Ноднин өвөлжилтийн бэлтгэл хангадаг үеэр нь шатахууны хомсдол үүссэн. Намаржаанаасаа өвөлжөөндөө очиж чадаагүй, өвс тэжээлээ татаж чадаагүй анхны цастай золгосон эрсдэлтэй байдалд орсон. Энэ жил шатахууны хомсдол харьцангуй гайгүй байх юм байна гэж ойлголоо. Үнийн асуудал дээр тодорхой мэдээлэл өгөөч. Үнэ харьцангуй тогтвортой байж чадах нь уу? Төгсгөлд малын индексжүүлсэн даатгал дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам малчдынхаа эрх ашгийг хамгаалах чиглэлд түлхүү ажиллаарай гэдгийг дуулгая. Баярлалаа.

Х.Булгантуяа: - Шадар сайд С.Амарсайхан хариулах уу?

С.Амарсайхан: - У.Отгонбаяр гишүүний хөндөж байгаа малын индексжүүлсэн даатгал чухал асуудал. Индексжүүлсэн даатгалын бодлого, хууль,

эрх зүйн орчныг боловсронгуй болгох, яаралтай шийдвэрлэх ёстой асуудал юм. Өвөл, хаврын эрсдэл, зуд турхантай үед малчдын эрх ашгийг хамгаалах, улмаар тогтвортой хөгжлийг хангахтай холбоотой бодлогыг дэмжиж, хэрэгжүүлэх чухал ажил юм. Энэ асуудлыг ойрын хугацаанд хэлэлцэж, ярилцаж Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэх, хуулийн төсөл дээр ажиллах ёстой.

Нэгдүгээрт, малын индексжүүлсэн даатгалын төлбөрийн нөхцөлийг сайжруулах хэрэгтэй байгаа. Анх хэрэгжиж эхэлснээсээ хойш цаг хугацаа ч өөрчлөгдсөн, нөхцөл байдал ч өөрчлөгдсөн. Тэгэхээр малчдын эрсдэлд тохируулсан даатгалын нөхөн төлбөрийг оновчтой тогтоох асуудлыг шийдэхгүй бол цаашид хэрэгжилт хангалтгүй байгаа. Нөхөн төлбөрийн хэмжээг цаг агаарын аюулт үзэгдэлтэй уялдуулахаас гадна бодитой тооцоолол хийх аргачлалуудыг шинэчлэх шаардлагатай. Тэгээд индексийн системийг илүү оновчтой болгох, нарийвчлалтай болгож малын эрсдэлийг бодитоор шуурхай тодорхойлох, орон нутгийн цаг агаарын нөхцөл байдалтай нь уялдуулах тогтолцоог бий болгох шаардлага байна.

Хоёрдугаарт, малын индексжүүлсэн даатгалын хуулийн хүрээний асуудлыг боловсронгуй болгох. Малчдын орлогыг хамгаалахад энэ даатгал чухал юм. Энэ хуулийн шинэчилсэн найруулгад индексжүүлсэн даатгал болон бусад төрлийн даатгалын хуульд ч давхар зохицуулалтыг хийж, илүү уян хатан, ойлгомжтой болгох асуудал байгаа. Ойлгомжгүй байгаа “индексжүүлсэн” гэдэг тухай малчид ойлгохгүй хүндрэлтэй байгаа учраас малчдын даатгалын компаниудын үйл ажиллагаатай уялдуулах бодлого шинэчлэгдэх ёстой.

Гуравдугаарт, малчдад чиглэсэн бодлогын хүрээнд төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулж, малчдын даатгалтай холбоотой эрсдэлийг хамгаалах хэрэгцээ, шаардлагыг илүү тодорхойлж, мэдээ, мэдээллээ хүртээмжтэй болгох ажлуудыг төлөвлөж хийхээр ажиллаж байна. Орон нутгийн малчдын орлого, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан шинэ даатгалын хөтөлбөрийг ойрын хугацаанд даатгалын эрсдэлийн сан, индексжүүлсэн даатгал зэрэг бүтэцтэй уялдуулан сайжруулах хэрэгтэй.

Даатгалын талаар малчдад дэлгэрэнгүй мэдээллийг өгч, тэдний ойлголтыг дээшлүүлэх, чадварыг нь нэмэгдүүлэх, мэдлэг сургалт олгох сургалтуудыг зохион байгуулах ажлыг “Шинэ Хоршоо” үндэсний хөдөлгөөний хүрээнд хийх юм. Энэ бодлого шийдвэр малчдын өөрсдийнх нь нөхцөл байдал, эрэлт хэрэгцээтэй уялдаж хэрэгжих юм.

Дөрөвдүгээрт, шатахууны асуудал байна. Шатахууны үнийн өсөлт өнөөдрийн байдлаар савлагаа, хөдөлгөөн байхгүй тогтвортой байгаа. Хангалт, нийлүүлэлт төлөвлөсөн ёсоор хийгдэж нөөц бүрдүүлж байна. Эрдэс баялаг, аж үйлдвэрийн яам болон импортлогч, түгээгч аж ахуйн нэгжүүд хоорондоо үйл ажиллагаагаа уялдуулах, зохион байгуулалтын ажлыг хамтран хийвэл цаашид шатахууны үнэ өртөг хэлбэлзээд байхгүй гэж үзэж байна.

Цаашид шатахууны хангалт, нийлүүлэлт нь цаг үеийн нөхцөл байдал, үүсэж болзошгүй хүчин зүйлүүдээс шалтгаалаад өөрчлөгдөх боломжтой байгаа.

Х.Булгантуяа: - Улсын Их Хурлын гишүүдээс, иргэд олон нийтээс ирсэн асуултыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.10-д заасны дагуу Улсын Их Хурал дах нам, эвслийн бүлэг тавьж, хариулт авлаа. Ийнхүү өнөөдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын өвөлжилттэй холбоотой мэдээллийг сонслоо.

Оролцсон гишүүддээ баярлалаа.

---oOo---

1.3.2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДРИЙН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ 5Ш АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН “ШИЛ” АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ



Л.Оюун-Эрдэнэ: - Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улс шинэ Үндсэн хуулиа баталж ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш 1992 оноос 2024 он хүртэл нутаг дэвсгэрийг төлөөлсөн 76 гишүүнтэй парламенттайгаар үйл ажиллагаа явуулж ирсэн бол 2024 оноос буюу энэ жилээс сонгуулийн холимог тогтолцоогоор бүрдсэн 126 гишүүнтэй парламент, түүнээс бүрдсэн хамтарсан Засгийн газар өөрийн түүхийг ийнхүү бичиж эхэлж байна.

Улсын Их Хурлын болон Орон нутгийн сонгуулийн 2024 он өндөрлөх дөхөж, улс төр, нийгэм, эдийн засгийн бүтцийг цоо шинээр харах нийгмийн захиалга бүхий түүхэн хариуцлагатай 2025 он эхлэх гэж байна.

Өнгөрснөө зөвөөр дүгнэхгүйгээр ирээдүйг зөв тодорхойлох боломжгүй гэдэгчлэн өнөөдрийн энэхүү мэдээллийг ондоо багтаж өгөх нь зүйтэй гэж үзлээ.

Өчигдөр Та бид хамтдаа 16-аас 20 жилийн хугацаанд гацсан хөгжлийн томоохон төслүүдийг хөдөлгөх түүхэн шийдвэрийг хамтдаа гаргалаа.

Ерөнхий сайдын хувьд улс орны хөгжлийн томоохон асуудлыг том зургаар нь харж дэмжсэн парламентын гишүүд Та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон “Шинэ сэргэлтийн бодлого”-д дэвшүүлсэн төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, бүтээмжийг дээшлүүлэх, иргэдийн мэдэх эрхийн баталгааг хангах зорилтын хүрээнд “Шил ажиллагаа”-г хэрэгжүүлж байна.

“Шил ажиллагаа”-г авлига, хүнд суртлыг бууруулах, иргэд нээлттэй мэдээлэлтэй нэг цонхоор, саадгүй байдлаар танилцах, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг бүрдүүлэх, мэдээлэл хариуцагч байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдалд үнэлгээ хийж, “Шилэн индекс”-ийг зарлах зорилготойноор хэрэгжүүлж эхэлсэн.

Монгол Улсын хөгжлийг сааруулагч гол хүчин зүйлсийн нэг болох авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлд

нийгэм, эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх, авлигыг үл тэвчих олон нийтийн хандлагыг төлөвшүүлэх, иргэдийн оролцоо, дэмжлэгт тулгуурлан авлигыг бүх шатанд таслан зогсоох зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулан “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгаврыг гаргасан.

“Шил ажиллагаа”-ны хүрээнд “shilen.gov.mn” цахим системийг 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр ашиглалтад оруулж, иргэд, олон нийтийг нээлттэй мэдээллээр хангаж, үндэсний хэмжээнд “Шилэн индекс”-ийг зарласан ба энэ хүрээнд 14 удаагийн хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж ажиллалаа.

Мөн яам, Засгийн газрын агентлаг болон аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит, өмчийн оролцоотой мэдээлэл хариуцагч байгууллагын 604 гаруй багц мэдээллийг “shilen.gov.mn” системд нээлттэй байршуулаад байна.

Одоогийн байдлаар тус системд иргэдээс нийт 15,624,726 удаа хандаж, холбогдох мэдээллийг авсан байна.

Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем буюу “shilen.gov.mn” системд 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар нийт 39 төрлийн 970,355 мэдээлэл байршуулсан. Үүнд:

1. Богдхан уулын дархан цаазат газар, Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт хамаарах 78 байршилд 4,568 га газрыг 2,079 хүн, хуулийн этгээдэд ашиглуулах шийдвэр гаргасан талаар;

2. Хүн, хуулийн этгээдийн эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийн ерөнхий үнэлгээний 10,812, нарийвчилсан үнэлгээний 4,696 буюу нийт 15,508 үнэлгээний талаар (2008 оноос хойш);

3. Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 13,399 барилгад өгсөн архитектур төлөвлөлтийн даалгавар, 4,721 барилгад өгсөн дүгнэлт болон тус комиссын бүрэлдэхүүний талаарх мэдээлэл (2008 оноос хойш);

4. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой 238 хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 1,608 гишүүний талаарх мэдээлэл;

5. Төрийн өмчид хамаарах 93.5 м² талбай бүхий объектыг түрээслэгч 102, түрээслүүлэгч 570 байгууллагын талаарх мэдээлэл;

6. Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээтэй холбоотой доор дурдсан багц мэдээлэл:

- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2009-2022 оны орлого, зарлагын мэдээллийг жагсаалтын хамт;

- Хөдөө аж ахуйн корпорацаас 1994-2022 оны орлого, зарлагын мэдээллийг жагсаалтын хамт;

-Улсын авто замын сангийн 2008-2023 оны хооронд нийт 107 хуулийн этгээдэд олгосон 187,4 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

-Соёл, урлагийг дэмжих сангийн 2020–2022 оны хооронд нийт 241 хүн, хуулийн этгээдэд олгосон 6,5 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

-Кино урлагийг дэмжих сангийн 2023 онд 11 хүн, хуулийн этгээдтэй байгуулсан 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилт, одоо хэрэгжүүлж байгаа гэрээний мэдээллийг жагсаалтын хамт;

-Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн 2012–2023 оны хооронд гэмт хэргийн хохирогч болсон 484 иргэнд олгосон 2.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, 1.6 тэрбум төгрөгийн авлагын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

-Боловсролын зээлийн сангийн 1996-2023 оны хооронд нийт 2836 суралцагчид гадаадын зээл, тэтгэлгийн чиглэлээр олгосон 32.8 тэрбум төгрөгийн санхүүжилт, түүнээс 316.0 тэрбум төгрөгийн зээлийн мэдээллийг жагсаалтын хамт;

-Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017-2023 оны хооронд давхардсан тоогоор 666 байгууллага, 18,477 суралцагчид олгосон 72.2 тэрбум төгрөгийн зарцуулалтын мэдээллийг жагсаалтын хамт;

-Шинжлэх ухаан, технологийн сангийн 2007–2022 оны хооронд нийт 381 хүн, хуулийн этгээдэд олгосон 2780 төсөл, хөтөлбөрийн 151.9 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

-Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2013-2022 оны хооронд 724 хүн, хуулийн этгээдэд олгосон 1091 төсөл, хөтөлбөрийн 17.2 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

-Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангаас 2009-2023 оны хооронд 2000 гаруй иргэнд 3.1 тэрбум төгрөгийн тусламж олгосон талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

-Нийгмийн халамжийн сангийн 2008-2022 оны орлого, зарлагын мэдээлэл;

-Нийгмийн даатгалын сангийн 2008-2022 оны орлого, зарлагын мэдээлэл;

-Хүүхдийн төлөө сангийн 2021-2023 оны хооронд үүсгэсэн нийт 11.0 тэрбум төгрөгийн хуримтлал болон үүнээс 106.7 сая төгрөгийг нийт 45 хүүхдэд 2 төрлөөр зарцуулсан талаарх мэдээлэл;

-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2012-2022 оны орлого, зарлагын мэдээлэл;

-Ирээдүйн өв сангийн 2017-2022 оны орлого, зарлагын мэдээлэл;

-Төсвийн тогтворжуулалтын сангийн 2011-2022 оны орлого, зарлагын мэдээлэл;

-Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018-2022 оны орлого, зарлагын мэдээллийг жагсаалтын хамт;

-Эрүүл мэндийг дэмжих сангийн 2008-2023 оны хооронд нийт 739 хуулийн этгээдэд олгосон 30.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг жагсаалтын хамт;

-Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2009-2022 оны орлого, зарлагын мэдээллийг жагсаалтын хамт;

-Спортыг дэмжих сангийн 2017-2019 оны хооронд нийт 57 хуулийн этгээдэд олгосон 66 төсөл, арга хэмжээний 4.9 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаар.

7.Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан шийдвэрийн талаарх мэдээлэл (2008 оноос хойш);

8.Эрх бүхий 18 байгууллагаас олгодог 14,344 зөвшөөрөл, ашигт малтмалын хайгуулын 885, ашиглалтын 1713 тусгай зөвшөөрлийн мэдээллийг жагсаалт.

Түүнчлэн, “Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем”-ийн 2.0 хувилбарыг хөгжүүлж, хиймэл оюуны ухааны сүүлийн үеийн GPT технологийг ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийн санд нэвтрүүлээ.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нээлттэй мэдээллийг 98 шалгуур үзүүлэлтээр 7 хоног бүр үнэлж, үнэлгээний мөрөөр сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Нийт 172 байгууллагыг үнэлэхэд дундаж үзүүлэлт 77.2 хувьтай байна. Үүнээс:

- Төрийн захиргааны төв байгууллагын дундаж үзүүлэлт 90 хувь;
- Төрийн захиргааны байгууллагуудын дундаж үзүүлэлт 93.7 хувь;
- Нутгийн захиргааны байгууллагуудын дундаж үзүүлэлт 72.6 хувь.

Мэдээлэл хариуцагч 974 байгууллагын 1136 албан тушаалтан “Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем”-д тоон гарын үсгээр нэвтэрч байнга ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг өөрчлөлтийн хамт тухай бүр байршуулах боломжийг бүрдүүллээ.

“Шил ажиллагаа”-ны үр дүнд төрийн үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналт дээшилж, Монгол Улс НҮБ-ын Цахим засаглалын хөгжлийн индексээр 2024 онд 28 байраар урагшилж, 193 орноос 46 дугаарт жагссан байна.

Түүнчлэн төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн шийдвэр, тайлан мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулах нь компанийн сайн засаглалын олон улсын суурь зарчим юм.

Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалын хаалттай байдал нь хуулийн этгээд үр ашиггүй ажиллах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх, төрийн өмч үнэгүйдэх, төрд үүсэх зардлыг нэмэгдүүлэх шалтгаан болж байгаа тул төрийн өмчит 119 компанийн ашиг, алдагдлын болон төсөвт төвлөрүүлсэн татварын мэдээллийг “Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем” болон “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас”-нд ил тод байршууллаа.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа ил тод, хараат бус, хөндлөнгийн хяналттай байх зарчимд үндэслэн гурван жил дараалан хангалтгүй гэж дүгнэгдсэн, үйлдвэрлэлийг өргөжүүлэх, технологийг шинэчлэхэд хөрөнгө оруулснаас бусад тохиолдолд гурван жил дараалан санхүүгийн алдагдал хүлээсэн төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах, шаардлагатай бол Засгийн газрын шийдвэрээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар аудит хийлгэх зохицуулалтыг тусгасан Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг боловсруулан олон нийтээс санал авч байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДРИЙН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ 5Ш АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН “ШИЛ” АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ХИЙСЭН МЭДЭЭЛЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх М.Тулгат, тус яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Бат-Өлзий, Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Салбар дундын зохицуулалт хариуцсан шинжээч Г.Энхтулга, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулга, “И-Монгол Академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Б.Мягмарнаран нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Тамгын газрын дэд дарга Ү.Амарбат, Хяналт шалгалтын газрын дарга Т.Нармандах, мөн газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг, ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны хүрээнд хийгдсэн “Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаар мэдээлэл хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.6-д заасны дагуу цөөнхийн төлөөллөөс Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Б.Жаргалан, ХҮН намыг төлөөлж П.Ганзориг, Үндэсний эвслийг төлөөлж А.Ундраа, Иргэний Зориг Ногоон Намыг төлөөлж Б.Батбаатар нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.11.-д заасны дагуу цахим хуудсанд иргэдээс асуулт ирээгүй болно.

Д.Амарбаясгалан: - Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь цөөнхийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Батбаярын Жаргалан, ХҮН намын төлөөлөл

Пүрэвжавын Ганзориг, Үндэсний эвслийн төлөөлөл Агваанлуvsсангийн Ундраа, Иргэний Зориг Ногоон Намын төлөөлөл Батын Батбаатар нар төв индэр дээрээс үг хэлнэ.

Батбаярын Жаргалан гишүүнийг индэрт урьж байна.

Б.Жаргалан: - Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1-д зааснаар Ерөнхий сайд нь төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцдаг.

Шил ажиллагаа гэх улс төрийн сурталчилгааны зорилготой нэр томъёог хууль зүйн хүрээнд авч үзвэл нээлттэй, мэдээллийн ил тод байдалтай холбоотой буюу Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Авлигын эсрэг хууль болон бусад хуулийн биелэлтийн талаарх мэдээлэл гэж ойлголоо.

Нээлттэй, ил тод байдал нь авлига, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх үр дүнтэй арга хэлбэр гэдгийг хүлээн зөвшөөрч ажиллаж байгаад талархалтай хандаж байна.

Ерөнхий сайдаас өгсөн мэдээллийг нягтлахад нээлттэй ил тод байдлыг тогтоосон хуулийн биелэлтийг хангалттай хариуцан ажиллаж чадахгүй байна гэсэн дүгнэлт гарч байна. Учир нь Засгийн газар хууль хэрэгжүүлэх гэхээс илүүтэйгээр улс төрийн ашиг хонжоо олох зорилготой ямар нэг ажиллагааг зарлан тунхаглаж зөвхөн энэ хүрээнд ажиллаж байгаа нь хууль хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгт нийцэхгүй байна.

Ямар нэг ажиллагааг цэрэг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбогдуулан зохион байгуулдаг. Харин эх орондоо иргэний ардчилсан нийгэм цогцлоохыг эрхэм зорилгоо болгосон ардчилсан Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан Засгийн газар нь хуулийн биелэлтийг хангаж ажиллах үндсэн чиг үүрэгтэй төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага юм.

Тодруулбал, Засгийн газар нь ямар нэгэн ажиллагаа явуулах бус Улсын Их Хурлаас баталсан заавал биелэх хүчин чадалтай хуулийг хэрэгжүүлэх, гүйцэтгэх үндсэн чиг үүрэгтэй гэдгийг Танд онцгойлон сануулж байна.

Өнөөдөр нээлттэй, ил тод байдлын харилцааг зохицуулж байгаа хуулиас тодорхой үр дүн өгч байгаа анхдагч хууль нь Ардчилсан нам Улсын Их Хуралд олонх байх үед буюу 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Шилэн дансны тухай хууль юм.

Шилэн дансны тухай хуулийн зорилт нь төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх явдал юм.

Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч, мөн төрийн санхүүжилт авч байгаа нам, эвсэл бүгд хамаардаг.

Өнөөдөр Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ энэ хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаар Улсын Их Хуралд ажлаа хариуцаж тайлагнах ёстой байтал хуулийн хэрэгжилт бус ямар нэг хийсвэр ажиллагааны талаар мэдээлж байгаа нь харамсалтай.

Түүгээр зогсохгүй “Шил” ажиллагаа гэх Ерөнхий сайдын танилцуулсан “shilen.gov.mn” систем болон түүнд байршсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нийтийн мэдээллийг бүхэлд нь хамарч чадахгүй байна.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг энэхүү санал, дүгнэлтээр Ерөнхий сайдаас гагцхүү бодит байдал буюу хуулийн биелэлтийг шаардаж байна. Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.10-т шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарыг нийтэд мэдээлэх үүрэгтэй гэж заасан байдаг.

2022 оны Үндэсний аудитын газрын шалгалтаар Засгийн газрын 13 яамны 12 нь Шилэн дансны тухай хуулийг дагаж мөрддөггүй, шилэн дансанд байршуулах ёстой мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, ил тод мэдээлдэггүй гэсэн зөрчил дутагдлыг илрүүлж байв.

Түүнчлэн 2016 он хүртэл Монгол Улс төрийн нууц мэдээллийг хуулиар тогтоон хамгаалж ирсэн. Гэтэл 2016 онд Монгол Ардын нам Улсын Их Хуралд олонх болсон даруйдаа буюу 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хүч түрэн баталж, төрийн нууцаас гадна албаны буюу төрийн байгууллагын нууц гэсэн шинэ ойлголтыг бий болгосон.

Ингэснээр маш олон гэрээ болон бусад мэдээллийг нууцад хамруулж, олон нийт мэдэх эрхгүй болж, мэдвэл шоронд орох нөхцөл бүрдсэн. Өөрөөр хэлбэл төрийн байгууллагын аль ч шатын дурын нэг дарга өөрийнхөө үйл ажиллагааг нууцад хамруулан олон нийтээс далдлах боломжийг бүрдүүлсэн нь манай улсад авлига цэцэглэн хөгжих таатай хөрс болсон бөгөөд үүнийг залруулах, өөрчлөх тал дээр Ардчилсан намын бүлэг тууштай ажиллах болно гэдгийг мэдэгдэж байна.

Үүнээс гадна улс төрийн нам нь шилэн ажиллагаанд хамрагдахгүй байна. Шил ажиллагааг хэрэгжүүлж буй Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нь өөрийн удирддаг намаа “Шил” гэх ажиллагааныхаа гадна үлдээснийг гайхан анзаарч байна.

Эрх баригч намын санхүүжилт “Шилэн бус ширэн байгаа”-г Танд дахин сануулья.

Манай улс авлигын индексээр 2016 онд 180 орчим орноос 87-д жагссан бол 2024 онд энэ үзүүлэлт 121 болж, 8 жилийн дотор 34 нэгжээр ухарсан. Авлигын аюул занал нь ардчиллын үнэт зүйлс, ардчилсан тогтолцоог сулруулж, шударга ёсыг үгүй хийж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулдаг бөгөөд төрийн тогтвортой байдал, сайн засаглал, эдийн засгийн хөгжилд заналхийлсээр ирлээ.

Тиймээс “Ширэн биш шилэн төр”-ийг хүсэж байгаа бол, “Авлигагүй нийгэм”-ийг бүтээхийг зорьж байгаа бол Засгийн газар өөрөөсөө олонхыг бүрдүүлсэн Монгол Ардын нам, мөн өөрөөсөө эхлэн үйл ажиллагаагаа шилэн болгож нийтийн манлайлал үзүүлэхийг хүсье.

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотойгоор Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг уншиж танилцууллаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: - Улс төрийн намын тухай хууль 18 жилийн дараа батлагдаад улс төрийн намууд татварт тайлангаа ил тод өгдөг болох хуулийн зохицуулалт өнгөрсөн жил батлагдсан. Энэ нь “Шил” ажиллагааны үр дүнгийн нэг юм.

Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзоригийг индэрт урьж байна.

П.Ганзориг: - Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэлд дурдагдсан авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй “Шил” ажиллагааны талаар Улсын Их Хурал дахь ХҮН намын зөвлөл дараах байр суурийг илэрхийлж байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шил” ажиллагааны үр дүнд төрийн үйл ажиллагааны ил тод байдлын зарчим цахимжуулах ажлуудад тодорхой дэвшил гарч байгаа хэдий ч цаашдаа Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийн хүрээнд сайжруулах анхаарах шаардлагатай дараах асуудлууд байна.

1.Шилэн дансны сайтуудад тодорхой мэдээллүүд олон нийтэд ил тод байдлаар байршиж байгаа хэдий ч холбогдох мэдээллүүд нь бүрэн бус, цаг хугацааны хоцрогдолтой ордог. Иргэд олон нийтэд ойлгомжтой бус байдалтай байна.

Уг асуудал дээр Засгийн газрын зүгээс төрийн мэдээллийн нэгдсэн стандарт форматад оруулж иргэд, олон нийт дүгнэлт, анализ хийх боломжтой зэргээр олон төрлөөр ашиглахуйц байдлаар байршуулах боломж нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

2.Төсвийн ил тод байдлын асуудлаар Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд Сангийн яамны танилцуулсан мэдээлэл

төсөвтэй холбоотой цахим мэдээллүүд нь олон нийтэд харьцангуй нээлттэйгээр нийтлэгдсэн боловч төсвийн ил тод байдлыг хангахын тулд улсын төсөв, түүний зарцуулалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар хэрэглэж болохуйц хялбар шийдлээр байршуулах талаар тодорхой саналууд гаргаж байсан.

Тухайлбал, энэ удаагийн Улсын Их Хурлын намрын чуулганаар 2024 оны Улсын төсвийн тодотгол, Монгол Улсын 2025 оны Улсын төсвийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдэд Сангийн яамнаас төсвийн мэдээллийг хайлт хийх боломжтой цахим файл хэлбэрээр олгоогүй нь Улсын Их Хурлын гишүүд улсын төсөвт дүн шинжилгээ хийхэд хүндрэл учирч байсныг цаашид анхаарч засах шаардлагатай байна.

3.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээ сайжруулах, шилэн ажиллагааг үргэлжлүүлэн төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ хэлцэл, мэдээллийн санг олон нийт нээлттэй, ил тод болгоно гэж заасан.

Тус заалт нь хамтарсан Засгийн газарт орсон намууд болон тэр дундаа ХҮН намын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт бөгөөд энэ нь төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэхтэй холбоотой хууль, тогтоомжийг шинэчлэн сайжруулах зорилготой юм.

Цаашид Төрийн болон албаны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжуудад зохих сайжруулалтуудыг хийж, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг улам нэмэгдүүлэх, дээр дурдсан нөхцөл байдлыг засаж сайжруулах чиглэлээр Засгийн газраас хууль тогтоомжийн шинэчлэлийн төслийг өргөн барих хэрэгцээ шаардлага байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй 5Ш ажиллагаа нь, тэр дундаа шил ажиллагаа ардчиллын суурь зарчим болох иргэдийн мэдэх эрхийг хангаж, төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, мөн аливаа албан тушаалтны авлига ашиг сонирхлоос ангид байх, урьдчилан сэргийлэх, цаашлаад бизнес, гадаад, дотоод хөрөнгө оруулалтын тооцоо орчныг бүрдүүлэх зэрэг чухал үүрэгтэй бөгөөд Улсын Их Хурал дахь ХҮН намын зөвлөл төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, аливаа санал санаачилгыг дэмжин хамтран ажиллах болно. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: - Үндэсний эвслийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Агваанлуvsангийн Ундрааг индэрт урьж байна.

А.Ундраа: - Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас авлигатай тэмцэх талаар авч хэрэгжүүлж буй шил ажиллагааны талаар мэдээлэл сонслоо.

“Shilen.gov.mn” сайт ажиллуулсан. Түүний хандалт 15 сая гаруй удаагийн хандалттай байгаа нь Монгол Улсын иргэд ил тод, авлигагүй нийгмийг бий болгох хүсэлтэй, нээлттэй мэдээллийг авах хүсэл эрмэлзэлтэй байгааг илэрхийлж байна.

Иргэд маань авлигагүй улс орныг хүсэж, ил тод байдлын чухлыг маш сайн ойлгож байна.

“Shilen.gov.mn” сайтад нийт хэдэн төрийн байгууллагууд мэдээлэл оруулах ёстойгоос хэд нь оруулж, хэд нь оруулаагүйг харуулбал илүү бодитой дүгнэлт гарахаар байлаа.

Харамсалтай нь мэдээлэл оруулсан байгууллагуудын гүйцэтгэлийг харуулж, төрийн байгууллагуудын хамрагдалтыг тооцоогүй нь бодит байдлыг дүгнэхэд учир дутагдалтай байгааг харуулж байна.

Нэг жишээ дурдахад Богдхаан уулын дархан цаазтай газарт газар олгогдсон байдлын талаарх мэдээлэл одоог хүртэл бүрэн ил тод бус хэвээрээ байна. 2015 оноос хойш Монгол Улс авлигалын индексээр нийт хэдэн байраар ухарсан талаар хуваалцъя.

2015 онд 72 дугаар байранд байсан бол 2016 онд 38 оноо авч 87 дугаар байраар ухарсан нь авлигатай тэмцэх үйл хэрэг нь тухайн үедээ оновчтой байгаагүйг шууд хэлж байна.

Монгол Улс бүсийн дунджаас доогуур буюу нийтдээ 100 онооноос 33 оноогоор 180 орноос 121 дүгээр байранд орж байгаа нь 2023 оны байдлаар өмнөх оноос нийтдээ 50 гаруй байраар ухарсан нь авлигатай тэмцэх үйл ажиллагаанд ахиц гарахгүй байгааг нотолж байгаа нэгэн баримт юм.

Цаашид сонгуулийг мөнгөнөөс хамааралтай байдаг байдлыг халах, үүнийг хууль тогтоомжийн хүрээнд зохицуулах, улс төрийн намуудын дотоод сонгуулийн журмыг ил тод болгох зэрэг төрийн байгууллагуудын ил тод байдлын үйл ажиллагааг нэвтрүүлж, гүйцэтгэл дээр анхаарал тавих нь авлигатай тэмцэх бодит үйлдэл болно гэж үзэж байна.

Бидэнд гоё ая тавьсан боевик киноны трейлерээс илүүтэй бодит гүйцэтгэл, үр дүн чухал байна. Жишээлбэл,

Румын Улсын Авлигатай тэмцэх газрын дарга Лаура Кодруца /Laura Codruța/ гэдэг эмэгтэй эх орондоо амьд домог болж байна. Тэрээр 2013-2018 оны хооронд Үндэсний Авлигатай тэмцэх газрын Ерөнхий прокурорын албыг хаших хугацаандаа нийтдээ улсдаа олон 100 сая еврогийн хохирол учруулсан авлигын 1100 гаруй хэргийг илрүүлж, 2 мянга гаруй төрийн өндөр албан хаагчдыг авлигын хэргээр шоронд суулгасан байна.

Лаура Кадруцагийн барьсан авлигачдын дунд парламентын гишүүд, үеийн Засгийн газрын сайд нар, агентлагийн дарга нар, муж, хотын дарга нар, төрийн өмчийн компанийн захирлууд оржээ.

Тэрээр тухайн үедээ сарын 3200 еврогийн цалинтай, ипотекийн зээлээр авсан 2 өрөө байранд амьдардаг байсан. Лаура Кодруца 2019 оноос Европын Холбооны Ерөнхий прокуророор томилогдон ажиллаж байна.

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотойгоор Улсын Их Хурал дахь Үндэсний эвслийн байр суурийг илэрхийллээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: - Иргэний Зориг Ногоон Намын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатарыг индэрт урьж байна.

Б.Батбаатар: - Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, иргэд сонгогчид оо,

Авлига бол Монголд амьдрах ёсгүй зүйл. Авлигын эсрэг олон үйл ажиллагаа зэрэгцэн явж байж сая Монгол Улс хөгжих боломж гарч ирнэ. Шилэн төртэй байх тухай асуудал өнөөдөр Ерөнхий сайдын мэдээллийн цагаар олон нийтэд танилцуулагдаж байна.

Улсын Их Хурлын гишүүдэд биш олон нийтэд, иргэд сонгогчдод танилцуулагдаж байна гэж Иргэний Зориг Ногоон Намынхан дүгнэж байгаа.

Иргэний Зориг Ногоон Нам Засаг барьж байгаа Улсын Их Хурлын 118 гишүүний “дүр үзүүлсэн үйлдлийг болио” гэж зөвлөж хэлж байна.

Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийнхаа дагуу аргагүйн эрхэнд засаг барьж байгаа нөхдүүд, цөөнхийн бүлгийн төлөөллийн үг хэлэхийг сонслоо гэдэг үгээр үгээ дуусгаж байна.

Улсын Их Хурал бол ард түмний бүрэн төлөөлөл учраас Улсын Их Хуралд ард түмэн бүгдээрээ сууж байгаа гэж ойлгох хэрэгтэй.

Ард түмний 118 хүн нь хамтдаа бүлэг үүсгэж, нэг засагтай болсон. Үлдсэн цөөнх нь цөөнхийн эрхийг эдлэх хэрэгтэй байгаа юм. Засгийг хамгаалах талаар 118-ын бүлгээс Ерөнхий сайдын мэдээллийн цаг дээр дүгнэлт уншдаг дүр үзүүлсэн ардчилал бидэнд хэрэггүй.

Шилэн байх тухай ойлголт бол иргэдийн мэдэх эрхийн тухай асуудал. Тэр мэдэх эрхийг цөөнх иргэдэд олгодог. Эрх мэдэл өөрөө өөрийгөө хянадаггүй. Эрх мэдэл бусдыг хянахын төлөө зориулагддаг гэдгийг онол, практикаар хангалттай мэднэ.

Өнөөдөр Улсын Их Хурал дахь хяналт шалгалт, хөндлөнгийн дүгнэлт гаргах Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, Хүний эрхийн дэд хорооны дарга энэ 118-ын бүлгээс томилогдож байгаа.

Та бүхэн шилэн байя гэж бодвол хяналт шалгалт хийх алба хаагчдын томилгоог цөөнхдөө чөлөөлж өгөх үүрэгтэй.

Улсын Их Хурлын бүтцийн болон бусад үйл ажиллагааны бүх зохицуулалтыг 118-ын бүлэг өөртөө хадгалж авч үлдэж байгаа.

Цөөнх юу хийх ёстой вэ? Өнөөдөр Монголын ард түмэнд ус агаар мэт хэрэгтэй байгаа цөөнхийн үүрэг гэж байгаа. Иргэдийн мэдэх эрхийг нь хангаж өгөх нь цөөнхийн хийх хамгийн гол чухал ажил. Хариуцлага үүрээд засгаа барьж байгаа олонх хийх ажлаа хийдэг байх хэрэгтэй.

Та бүхний зөв зүйтэй санаачилж хийсэн ажлыг дэмжинэ, харин буруу зөрүү бусдаас нууж, хааж, араар нь хөшигний цаана хийж байгаа зүйлийг буруушаана, шүүмжилнэ. Хөшиг болгоныг, цонх болгоныг нээлттэй байхын төлөө Иргэний Зориг Ногоон Намынхан ажиллах болно.

Бид иргэдийгээ зүрх сэтгэлтэй, мөрөөдөлтэй байлгах, тэдэнд ирээдүйдээ итгэх итгэлийг нь олгох ёстой гэж ойлгодог. Байгаль орчин, амьдрах орчны таатай нөхцөл, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны соёл иргэншлийг Монголын ард иргэд, ирээдүйн үр хойчид үлдээхийг ногоон соёл иргэншил гэж ойлгодог.

Монгол Улсын 3 сая 500 мянган иргэд, эхийнхээ хэвлийд байгаа хүүхэд хүртэл ээжийнхээ авч хэрэглэж байгаа төмрийн бэлдмэлийн татварыг төлж байна.

Татвар төлөгчдийн мөнгийг хэрхэн хянах ёстой, хэрхэн захиран зарцуулах ёстойг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо шийдэх учиртай. Энэ талаарх мэдээллийг олон нийтэд ил тод гаргаж тавьдаг байх ёстой. Эрх баригчдад хяналт тавьж, зогсоох зүйл дээрээ зогсоодог байх ёстой. Энэ асуудал өнөөдөр шийдэгдэхгүй л байна.

Улсын Их Хурал хүний эрхийн зөрчлийг арилгах чиглэлээр тодорхой хэмжээнд ажил хийх гэж эрмэлзэж байгаа. Гэсэн хэдий боловч, өнөөдөр хүний эрхийн зөрчлүүд газар сайгүй болж байна. Үүнийг эрх мэдэлтэй хүмүүс, эрхээ зөрчүүлээгүй хүмүүс мэдэхгүй ээ. Иргэд илүү мэдэрч байгаа.

Тийм болохоор иргэдийн мэдэх эрхийг хангахын төлөө хийж байгаа ажилдаа цөөнхийг буюу эрх баригчдаас салангид байгаа иргэдийгээ оролцуулдаг мэдэх эрхийг нь дэмждэг чиглэлд илүү ажиллах шаардлага тулгарч байна.

Та бүхнийг цаашид олон зүйл дээр тунгалаг, ойлгомжтой, тодорхой байгаасай гэж хүсэх байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: - Одоо мэдээлэлтэй холбогдуулан Ерөнхий сайд болон ажлын хэсгийн гишүүдээс цөөнхийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлнэ.

Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаа асуулт асууна.

Ж.Баярмаа: - Сайн байна уу? Ерөнхий сайд аа. “5Ш” ажиллагаа мэдээж тодорхой зорилготой. Эцсийн үр дүнд хүрэхийг зорьсон жил байх гэж найдаж байгаа.

Авлигын талаарх мэдээллийг бүгд мэдэж байгаа. Манай улс авлигаас ухарч байгаа хамгийн ноцтой 6 орны нэг болчихсон яваад байгаа. 33 гэдэг оноо бол ардчилсан бус орнуудын авдаг оноо байгаа. Манай улсын ард дайн дажинтай, зөрчил мөргөлдөөнтэй Сьерра Леон, Шри-Ланк гээд улс жагссан. Харин манай улсын өмнө Беларусь Улс буюу тоталитар дэглэмтэй улс жагсаж байна. Иймд манай улс авлигын индексээр хэрхэн ухарсан гэдэг нь тодорхой харагдах юм.

Авлигатай тэмцэх жилийг зарласан. Гэвч үйл ажиллагаанууд уран сэтгэмж бүхий сүржин явагддаг ч үр дүн нь жаахан даржин юм уу даа гэж харагдаж байгаа.

“Шилэн ажиллагаа”, “Шүүр ажиллагаа” бол дандаа нэг үзэгдэлтэй, тохиолдлуудтай тэмцээд байгаа юм шиг санагддаг. Гэтэл цаанаа нэг шалтгаан гэж байгаа. Яагаад авлига тасрахгүй байгаа юм бэ? Авлигыг бий болгож байгаа үндсэн шалтгаан, хүчин зүйлсүүд нь юу юм бэ гэдэг дээр ямар ажил хийгдэж байгаа талаар тодорхойгүй байна.

Авлигыг үүсгэж байгаа гол шалтгаан гэвэл төрийн алба, төрийн өмчит болон төрийн оролцоотой компаниуд, төрийн үйлдвэрийн газрууд, энэ бүхэн авлигыг үүсгэж байгаа. Мөн данхайсан төр өөрөө авлигыг бий болгох нөхцөлийг үүсгэж байгаа.

Энэ зөвшөөрлүүд хэчнээн байна вэ? Элдэв янзын дарамт шахалт үзүүлэхүйц хэмжээний олон тооны зөвшөөрлүүд авлигын хүчин зүйлс болдог.

Америкийн Нэгдсэн Улсын жишээ, Аргентины жишээг бид бүгд ярьдаг, мэддэг. АНУ-д Efficiency DOGE^[Department of Government Efficiency (DOGE)] /Төрийн удирдлагын үр ашгийн хэлтэс/ гээд яамны статусгүй хэрнээ хөндлөнгийн байгууллагыг байгуулаад ажиллуулах гэж байгаа.

Төрийн албыг бараг 75 хувиар багасгахад гэмгүй гэж Вивек Рамасвами /Vivek Ramaswamy/ гээд хүн хэлсэн байгаа. Улмаар Засгийн газрын зардлын гуравны нэг буюу 6 триллионоор багасгахад, төрийн үйл ажиллагаа асуудал байхгүй явагдана гэж байгаа. Тэгэхээр танаас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: - Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууж, үг хэлж болно.

О.Цогтгэрэл: - Ил тод байдлын талаар өнгөрсөн хугацаанд Засгийн газраас хийж байгаа, хийж ирсэн ажлын үр дүнгийн тухай тайлан байна.

Ил тод байдлыг олон ач холбогдолтой гэдэг дээр бүгдээрээ л санал нэгддэг. Мэдээж хамгийн чухал нь авлигатай тэмцэх, авлигын асуудалд ахиц дэвшил гарах, үзүүлэлтүүд, индексүүд сайжирсан байх.

Хоёрдугаарт нь, авлигаас гадна үр ашиг гэдэг зүйл, бүтээмж гэдэг зүйл гарч таарна. Тэр тусмаа сүүлийн үед Засгийн газраас “Төрийн бүтээмж” гэдэг үгийг ашигладаг болсон нь сайшаалтай байна.

Эндээс би тодорхой асуулт асуух гээд байгаа нь ер нь “бүтээмж” гэдэг зүйл өөрөө тоогоор илэрхийлэгддэг. Чанарын асуудал арай өөр. Төрийн бүтээмж ярьж байгаа учраас төрийн бүтээмжийн тоо хэмжээ хэд байгааг хэд болгох гэж байгаа вэ? Ил тод, нээлттэй байдал нь энд төрийн бүтээмжид хэрхэн нөлөөлөх талаар нэг хариулт авъя мөн байр суурь, бодлого, стратегия хэлж өгөөч.

Үүнтэй холбогдуулж нэг зүйл тодруулах гэж байна. Сүүлийн арваад жилд Монгол Улсын төрийн албан хаагчийн тоо 140-өөс 230 мянга орчим болоод нэмэгдчихсэн. Энд цахимжиж байна гээд мөнгө төсөвт тавиад байдаг. И-Монголиа амжилттай байна гээд байдаг. Тэгвэл яагаад төрийн алба 10 жилийн хугацаанд 60-80 хувиар нэмэгдчихэж байгаа вэ? Үнэхээр цахимжилт явж байгаа бол, технологижиж байгаа бол, бүтээмж нэмэгдэж байгаа бол төрийн алба хаагчийн тоо буурах ёстой. Энэ зөрүүтэй хүний тоо нь баялаг бүтээдэг салбарт шилжих учиртай. Гэтэл ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний хууль гээд нөгөө талдаа бизнесийн салбар нь ажиллах хүчингүй болчихсон байдаг. Төрийн алба, төрийн өмчит компаниуд нь бараг 10 жилд хоёр дахин нэмэгдчихээд байдаг.

Нэг талаас техник, технологийн дэвшил, төрийн бүтээмж яриад нөгөө талд ажиллах хүчний хомсдол үүсээд байгаа нь бодлогын хувьд өөр хоорондоо огтлолцол үүсэхгүй болоод байна. Үнэхээр бүтээмж нэмэгдээд байгаа бол хүний тоо хасагддаггүй гэхэд ядаж хэвэндээ баймаар байгаа юм.

Бүтээмжтэй холбоотой зүйлийг аль болох тоогоор илэрхийлж зорилго зорилтдоо хүрч байгаа үр дүнгээс хэлж өгөөч. Тоогоор гэдэг нь тухайлбал, Монгол Улсын дундаж бүтээмж 2023 оны дүнгээр 22 сая орчим төгрөг байна. Хамгийн өндөр нь уул уурхай жилд 52 сая төгрөг, хөдөө аж ахуй 10 сая төгрөг, уул уурхай, хөдөө аж ахуй хоёрын хооронд 5 дахин зөрүүтэй. Дундаж нь 22 сая төгрөг байна гэх мэтээр тоонууд байна. Монгол Улсад өнөөдөр төрийн бүтээмж ярихад мөнгөн дүнгээр илэрхийлбэл яаж гарч байгаа вэ гэдэг дээр хариулт авмаар байна.

Д.Амарбаясгалан: - Төрийн бүтээмжийн асуултад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: - Төрийн албан хаагчдын тоо 220 мянга гараад байгаа. Үүнээс төрийн захиргааны албан хаагч буюу төрийн жинхэнэ албан хаагч 20 мянга байгаа. Энэ тоо яагаад жил ирэх тусам өсөх болсон бэ гэвэл сургууль баригдахаар, цэцэрлэг баригдахаар, эмнэлэг баригдахаар төрийн албан хаагчдын тоо нэмж байгаа гэж харагддаг. Энэ 220,000 нь төрийн үйлчилгээний, бусад улс төрийн албан хаагч нар байгаа.

Төрийн жинхэнэ албан хаагч нар яагаад хэт их ачаалалтай байгаад байна вэ гэдэг нь төрийн бүтээмж, нөгөө орц, гарц гээд байгаа нөөцийг зөв хуваарилаад гарцаа бий болгож чадахгүй байгаатай холбоотой. Тийм учраас

ирэх онд Засгийн газраас төрийн албаны шинэчлэл, эрх зүйн реформыг хийнэ гэж төлөвлөснийхөө дагуу Бүгд Найрамдах Солонгос Улсын сайн туршлагад үндэслээд төрийн албаны ерөнхий хуулийг өргөн барина. Энэ хүрээнд төрийн үйлчилгээ, төрийн улс төрийн алба, төрийн захиргааны алба тус тусдаа зохицуулагдах юм.

Гаднын жишгийн дагуу public service, CV service гэдэг байдлаар ангилаад “Нийтийн үйлчилгээний алба” гэж салгаад багш, эмч нарыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулдаг болох хэрэгтэй байна.

О.Цогтгэрэл даргын хэлж байгаа үнэн. Үнэхээр цахимжилтыг нэмэгдүүлэхийн хэрээр яагаад энэ ачаалал буурахгүй байсан юм бэ, яагаад цомхотгол хийгдэхгүй байгаа юм бэ гэвэл нэгд дүрэм, журмын түгжрэл байсан.

Тийм учраас өнгөрсөн парламентын хугацаанд 109 хуульд өөрчлөлт оруулсан. Энэ өөрчлөлтийн дараа 70 хуулийн өөрчлөлт яригдаж байгаа. Төрийн албанд бичгийн цааснаас салья гэхээр цаасаар заавал шаардана гээд хуультай гээд олон асуудлууд байгаа.

“И-бизнес” гэдэг бизнесийн платформ хийгээд бараг 100 зөвшөөрлийг цахимаар олгоод байхад заавал үнэт цаас хэвлээд зөвшөөрөл өгнө гэсэн органик хуультай. Түүнийг зохицуулахын тулд дахиад 30 хуулийн өөрчлөлтийг хийж байж төрийн албан хаагч нар асуудалгүйгээр ажиллах гээд байгаа.

Дээрээс нь Зөвшөөрлийн хуулиар 360 зөвшөөрөл зохицуулснаас 100 зөвшөөрлийг мэргэжлийн холбоонд шилжүүлэх бололцоо байгаа.

Ингэж чадвал төрийн албан хаагчдын нийтийн үйлчилгээ эрхэлж байгаа хүмүүс мэргэжлийн холбоонд шилжих ёстой. Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо зэрэг олон холбоо тусгай зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлдэг, сургалт явуулдаг, судалгаагаа хийдэг, төрийн зарим чиг үүргийг шилжүүлдэг болно.

Үүнийг Мэргэжлийн холбооны хуулиар зохицуулсан. Одоо Улсын Дээд шүүх бүртгэж эхэлж байгаа. Тэгэхээр төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоонд шилжүүлэх нэг алхамыг хийнэ.

Ирэх оноос Засгийн газар “Их өгөгдөл”-д суурилсан шийдвэр гаргахтай холбогдуулаад real time-аар бүх мэдээллүүдийг хянадаг болно. Ингээд улсын хэмжээнд нэгдсэн ERP систем хэрэглэж эхлээд аймгууд анх удаа Засгийн газарт албан бичгээ цахимаар шууд шийдэхэд, хариу нь тэр даруй илгээдэг болгосон. “Цаасгүй засаг” арга хэмжээний хүрээнд жилд 20 тэрбум төгрөг хэмнэнэ.

Бүтээмжийг нэмэгдүүлнэ гэдэг бол салбар болгоны асуудал. Орц, гарцын асуудал. Байгаа нөөцөө хэрхэн зөв хуваарилах вэ. Үүнд ямар хууль саад тотгор учруулж байна вэ гэдэг саадуудыг арилгах цогц арга хэмжээг төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх хүрээнд авч хэрэгжүүлнэ. Эдгээр 6 чиглэлийн ажлуудыг хийвэл төрийн бүтээмжийг 26 хувиар өсгөнө гэдэг зөвлөмжийг OECD өгсөн.

Энэ 6 чиглэлийн арга хэмжээг ирэх онд авч хэрэгжүүлнэ. Цаас бичиг нэхээд байдаггүй болох бөгөөд 20 тэрбум төгрөг хэмнэж байна. Нэг тайлан мэдээлэл, үнэлгээг real time-аар аваад Засгийн газрын гишүүд e-cabinet-аар хараад хянаад шийдвэр гаргалт нь өөрөө ухаалаг болж байна.

Ерөнхий сайдын мэдээлэл дээр гарсан төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх тухай хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Байгууллагыг татан буулгах, нэгтгэх, нийлүүлэх, хөрөнгө босгох чиглэлээр листэд оруулах ажлуудыг шат дараалалтай хийнэ. Албан газар, төрийн өмчийн компани гэдэг хоёр л статус бий болно. Ингээд төрийн өмчит болон орон нутгийн өмчийн компани 40 хувь буурна.

Ингэж чадвал тэр хэмжээгээр бүтээмж нэмэгдэнэ. Энэ хуулиар төр ямар бизнест оролцохгүй вэ, ямарт нь оролцох вэ гэдгээ 10 жилээр зарлана. Улсын Их Хурал өөрөө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: - Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: - “5Ш” ажиллагааны хүрээнд “Шил” гэдэг мэдээллийг өнөөдөр хийж байна. Тэгэхээр түрүүн 118-ын бүлгийн гишүүн Ерөнхий сайдтай сайн байна уу гээд хэлчих шиг болсон. Бодвол сайн байна гэдэг хариултыг нь өгвөл шилэн талд орох байх.

“Эрх мэдэл өөрийгөө хянадаггүй бусдыг хянадаг” гэж би түрүүн индэр дээрээс хэлсэн.

Та бүхний бүх эрх мэдэл 118-ын бүлэгт буюу 3 намд хадгалагдаж байгаа. Цаашилбал 118-ын бүлэг маань цөөнхийн эрх мэдлийг хуваалцдаг болчихсон. Цөөнх гээд индэр дээрээс үг хэлэх хэрэг байдаг юм уу.

Яг үнэндээ хараад байхаар бие биеэсээ асуулт асуугаад, засаг бүрдүүлж байгаа 3 намын сайд нар нэгнээсээ асуухад өөр намын сайд өмнөөс нь хариулж өгөөд байгаа.

Энэ чинь олонх юм уу, цөөнх юм уу. Улсын Их Хурал дээр байгаа дэгийн тухай хуультай холбоотойгоор энэ нөхцөл байдал нь Засгийн газарт хэрэгтэй байгаад байгаа юм уу, хэрэггүй байгаад байгаа юм уу?

Үүнийгээ өөрчилье. Засгийн газар кабинетын зарчмаар ажилладаг гээд Улсын Их Хурал, Засгийн газар хоорондын харилцааг нь шилэн байлгах, бусад шийдвэрүүд нь шилэн байхад нь дэм болгох үүднээс олон л хуулийн төсөл Засгийн газар санаачилж оруулж ирдэг.

Ил тод байдлаа яаж хангах гээд байгаа юм бэ? Ямар арга хэрэгсэл, ямар хэлбэрээр, юу хийж байж ил тод байдлыг хангах юм бэ? Ил тод байдлыг хангана

гэдэг чинь ерөнхийдөө шилэн гээд яриад ирэхээрээ дандаа засаг талын, эрх баригч талын нээлттэй ил тод байдал гэдэг талаасаа хандаад эхэлдэг.

Нөгөө талдаа буюу иргэдийн мэдэх эрх гэдэг талаас хэр хандаж чадах юм бэ? Ил тод байдал чинь түүндээ хүрч үйлчилж чадах юм уу?

Ямар нэг хэмжээгээр шүүмжлэл, санал хэлсэн, шоглоод ганц үг хэлсэн хүмүүс ч гэсэн их бага хэмжээгээр шийтгэл аваад л байгаа шүү дээ. ХҮН намын П.Наранбаяр сайд руу өндөг шийдлээ гээд Зөрчлийн хуулиар долоо хоног баривчлагдаж байна. Шүүх бол арга байхгүй шүү дээ. Хууль дээр бичсэн болохоор, түүний дагуу л хариуцлага хүлээлгэнэ.

Ерөнхий сайдаа шүүмжилж асуулт асуунгуутаа өөрийнхөө намын хүнээс хариулт авдаг зүйл байж болох юм уу? Үүнийгээ өөрчлөхгүй юм уу?

Д.Амарбаясгалан: - Оюунсайханы Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: - Ил тод байдал чухал. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн талаар Б.Жаргалан гишүүн түрүүнд үгэндээ хэлсэн

Албаны нууц гэдэг ангилалд оруулаад хаалттай худалдан авалт хийдэг. Эндээсээ хөрөнгө мөнгө завшдаг зүй бус явдлууд зөндөө гарсан. Хүний эрхийн багц хуулиудыг Засгийн газраас өргөн барьж байгаа. Энэ хуулиуд дотор Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулъя. Албаны нууцад өөрсдийнхөө хууль бус үйлдлийг далдлах зорилгоор албаны нууцад хамаарахгүй байх гэсэн харилцааг оруулж байгаа.

Дээрээс нь ил тод байдал бол авлигатай салшгүй холбоотой яригддаг зүйл. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын авлигын нөхцөл байдал дордож байгаа.

Хамтарсан Засгийн газраас авлигын эсрэг багц хуулийн төслүүдийг өргөн мэдүүлэх гэж байгаа. Эхний танилцуулга нь Засгийн газарт хийгдчихсэн. Энэ хүрээнд Авлигын багц хуулиуд, мөн Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах, нөхөн төлүүлэх тухай хууль зэрэг хуулиуд хийгдэж байгаа.

Авлигын эсрэг тэмцэл юу болох вэ, яаж хийх вэ? Хамтрах гэдэг ойлголт авлигын эсрэг тэмцэлд хамаагүй. Тэр хамтарна уу, ямар нам байна, энэ танхим дотор сууж байгаа хүн байна уу, урьд нь төрийн өндөр албан тушаалд байсан уу гэдэг энэ авлигын эсрэг тэмцэлд ерөөсөө хамаагүй. Ил далдаар янз янзын мессеж өгч байгаа. Зарим нэг хууль хяналтын байгууллагын дарга нараар дамжуулж “дэмий юм биш үү”, “хүн хилсдүүлэх гэж байгаа юм биш үү”, “ийм хууль гаргаад хэрэггүй дээ” гээд нөхөрсөг байдлаар гэдэг зөндөө сануулгууд өгч байгаа, ирж байгаа.

Тэгэхдээ Монгол Улсын Засгийн газар авлигын эсрэг тэмцлээсээ ухрахгүй. Үүнийгээ бид хийж хэрэгжүүлэх ёстой. Ингэж байж урагшаа явна.

Ардчилсан намын гишүүн байж хөрөнгө хураах тухай ярилаа гэж байгаа. Ардчилсан намын гишүүн байх, аль намын гишүүн байх энд ерөөсөө хамаагүй.

Хулгай бол хулгай байдаг, хулгайч бол хулгайч байдаг. Авлигал бол авлигал байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 3-д “Монгол Улсын иргэн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах эрхтэй” гэж заасан. Хэн ч хулгай хийхгүй, хэн ч авлига авахгүй.

Тэгэхээр энэ чиглэлийн багц хуулийн төсөл орж ирнэ. Энэ хуулийн төслүүд батлагдаад Засгийн газраас өргөн мэдүүлж байгаа. Хүний эрхийн багц хуулиуд батлагдвал хүний эрхийн нөхцөл байдал өөрөө ил тод байдалтай холбоотой авлигын индексэд нөлөөлдөг зүйл. Өмнөх сайдууд, нэн ялангуяа өмнө нь Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж байсан Х.Нямбаатар сайдын үеэс санаачилга гаргаад авлигын индексийг бууруулах талаар явж байсан зөндөө ажлууд байна.

Үүнийг сүүлийн 6 сарын хугацаанд маш идэвхжүүлж байгаа. Ерөнхий сайдын өгсөн үүргийн дагуу Transparency International байгууллагын удирдлагууд, олон улсын байгууллагууд хүний эрх, авлигын чиглэлийн асуудлуудыг танилцуулж байгаа. Тийм учраас цаашид авлигын индекс буурна гэсэн хүлээлттэй байгаа.

Д.Амарбаясгалан: - Цэндийн Баатархүү сайд нэмж хариулт өгье.

Ц.Баатархүү: - Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Цахим шилжилт тодорхой хэмжээнд амжилттай явж байгааг НҮБ-аас гаргадаг цахим засаглалын хөгжлийн индекс тодорхойлж байдаг.

Монгол Улс бол 193 улсаас 28 байр ахиж 46 дугаар байранд орсон. Ази тивд 13 дугаар байранд орж байна. Бусад олон индекс үзүүлэлт 90-ээс 100 гаруй, 103-ын хооронд байдаг. Цахим засаглалын хөгжлийн индекс харьцангуй сайн явж байна.

Гэсэн хэдий ч төрийн байгууллага дээр иргэн очоод үйлчилгээ аваад дараагийн төрийн байгууллага дээр үйлчилгээ авах гэхээр цаасаар ямар нэгэн лавлагаа тодорхойлолт нэхдэг байдал хэвээрээ байна. Үүнийг нэг мөсөн шийдэх олон ажлын хэсэг гарч ажиллаж байгаа. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хяналт үнэлгээний үндэсний хороо, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Бүтээмжийн хороо, Ч.Анар гишүүн гишүүнээр ахлуулсан Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гараад ажиллаж байна. Ажлын хэсэг цахим шилжилт үнэхээр амжилттай байгаа бол төрөөс үзүүлж байгаа олон лавлагаа, үйлчилгээ, зөвшөөрлүүдийн давхцалыг арилгаж, процессыг нь хэдэн хувиар цөөлөх юм бэ, хэдэн ажлын байрыг хэмнэх юм бэ гэдэг бодит хэмнэлтийн дүнг 2025 оны 1 дүгээр сард гэхэд Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болгохоор ажиллаж байгаа.

Үүний үр дүнд цахим шийдэл гэдэг технологийн шийдлийн цаана нь төрийн үйл ажиллагааны процесс, давхцал цэгцэрч, иргэдэд илүү ил тод болно.

Хоёрдугаарт, ил тод байдлын тухай Улсын Их Хурлын гишүүд асууж байна.

“Shilenhyanalt.gov.mn”, “shilen.gov.mn” гэдэг сайтуудын хяналтыг мэргэжлийн холбоо, олон нийтийн байгууллага, төрийн бус байгууллагуудад хяналтыг шилжүүлэхээр ажиллаж байна.

Иргэд, төрийн бус байгууллагууд, мэргэжлийн байгууллагууд төрийн үйл ажиллагаа, мэдээллээ цаг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: - Ерөнхий сайд нэмж хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: - Өнөөдрийн үг дээр зориуд үе солигдсон шинэ парламент нөлөөтэй толины тусгалгүйгээр авлигын суурь асуудлуудыг олж тогтолцооны хувьд засаж чадна гэдэгт итгэж байна гэдэг үгийг илэрхийлсэн. Шинэ парламент авлигын тухай анх удаа ярьж байна. Өмнө нь авлигалтай холбоотой олон асуудлууд болсон.

Авлигатай холбоотой асуудлуудыг анхаарлын төвд оруулахын тулд зориуд “БШ” ажиллагаа гэж нэрлэсэн. Энэ нэршлээрээ олон нийт анхаарч нийгмийн дэмжлэг авлигын асуудлууд дээр анхаарлаа илүүтэй төвлөрүүлээсэй гэдэг агуулгаар хандсан. Өнгөрсөн хугацаанд хэд хэдэн зүйл хийгдсэн.

Нэгдүгээрт, сангууд болон төрийн байгууллагуудын мэдээллүүд далд байсныг бүгдийг нь ил болгосон. Олон сангууд дээр асуудал үүссэн. Нам харгалзахгүй л асуудлууд үүссэн. Өнгөрсөн бүх л цаг хугацааг дүгнэх шаардлагатай гэж л үзсэн.

Өмнөх парламент дээр нэлээдгүй ч эмоцитой асуудлууд болж байсан. Та бүхэн санаж л байгаа байх. Хөгжлийн банкны чанаргүй зээлүүдийг нээлттэй болгох үед талбай дээр жагсаал ч болж байсан. Нүүрсний худалдан авалтыг нээлттэй болох үед жагсаал болж байсан. Олон парламентын гишүүд холбогдож хуулийн байгууллагаар шалгагдаж, хэрэгт татагдаж байсан. Та бүхэн энэ үйл явдлыг харж л байсан байх.

Тийм учраас энэ бүх үйл явдлуудыг гаргаж, парламентын төлөөллийг нэмэх нь зүйтэй, олон ургалч үзэлтэй парламент байх нь өөрөө зөвхөн тойрогт барьцаалагдахгүй, асуудлыг илүү том зургаар нь харахад бол чухал гэж үзсэн. Мөн бүсчилж асуудлыг томсгох нь чухал гэдэг агуулга тэр үеийн дүгнэлтээс гарч байсан гэдгийг хэлье.

Парламентаас авлигын асуудлууд дээр гаднаас харах нэг өөр, дотор орж ирээд харах бол нэг өөр байдаг. Зориуд энэ үгийг О.Алтангэрэл сайд, намын хамт олондоо ч гэсэн хэлж байсан.

Хууль зүйн сайд, Ерөнхий сайд хоёр бол өөр намаас байх нь чухал гэдэг зүйлийг хэлж байсан. Яагаад гэвэл урьд нь шүүх дээр ч юм уу асуудлууд дээр

хэрэг гацаад байна, асуудлууд болоод байна гэхээр нэг намын өнцгөөс хараад, тэр нь олигтой бодитой дүгнэлтэд нийгмийн хувьд очиж чаддаггүй.

Одоо ямар ч “нөлөөтэй толины тусгалгүйгээр” нам гэдэг эрх ашгийг хойш нь тавиад бодит байдалд дүн шинжилгээ хийгээд үзээрэй. Хэдэн хэргүүд хаанаа гацаж байгаа. Шүүх дээр хэдэн хэрэг очоод буцсан, яагаад ингээд байгаа гээд та бүхэн хараарай.

Тийм учраас 126 гишүүнтэй парламент авлигын асуудлыг зөвхөн нэг, хоёр кэйс биш бодит асуудал хаанаа байна гэдгийг илүү углуургаар нь хандаасай гэж хүсэж байна.

Цахим засаглалтай холбоотой асуудлыг хөндөж ярьж байна. Төрийн өмчит компаниудын ил тод засаглалын асуудлыг ярьсан. Олон жил ярьсан төрийн өмчит компаниудыг цэгцэлье. Татвар, нийгмийн даатгалтай холбоотой багц зөвлөмжүүд байгаа. Үүнийг мөн цэгцэлье.

Д.Амарбаясгалан: - Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

---oOo---

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД
ЕРӨНХИЙ САЙДЫН ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ**

№60

Эмхэтгэсэн:	Д.Энхмаа
Хянасан:	Ч.Онончимэг
Эх бэлтгэсэн:	Б.Төгсзаяа

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хяналт шалгалтын газраас эрхлэн гаргав.

УИХ-ын Тамгын газрын Хэвлэх, олшруулах цехэд бэлтгэв.